



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-112

1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	7-112
--	-------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
9 дүгээр сарын 19-ний өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 69 гишүүн хүрэлцэн ирж, 54.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баасанжаргал, Д.Батлут, Ж.Баясгалан, Г.Ганбаатар, Л.Мөнхбаатар, Н.Наранбаатар, Д.Пүрэвдаваа, Б.Пүрэвдорж, О.Саранчулуун, А.Ундраа, С.Цэнгүүн;

Чөлөөтэй: С.Одонтуяа, М.Сарнай, Л.Энхнасан;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Ц.Идэрбат, Ч.Лодойсамбуу, Л.Мөнхбаясгалан;

Тасалсан: Ж.Бат-Эрдэнэ;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-1 цаг 39 минут, Н.Алтаншагай-1 цаг 00 минут, С.Амарсайхан-27 минут, М.Бадамсүрэн-02 минут, Д.Батбаяр-2 цаг 22 минут, Х.Баттулга-25 минут, Б.Батцэцэг-23 минут, Ж.Баярмаа-13 минут, Б.Бейсен-11 минут, Э.Болормаа-40 минут, Х.Булгантуяа-05 минут, С.Бямбацогт-24 минут, Ж.Галбадрах-10 минут, А.Ганбаатар-06 минут, С.Ганбаатар-1 цаг 34 минут, Д.Ганбат-04 минут, П.Ганзориг-12 минут, Л.Гантөмөр-1 цаг 24 минут, Ц.Даваасүрэн-49 минут, Г.Дамдинням-01 минут, Т.Доржханд-1 цаг 16 минут, Б.Дэлгэрсайхан-21 минут, Б.Жаргалан-15 минут, Ц.Мөнхтуяа-08 минут, З.Мэндсайхан-05 минут, П.Наранбаяр-07 минут, Б.Пунсалмаа-07 минут, П.Сайнзориг-13 минут, Ц.Сандаг-Очир-02 минут, Р.Сэддорж-06 минут, Б.Түвшин-04 минут, Х.Тэмүүжин-01 минут, Н.Учрал-01 минут, Д.Цогтбаатар-22 минут, Ж.Чинбүрэн-10 минут, Б.Чойжилсүрэн-03 минут, Л.Энх-Амгалан-30 минут, Ж.Энхбаяр- 39 минут, Р.Эрдэнэбүрэн-29 минут.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын

Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрэм, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Ж.Дэлгэрсайхан, А.Энхбат, Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Бадамсэрээжид, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Улсын ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Ариунболд, Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Б.Энх-Амгалан, мөн газрын Захиргаа, санхүүгийн газрын дарга Б.Батцэцэг, Ерөнхийлөгчийн хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх Г.Ганболд, Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, менежер Э.Баттогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогын газрын дарга Т.Баясгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 10 цаг 10 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон төрийн аудитын төв байгууллагын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Д.Энхтуяа, Б.Уянга, З.Мэндсайхан, Ж.Батсуурь, Ц.Туваан, Ц.Баатархүү, П.Мөнхтулга, Ц.Сандаг-Очир, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, Ж.Золжаргал, Ч.Номин, М.Мандхай, Ч.Анар, Г.Хосбаяр, Д.Жаргалсайхан, Х.Тэмүүжин, Э.Болормаа, Ц.Мөнхтуяа, Ж.Галбадрах, Ж.Баярмаа, А.Ганбаатар, Б.Заяабал, Б.Жаргалан, Н.Алтаншагай нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Боловсролын сайд П.Наранбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 05 минут үргэлжилж, 13 цаг 05 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 10 минутад эхлэв.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгээс Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Б.Жаргалан ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./17:20/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 16 минут үргэлжилж, 126 гишүүнээс 107 гишүүн хүрэлцэн ирж, 84.9 хувийн ирцтэйгээр 17 цаг 21 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өглөөний амар амгаланг айлтгая 66 гишүүн бүртгэгдэж ирц 52.4 хувьтай байна. Бүртгэлд орсон гишүүдийг танхимд орж ирэхийг урья.

2025 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Асуулт асуухаар нэр өгсөн гишүүд байгаа. Чуулганы нэгдсэн хуралдаанаар өнөөдөр 3 асуудлыг хэлэлцэхээр оруулж байгаа.

Нэгдүгээрт, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Хоёрдугаарт “Алт 3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэнэ.

Гуравдугаарт Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 7 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ ээ.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна аа.

Улсын Их Хурлын гишүүд нэр өгсөн дарааллын дагуу асуулт асууна. Ерөнхий сайдад мэдээлэл хүргээрэй. Баярмагнайн Баярбаатар гишүүн асуулт асууя.

Б.Баярбаатар: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе ээ. 1 дүгээрт энэ Эдийн засаг хөгжлийн яам Учрал сайд хариулах болов уу гэж би бодож байна. Ер нь энэ нэг ойлголтыг зөв өгмөөр байна аа. Өчигдрийн хуралдаан дээрээс ажиглахад энэ Улсын Их Хурлын баталж өгсөн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний дагуу гэж яриад байгаа юм. Яах вэ Улсын Их Хурал баталж өгсөн л дөө. Тэгээд тэр үед Засгийн газар өргөн барьсан юм л даа. Засгийн газрын өргөн барьсныг нь хэлэлцэж баталсан юм. Би тэр үед энэ төрийн албан хаагчийн 9 хувь гэдэг дээр би эсрэг байр суурь илэрхийлээд протоколд үгээ үлдээж байсан юм. Яагаад гэхээр энийгээ цомхотгох аргачлал чинь байхгүй байна. Нөгөө дахин инженерчлэл чинь яаж уялдах юм бэ? Баахан квот өгөөд явах гээд байгаа юм биш үү гэсэн.

Өнөөдөр ингээд нэг баахан квот авчихсан байгууллагууд хөдөө орон нутаг хаа сайгүй л ингээд яваад байгаа. Яах вэ энэ тэгээд төсөвт хэмнэлт гарна гэж үзээд ингэж байгаа юм байна. Энийг дагаад ингээд 7 мянган хүн тэтгэвэрт гарах гээд өргөдлөө өгчихсөн. Төсөвт төрж байгаа дарамт нь 375 тэрбум төгрөг. Нэг удаагийн нэг жилийн хугацаанд энийг олгох боломжгүй учраас 2 хуваана гэж байгаа юм. Энэний аргачлал нь яг ямар аргачлал юм бол? Тэгвэл тэр 7 мянган хүний 3500-г нь нэг жил хойш нь татах гэж байгаа юм уу, эс үгүй бол тэтгэмжийг нь 2 хуваах гэж байгаа юм уу? Тэр хүнийг нь 2 хуваалаа гэж үзэхэд тэр дараа жил рүү шилжиж байгаа улсууд нь нэг жилийн хугацаанд ажлаа хийж байх явцдаа нөгөө цомхотголд ороод халагдчихвал яах вэ? Энэний баталгаа байна уу? Төр ямар баталгаа гаргаж өгөх вэ? Энэ чинь цаашлаад яривал хүний эрхийн асуудал. Ингээд дараа нь 7 мянган хүн тэтгэвэрт гарлаа. Нөгөө жилд нэг 14 мянга орчим хүн тэтгэвэрт гардаг нь одоо бараг 20 гаран мянга болж байх шиг байна л даа. Тэгээд энэ тэтгэврийн данс чинь дийлэх юм уу. Яваандаа нөгөө ажилгүйдлийн сан чинь дийлэх юм уу? Тэгээд буцаад бараг энэ чинь нөгөө нэг төсөв хэмнэх гэсэн биш бараг хэсэг хугацааныхаа дараа энэ чинь төсөвтөө нэлээдгүй өндөр дарамт болоод ирчхэж байгаа юм биш үү гэдэг нэг ийм зүйл байна.

Дараагийн нэг асуудал бид нар энэ 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд энэ ядуурлыг бууруулж 22 хувьд хүргэнэ гэсэн. Энэ дээр ер нь төсөв яг ямар агуулгатай ямар байр суурь орж ирсэн юм? Яг төсвөөс харахад бол тийм 22 хувьд буулгахаар тийм арга хэмжээнүүд энд харагдахгүй. Бид нар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр энэ 2026 оны хөгжлийн төлөвлөгөө 2 дээр чинь аль алин дээр нь энэ ядуурлыг 22 хувьд хүргэнэ гээд заачихсан байгаа. Энэ эрүүл мэндийн сайд байхгүй байх шиг байна. Энэ эрүүл мэндийн төсөв жоохон чамлалттай санагдаад байгаа юм. Дээр нь энэ эд, эрхтэн шилжүүлэх төв барина. Энэний 43.1 тэрбум төгрөг суугдсан юм байна. Тэгэхдээ энэнээс гадна өнөөдөр энэ эрхтэн шилжүүлэхтэй холбоотой энэ ядаж нэг 400, 500 сая төгрөгийг нь дотроо гүйлгээд суулгахгүй бол нэг ч гэсэн хүний амь нас өнөөдөр энэ элэг шилжүүлэн суулгах энэ бүлэг таарахгүй хүмүүсээс элэг шилжүүлэн суулгахад хамгийн багадаа нэг 20 сая төгрөгийн зардал гардаг юм. Дээшээгээ 60 сая төгрөг олдог. Тэгээд энэ мөнгө.../минут дуусав.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Учрал сайд.

Н.Учрал: Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг Их Хурлаас баталсан.

Тухайн үед улсын жилийн төлөвлөгөөг алсын хараа урт хугацааны бодлого, дунд хугацааны бодлого дээр суурилж оруулж ирсэн. Тухайн үед жилийн төлөвлөгөөнд 9 хувийн хэмнэлт хийнэ гэдэг ийм зорилт орж ирсэн. Энэ зорилтыг хангуулахад юу хийх вэ гэвэл чиг үүргийн шинжилгээ, дахин инженерчлэл хийх ёстой. Сүүлийн 10 жилд төрийн албан хаагчдын тоо 39.3 хувиар өссөн. Тэгээд төрийн үйлчилгээний захиргааны тусгай албан хаагчдыг тэр төрийн 4 төрлийн албан хаагчдыг бүгдийг нь төрийн алба юм гэж үзэхээр сургууль баригдах болгонд багш нар өсдөг. Эмнэлэг баригдах болгонд мэдээж эмч нарын тоо өсдөг. Ийм байдлаар бол яваад ирчихсэн.

Тийм учраас төрийн албан хаагчдын тоо 39.3 хувиар өсчихжээ. Түүний үр дүнд бид нар чиг үүргийн бүрэн шинжилгээ хийгдэх буюу давхардлыг арилгах чиг үүргийн давхардлыг арилгах чиглэлээр бол ажлуудыг хийсэн. Энэ утгаараа давхардлыг арилгаж зарим үйлчилгээг цахимд шилжүүлэх зарим давхардсан чиг үүргийг нэгтгэх чиглэлээр нийтдээ 2.2 их наяд төгрөгийн хэмнэлтийн тодотгол

хийсэн. Ингэснээр төр бол хэмнэлт хийсний үр дүнд өнөөдөр эдийн засгийн өсөлтийг 5.7хувьд тооцох ийм бололцоо бол бүрдсэн. Тэгээд 9 хувийн энэ цомхотгол хийнэ гэж байгаа бол зүгээр ингээд бүгдийг нь тайрч хаяад бүх түвшинд 9 хувийн цомхотгол хийнэ гэж байгаа үг огт хэлбэр биш. Бид нар сая чиг үүргийн шинжилгээ хийхдээ төсвийн ерөнхийлөн захирагч нар салбар дотроо чиг үүргийн давхардлаа хэрхэн арилгаж эндээс 9 хувийн хэмнэлт хийх вэ гээд салбар болгоноор яригдаж байгаа асуудал болохоос биш бүгдийг нь тэгшитгээд 9 хувь хий гэдэг ийм үүрэг бол энэ жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй. Тэр ч утгаараа бид нар өнгөрсөн хугацаанд төрийн хэмнэлт бүтээмжийн зөвлөл гэж опен говермент партнершип буюу энэ нээлттэй засаглал үйлчлэлийн өгсөн чиглэлийн дагуу чиг үүргийн шинжилгээ хийсэн юм аа.

Ингээд 9 хувийн цомхотголыг хийхэд бол хэн нэгний эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр бид нар давхардсан чиг үүргүүдийг нэгтгэж чадсан. Ингээд бодитой хэмнэлт бол үүнээс бий болж байгаа. 9 хувь буюу төрийн энэ цомхотголыг хийснээр цалингийн зардал 683.2 тэрбум төгрөгөөр, төсвийн хэмнэлт 815.5 тэрбум төгрөгөөр буюу төсвийн нийт зардлын 2.85, ДНБ-ий 1.22 хувьтай тэнцэх хэмжээний хэмнэлт болж чадсан нь бол энэ чиг үүргийн давхардал арилгасны тодорхой үр дүн юм гэж бодож үзэж ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ ажлуудыг хийхийн тулд бол бид нар зэрэгцүүлээд бодлогын шинэчлэлүүдийг хийж байна. Ерөнхий сайдын зарласнаар энэ дижитал пост гэдэг санаачилга амжилттай хэрэгжиж байна. Үүний үр дүнд Засгийн газар мэдээлэл технологийн виртуал бүсийг байгуулаад компани онлайнаар байгуулаад үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг амилуулах энэ журмуудыг өчигдөр Засгийн газрын хуралдаанаар 3 дахь өдөр бол гаргасан.

Дээрээс нь ядуурлын түвшнийг бууруулах зорилт бол улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд бол туссан. Тэгэхээр 2022 оны байдлаар ядуурлын түвшин 27.1, 27.2 хувь байсан. Ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй 914.2 мянган хүн байсан. Тэгэхээр эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд дорвитой арга хэмжээ авах чиглэлээр энэ хувийн хэвшлийг дэмжих бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр Эдийн засгийн эрх чөлөөний хууль, Хөрөнгө оруулалтын хууль, Зөвшөөрөл мэдэгдлийн хууль, өчигдөр гишүүдийн ярьж байгаа Тендерийн хуулиудыг 10 дугаар сард өргөн мэдүүлэх гэж байна.

Дээрээс нь нөгөө мөчлөг сөрсөн бодлогынхоо хүрээнд татварын багц хуулийн шинэчлэлийг ингээд эхлүүлж байна. Энэ бол ингээд бүхэлдээ хамтдаа.

Х.Булгантуяа: Баярбаатар гишүүн нэмж тодруулъя.

Б.Баярбаатар: Учрал сайдын хэлж байгааг ойлгоод байгаа юм аа. Тэгээд ер нь энэ яг зүгээр бид нарын энэ чуулганы танхимд яриад энэ гоё гоё хөтөлбөрүүдийн нэрийг хэлээд зорилтуудын нэрийг хэлээд бид нар ингээд яриад нэг нь асуугаад нэг нь хариулаад байгаа юм аа. Яг дунд шатандаа очихоор наадах чинь арай өөр л байдал ажиглагдаад байгаа юм. Бид нар олон төрийн албан хаагчтай уулзаж байгаа юм. Энэ 36 сарын тэтгэмжийн асуудлыг би сая ярилаа нэг удаагийн 36 сар хүртэл хийнэ.

Энэ бол төрд итгэх итгэлийг асар ихээр сулруулж байна. Төрийн албан хаагчдыг, ялангуяа энэ цагдаа, онцгой энэ мөрдөст албан хаагчид. Өдөр шөнөгүй

нойр хоолгүй ажилладаг энэ улсуудынхаа эрх зүйн байдал дээр бид нар ингээд дордуулсан байдлыг цаашид ер нь гаргаж болохгүй байх гэсэн ийм байна.

Дээр нь тэр би тэр эд эрхтэн шилжүүлэх тэр нэг бас Эрүүл мэндийн сайдад протоколд тусгачихъя. Ядаж нэг 400 сая төгрөгийг нэг шилжүүлэн суулгаж өгөөч ээ. Нэг ч гэсэн хүний амь нас аврахад хэрэгтэй юм болов уу гэсэн ийм саналыг протоколд тусгачихъя аа.

Баярлалаа.

Х.Булгантуяа: Баярбаатар гишүүн үг хэлж хэллээ. Доржзовдын Энхтуяа гишүүн.

Д.Энхтуяа: Өглөөний мэнд хүргэе ээ.

Би Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдаас асууя. Ахмад настны асуудлаар энэ 2025 оны 1 дүгээр сард чуулган зохион байгуулсан. Энэ чуулган дээр манай яамныхан нэлээд олон амлалтуудыг ахмадууддаа өгсөн байгаа. Энэ дээр бол ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ахмадын өргөө байгуулах, ахмадын сэргээн засах төвүүдийг бий болгох, ахмадын асрамжийн асуудлаар хувийн хэвшлийг дэмжих барилга байгууламж барихад дэмжлэг үзүүлнэ гэж нэлээн олон амлалтуудыг өгсөн. Тэгээд өнөөдрийн орж ирсэн энэ төсөв дээр бол инфляцтай холбогдуулж тэтгэвэр тэтгэмжийг 6 хувиар нэмнэ гэснээс өөр нэг тийм дэмжлэг юу харагдахгүй байна.

Тэгэхээр би дутуу харсан байж магадгүй. Яг энэ дээр нийгмийн халамжийн сангаас 10-аас доошгүй хувийг ахмадын нийгмийн оролцоог хангах гэсэн ийм заалттай байгаа. Тэгэхээр энэ ахмад настны хөдөлмөр эрхлэлт нийгмийн оролцоог хангахад 2026 онд яг ямар төсөв суусан бэ? Энэ дээр та надад хариулт өгөөч.

Хоёрдугаар асуулт. Сангийн сайд хариулах юм болов уу? 10 гаруй жилийн хугацаанд манайх энэ зээлийн хүүгийн татаас, зээлийн хүүгийн дэмжлэг гэдгийг энэ төсөв дээр суулгаж татвар төлөгчдийн мөнгөнөөс дэмжлэг үзүүлж байгаа.

2026 оны энэ өгсөн төсөв дээр 378 тэрбум төгрөгийг арилжааны банкнуудад зээлийн хүүгийн дэмжлэг хэлбэрээр тусгасан байна аа. Тэгэхээр энэ дээр бол нэг 4 хөтөлбөр явж байгаа. Цагаан алт, Шинэ хоршоо, Атрын 4 дүгээр аян болон Хүнсний хувьсгал гээд. Тэгээд энийг бол дэмжихгүй байгаа биш дэмжээд байна аа. Гэхдээ энэ гишүүдийн хэлж байгаа санаанууд бүх л салбар бол хүндрэлтэй байна. Дампуурч байна гээд ингэж байна. Тэгэхээр яг энэ татвар төлөгчдийн мөнгөнөөс яг энэ арилжааны банкнуудад ийм дэмжлэг үзүүлэх ямар зүйл заалт байдаг юм бэ?

Ингэснээрээ яг үр дүн нь ямар үр дүн гараад байна гэдэг дээр нэг хариулт авъя. Ерөнхий сайдаас асууя.

Баялгийн сангийн тухай хууль хэрэгжиж эхлээд 1.6 жил болж байна аа. Баялгийн сангийн тухайд бол энэ 3 сан бол миний бодлоор энэ бодлого, мөн төлөвлөлт нь тусдаа байвал ямар байсан юм бэ гэсэн ийм санал байна. Өнөөдөр яах вэ хуримтлалын санд Ирээдүйн өв санд бол нэг 4 гаруй их наяд төгрөг цугларсан байна. Энэ сайшаалтай байна. Хуримтлалын санд бол 600 хэдэн тэрбум төгрөг байна. Хөгжлийн сан бол өнөөдөр 0 ийм хуримтлалтай байна. Тэгэхээр нэгэнт

хуримтлал явах нь тодорхой бус, хуримтлал үүсгэх нь тодорхой бус байгаа энэ хөгжлийн сангийн асуудлыг та ямар хэлбэрээр харж байгаа юм бэ? Өнгөрсөн энэ 2 сард байгуулагдсан Чингис хаан баялгийн сан бол удирдлага нь Эрдэнэс Тавантолгой компанийн доор байгаа.

Х.Булгантуяа: Гэр бүл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд эхлээд хариулъя.

Т.Аубакир: Баярлалаа.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2026 оны төсөвт ахмад настанд нийт нэг 270.9 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөөд байгаа. Нийгмийн халамжийн сангаас 543 мянган ахмад настанд 250.5 тэрбум төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрт 2065 ахмад настанг хамруулж 11.7 тэрбум төгрөг улсын төсвөөс ахмад настны асрамжийн үйлчилгээнд 8.7 тэрбум төгрөг тус тус зарцуулахаар төлөвлөж байгаа. Манай салбарын харьяанд маш олон ахмадын сувилал хувийн хэвшлийнхэнтэй хамтарч ажилладаг хувьсах зардлыг өгдөг гэх зэрэг үйл ажиллагаанууд явагдаж байгаа. Өчигдөр бол ахмадын холбооны төлөөлөлтэй уулзсан. Мөн ахмадын холбооны төлөөллийн зүгээс 7 төрлийн шаардлага хүргүүлсэн байж байгаа. Таны дурдсан тэр 7 төрлийн шаардлага дотор таны дурдсан сая тэтгэвэр тэтгэмжийг нэмэх тухай асуудал мөн тавигдаж байгаа. Нийтдээ ер нь улсын хэмжээнд ахмадуудаас энэ тэтгэврийн асуудлыг жоохон нэмэх шаардлагатай байна гэсэн шаардлагууд янз бүрийн хэлбэрээр ирж байгаа.

Та мэдэгдсэн байна лээ. 1.5 сая төгрөг хүргэх шаардлагатай гэж. Улсын төсөв инфляцын байдалтай уялдуулаад салбарын яамнаас бол 10 орчим хувиар нэмэх шаардлагатай байна гэсэн тооцооллыг гаргасан. Сангийн яамнаас 6 хувь орчим болгоё гэсэн. Мэдээж хэрэг энэ төсвийн хэлэлцүүлгийн явцад дахиад орон зай гарах юм бол тодорхой хэмжээнд мэдээж хэрэг өнгөрсөн жилийн буюу ирэх жилийн инфляцтай уялдуулаад нэмэх зайлшгүй шаардлагатай байгаа. Салбарын яамнаас 10.3 хувиар нэмэх шаардлагатай гэдэг саналаа хүргүүлсэн гэх зэрэг үйл ажиллагаануудыг бол зохион байгуулаад явж байна аа.

Тэгээд ахмад настны тогтвортой орлогын эх үүсвэрийг хангах зорилгоор ахмад настнуудыг үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлэхийг дэмжих чиглэлээр хуулиудад дараах заалтуудыг жишээлбэл тусгасан байж байгаа. Ахмад настныг авч ажиллуулж байгаа байгууллага ахмад настан өөрөө хүсвэл тэтгэврийн даатгалын шимтгэл 8.5 хувийг төлөхгүй байх зэрэг. Мөн одоо энэ удахгүй бас орон нутгийн төсөв батлагдахтай холбоотой салбарын яамнаас бол орон нутгийн удирдлагууд руу хуулиа дагаж мөрдөх нөгөө 3 хувийг зарцуулах тэрийг төсөв дээрээ суулгаж өгөх гэх зэргээр ажиллаад явж байгаа.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Энхтуяа гишүүний асуултад хариулъя аа. Энэ хүүгийн татаасууд маань банканд өгч байгаа татаас биш шүү дээ. Зээлдэгч нарт өгч байгаа татаас байхгүй юу. Улсын Их Хурал дээрээс батлагдсан үндэсний хөтөлбөрүүд байгаа. Үндэсний хувьсгал, Цагаан алт, Хоршоо гээд. Тэндээс авч байгаа иргэд ААН-үүдэд өгч байгаа хөнгөлөлтийн татаас юм байгаа юм. Банканд биш банканд огт биш шүү. Хэрэв зээ яг банкныхаа шаардлагыг хангаад зээл авч байгаа бол зээлдэгчид өгч байгаа татаас юм байгаа юм. 378 тэрбумаар 3 их наядын санхүүжилтийг түлхэж

гаргаж байгаа юм. Энэ өөрөөр хэлбэл мөнгөний үржүүлэгч, 378 тэрбум төгрөг хэдэн хүнд, хэдэн аж ахуйн нэгжид очих вэ, 3 их наяд төгрөг хэдэн ААН, иргэдэд очих вэ?

Их Хурлаас баталсан энэ үндэсний хөтөлбөрүүдийн зорилтот түвшин хүрсэн үр дүнг яамдын сайд нар маань илүү их тодорхой ярих нь зүйтэй.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Өмнө нь бид ЖДҮ-ийн сан ч гэдэг юм уу яг төрийн албан хаагч нар тэр нөгөө зээлийн эрсдэлийг нь судлаад тэрэнд нь оролцоод зээлдэгчээ сонгоод өгч байдаг тэр буруу практикийг хэдүүлээ тэр алдааг давтаж болохгүй. Мэргэжлийн байгууллага ороод тэрийг нь эрсдэлийг нь тэр мэргэжлийн байгууллага өөрөө хариуцаад, харин чиглэлийг нь яамдууд бодлогоороо чиглүүлээд ингээд явах нь зөв юм байгаа юм тийм. Аубакир сайд Засгийн газраас өргөн барьсан шийдвэр дотроос яам яамд энд орж ирсэн хойно өөрөө өөрсдийнхөө бодлогыг салгаад явна гэвэл тэрийгээ эртхэн хэлээрэй. Засгийн газар төсвөө өргөн барьчихсан байгаа шүү.

Х.Булгантуяа: Энхтуяа гишүүн нэмж тодруулах уу?

Д.Энхтуяа: Би Ерөнхий сайдаас 3 дахь хариултаа авчхаад тэгээд тодруулъя.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Энхтуяа гишүүний асуултад хариулъя. Үндэсний баялгийн сангийн үзэл санааг 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд бид санаачилж оруулсан. Энэ Норвегийн Үндсэн хуулиас жишээ авч байгалийн баялгийн үр өгөөжийг нийт ард түмэндээ үр өгөөжтэй байх зорилгоор дийлэнх үр өгөөж нь оногдож байх зорилгоор Үндэсний баялгийн сангийн хуулийн эрх зүйн зохицуулалтыг бий болгоно гэж хуульчилсан юм. Яагаад гэвэл 2015 онд энэ Үндэсний баялгийн сангаас өмнө ирээдүй өв санг Норвег бол бүх асуудлаа шийдчихсэн улсын ирээдүйдээ үлдээх агуулгатай Сангийн хуулийг нь түрүүлээд баталчихсан учраас одоо ба ирээдүй үеийн иргэн бүрдээ хүртээмжтэй байх агуулгыг Үндсэн хуульчилж оруулсан юм. Гэтэл Ирээдүй өв сан маань өөрөө 1.2 тэрбум долларыг энэ ирээдүй өв сангийн хуулиараа гадаадад байршуулна гээд заачихсан учраас саяын 4 их наяд төгрөг чинь.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдын микрофоныг нэмж өгье.

Г.Занданшатар: Бага хүүтэй байршаад байгааг илүү үр өгөөжтэй болгож засаж залруулах шаардлагатай байна аа. Энэ дээр Улсын Их Хурлын гишүүд хамтарч ажиллаж хууль санаачилж ажиллаач ээ. Ингэж байж энэ орон сууцжуулалтын хөтөлбөр, ингэж байж энэ хуримтлалын сан, хөгжлийн сангууд чинь амилна аа. Сохор зоосыг ч гэсэн сэгсэрч бай. Тэгвэл үр төлөө өгдөг юм гэж итгэлт баян сургадаг шиг манай энэ сангийн менежмент маань илүү үр дүнтэй, ил тод, шударга хамгийн гол нь ард түмэндээ одоо ба ирээдүй үедээ ард түмэндээ хоёуланд нь өгөөжтэй байх зарчмыг хуульчлах хэрэгтэй байна. Энэ л агуулгыг бид энэ Үндэсний баялгийн сангийн хөтөлбөр болгож жичид нь тусад нь хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.

Өнөөгийн байдлаар 4 их наяд төгрөг байршиж байгаа. Ирэх жил 5, 6 их наядад хүргэнэ.

Х.Булгантуяа: Энхтуяа гишүүн нэмж тодруулна.

Д.Энхтуяа: Би танаас ингэж асуусан юм аа. Энэ 2 сард байгуулагдсан Баялгийн сан, Чингис Хаан компани яагаад Эрдэнэс Монгол компанийн доор охин компани болж байгуулагдсан бэ? Энэ бодлогыг нь дээрээ зохицуулаад төвлөрөлтийг нь төвлөрүүлэлт мэдээж хөрөнгө төвлөрүүлэлтийг бол энэ Эрдэнэс Монгол компани хийх нь ойлгомжтой. Гэтэл нөгөө бодлогоо хийж байх том толгой компани нь төвлөрүүлэх компанийнхаа доор орчихсон ингээд яваад байна. Тэгэхээр энэ чинь нөгөө нэг бодлого удирдлагын энэ уялдаа холбоо нь зөрөөд байгаа юм уу гэсэн ийм асуултыг асуугаад байгаа юм. Одоо манай урьд нь хийгдсэн одоо энэ явж байгаа сан бол сайн явж байгаад баяртай байна аа. Урьд нь 2007 онд Монгол Улсын хөгжүүлэх сан Хүний хөгжлийн сан, Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүй өв сан, Үндэсний баялгийн сан гээд маш олон сангууд маань их амжилттай явж чадахгүй байгаа.

Тэгэхээр бид нар энэ баялгийн сангийнхаа энэ 3 санг бодлогыг нь удирдлагатай нь тусад нь байлгаж байж байж энэ амжилтад хүрэх юм биш үү гэсэн ийм асуудлыг танаас асуугаад байгаа юм аа.

Х.Булгантуяа: Тэгэхээр энийг өөрчлөх боломж байгаа юу? Ерөнхий сайдын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Үндэсний баялгийн сангийн зохицуулалт, менежмент нь өөрөө Үндэсний баялгийн сангийн хуулиар явж байгаа. Ирээдүй өв сангийн удирдлагыг Монголбанк хэрэгжүүлдэг ээ. Ер нь Норвегийн сан олон улсын жишиг бол хараат бус хөндлөнгийн мэргэжлийн удирдлагаар удирдуулах чиг заалттай. Тийм учраас Үндэсний баялгийн сангийн хуулийг цаашдаа хэрэгжүүлэх зорилгоор Эрдэнэс Монгол, Эрдэнэс Тавантолгой гээд та хэлчихсэн учраас би хариулъя.

Эрдэнэс Монгол компани өөрөө Үндэсний баялгийн сангийн менежмент нь болж хувирах ёстой юм өөрөө. Түүнээс доороо юм уу дээрээ байх нь гол биш. Хөрөнгийн менежментийг нь дансны менежментийг нь Монголбанк хэрэгжүүлэхээр Монголбанкны бодлогын хүүгээс дээгүүр үр өгөөжтэй байхаар хуульчилсан байгаа. Үндэсний баялгийн сангийн хуулиараа л явна. Хуульд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагууд байна. Тэр чиглэлээр хамтарч ажиллая гэж би хэлээд байгаа нь энэ 3 сангийн менежмент чинь тусдаа координацгүй зохион байгуулалтгүй байгааг хуульчаар өөрчилье өө. Тэрэн дээр Улсын Их Хурлын гишүүд санаачлаад хамтран ажиллаач гэж байгаа юм.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга.

Б.Уянга: Өглөөний мэнд хүргэе.

2026 оны төсвийн орлого тал дээр төвлөрөөд асуулт асуух хэрэгтэй байна аа. 2026 онд болохоороо Монгол Улсын төсөв бол алдагдалтай орж ирж байгаа. Бид нарын бий болгох орлого зарлагаа гүйцэхгүй. Тэгээд дутаж байгаа мөнгөө болохоороо энэ төсвийн танилцуулга дээр Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр зохицуулна гэж байгаа. Тэгээд 2026 оныхоо орлогыг нарийвчлаад харах юм бол мэдээж татварын, татварын бус гээд татварын орлогод нь АМНАТ хамгийн их жинг эзлээд ААНОАТ, ХХОАТ гээд бусад албан татварууд орж байгаа. Тэгээд цаашдаа

ер нь энэ зарлага нь орлогоо гүйцэхгүй байгаа юм чинь энийгээ ямар бодлого Сангийн яамнаас хэрэгжүүлэх гэж байгаа юм болоо гээд танилцуулга дээр уншингуут мэдээж нүүрсний экспортыг нэмнэ 90 саяд хүргэнэ гэж орж ирж байгаа юм. Тэгээд нэлээн олон Улсын Их Хурлын гишүүд энэ хэр бодитой вэ гэдэг дээр асуулт асууж хариултаа авсан.

Дараагийн нэг орлого нэмэгдүүлэх аргыг болохоороо энэ татварын хамрагдал, татварт хамрагдах энэ түвшнийг нь нэмэгдүүлнэ ээ. Яг энэ өгүүлбэрээр нь унших юм бол зах худалдааны төвүүд цахим худалдаа эрхлэгчдийн төлбөрийн баримт олголтыг идэвхжүүлнэ, хялбаршуулна. Бүртгэлийг сайжруулах замаар НӨАМТ-ын хамрагдалтын түвшнийг нэмэгдүүлнэ. Татварын суурийг өргөжүүлнэ гэж яг өгүүлбэрээрээ орж ирсэн байгаа юм.

Тэгэхээр яг энэн дээр яг юу хийх юм бол? Тэгээд энэ хамрагддаггүй яг хэчнээн ААН байдаг юм, иргэд байдаг юм. Тэгээд Татварын ерөнхий газар ер нь яг энэн дээр яаж төвлөрч ажилладаг юм. 2026 онд яаж төвлөрч орлогоо бид нар нэмэгдүүлэх юм бэ? Цааш цаашдаа яаж нэмэгдүүлэхээр ажиллаж байгаа юм. Энэ талаар хариулт авмаар байна. Тэгээд яах вэ зүгээр бизнес худалдаа эрхлэгчид НӨАТ бүртгэлгүй ингээд үйл ажил баталгаагаа явуулаад л байгаа. Тэгээд НӨАТ-д бүртгүүлснээрээ бүртгүүлээгүй байхаасаа яг юугаараа илүү байдаг юм?

Тэгээд зөвхөн зах, худалдааны төвүүд, цахим худалдаа эрхлэгчдийн хамрагдалт муу биш л байгаа байх л даа. Тэгэхээр яг ямар ажлуудыг хийх вэ? Ер нь давуу тал бүртгүүлэгч байгаач тэгвэл ийм давуу тал бий болно оо гэдгийг нэлээн сайн тодруулаад ойлгуулах ёстой байх. Тэгэхээр ер нь Татварын ерөнхий газраас Сангийн сайдаас энэ дээр 2026 онд төлөвлөж байгаа болон цааш цаашдаа авч хэрэгжүүлэх ажлыг асуумаар байна аа.

Хоёрдугаарх нь болохоороо Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаас Дамдинням сайдаас энэ түлшний шатахууны нийлүүлэлттэй холбоотой асуултыг асууя. Тэгээд 1 минутаа нэмээд авчихъя даа дарга. Арай л амжихгүй байх.

Урьд нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд өөрийн биеэр ажиллаж байсан хүний хувьд тэгээд Монгол Улс шатахууныхаа нийлүүлэлтийг бүрэн хараат байдлаар буюу 99 хувийг нь ОХУ-аас авдаг. Тэгэхээр энэ байдал геополитикийн нөхцөл байдалтай холбоотойгоор 2026 онд хурцдах иймэрхүү нь байдалд хүрэхээр байна уу? Минутаа нэмж авчхаад үргэлжлүүлье.

Х.Булгантуяа: Эхлээд Дамдинням сайд хариулах уу? Дамдинням сайдын микрофоныг өгье.

Г.Дамдинням: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе ээ.

Уянга гишүүн бас манай салбарт ажиллаж байсан хүн яг л яаж байна даа.

Тэгээд намар болоод энэ улирлын шилжилтээр энэ түлшний асуудал дандаа л гарч ирж байдаг. Манай улс өмнө нь 100 хувь хараат ийм байдалтай байгаа. Зүгээр үнэнийг ний нуугүй л хэлчихье дээ. Тэгээд ер нь зөвхөн 8 дугаар сард гэхэд манай гол ханган нийлүүлэгч ОХУ-д 12 нефть боловсруулах үйлдвэр халдлагад өртсөн байна. Энэ нь тус улсын хүчин чадлын 17-оос 20 орчим хувийг байхгүй болгосон гэсэн үг. Мөн бас энэ хэрээр 4-өөс 5 газар ложистикийн гол төмөр замын

төвүүд дээр халдлагад өртсөн. Тэгээд ОХУ-аас 8 дугаар сар болон 9 дүгээр сард бүтэн дотоодын АИ 92 бензиний хязгаарлалтыг хийчихсэн экспортлохгүй байгаа. Гэрээтэй орнууддаа өгч байна. Манай орны хувьд бол гэрээтэй байгаа. Тэгээд тийм учраас нийлүүлэлт явж байгаа. Тэгэхдээ бид цаашдаа энэ маягаараа явахад бол тун хүнд болно, тун хүнд болно. Бид нар сав барихаас өөр аргагүй болно. Сав барина гэхээр манай улсын нийт хүчин чадал бол 210 орчим мянган тонн байгаа. Энэ нь бол 27 хоногийн нөөцөө бид нар хадгалж чаддаг гэсэн үг. Хувийн хэвشلүүд дээрээ байдаг манай савнууд. Тэгээд энэ савнуудаа нэмье гэхээр хувийн хэвшлийнхэн маань санхүү хөрөнгийн чадваргүй байдаг. Дийлэхгүй байдаг.

Бензиний үнэ ойлгомжтой ийм томъёотой байдаг ашиг орлого нь. Тэгэхээр бид нар бол хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр гаргаж өгч энэ Цагаан алт шиг ч гэдэг юм уу ийм хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг ААН-үүддээ өгч байж ядаж 1 сарын нөөцөө хадгалж чаддаг савтай болох тухай асуудлыг нэн даруй шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3-аас 6 сарыг хадгалах хэмжээний савтай болно гэдэг ийм зорилт тавьчихсан байгаа. 2027 онд манай Алтанширээд баригдаж байгаа үйлдвэр бүрэн дуусна гэсэн ийм эрчимтэй ажиллаж байна. Гэхдээ бид тэр үйлдвэр баригдсан ч саваа барихаас өөр гарцгүй. ОХУ-аас бол үндсэндээ зах хязгаар нутгууддаа тээврийг нь татаасаар хийдэг байсан бол тэр татаасаа цуцалсан. Өөрөөр хэлбэл манай хилийн ойролцоо ирэх шатахууны үнэ өсөж ирж байгаа гэсэн үг. АИ 92 дээр бид нар бол хатуу тогтоочихсон гэрээтэй. Энэ гэрээгээ сунгах ажлыг хийх гээд манай яамнаас ажлын хэсэг явж байгаа. Явах гэж байна. Тэгээд цаашдаа бол үнэ өсөх магадлал байна аа.

Хоёрдугаарт манай гол нэрийн бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ унаж байгаа. Биет хэмжээг нэмэгдүүлнэ гэдэг бол дизель түлшний хэрэглээ өснө өө гэсэн үг. Хэрэглээ өснө өө гэсэн үг. Энэ хэрээрээ үйлчилгээнийх нь уур уурхайн салбарыг тойрч байдаг үйлчилгээний салбарын шатахууны хэрэглээ өснө гэсэн үг. Тэгэхээр бид нарт нөөцлөх саваа барихаас өөр гарцгүй.

Төгсгөлд нь ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путины Монгол Улсад 2024 оны 9 дүгээр сард хэрэгжүүлсэн хийсэн айлчлалын үеэр Газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон Агаарын тээврийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг яаралтай эцэслэж өгөхгүй бол бид цаашдаа ажиллахад хүнд байна шүү гэдэг мэдээллийг биднийг сая Владивостокод очиход өгсөн. Тэгэхээр бид бол энэ асуудлыг шийдэхийн тулд татвартай холбоотой асуудал байгаа. Их Хурлаар оруулж л таарчих гээд байгаа. Тэгээд төсвийн дундуур л дараа оруулна даа гээд бэлдэж байна. Ийм л нөхцөл байдалтай байна. Ний нуугүй үнэнийг нь л хэлж байна.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Уянга гишүүний асуултад хариулъя.

Бид татварын томоохон реформыг бэлдсэн байгаа. Тэгээд 2026, 2027, 2028 онуудад үе шаттай, шат дараалалтайгаар төсөвтөө ингээд шингээгээд томоохон реформыг явна аа. Энүүний мэдээж эцсийн зорилго бол иргэд ААН-үүд дээр очиж байгаа татварын дарамтыг бууруулах, энэ нь нөгөө талдаа мөн эдийн засгийн

идэвхжилийг дэмжих, татварын суурь баазыг тэлэх мөн ийм зорилготой. Тэгэхээр хамгийн эхний бид нарын хөдөлгөж байгаа барометр бол татварын урамшууллын 2-оос 5 хувь руу очиж байгаа юм сая төгрөг хүртэлх.

Тэгэхээр энэ НӨАТ-ын суурийг бол нэлээн хөдөлгөнө өө нэлээн хөдөлгөнө. Өөрөөр хэлбэл эргэлтэд орохгүй байгаа татварт бүртгэгдэхгүй байгаа энийг хамаагүй тэгээд далд эдийн засаг гэж нэрлэмээргүй байгаа юм энэ чинь ерөөсөө татварын орчин нь өөрөө ийм байгаа учраас.

Тийм учраас бүртгэлийг сайжруулснаар суурь нэлээдгүй тэлнэ ээ.

Х.Булгантуяа: Жавхлан сайдын микрофоныг нэмж өгье. 4 номер уу? Ажлын хэсэг 4 номер.

Ч.Чимидсүрэн: Татварын ерөнхий газар Чимидсүрэн.

Сангийн сайдын мэдээлэлд нэмж мэдээлэл өгье. Ер нь Монгол Улсын хэмжээнд татвар төлөгч ААН-ийн тоо бол 256 мянга бий. Бүртгэлтэй идэвхтэй үйл ажиллагаа нь бол 172 мянга байна. Иргэний хувьд бол 2 сая 554 мянган иргэн бол бүртгэлтэй бий. Татварын төрлөөрөө янз бүрийн оролцоотой байгаа. Үүн дээр түрүүний хэлсэн төсвийн 2026 оны хууль дагуулж бол НӨАТ-ын хуульд 2 хувийн буцаалтыг 5 хувийн буцаалт болгох бол татварын бааз нэмэгдүүлэх чиглэлээр орж байгаа хууль эрх зүйн зохицуулалт. Үүнээс гадна зохион байгуулалтын тодорхой ажлууд хийж татвар төлөгчийн бааз суурийг нэмэгдүүлэх талаар бол ажиллаж байна.

Тухайлбал Цахим хөгжлийн яамтай, Сангийн яам, татварынхан хамтраад энэ цаасгүй төлбөрийн баримтыг автоматаар бүрдүүлдэг асуудлыг энэ систем нийлүүлэгчдийн холбоо болгон түүнийг хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтраад хэрэгжүүлээд.

Х.Булгантуяа: 4 номерын микрофоныг нэмж өгье.

Ч.Чимидсүрэн: Хоёрт нь бол Татварын ерөнхий газар дээр энэ оноос эхлэн яг татвар төлөгчөө таньж мэдэх, зөвлөн туслах, байршилд суурилсан бааз суурийг нэмэгдүүлэх чиглэлээр И туп аппликэйшнийг бол утсан дээр хийгээд бүх байцаагч нар бол эхний ээлжид зах худалдааны төв, тэгээд дараа нь бусад үйлчилгээний газар бизнес эрхлэгч дээр бол ажиллаад бааз сууриа нэмэгдүүлэх ажлаа хийгээд явж байна. Эхний үе шатны буюу зах худалдааны төв дээрх бааз сууриа нэмэгдүүлэх дээр бол бүрэн судалгааг бол хийсэн. Ингэснээрээ бол тухайн татвар төлөгчийн и баримт бүрдэлт олгож байна уу үгүй юу гэдэг дээр нь автоматаар системээр бол ингээд хяналт тавих боломж бол ингээд бүрдээд явах юм байгаа юм.

Нөгөө талаар энэ зөвлөн туслагч эрсдэлээс хамгаалах чиглэлийн ажлууд нь давхар үүрээд явж байгаа. Ингэснээрээ одоогийн байгаа энэ и баримт олголт 74 хувийг дээш нь нэмэх бол боломж бүрдэнэ бүрдэнэ байна гэж бодож байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Батшугар сайд нэмж хариулъя.

Э.Батшугар: Уянгаа гишүүний асуултад нэмж хариулахад бол ирэх 7 хоногоос нөгөө И баримтын бичгийг шууд автоматаар картаар нь бүртгэдэг болчихож байгаа. Тэр нь яаж хэрэгжих вэ гэхээр жишээлбэл 500 төгрөгийн зогсоолын төлбөрийн И баримтын хүмүүс уншуулдаггүй нийт энэ и баримтын 50 хувь нь уншуулдаггүй юм байна лээ. Зарим нь нөгөө нэг хэвлэхдээ бүдэг хэвлэхихсэн гэх мэтчилэн. Тэгэхээр банкны аппликэйшн руугаа ороод тэгээд аль картаа сонгохын картаа сонгоод тэр нь автомат и баримтыг бүртгэдэг болно, унтрааж ч болно. Тэр өөрөө сонголтоороо заавал бүртгэнэ гэсэн үг биш гэхдээ аль болох цахимжуулаад, хялбар болгоод нөгөө талдаа нэлээн цаас хэмнэж байгаа зүйл л дээ. Тэгээд эхнээсээ бол 3 банк ирэх 7 хоногоос ороход бэлэн болчихсон байгаа тест хийгээд явж байгаа. Цаашлаад бүх л банкууд оруулна гэж хэлмээр байна аа.

Х.Булгантуяа: Уянга гишүүн нэмж тодруулна.

Б.Уянга: Дамдинням сайдаас нэмээд тодруулъя. Энэ шатахууны нөөц сав Монгол Улс яг өөрсдөө 1 сарынхаа хэрэгцээг хангая гээд яригдаж байгаа асуудлыг хэд хэдэн удаа сонссон. Тэгээд энийг их талархаж хүлээж авч байгаа. Яагаад вэ гэвэл яг өгч байгаа үед нь нөөцлөөд авчих хэрэгтэй байдаг. Тэгээд 1 хувийн хэвшлээр л энэ савуудаа бариулах байх л даа. Яг энэ хөнгөлөлттэй зээлийн асуудал 2026 оны төсөвт ер нь тусчихсан байгаа юу?

Х.Булгантуяа: Дамдинням сайд хариулъя

Г.Дамдинням: Уянга гишүүн тэгээд яг одоогийн байдлаар бол Засгийн газар дээр би мэдээлэл оруулж танилцуулаад тэгээд сая Владивостокод очиж ОХУ-ын Эрчим хүчний сайд Цивильев болон Байгалийн нөөцийн сайд Козлов нартай уулзаж тогтвортой байлгах талаар ярилцсан. Тэд амлалт өгсөн. Монгол Улсын ерөнхий сайд Занданшатар, ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путинтэй энэ тохиролцоог хийсэн байгаа. Гэхдээ бидний хувьд энэ сав суулгыг бүрдүүлэх хийх ажил олон жил яригдаж байгаа энэ асуудлыг Сангийн яамтайгаа ярилцаад бэлтгэл ажлыг хангаад явж байгаа. Удахгүй нааштай тодорхой шийдвэр гарах байх.

Ер нь бол 1 сарын сав хэрэглээг хангах хэмжээний сав хийнэ гэдэг бол 500 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаарддаг. Монгол Улсын 3 сарын хэрэгцээ гэдэг бол үндсэндээ 1.5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт шаарддаг ийм том хөрөнгө оруулалт байгаад байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Загджавын Мэндсайхан.

З.Мэндсайхан: 2026 оны улсын төсвийг ерөнхийд нь тоймлоод харах юм бол сайн талууд байна. Төсвийн тэнцвэрийг хадгалах, орлого зарлагыг тэнцвэржүүлэх, зардлыг алдагдлыг бууруулах чиглэлээр макро орчинд иргэд тогтвортой байдлыг үүсгэх ийм эерэг нөлөөтэй ч гэдэг юм уу өрийн дарамтыг бууруулах, мөн иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн гээд. Гэхдээ ерөнхийдөө бүтцийг нь аваад үзэх юм бол эрчим хүч, дэд бүтэц давамгайлсан хөрөнгө оруулалтуудтай ялангуяа энэ инновац ЖДҮ-лэлийг дэмжих чиглэл маш сул байна. Тэгэхээр ЖДҮ-лэлийн хувьд төсөв дээр энэ жил 44.9 тэрбум төгрөгийг өмнөх олгосон зээлийн эргэн төлөлтөөр төлөхөөр тусгаад өгчихсөн байна. Ингээд ер нь ойрын 2, 3 жил ийм байдалтай яваад байгаа. Тэгэхээр ЖДҮ-лэлүүдийн маань хувьд ер нь нэг бодлогын гадна үлдээд байна аа.

Энэ дээр Засгийн газар маань ер нь нэг онцгой анхаараач ээ. Жишээлбэл цагаан алт хөтөлбөр үндэсний хөтөлбөр гээд хөнгөн үйлдвэрүүдийг дэмжих үндэсний хөнгөлөлттэй зээл олгодог энэ хөтөлбөрүүд маань амжилттай хэрэгжиж байдаг.

Гэтэл бүхэл бүтэн агентлагийн маань хийж байгаа ажил нэг иймэрхүү түвшинд байгаад байдаг. Яг ЖДҮ-лэлээ дэмжсэн бодитой бодлого байхгүй болчихоод байна. Тэгэхээр энэ агентлагийн асуудлыг ер нь ямархуу байдлаар харж байгаа юм эргэж харах шаардлага байна шүү гэдгийг нэг хэлмээр байна.

Иргэнийхээ өрхийн татварын дарамтыг бууруулах чиглэлээр сая хүртэлх төгрөгийн худалдан авалтыг 50 хувь хөнгөлөөд түүнээс дээшхийг нь 20 хувь хөнгөлнө гээд энэ бол их зөв зүйтэй хуулийн өөрчлөлт орж иржээ гэж. Гэхдээ нөгөө талдаа ААН-үүд юу хүсэж байна гэхээр энэ нэмэгдсэн өртгийн албан татварт хөнгөлөлтөөсөө илүүтэй жигд хамрагдах байдал байгаад байгаа юм. Шатлалдаа тавиад өгчихдөг, заримыг нь татвараас хөнгөлөөд өгчихөөр эргээд энэ татварын чинь дарамтыг иргэн өөрөө л төлж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ ачааллыг бууруулах чиглэл дээр ААН-үүдийг бүрэн хамруулах чиглэл дээр Засгийн газар яг ямар бодлого баримталж байна аа? Төсвийн орон зай бага байна гэж ярьж байгаа бид нарт хөрөнгө оруулалт хийх төсвүүд дээр орон зай бага байна. Тэгэхээр энэ баялгийн сангийн хуульдаа өөрчлөлт хийх чиглэлээр Засгийн газар төлөвлөж байгаа зүйл байна уу? Жишээлбэл бид нар Ирээдүйн өв сандаа АМНАТ-аас орж ирсэн орлогынхоо бараг 65 хувийг нь хуримтлуулчхаж байгаа.

Тэгэхээр Хөгжлийн сан руугаа бид нар энэ хуримтлалынхаа хувь хэмжээг багасгаад хөгжлийн сан руу хийгээд хөгжлийн сангаасаа бид нар энэ томоохон төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлээд явах тэр чиглэлээр нь анхаарч болохгүй юм уу? Тэгэхгүй бол ингээд төсвийн орон зай байхгүй гэдгээр хөрөнгө оруулалтууд маань он дамжаад цаг хугацаа инфляцад идэгдээд төсөвт өртөг нь өсөөд явдаг бүтээн байгуулалт нь сунжраад явдаг асуудал үүсээд байна. Нэгэнт Ирээдүйн өв санд хадгалж байгаа хөрөнгө чинь бид нарын өнөөдрийн хөгжлийн сангаар дамжуулаад хийж байгаа хөрөнгө оруулалт гэдгээс мөн л бид нар ирээдүйдээ л хийж зориулж хийж байгаа асуудал шүү дээ.

Тэгэхээр энэ баялгийн сан дээрээ өөрчлөлт хийх энэ чиглэлээр төлөвлөсөн зүйл байна уу гэдгийг асууя аа. Тэгээд тодруулъя.

Х.Булгантуяа: Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Үндэсний баялгийн сангийн хуулийг бид 2024 онд баталсан. 2019 онд бид Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Байгалийн баялгийн өгөөжийг өнөөдөр амьдарч байгаа иргэд болон ирээдүй хойч үедээ тэнцүү өгөөжийг нь хүртээх ёстой гэсэн үндсэн хуулийн заалт оруулсан. Энэ заалтаа амилуулах гэж Үндэсний баялгийн сангийн тухай хууль баталсан. Өнөөдөр Монгол Улсын үндэсний баялгийн сан 3 сангаас бүрдэж байгаа. Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн. Эндээ байгалийн баялгийн өгөөжөөс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Ирээдүйн өв сангийн 65 хувийг бүрдүүлж байгаа. Энийгээ хойч үедээ илүү хадгалж байгаа. АМНАТ-ийн 25 нь улсын төсөв рүү, 10 хувь нь орон нутгийн төсөв рүү орчхож

байгаа. Гэтэл нөгөө хуримтлалын санд иргэдийн эрүүл мэнд, боловсрол, орон сууцын асуудлыг шийднэ гээд хуримтлалын сан байгуулчихсан. Түүндээ бол ТӨК-удын төр эзэмших ноогдол, 34 хувийн ноогдол ашгаас л бүрдэж байгаа.

Хөгжлийн сан бол төсвийн давсан орлогоос бүрдэнэ гэсэн ийм 3 сантай болчихсон. Хөгжлийн сан өнөөдөр төсвийн орлого ер нь давдаггүй, Хэзээ ч тэр сан нь үндсэндээ мөнгө хуримтлагдаж, энэ хөгжлийн томоохон дэд бүтцийн, эрчим хүчний, замын бусад одоо хүний хөгжлийн, боловсрол, эрүүл мэндийн гээд асуудлаа шийдэх боломжгүй. Энэ санд нь мөнгө хуримтлагдахгүй ийм хуультай болчихсон. Энийг өөрчилж сая таны хэлж байгаа энэ хөгжлийн санг эх үүсвэртэй болгох хөгжлийн сангаараа дамжуулж томоохон төсөл хөтөлбөрүүд хөгжлийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ийм боломжийг болгох ёстой. Энэ дээр ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Хуримтлалын санд зөвхөн ТӨК-ийн 34 хувьд ноогдол ашиг гэхээр маш бага хуримтлагдаж байгаа, маш бага. Өнгөрсөн жил иргэддээ бид 100 гаруй мянган төгрөг л хуваарилж өгсөн.

Хэрвээ АМНАТ-өөсөө өнөөдөр амьдарч байгаа иргэддээ хуримтлалын санд нь ингээд шууд улирал болгон АМНАТ орох болгонд нь данс руу нь орж байдаг тэр нь иргэдийн эрүүл мэнд, боловсрол, орон сууцынхаа асуудлыг шийдэхэд нь зарцуулагдах бодитой хөрөнгө болж өсөж үржиж байдаг. Ийм болчих юм бол байгалийн баялгийн өгөөжийг өнөөдөр амьдарч байгаа иргэд маань бодитой хүртээд үүндээ сэтгэл хангалуун байгалийн баялаг олборлох борлуулахад эсэргүүцээд байх биш эсэргүүцэлгүй дэмждэг болох ийм байж болох юм. Тэгээд энийг нэг яаж цаашид үндэсний баялгийн сангаа зөв зүйтэй болгох вэ? Зөвхөн ирээдүй хойч үедээ үедээ 65 хувийг нь хадгалаад үлдсэн 35-ыг нь төсөвтөө оруулчихдаг энэ маань өнөөдөр амьдарч байгаа иргэдэд шударга бус байгаад байгаа юм.

Ирээдүйд амьдарч байгаа иргэд одоо амьдарч байгаа иргэд эн тэнцүү хүртэх ёстой гэсэн Үндсэн хуулийн заалттай. Мөн Хөгжлийн сангаа өнөөдөр бид нар хөрөнгөтэй болгож мөнгийг нь арвижуулж өнөөдөр тулгамдсан хөгжлийн хөтөлбөрүүдээ санхүүжүүлж хэрэгжүүлэх шаардлага байгаа. Тийм болохоор энэ тал дээр бас манай Их Хурлын гишүүд анхаарч ажиллаасай. Засгийн газраас энэ дээр тодорхой Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах талаар ажлын хэсэг гарч ажиллаж байгаа. Мөн үүнээс гадна стратегийн ордуудын 34 хувийг төрд авах ажиллагаа ажлын хэсэг ажиллаад эхэлсэн байгаа. Хувийн хэвшлүүдтэйгээ стратегийн орд эзэмшиж ААН байгууллагуудтай хэлэлцээрт ороод эхэлсэн байгаа. Эндээс тодорхой хэмжээний Үндэсний баялгийн сангийн тодорхой эх үүсвэр бүрдэх бололцоо боломж бүрдэнэ гэдгийг хэлье ээ.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Мэндсайхан гишүүний асуултад хариулъя аа. Татварын багц хуулийн өөрчлөлт дотроос та их чухал сэдэв хөндлөө. НӨАТ-ын үндсэн 4 параметрийг бид хөдөлгөж байгаа.

Нэгдүгээрт буцаан олголтыг 2-оос 5 руу.

Хоёрдугаарт гааль дээр НӨАТ авдгийг больё оо. Энийг мөнгөн суурьтай борлуулалттай нь уялдуулж хойшлуулъя гэдэг. Ингээд хойшлуулаад хугацаандаа сайн төлөөд байвал дахиад хугацааны урамшуулалтай байхаар. Мөн НӨАТ-ын

дамжуулан төлөгч, суутган төлөгчийн босгыг 50 саяыг 400 сая болгож байгаа. Эцэст нь энэ НӨАТ-ын өөрчлөлт дээр санал асуулга явахад иргэд ААН-үүдийн хамгийн их тавьж байсан санал бараг 70, 80 хувьд нь өгч байсан санал бол бүгдээрээ л шударга жигд НӨАТ суутган төлөгч болъё өө. НӨАТ төлөгч болъё гэдэг ийм шаардлага тавьсан байгаа юм.

Х.Булгантуяа: Жавхлан сайдын микрофоныг нэмж өгье.

Б.Жавхлан: Одоогоор 47 хууль дээр, 47 нэр төрлийн бүтээгдэхүүн дээр НӨАТ-ын чөлөөлөлт байдаг юм. Энийг бүгдээрээ төлдөг болгоё гээд одоо яг ди парламент дээр тавьчихсан байгаа НӨАТ-ын багц хуулийн өөрчлөлтийн тэр төсөл дээр яг энэ заалтууд орчихсон явж байгаа. Энийг бүгдээрээ дэмжинэ байх гэдэгт би итгэлтэй байгаа. Ингээд ер нь бол НӨАТ эцсийн хэрэглэгч өөрөө төлдөг татвар. Тэрнээс биш үйлдвэрлэгч, суутган төлөгч, дамжуулагч биш. ААН-үүд уг нь агентын үүрэг л гүйцэтгэх ёстой. Гэтэл тэд нар дээр НӨАТ-ын дарамт очоод байна гэдэг маань энэ юм болохгүй байна л гэсэн үг. Хамгийн том шалтгаан нь энэ дундаас зарим нэг бүтээгдэхүүнүүд нь НӨАТ төлөгч биш болчихоор энэ бараг ингээд нөгөө АМНАТ шиг ААН-үүд дээр торгууль болж очоод байгаа юм.

Тийм учраас энийг бүгдээрээ больё оо. Бүгдээрээ жигд НӨАТ төлөгч больё оо гэдэг дээр хуулийн өөрчлөлт явж байгаа.

Х.Булгантуяа: Мэндсайхан гишүүн нэмж тодруулна.

З.Мэндсайхан: ЖДҮ-лэлийг дэмжих чиглэл дээр ер нь яг ямар бодлого барих юм бэ? Зээлийн төсөвт сууснаар бол нэг 45 орчим тэрбум төгрөгийг эргэн төлөлтөөр цаашид хөнгөлөлттэй зээл хэлбэрээр гаргаад явна гэсэн байдлаар тусгасан байна л даа. Тэгэхээр одоо явж байгаа энэ ХАА-н салбарыг дэмжих хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих энэ арилжааны банкнуудтай хамтарсан энэ Засгийн газрын бодлого чинь их зөв байгаад байгаа. Тэнд 44 тэрбум төгрөгийг буцаан төвлөрүүлээд эргээд ЖДҮ-лэлүүдэд олгоно гэдэг бол гүйцэтгэлээрээ нэг 20-оос 30 тэрбум төгрөг л зээлээр гарч байгаа юм. Зээлд гарч байгаа юм. Тэгэхээр энэ арилжааны банкаар дамжуулж хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөртэйгөө уялдуулаад явбал яасан юм бэ? Яг энэ ЖДҮ-лэлийн агентлаг байгаад байгаа шалтгаан одоо ерөөсөө тодорхойгүй болчихоод байна л даа. Тэгэхээр ийм агентлаг байлгах шаардлага байгаа юм уу? Энэ дээр нэг Сангийн сайд хариулт өгөөч.

Х.Булгантуяа: Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Мэндсайхан гишүүний асуултад нэмж хариулъя аа. Ер нь тэр арилжааны банкаар явах нь их зөв схем юм байгаа юм. Хэд хэдэн давуу талтай. Жижиг, дунд ААН-үүд маань боловсрох ёстой. Том ААН болох ёстой. Тэгэхээр банктai харилцаад төслөө бичдэг, төслөө хамгаалдаг, санхүүгийн сахилга баттай, бизнес үр өгөөжийнхөө төлөвлөлтөө сайн хийдэг гээд ингээд бойжих талдаа банкаар явах нь их зөв юм байгаа юм. Харин тэрэндээ хүрч чадахгүй, банкны баталгаагаа гаргаж чадахгүй, ААН-ийнхээ төлөвлөлт ингээд хийж чадахгүй, дөнгөж гараанаас гарч байгаа ийм бизнесүүд дээр одоо төр тусгайлан бодлого хэрэгжүүлэхгүй бол тэр хэсэг маань орхигдоод байгаа юм аа.

Тийм учраас ЖДҮ-лэлийн сан бол 300 сая төгрөг хүртлээ бол өөрсдийнхөө нэгжүүдээр дамжуулаад сонгон шалгаруулалт хийгээд, аймаг орон нутгийн

удирдлагууд тэндээс орон нутгийн бодлоготой нийцүүлж ингэж нэг тодорхой хэмжээгээр зээл өгөхгүй бол.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Тэгэхээр төсвийн зардал, зардлын өсөлтийг хязгаарлалт, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулна, хувийн хэвшлээ дэмжинэ гээд ингээд яриад тунхаглаад байгаа юм. Тэгээд яг бодит зүйлийг асуунгуут нэг тодорхой хариултууд гарч ирж чадахгүй байгаа байхгүй юу. Жишээлэх юм бол төрийн өмчит газруудыг цөөлнө. 100 гаруй төрийн өмчийг одоо нэг 70 орчим болгоно гээд байгаа юм. Яг ямар ТӨК-удыг хувьчлах гэж байгаа юм. Яг ямар ямар ТӨК-удыг олон нийтийн мэдэлд оруулах гэж байгаа юм. Энэнээс төсвийн зардал яаж хасагдаж хувийн хэвшлийг дэмжих боломж бүрдэж байгаа юм бэ гэсэн асуултыг асуумаар байгаа юм.

Дээр нь хувийн хэвшлийг дэмжинэ л гээд байгаа болохоос яг хувийн хэвшлийг ингэж дэмжих гэж байгаа юм гэсэн 1, 2, 3 гэсэн энэ зүйлийг сонсмоор байгаа юм.

Дараагийн нэг зүйл бол хувийн хэвшлийг дэмжинэ гэнгүүт шинэ хоршоо гээд ярина. Би ер нь нэг маш тодорхой асуулт асуучихъя. Энэ шинэ хоршоо хөдөлгөөнд одоо хэдэн их наяд юм уу, хэдэн 100 тэрбум төгрөг зарцуулаад байгаа юм. Яг хөдөөгийн 21 аймаг, 9 дүүргийн тархалтыг хармаар байна би. Миний бодлоор зарим аймагт ер нь хоршоо байхгүй ч байхыг үгүйсгэхгүй ч байж болно. Хоршоонд авсан мөнгөнүүд нэг приус аваад, жийп машин аваад, хадан хашаа болоод хадлангийн ганц нэгэн трактор аваад л дууссан байх. Тэгсэн мөртөө энэнд хэдэн 100 тэрбум төгрөгийн татаас олгоод байгаа юм. Тэгээд энийг зогсоож болдоггүй юм уу? Нэгэнт хүртээмжтэй биш байна, тархалттай биш байна, энийг харин орон нутагт суурьшиж байгаа орон сууцын ипотекийн зээлд гэдэг юм уу тэрний зөрүүнд гэдэг юм уу өгөх юм бол хүмүүсийн амьдралд хувийн хэвшил чинь харин торс хийтэл дэмжигдэх юм биш үү гэсэн ийм санааг хэлэх гэж байгаа юм.

Дээр нь би Бямбацогт сайдаас асуумаар байна. Учрал сайдаас асуумаар байгаа юм. Энэ орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага гэдэг зүйлийг дуусгалаа. Энд аймгийн Засаг дарга хийж байсан, Иргэдийн хурлын дарга хийж байсан хүмүүс маш олноороо сууж байна.

Жил болгон л төсөв дагасан хуулиар өөр нэг хуулиар хуруу хумсыг нь мулталсаар байж байгаад нөгөө шүдгүй арслан гэдэг шиг бүүр хумс, хуруу, шүд юу ч байхгүй. Зүгээр тэнд нэг хоосон тогтолцоо бий болчихсон. Хөдөөгийн сумын, аймгийн айлуудын 07 газрыг өгөх гээд Засгийн газар мэдэж ер нь яах юм. Ямар ч хэрэггүй шүү дээ. Тэгээд дээрээс зөвшөөрөл ирээгүй гээд ингээд тендер ном чинь 4 сарын 1-ний дотор зарлагдсан байх ёстой, газрынх нь зөвшөөрөл нь очоогүй гээд л ингээд бүх зүйлүүд дуусдаг.

Дээр нь түгээмэл тархацтай ашигт малтмалын зөвшөөрлийг Засгийн газар өгч яах юм бэ? Тэнд одоо барих гэж байгаа замыг, тэнд барих гэж байгаа орон сууцыг.

Х.Булгантуяа: Өмч хувьчлалтай холбоотой, ТӨК-удтай холбоотой. Цэнгэл дарга эхлээд хариулъя. 3 номерын микрофон.

Б.Цэнгэл: Батсуурь гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр 109 төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниуд үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ тоо бол тодорхой хэмжээгээр дээшилж доошилдог ийм зүйлүүд бий. Бид нар сая энэ 2 сарын хугацаанд бол 6 компанийг өөрчлөн байгуулсан, нэг компанийг татан буулгасан. Эрчим хүчний 7, 8 компанийг нэгтгэж нийлүүлсэн. Одоо бид ойрын хугацаанд АЗЗА-г бол бүтцийг нь өөрчлөх асуудлыг засгийн хуралд танилцуулахаар ажиллаж байна. Үндсэн чиглэлийг засгийн хурлаар хэлэлцүүлэх гэж байгаа. Үндсэн чиглэлээр бид 9 компанийг оруулж ирнэ. Эндээс 34-өөс 66 хүртэлх хувийг МХБ-ээр дамжуулж олон нийтэд нээлттэй IPO гаргах асуудлыг ярина. Энэ удааг бид тодорхой хэсгээр төсөвт төвлөрүүлэх IPO гаргаж байгаа компаниуд бол компанийн хөгжүүлэлт нь орж ирж байгаа орлогыг нь төвлөрүүлэхээр ингэж ажиллаж байна аа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Батсуурь гишүүнийхээ асуултад хариулъя. Хувийн хэвшлийг бид дэмжих энэ бодлого өөрөө нэлээн тийм өргөн агуулгатай. Ооо яг хууль дээр хамгийн тодорхой орж ирж байгаа зүйл бол Төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг бид нар нэлээн хөнгөвчилж байгаа. Энд маш том орон зай байгаа. Асар том орон зай байгаа. Хуулиа нэлээн чанга хийчихжээ гээд эргээд бид ингэж үзээд байгаа юм. Нэлээн суллаад шалгууруудыг нь жоохон намсгаад ингээд явуулчихъя гээд ийм өөрчлөлт орж ирсэн байгаа. Энийг нэлээн дэмжээд өгөөрэй ингээд нэлээн юм хөдлөх байх.

Хоёрдугаарт хувийн хэвшлээ дэмжих хамгийн том бодлого бол энэ Татварын багц хууль юм байгаа юм. Татварын реформ. Хамгийн сүүлд бид 2019 онд татварын багц хуульд өөрчлөлт хийхдээ олон улсын стандарт руу нийцүүлэх гэж бид нар дүрэм журмаа нэлээн өөрчилсөн. Энэ удаа бол тоон дээр нэлээн олон параметруудийг хөдөлгөж байгаа. Нийтдээ 16. 16 параметр.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: НӨАТ, ХХОАТ, ААНОАТ гээд нэлээдгүй юм хөдөлнө өө. Нэлээд өндөр өртөгтэй ийм багц хуулийг өөрчлөлт хийж байгаа. Энийг та бүхэн маань сайн дэмжиж өгнө өө гэдэгт би итгэлтэй байна аа.

Гуравдугаарт хамгийн том зүйл бол ерөөсөө энэ дэд бүтэц юм байгаа юм. Энэ дэд бүтэц тавиад байгаа эрчим хүч энэ замуудынх чинь үзүүр дээр хувийн хэвшилд л хөрөнгө оруулалт хийх ёстой тэгж байж өртгийг нь бууруулна. Тэгж байж өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлнэ.

Дээрээс нь төр өөрөө хариуцдаг хамгийн том хариуцлагатай зүйл бол энэ нэг макро тогтвортой байдлаа төр өөрөө нэг аятайхан аваад явж байвал хувийн хэвшлээ дэмжиж байгаа хамгийн том юм байгаа юм. Бизнес нь оролцож болохгүй харин орчныг нь бүрдүүлэх ёстой. Зээлжих зэрэглэлийг нэмж өгөх ёстой, төлбөрийн тэнцлээ нэг аятайхан байлгаж байх ёстой. Инфляцаа нэг нам доор түвшинд зорилтот түвшиндээ ядаж байлгаж байх ёстой энэ бүхэн рүү төсвийн бодлого чиглэж байгаа гэдгийг хэлье ээ.

Х.Булгантуяа: Түгээмэл тархацтайг Дамдинням сайд. Шинэ хоршоог хариулахад бэлдэж байгаарай.

Г.Дамдинням: Батсуурь гишүүн бас нэг талдаа зөв асуулт л хөндөөд байгаа. Үнэн төвлөрүүлээд байх шаардлагагүй мэт боловч нөгөө талдаа энэ ашигт малтмалын хууль бус олборлолттой холбоотой асуудлууд байгаад байдаг юм. Манай Туваан сайд эд нар бүгдээрээ л мэдэж байгаа. Одоо гэхэд байна шүү дээ Дундговь аймагт 31, Өмнөговь аймагт 13, Сэлэнгэ аймагт 10, Төв аймагт 9 түгээмэл тархацтай ашигт малтмалын лицензийг, ашигт малтмалын хурдацтай газар аваачаад зэрэгцүүлээд өгчхөж байгаа юм. Тэгээд олборлолт хийгээд байгаа юм.

Тэгэхээр өнгөрсөн жил гэхэд 1770 орчим хүсэлт ирснээс 723 дүгнэлтэд дүгнэлт гаргаж 1047-г нь татгалзсан. Яагаад гэвэл хууль бусаар ашигт малтмал олборлочих гээд байгаа учраас. Гэхдээ сая Монгол Улсын Засгийн газраас 120 гаруй хоног хүртэл хүлээгддэг байсан түгээмэл тархацтайгийн зөвшөөрөл олгодог засгаар ордог байсныг болиулж манай яам өөр дээрээ агентлаг орон нутгийн Байгаль орчны газар, тэгээд орон нутгийн Засаг дарга тэгээд компанитайгаа нийлж гэрээ байгуулаад 14 хоногт өгдөг журам баталсан байгаа шүү.

Х.Булгантуяа: Шинэ хоршоо Амарсайхан шадар сайд. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын тухай асуусан.

С.Амарсайхан: Шинэ хоршоо өнөөдрийн байдлаар 99980 гишүүнтэй, 10177 хоршоо байгуулагдсан. Үүнээс 7630 хоршооны 24945 малчин өрх 844.7 тэрбум төгрөгийн санхүүжилтэд хамрагдаж өнөөдрийн байдлаар эргэн төлөлт 58.5 тэрбум төгрөгийн эргэн төлөлттэй ийм байгаа. Энэ хоршоод байгуулагдаагүй, Шинэ хоршоо хөтөлбөрт хамрагдаагүй аймаг орон нутаг гэж огт байхгүй. 21 аймаг Улаанбаатар хот гээд 22 засаг захиргааны нэгжид нийт энэ 99 мянган хоршоологчид хамрагдаж байна.

Жишээ нь Улаанбаатарт бол 31 хоршоо байна. Сүхбаатар аймагт бол Батсуурь гишүүний сонгосон Сүхбаатар аймагт 272 хоршооны 6094 малчин өрх 23.9 тэрбум төгрөгийн зээл авсан байна. Хэнтий аймагт 157.

Х.Булгантуяа: Амарсайхан сайд нэмж хариулъя.

С.Амарсайхан: Хэнтий аймагт 127 хоршоо, нийтдээ 495 малчин өрх хамрагдаж 19.5 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан гээд ингээд аймаг аймгаараа, сум сумаараа, баг багаараа гарчихсан явж байгаа. Хамгийн их хоршоо байгуулагдсан аймаг бол Архангай аймаг 600 гаруй хоршоо байгуулагдсан байна. Цаашлаад тэгээд аймаг аймгаараа яриад явах юм бол Архангай аймагт 615 бол Говь-Алтай аймагт 467 тэгээд Дундговь аймагт 556, Хөвсгөлд 517 ч гэдэг юм уу хамгийн бага нь Дархан-Уул аймаг 64, Орхон 48, Баян-Өлгий 152, Улаанбаатар 31 гээд. Ингээд нийтдээ энэ хоршоод идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа. Хоршооны үйл ажиллагаа цаашаа улам идэвхжинэ.

Хоршооны 2 дахь үе шатыг удахгүй эхлүүлэх гэж байна. Энэ нь өөрөө анхан шатын хоршоодоос дундын шатын хоршоодыг бий болгож цаашлаад үндэсний хоршоодыг бий болгох. Зээлийг 14 төрлөөр олгож байгаа бол төрлийг нь нэмэгдүүлээд.

Х.Булгантуяа: Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын тухай. Жавхлан сайд хариулах уу? Одоо тэгээд хэн хариулах вэ? Жавхлан сайд аа? Харин тийм дөнгөж гарчхаад ирье гээд гарсан уг нь. Батсуурь гишүүн нэмж тодруулъя.

Ж.Батсуурь: Асуултууд тодорхой бус байна аа. Тэгээд асуултдаа хариулт авч үндсэндээ бүрэн чадахгүй байна. Тэгэхээр ер нь бидний олон жилийн алдаа оноо хэт төржсөн, хэт төсөвжсөн, хэт төвлөрсөн л алдаагаа засах гээд л ингээд л яваад байгаа шүү дээ бид бүхэн. Би нэг минутаа нэмээд авчихъя. Нэг минутад чинь асууж амжихгүй байна. Жишээлэх юм бол нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаа төвлөрүүлээд үндсэндээ нам дээрээ татчихмаар юм байна даа танайхан. Аймгийн дарга ч гэж тэнд хэрэг алга. Иргэдийн хурлын дарга ч гэж хэрэг алга. Тэгээд нам дээрээ бүх аймгийн дарга нарыг авчраад сумын дарга нарыг хэлтэс газар болгоод ингээд авчихвал бүүр амар юм шиг байна. Тэгээд орон нутагт мэддэг хийдэг ажил гэж үндсэндээ байхгүй болчихсон. Нэг цалин авдаг хэдэн хүмүүс.

Дээрээсээ шийдвэр ирэхгүй бол ямар ч ажил явахгүй ийм нөхцөл байдалтай.

Х.Булгантуяа: Батсуурь гишүүн нэмж нэг минут.

Ж.Батсуурь: Дээр нь 10 аймгийн дулааны станц энэ бол үндсэндээ орон нутагт нь бүх эдийн засгийг боомилж байна шүү дээ. Орон сууц барья дулаан байхгүй. Эдийн засгийг тэлье тэлэх боломж байхгүй. Тийм болохлоор энэ дулааны станцыг тэр нөгөө газар нь дампуурсан барьсан гэсэн тайлбаргүйгээр ямар нэгэн аргаар энэ 2026 ондоо бүгдийг ашиглалтад оруулмаар байна аа. Ингэж байж жинхэнэ тэр хувийн хэвшлийг чинь дэмжих ипотекийн зээл, орон сууц, тэр дэд бүтэц бүх юмны чинь амь амьсгал. Улаан хоолой судас нь бол 10 аймгийн дулааны станц байж байгаа.

Ингээд л жил болгон шилний цаанаас чихэр горьдоогоод л энэ жил, энэ жил гэж явсаар байтал хэдэн Засгийн газрыг тоолов доо. Одоо хүсэх юм ерөөсөө ирэх 2026 онд 10 аймгийн ДЦС-ыг л ашиглалтад оруулна.

Х.Булгантуяа: Бат-Амгалан сайд хариулах уу? Батсуурь гишүүн үг хэллээ. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Энэ манай 26 оны төсөв хүний хөгжил бол хамгийн том мега төсөл өө гээд ингээд их сайхан гоё уриатай ийм төсөв байгаад байгаа. Тэгээд саяхан л бид нар энэ төсвийг алдагдалгүй батлах асуудал яригдаад алдагдалгүй баталж байсан. Дээрээс нь саяхан хэдхэн сарын өмнө баталсан 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл дээр төсвөө л алдагдалгүй байлгана гээд л баталсан. Тэгээд ингээд орж ирэхээр 1.4 их наядын алдагдалтай орж ирээд байгаа юм. Тэгэхээр яах вэ энэ алдагдал нь байна гэж үзье. Зайлшгүй гээд үзэхэд энийгээ энэ уриатайгаа хавсруулаад энэ хүний хөгжил тал руугаа ялангуяа энэ ахмадуудын тэтгэвэр тал руугаа нэлээн хуулиа бариад явуулчихмаар байна аа. Энэ жилийн инфляц бид нарт статистикаас өгсөн тоогоор 8.8 гээд бэлхнээ өгчихсөн байгаа. Яах вэ арай л бага харагдаж байгаа.

Тэгэхээр 10 хувиар ядаж энэ тэтгэврээ нэмээд жил жил дээрээ нэмээд явбал энэ 4 жилийн хугацаанд нэг 40 хувийн нэмэгдэл орчих боломжтой. Ингээд нэг жоохон ч гэсэн ахиц гарах ийм төлөв харагдаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр ийм боломж байхгүй юу? Алдагдалтай л батлах гэж байгаа юм бол.

Хоёрдугаарт энэ орлого зарлагын баланс алдагдаад байгаа. Юу гэхлээр ДНБ-д эзэлж байгаа энэ орлогын хувьд тэр дундаа хамгийн голыг нь бүрдүүлдэг уулын уурхайн салбарын орлого гэхэд 16.7 хувийг эзэлж байсан бол энэ жил 14.5 гээд энэ нүүрсний үнэ буурсантай холбоотой ингээд багасаж байгаа юм. Харин эсрэгээрээ төсвийн ДНБ-д эзлэх зарлага нэмэгдчихсэн харагдаж байгаа юм 36.8 хувиас 37.7 хувь гээд. Бид нарт өгөөд байгаа энэ ном дээрээс л авсан мэдээллүүдээ хэлж байна л даа.

Тэгэхээр энэ алдагдал чинь ингээд энэ зарлага руугаа ороод байна. Тэгэхээр энэ асуудлаа бас түрүүний миний алдагдалгүй төсөв гээд хэлээд байгаа чинь энэ зарлага бууруулах, танах энэ тал дээр бодлого барьж ажилласан уу гэдэг ийм зүйлийг асуумаар байна. Энэ төсвийг харж байхад энэ хүүгийн татаацууд явж байна. Манай 2 дахь том салбар ХАА-н салбар дээр маш олон татаасууд явж байна. Тэгтэл энэ жил ХАА-н салбар тэр дундаа газар тариалангийн салбар дээр гантай холбоотой маш их асуудал үүссэн юм. Тариаланчид бол үгээ хэлж байна. Зээл ихтэй нөгөөдөх нь нэхэгдэж байгаа ургац алдчихсан. Ногоочид ургац алдчихсан. Мэдээж ХАА-н сайд яваад ажиллаж байгаа. Тэгэхээр тэрүүгээр гайгүй газруудаар нь ороод байна гайтай газар зөндөө байна гээд над руу энэ манай энэ тариалангийн бүсийнхэн маань яриад байна. Тэгэхээр энэ дээр энэ тариаланчид руугаа чиглэсэн зээлүүд дээр нь энэ хүүг нь хөнгөлөх.

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Туваан сайдынхаа асуултад хариулъя. Алдагдлаа бол та маш сайн ойлгочихсон байна. Баярлалаа. Энэ хөгжил эдийн засгийн өсөлтийг дэмжсэн л ийм алдагдал. Тэрнээс биш цалин тэтгэвэр, тэтгэмжээ тавьж чадахгүй алдагдалд орж байгаа зүйл огтоос биш гэдгийг та ойлгожээ. Их баярлалаа. Орлого зарлагын баланс дээр та нэг юу хараадхаарай. Өчигдөр бид төсвийн хүрээгээ ярьж байхдаа есхөн тоо л ярьж байгаа шүү дээ. Есхөн тоон дотор 2 тэнцэл байгаа. Суурь тэнцэл тэнцвэржүүлсэн тэнцэл гээд. Тэр суурь тэнцэл чинь л орлого зарлагын балансыг хэлж байгаа юм. Бид татварынхаа орлогоороо цалин тэтгэвэр тэтгэмж бүх юмаа тавиад бүүр цаана нь 2 хувийн ашигтай байгаа. Тэгэхээр орлого зарлагын баланс бол ерөөсөө огт алдагдаагүй. Яг энэ тэнцлийн алдагдал гэж байгаа бол нөгөө бидний яриад байдаг мега төслүүдээ л зээлээр санхүүжүүлж байгаа. Ийм л зөрүү байгаа.

Тэгэхээр бид төсвийнхөө суурь зардал дотроо таны ярьж байгаа тэр хүний хөгжил мега төсөлтэй орон зай гаргахын тулд тэр орон зайг энэ одоо томоохон төслүүдээрээ идэхгүйн тулд тусад нь гаргаж алдагдал болгож байгаа гэдгийг л сайн ойлгоорой. Өөрөөр хэлбэл энэний цаана хүний хөгжил мега төсөл буюу боловсролын салбар, эрүүл мэндийн салбараар санхүүжих ёстой бүх төсөл арга хэмжээнүүд бүрэн санхүүжигдээд цаана нь бүр нэмэх 2 хувийн ашигтай байгаа гэдгийг л бүгдээрээ харах хэрэгтэй байна аа.

Хүүгийн татаас дээр очиж байгаа салбар Их Хурлаар батлагдсан үндэсний томоохон хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж явж байгаа. Энд гарч байгаа үр дүнгийн талаар салбарын сайд тоонууд хэлэх байх гэж бодож байна.

Х.Булгантуяа: Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: ХХААХҮЯ бүрэлдэхүүн үндсэндээ бараг 100 хувь орон нутагт ажиллаж байгаа, бүтэн тойрч байгаа. Хагас бүтэн сайн өдөргүй явж байгаа. Байгаль цаг уурын хүндрэл тохиолдсон зарим бүс нутагт эхний ээлжид чамлахаар чангатга гэж боломжийн үр дүн үзүүлж байгаа газрууд байгаа. Ургацаа хурааж авах нь 1 дүгээр зорилт.

Хоёрдугаар асуудал буюу тариаланчид ногоочдоос нийтлэг ирж байгаа энэ зээлийн төлөлтийг хойшлуулах асуудал байгаа. Засгийн газарт танилцуулсан. Ерөнхий сайд үүрэг өгсөн. Засгийн газраар энэ махны хангалт, мал худалдан авалт, гурилын, тогны тогтвортой байдал, улаан буудайн нийлүүлэлт ингээд зээлэх хүүтэй холбоотой асуудлыг багцаар оруулаад шийд гэсэн ийм үүрэг өгсөн оруулах болно. Гэхдээ бид 9 сардаа ургацынхаа гол ургацаа аваад үндсэндээ балансаа нэг тохиргоогоо хийгээд эцсийнхээ нэг тооцоогоо гаргана.

Х.Булгантуяа: Энхбаяр сайдын микрофоныг нэмье.

Ж.Энхбаяр: Мөн Улсын Их Хурлаас баталсан энэ голлох хөтөлбөрүүд цаашдаа үргэлжилнэ тогтвортой байна. Ирэх жил гэхэд бид нар ахиад энэ нэг зээл хүү татаас гээд дэмжлэг гээд нийт 395 тэрбум төгрөгийн татаас урамшууллын бодлого ахиад л үргэлжилнэ. Ялангуяа газар тариалан, ногоочид, малчид, фермерүүд, үйлдвэрлэгчид, хоршоологчдодоо зориулсан бодлого үргэлжилнэ. Арьс ширний, ноос ноолуурын, сүүний, улаан буудайн, хүнсний ногооны дэмжлэгүүд үргэлжилнэ. Салбарын бодлого 2026 ондоо тогтвортой хадгалагдана.

Х.Булгантуяа: Туваан гишүүн тодруулна.

Ц.Туваан: Энхбаяр сайдаа юу яаж байгаа юм аа. Энэ маш их олон тэрбум төгрөг хүүгийн татаасд өгч байгаа. Энэ дотор өнөөдөр асуудалд нэрвэгдчихээд байгаа тариаланчид ногоочид дээр олгочихсон зээлийн хүүгийн татаас руу шилжүүлж болох уу гэж би асуугаад байгаа юм. Ийм боломжтой юу. Энийг авахгүй бол зээлээ төлөх боломжгүй тариаланч, ногоочид маш их байна шүү гэдгийг хэлье.

Хоёрдугаарт энэ урамшуулал яагаад ингээд дураараа хасагдаад байгаа юм бэ. Төв аймгийн Архуст сумын Засаг дарга Энхтөмөр, Батсүмбэр сумын иргэдийн Хурлын Төлөөлөгч Наранцэцэг, Дархан-Уул аймгийн Орхон сумын тариаланч Мөнхцэцэг нар манжингийн урамшуулал ярьж байгаа юм. Шар манжингийн урамшууллыг хасаад хаячихсан. Ямар шийдвэрээр хассан. Мөнхцэцэг гээд Дархан, Орхоныхон болохоор хүрэн манжингийнх.

Дээрээс нь энэ урамшуулал олголтын асуудал маш төвөгтэй болсон. Нөгөө ЭМД-ын сан дээр сандаа тохируулж энэ хэмнэлтийн бодлого.

Х.Булгантуяа: Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Хүнсний хувьсгалын гол зорилт бол тодорхой нэр төрлийн ХАА-н гаралтай барааг дотооддоо тарьж ургуулах үйлдвэрлэх. Ингээд төмс дотоодоосоо 100 хувь хангачихсан тул энэ урамшуулалд хамрагдахгүй байгаа. Шар манжин дотоодоосоо 100 хувь хангачихсан. Зорилт түвшинд хүрсэн гэсэн үг. Ингээд бид нар зорилт түвшинд хүрснээ багасгаад, багасгаад дэмжих талдаа 4 улирлын хүлэмжид тарьж байгаа энэ навчит ногоо, энэ үнэтэй импорт их өндөр гараад байгаа ногоо руугаа төвлөрнө. Ингээд бид нар бодлого мөнгө биш. Зорилт хүрлээ бид эндээс

гарах бодлогоо хэрэгжүүлнэ. Энэ жилийн онцлог бол зарим урамшууллуудаа багасгаад, багасгаад, үйлдвэрлэлтэй нь холбоод ингээд үр дүн хүрснээсээ бид гараад эхэлнэ гэсэн үг. Ийм маягаар энэ бол манай нийт Их Хурлын гишүүдийн тавьж байгаа шаардлага байгаа. Нөгөө талаас салбарыг бид нар төрийн бодлого хэрэгжсэн үр дүн гарсан бол холдох хэрэгтэй. Ингээд тоног төхөөрөмж нь, технологи нь, санхүү.

Х.Булгантуяа: Туваан гишүүн нэмж тодруулна аа.

Ц.Туваан: Манай нэг ах дайнаа ирэхээр дариа нухна гэж юманд бэлэн бай гэж хэлдэг байсан. Дайн болсон л доо хойно. Түрүүн Дамдинням сайд хэлж байна. Өнгөрсөн Их Хурлын хугацааны үед бид нар энэ ОХУ-тай хийсэн 2 хэлэлцээрийг зурж явуулаад 2 дахийг нь Их Хурлаар ёсчлох дээрээ хүмүүс юу юу ярьж байлаа. Одоо санаж байгаа байх. Тэрний асуудал чинь тулаад ирчихлээ шүү. Ерөнхий сайд ч тэр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд ч тэр энэ бензиний үнэтэй холбоотой үгэндээ болгоомжтой хандмаар байгаа юм шүү. Энэ асуудал чинь манайхан ингээд л сайд дарга нар тэгсэн гээд явчихдаг юм шүү.

Тэгэхээр энэ дээр нөгөө савны асуудал яриад л байсан байхгүй. Бид нар 3 сарын саваа бүтэн болгохын тулд, нөөцийн савтай болгохын тулд 900 орчим тэрбум төгрөг шаардлагатай өндөр. Тэгэхээр энэнээс нь зах зухаас нь аваад ингээд шийдмээр байгаа юм. Өнөөдөр баруун бүсийн бензин орж ирэх асуудал хаагдчихсан л явж байгаа.

Х.Булгантуяа: Үг хэллээ. Туваан гишүүн. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү.

Ц.Баатархүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Төсөв гэдэг бол тоогоор л илэрхийлж байгаа хөгжлийн бодлого. Монгол Улсад Эдийн засгийн хөгжлийн хурал зөвлөгөөн бол байна. Гэхдээ эдийн засгийн хөгжил алга. Уул уурхайн бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний үнээс шалтгаалсан эдийн засгийн өсөлт уналт гэдэг зүйл байна. Эдийн засгийн хөгжил алга. Эдийн засгийг хөгжүүлэх хурал зөвлөгөөн маш их байна гэдгийг онцолж хэлье.

Тэгээд би 3 зүйл асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт, Монгол Улсын Засгийн газар боловсролыг нь жил болгон зарласан. Энэ уриа лоозон биш бүх түвшинд ингээд боловсролыг дэмжих энэ чиглэлд анхаарч ажиллах байх гэж бодож байна. Бидэнд ажлын уялдаа шаардлагатай байгаа юм болов уу гэж харагдаж байна. НЗД-ын орлогч өдөр болгон энэ боловсролын яам удирдлагаа томилохгүйгээс болоод сургууль, цэцэрлэг ажиллахгүй байна. Нийслэлийн маш олон сургууль, цэцэрлэг суух сандалгүй тавилгагүй байна гэж ярьж байна. Манай нийслэл Улаанбаатар хот чинь өнгөрсөн жилжин бордюраа сольсон. Энэ жилжин зүгээр байсан явган хүний замуудыг сольсон, одоо ч сольсоор байна. Энэ дуусаагүй байна. Биднийг нийслэлд байхад 800 тэрбумын төсөв байсан. Энэ жилийн Улаанбаатар хотын төсөв 10 их наяд болж байна. 10 дахин нэмэгдэж байна. Мянган хувиар өсөж байна. Улаанбаатар хотын энэ хүмүүсийн ая тухтай амьдрал 10 дахин нэмэгдэж байгаа юм уу. Энэ ажлаа уялдуулаад энэ бордюр солих энэ цементэн хавтан солих мөнгөөрөө энэ сургууль, цэцэрлэгийнхээ тавилгыг, тоног төхөөрөмжийг шийдэж болохгүй байгаа юм уу?

Боловсролын сайд уриад нэг Засгийн газар 1 нийслэл нийлээд энийгээ шийдчихэж болохгүй байгаа юм уу. Яагаад ингээд сошиалаар хэвлэл мэдээллээр бие бие рүүгээ ингээд попрод нийслэлчүүдийг хохироож байгаа юм бэ гэдгийг Наранбаяр сайдаас асууя.

Хоёрдугаарт нь агаар орчны бохирдлын асуудлаар Засгийн газар ямар байр суурьтай байгаа юм бэ? Энэ их өвчлөл, ханиад томуу, их хүүхдийн өвчлөл, эрсдэл чинь энэ агаарын бохирдолтой холбоотой. Монгол Улс нүүрстэй байгалийн баялагтай. Бидний өвөг дээдсийн үлдээсэн өв их. Энэ өвөө бид нар зарж борлуулчихаад БНХАУ-аас 226 тэрбум төгрөгөөр коксожсон нүүрс авах энэ бодлого чинь хэвээрээ юү гэж асууя аа. Цаашдаа Монгол улс өөрөө нүүрсний коксожсон энэ.

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Энэ Баатархүү сайдын ярьж байгаа зөв өө. Одоо би сая ажил аваад нэг Монголын эдийн засгийн форум зохион байгуулах ажил руу орсон. Нэгэнт гадаад дотоодын зочдыг урьчихсан тэгээд наадмын өмнө олон зочид төлөөлөгч нар ирчихсэн байх үед бид нар хийх ёстой. Анх удаа бид нар нэг хувийн хэвшил өөрсдөө энэ санхүү мөнгөө босгоод хийгээсэй. Төр дэмжлэг үзүүлээд ядаж тэр нэг хувийн хэвшил хийж байгаа эдийн засгийн форумд нь төрийн албаныхан ч юм уу, сайд дарга нар хэрвээ оролцох гэж байвал өөрсдөө яг тэр бусад хувийн компаниудтайгаа адилхан таксаа төлөөд ордог энэ зарчим руу шилжье л гэж хичээсэн. Сая энэ эдийн засгийн форум дээр очиход хувийн хэвшлийнхэн нэг зүйлийг асууж байгаа юм. Компаниуд ч гэсэн. Та нар энэ гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг ер нь гаргаж өгөх юм уу, өгөхгүй юм уу? Төр лиценз өгдөг, төр бодлого гаргадаг, тэгээд ажлаа эхэлье гэхээр эхлүүлдэггүй. Төр энэ шийдвэртээ ер нь үнэн байх юм уу гэж л асууж байгаа юм.

Тийм учраас гадаадын хөрөнгө оруулалтын хууль энэ Эдийн засгийн эрх чөлөөний хууль, Зөвшөөрөл мэдэгдлийн хууль, Тендерийн хууль гэсэн энэ хуулиудыг парламентаараа баталж өгөөч л гэж бид нар хүсэж байгаа юм. Ингээд бид энэ хуулиудыг легал инфо дээр тавьсан. Хэлэлцүүлээд эхэлчихлээ. Тэгээд гадаадын хөрөнгө оруулалтын форум, энэ эдийн засгийн форум хэрвээ дараа жил Гадаадын хөрөнгө оруулалтын хууль батлагдаагүй байвал хийхгүй гэдгээ би Эдийн засаг хөгжлийн сайдын хувиар хэлсэн.

Одоо ер нь Монголоор дүүрэн панелист, модераторууд болчихлоо шүү дээ. Панелист гэдэг мэргэжил гарлаа. Модератор гэдэг бараг ийм цол бий болчихоод байна шүү дээ. Хувийн хэвшил өөрсдөө энэ панел формоо зохион байгуулаад, санал санаачилгаа гаргаад төрийнхөнд хүргүүлээд түүнийг нь төр нь авдаг бол энийг урам зоригтой хийнэ. Гэхдээ бид нар өөрсдөө тэнд очиж модератор болж байх хэрэггүй юм байна. Модератор болж байвал асуудлыг шийдэх хэрэгтэй. Шийдэхгүй бол тэнд очиж модератор хийхгүй.

Тийм учраас нэг л бодлого барьж байгаа юм. Засгийн газрын гишүүд хэрвээ янз бүрийн панел модератор хийх гэж байвал очоод асуудал шийд үгүй бол оролцох хэрэггүй. Төрөөс нэг ч төгрөг гаргаж янз бүрийн ийм том том хэлэлцүүлэг формууд хийхээ зогсоох хэрэгтэй гэдэг ийм байр суурьтай байсан учраас эдийн засгийн форм дээр яг хэмнэлтийн үе 2.2 хувьд буюу их наядын хэмнэлтийн тодотгол хийж байсан үед энэ асуудал дээр бол асуудалд ингэж хандсан, хэмнэсэн.

Тэгээд болж байсан 2.2 их наядыг хэмнэж болж байсан. Тэгэхдээ хэмнээд сайжирдаг бол сайжирч байна шүү дээ. Цаашдаа яаж зөв явах вэ гэхээр эдийн засгийн хэрэгжүүлэх бодлого л хэрэгтэй гэдэг утгаараа төсвийн сахилга батыг барьсан ийм бодлого оруулж ирээд Эдийн засгийн эрх чөлөөний хуулиар 110 хуулийг өөрчилж татварын багц хуулиуд зэрэг хэлэлцэж эхлэх гэж байна, олон нийтийн хэлэлцүүлгүүд эхэлж байна.

Ингээд энэ чуулганаар эдгээр хуулиудыг батлан гаргачхаад хуулиудаа хэрэгжүүлэхийг нь Их Хурлын гишүүд Засгийн газраас шахаад явах нь зөв өө гэж бодож байгаа. Саяын агаарын бохирдлыг бууруулах асуудал дээр би түрүүн хэлж байсан. Хөгжлийн төслүүдийг эрэмбэлсэн. Засгийн газрын 14 төслийг 4 бүлэг 15 зүйл олон улсын аргачлалаар эрэмбэлсэн. Энэ эрэмбийн дагуу бол энэ агаарын бохирдлыг бууруулахад аж үйлдвэрийг дэмжих ёстой тэр дундаа Гантөмөр сайдын үед эхлүүлж байсан энэ Багануурын Пиролизын үйлдвэрийг барьж байгуулах шаардлагатай. Ингээд ТЭЗҮ-ийг нь боловсруулаад дуусаж байгаа юм байна лээ. Одоо энэ Багануурын пиролизын үйлдвэрийг барьж байгуулах ажил руу бол хувийн хэвшилд нээлттэй зарлаж энэ үйл ажиллагааг явуулж эхэлнэ гэдгийг хэлье ээ.

Х.Булгантуяа: Наранбаяр сайд нэмж хариулъя.

П.Наранбаяр: Энэ нийслэлийн Баатархүү гишүүний асуултад хариулъя. НЗД-ын орлогч гээд нэг залуу юм болгон дээр фэйсбүүкээр дамжаад юм яриад яваад байгаа. Асуудлаа шийдэж байгаа нь зөв өө зөв. Энийг бид дэмжиж байгаа. Төрийн байгууллага хоорондоо албан бичиг гэдэг нэг хэл байдаг энийгээ хэрэглэх хэрэгтэй. Мөн болохгүй байгаа асуудлуудаа шууд ярилцаад явахын оронд ийм байдлаар яваад байх нь өөрөө зохимжгүй л дээ. Төрийн байгууллагын яг төрийн албан хаагчийн ийм ёс зүй асуух ёстой гэж би бодож байгаа.

Өнөөгийн нөхцөл байдалд бид нэг 2446 сургууль, цэцэрлэг, боловсролын байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Энд 1.2 сая сурагч оюутнууд суралцаж байна. Энэ бүхнийг ингээд бүрэн ширээ сандал тоног төхөөрөмжөөр нь хангахад бараг 1.9 их наяд төгрөг шаардлагатай. Бид тэгээд жилдээ 40 тэрбум орчмыг л энэ.

Х.Булгантуяа: Наранбаяр сайдад нэмж микрофон өгье.

П.Наранбаяр: Тоног төхөөрөмж дээрээ тавьдаг. Бид энэ нийслэлд ашиглалтад орчихсон сургууль цэцэрлэгийн ширээ сандлыг хангах талаар тодорхой арга хэмжээг авсны үр дүнд сургууль, цэцэрлэгүүд ширээ сандлаар хангагдаад явж байгаа. Харин сургуулийн захирал, эрхлэгч нарыг улсын комисс ажиллаад тэрний дараа нийслэлийн Боловсролын газраас сургуулийн нэр номерыг нь өгсний дараа сургууль цэцэрлэгийн эмнэлгийн эрхлэгч нарыг АТГ-д томилох хүнээ материалыг нь явуулж хуулийн зөрчилгүйгээр томилох ажлыг хийж байгаа. Одоогоор ийм асуудал үүсэхгүй, үүсээгүй байгаа. Юуны хувьд бол Нийслэлийн боловсролын газар өөрөө энэ асуудлыг шийддэг юм энэ чинь яамтай шууд холбоотой биш. Тэгээд хууль бус юмыг яамнаас шаардаад байж болохгүй. Энэ чинь тухайн орон нутаг нь өөрөө томилдог ийм хуулийн заалттай.

Бид хэрвээ энэ Нийслэлийн боловсролын газар энэ цаг алдсан, хариуцлага алдсан байвал Боловсролын газартай хариуцлага ярихаар байгаа гэж ингэж хариулъя.

Х.Булгантуяа: Баатархүү гишүүн нэмж тодруулна.

Ц.Баатархүү: Энэ жилдээ гаднаас коксожсон нүүрс худалдаж авах юм байна гэж ойлголоо. Цаашдаа Багануураа түшиглэсэн үйлдвэр барих юм байна гэж ойлголоо. Ер нь энэ агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр Монгол Улс бол нэгдсэн стандарт нэгдсэн бодлого байхгүй яваа шүү. Зуухаа сольсон, яндангаа сольсон, түлшээ сольсон, газан халаалт руу шилжих гэж үзсэн, хийн халаалт руу шилжих гэж үзсэн. Одоо дахиад түлшээрээ солих гэж байна. Хамгийн зөв шийдэл бол ногоон зээл гэр хорооллын дахин төлөвлөлт шүү гэдгийг дахин сануулъя.

Хоёрдугаарт энэ нийслэл Улаанбаатар хотын төсөв бол багадаагүй шүү дээ. Манай улсын төсвийг харах юм бол өнгөрсөн жил бордюрын жил байсан. Энэ жил явган замын хавтангийн жил байсан. 2026 оныг боловсролын жил болгож зарлаж байна. Тэгээд 1 мөсөн боловсрол руугаа анхаарч энэ баг.

Х.Булгантуяа: Баатархүү гишүүн үг хэллээ. Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн.

П.Мөнхтулга: 126-тай парламент 5 дахь төсвөө хэлэлцэж байна.

Энэ 5 удаагийн төсөв хэлэлцэхэд нэг л юм асуудаг юм. Бид нар хэзээ ХАА-н арьс шир, дайвар бүтээгдэхүүнүүдээ боловсруулдаг улс болгох юм бэ? Монголчууд жилдээ 17 сая малыг эдийн засгийн эргэлтэд оруулж байна. 17 сая малаас 17 сая арьс шир, дайвар бүтээгдэхүүнүүд гарч байгаа. Бүгд хог дээр хаягдаж байгаа. Энэ тоог жилээр бодоод үзэхлээр нэг малчин өрх жил болгон 3-аас 4 сая төгрөгийн боломжоо алдаж байгаа. Энэ тоог нийлүүлээд бодоод үзэхлээр Монгол Улс 1 их наяд төгрөгийнхөө эдийн засгийн боломжийг жил болгон алдаж байгаа. Жил болгон энэ малынхаа хэрэглэж болохуйц энэ дайвар бүтээгдэхүүн арьс ширийг хог дээр хаяж жалганд булж байгаа. Энэ асуудал дээрээ бид нар 5 удаа төсөв хэлэлцэхэд нэг ч удаа анхаарсангүй ээ. Төрийн үүрэг бол дэд бүтцийг нь барьж өгөх, цэвэрлэх байгууламжийг нь барьж өгөх, эрчим хүчний эх үүсвэрийг нь шийдэж өгөх, замыг нь тавьж өгөх.

Хувийн хэвслүүд энэ бүгдийг хийх юм бол хэзээ ч энэ төсөл амжилтад хүрэхгүй, хэзээ ч зардлаа нөхөхгүй. Тэгэхээр төр үүргээ хэзээ биелүүлэх юм бэ? 1 дүгээр асуулт.

Тодотголоор хасагдсан олон хөрөнгө оруулалтууд байгаа. 2025 оны төсөвт хангайн бүсийн 34 сумд зуун зуун жилээ тэмдэглэсэн мөртөө өнөөдөр нүхэн жорлонтойгоо байгаа сумуудад цэвэрлэх байгууламж тавьж өгсөн. Энийг тодотголоор хассан. 1700 оны 16 дугаар зууны үеийн сүм хийд Луу гүний хүрээг сэргээх, түүх соёлоо хадгалж үлдэх төсөв суулгасан байсан. Энийг хассан. Энэ 2025 онд суусан байсан төсвүүдийг 2026 онд эргэж суулгах уу? Яагаад хассан юм бэ? Шалтгаан.

Гуравт нь гадаа ахмадууд жагсаж байна аа. Тэтгэврийн зээлийн хүү, тэтгэвэр нэмэх асуудлаар жагсаж байна. Гарч уулзсан. Тэтгэвэр нэмэх боломжгүй юм бол ядаж зээлийн хүүг бууруулаад өгөөч гээд, надад зээлийн гэрээгээ өгсөн. Зээлийн гэрээг нь харсан 20 хувьтай байна лээ. Монгол Улсад төр гэж байгаад тэтгэврээ тавьж л байгаа бол, хугацаандаа тавьж л байгаа бол энэ хамгийн эрсдэлгүй зээл.

Хамгийн эрсдэлгүй буцаан төлөлт. Тэгтэл яагаад хамгийн эрсдэлтэй зээлийн хүүтэй адилхан байгаа юм бэ гэдэг асуулт. Энийг Сангийн сайдаас асуумаар байна. Монголбанкны төлөөлөл байвал асуумаар байна. Яагаад хамгийн эрсдэлгүй хугацаандаа төлөгддөг зээл эрсдэлтэй зээлийн хэмжээнд 20 хувь дээр байгаа юм бэ? Энийг бууруулах боломжтой юу?

Дөрөвт нь өвөлжилтийн бэлтгэл ямар байгаа вэ? Өнөөдөр Архангайд өвс 16 мянга байна. Тэгэхээр 30.

Х.Булгантуяа: Энхбаяр сайд эхлээд хариулъя.

Ж.Энхбаяр: ХАА-н гаралтай түүхий эд үүн дотроо арьс шир, ноос ноолуураа боловсруулахын тулд бид Улсын Их Хуралд цагаан алт хөтөлбөрийг батлаад хэрэгжүүлж байна. Эхний жилийнхээ үр дүнг үзэх гэж байна. Ноолуур дээр нэлээн томоохон ахиц гарсан. Ноолуурын салбар дотооддоо 100 хувь цэвэр ноолуур гаргах ийм бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Амжилттай хэрэгжиж байгаа буюу ноолуураа бид нар 100 хувь самнаж экспортод гаргадаг болсон. Энийгээ дагаад сарлагийн хөөвөр тэмээний ноос сайн явж байгаа. Хонины ноосны асуудал сайн явж байгаа. Арьс ширэн дээр асуудал байгаа. Нөгөө талаар дэлхийн арьс ширний зах зээл өөрөө жоохон уналттай байгаа. Шинэ технологиуд гарчихсан. Арьс шир сайн байхын тулд бид нар мал эмнэлэг дээр онцгой анхаарах зайлшгүй шаардлага байна.

Тэгэхээр мал эмнэлгийн бодлогыг нэлээн сайн дэмжихгүй бол яг зохист хэмжээнд очиж чадахгүй л байгаа. Гал унтраах маягаар л явж ирж байгаа, нэг.

Үйлдвэрийн бодлого. Баруун бүсийн Ховдын арьс ширний үйлдвэрийн парк үндсэндээ улсын төсвөөр хийх ажлууд энэ жилийн төсөвтөө 2026 онд батлагдаад дуусна. Үндсэндээ төр хийх ажлаа хийж дуусна гэсэн үг. Эрчим хүч, дэд бүтэц, бохир, цэвэр, цахилгаан, зам, мэдээ, тохиолдлыг нь бүтэн холбож дуусна. Улаанбаатар хотод Эмээлт, арьс ширний парк нийт хот 30 тэрбум төгрөгийн төсөв батлаад цэвэрлэх байгууламжийг нь дулааны эх үүсвэр цахилгаантай нь шийдээд ажил явж байгаа. Зураг төсөл бүх юм ТЭЗҮ бүрэн боловсрогдсон. Төсөв нь батлагдсан ажил явж байна.

Энэ 2 дээрээ л гол арьс ширний боловсруулалтын бодлого явагдана. Нийт Монгол Улсад 27 үйлдвэр байна арьс ширний. 26 нь энэ төвийн бүсэд байгаа. Өвөрхангайд нэг үйлдвэр байгаа.

Шаардлагатай хөрөнгө оруулъя, дэмжье, өргөтгөө гэсэн ААН-үүдэд хөнгөлөлттэй зээл хангалттай байгаа. Цагаан алт бодлогын хүрээнд хөнгөлөлттэй эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийг Их Хурал шийдчихсэн. Нөгөө талаар яг энэ салбарт ажил хийж орох хувийн хэвшлийн сонирхол маш их хязгаарлагдмал байгаа. Залуучууд энэ салбарт ажиллах жоохон дур сонирхол жоохон бага байгаа ний нуугүй хэлэхэд. Ажиллах хүчний асуудал үүсэж байгаа. Хэдий тийм ч хэд хэдэн үйлдвэрүүд өргөтгөл хийгдсэн. Шинэ шугамууд тавигдсан. Энэ оны эцэс гэхэд арьс ширэн дээр нэлээн боломжийн ахицууд гарна. Хүссэн Их Хурлын гишүүдийг бид нар аялал зохион байгуулж, үйлдвэрийн өргөтгөлүүд хийгдэж байгаа, шинэ бүтээгдэхүүн гаргаж байгаа үйлдвэрүүдээр ийм аялал зохион байгуулж бодит байдал дээр танилцуулах бүрэн бололцоотой.

Үүнээс цааш төр алхаж болохгүй гэдэг бодлогыг Их Хурал баталсан. Хувийн хэвшлийн хийж болох ажилд төр орохгүй. Төр арьс элдэхгүй, төр тариа тарихгүй, төр ногоо хураахгүй. Бүгд хувийн хэвшил. Хувийн хэвшил хийхэд шаардлагатай хөнгөлөлттэй зээлээр хангах бодлогыг хэрэгжүүлж байгаа. Зээл хүрэлцээтэй байгаа боломжийн юм байгаа.

Х.Булгантуяа: 4 номер. Ажлын хэсгийн микрофон дээрээс хариулъя. Бат-Амгалан сайд эхлээд хариулъя. Сангийн яамныхан бэлдэж байгаарай.

Э.Бат-Амгалан: Мөнхтулга гишүүний асуултад хариулъя. Мэдээлэл өгье. Сая аймгуудын цэвэрлэх байгууламжийн талаар асууж байх шиг байна. Ерөнхийдөө 21 аймгаас 13 аймаг АХБ-ны тусламжаар, 5 аймаг Польшийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр ингээд цэвэрлэх байгууламжууд хүчин чадлаараа ашиглалтад орчихсон ажиллаад явж байна. 3 аймгийн хүчин чадал бол ер нь өнөөдрийн байдлаар бас хоногийн хэрэглээ, сарын хэрэглээ жилийн хэрэглээ нь гүйцэхгүй байгаа. Тэрэнд бол Баянхонгор, Ховд, Сэлэнгэ аймгууд орсон байгаа. Дорнод аймгийн 5 мянган м³-ийг 10 мянган м³ болгохоор энэ жил 2026 оны энэ төсөвт асуудлуудыг нь суулгаад явж байгаа гэдгийг хэлье ээ.

Х.Булгантуяа: Мөнхтулга гишүүн нэмж тодруулна. Аймгуудынхыг асуугаагүй ээ. Нөгөө манай Хангайн бүс дээр 34 сумын цэвэрлэх байгууламж нийт бүсүүдийн инженерийн шугам сүлжээ гэдэг томъёололтой. Өмнөх 2025 оны төсөв дээр 213 тэрбум төгрөгийн тодорхой хувь нь Хангайн бүс дээр зарцуулагдана аа.

34 сумыг цэвэрлэх байгууламжтай болгоно оо гэчихсэн ийм төсөв явж байсан юм аа. Тэгсэн хасагдсан. Луу гүний хүрээг сэргээх төсөв явж байсан юм. 1.8 тэрбумын төсөв явж байсан, тэр хасагдсан. Ажлаа хийгээд явж байсан байхгүй юу. Тендер нь шалгараад компаниуд нь ажлаа хийгээд явж байсан чинь төсвийг нь хасаад хаячихсан. Одоо нөгөө компаниуд нь хаанаас тэр гаргасан зардлаа авах юм бэ буцааж төсвийг нь тавих юм уу яах юм гэдэг ийм асуулт байна. Тэтгэврийн зээлийн хүү бас хариулаагүй байгаа. Өвөлжилтийн бэлтгэл бас.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон.

Ж.Дэлгэржаргал: Мөнхтулга гишүүн асуултад хариулъя. Дэлгэржаргал Сангийн яам.

2025 оны төсөв дээр төрийн хэмнэлтийн хуулийн дагуу гэрээ хийгдээгүй ажлууд хэмнэлтэд орсон. Тэгэхээр хэмнэлтэд ороод яг энэ цаашаа хэрэгжихэд ийм асуудал үүссэн учраас 2026 оны төсөвт гэрээгүй буюу хэмнэлтийн хуулийн дагуу хэмнэлтэд орсон төсөл арга хэмжээг бид нар төлөвлөөгүй байгаа. Тэгэхээр ямар нэгэн гэрээтэй ажлуудын санхүүжих дүнг бууруулах уу? Хасах гэдэг асуудал байхгүй. Өөрөөр хэлбэл Архангай аймаг хангайн бүсэд явж байгаа энэ цэвэрлэх байгууламжийн төслүүдийн хувьд бол БХБ-ын сайдын бүсүүдийн инженерийн дэд бүтэц гэдэг багц төслийн арга хэмжээнд явж байгаа. Өөрөөр хэлбэл хууль дээр болохоор яг багцаараа яваад яг задаргаа ингээд 100 гаруй задаргааг хууль дээр яг нэрээрээ байхгүй. Тэгэхээр энэ багц нь өөрөө 2026 оны төсөв дээр үргэлжлээд явж байгаа учраас энэ хууль, энэ төсөл батлагдсаны дараа Сангийн сайд болон БХБ-ын сайдын хамтарсан тушаалаар нөгөө гэрээтэй төслүүд дээрээ үргэлжлүүлээд хэд хэдийг хуваарилах уу гэдэг хуваарь нь хийгддэг ийм журмын заалттай.

Х.Булгантуяа: Аубакир сайд хариулъя. Тэгээд тэтгэврийн зээлтэй холбоотой асуудал. Тэгээд Энхбаяр сайд өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой. Ямар ч байсан Аубакир сайд хариулъя. Микрофон нь асчихсан байна.

Т.Аубакир: Монголбанкны Ерөнхийлөгч болон Мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр тэтгэвэр тэтгэмжийн орлого барьцаалсан зээлд 2025 оны 3 сарын 10-ны өдрөөс эхлэн тодорхой хязгаарлалт тогтоосон байсныг 2025 оны 7 сарын 7-ны өдрөөс цуцалсан. Одоо бол тэтгэврийн зээл хэвийн олгогдоод явж байх ёстой. Мэдээж хэрэг зарим арилжааны банкнууд өөрийн шаардлагуудаа тавиад ажиллаж байгаа. Ингээд хэвийн болоод рэх ирэхтэй нь зэрэг тэтгэврийн зээл авах эрэлт улам нэмэгдэж байгаа. Энэ тэтгэврийн зээлийн хүүг бууруулах бололцоотой юу үгүй юу гэдгийг Монголбанк хариулсан нь дээр байх.

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Мөнхтулга гишүүний асуултад хариулъя аа. Ганц тэтгэврийн зээл ч биш ер нь бүх зээлийнхээ хүүг буулгамаар байна. Бид нарын эцсийн зорилго л энэ шүү дээ. Тэгэхээр Засгийн газраас хийж чадах зүйл бол энэ макро тэнцвэртэй байдлаа л хадгалах юм байгаа юм. Ерөнхий энэ инфляцаа нэг алдчихгүйхэн шиг нөөц дээрээ анхаарал тавиад ийм л зүйлийг бид хийж чадна. Их хурлаас батлагдсан томоохон үндэсний хөтөлбөрүүд дээр бол тусгайлсан хүүгийн хямдруулалт хийж зээлдэгч нарт нь татаас өгдөг. Тэтгэврийн зээл дээр бол яах аргагүй энэ макро суурь баланс маань л нөлөөлнө. Тэгээд тэтгэврийн зээл яах вэ том зээл биш, нөгөө жижиглэнгийн зээл байдаг учраас харьцангуй өндөр хүүтэй яваад байгаа. Саяын Аубакир сайдын хэлсэнчлэн энэ тэтгэврийн зээл дээр нөгөө өр зээлийн харьцаа нь нэлээн чангалчихсан байсан. Тэрийг буцаагаад суллагчид лээ. Зүгээр уг нь мөнгөний бодлогоо хатууруулж байснаа буцаагаад тэрэн дээрээ зарим суурь бригадуудаа яагаад ч юм буцаагаад.

Х.Булгантуяа: Өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой хариулт авах уу? Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Манай эрхлэх ажлын хүрээнд байгаа өвөлжилттэй холбоотой асуудал дээр бид ажлын хэсэг гаргаад Засгийн газраар асуудлаа хэлэлцүүлээд албан даалгавар үүрэг аваад ингээд улс орны хэмжээнд зохион байгуулалтаа хангаад явж байна.

Нэгдүгээрт бол отрын бүс нутгийн буюу энэ жилийн ган зудтай аймгуудаас отор нүүдэл хүлээж авах бэлчээрийн даацад тохирсон малын асуудал. Тэгээд хилийн бүсэд ТХГН-т мал өвөлжих, оторлох гээд зохион байгуулалттай ажлуудыг хийж байна. Нөгөө талаас өвөлжилттэй холбоотойгоор хүндэрсэн аймгуудаас мал мах бэлтгэлийг эрчимжүүлж байна. Мал махны экспортыг бүх талаар одоо хөшүүрэгдэж дэмжиж байна. Аль болох их борлуулалт хийж, мөнгө болгох асуудал дээр малчдадаа хоршоологчдодоо туслах бодлогыг явуулж байна. Нөгөө талаас өвөлжилттэй холбоотойгоор хадлан тэжээлийн зохион байгуулалтыг ялангуяа зүүн бүсийн тэжээлийн нөөц сайтай.

Х.Булгантуяа: Энхбаяр сайдад нэмж нэг минут өгье.

Ж.Энхбаяр: Нөгөө талаас хадлангийн нөөц сайтай зүүн бүсийн аймгуудад бусад аймгуудад газар хуваарилж хадлангийн анги салаануудыг гаргаж, өвс

бэлтгэх, тэжээл бэлтгэх ажлууд явж байна. Газар тариалангийн бүсэд таригдсан тэжээлийн ургамлыг МАА-н салбарт нийлүүлэх ийм бодлогын арга хэмжээ орон нутагт нөгөө орон нутгийн нөөц бүрдүүлэх ажлуудыг орон нутгийн удирдлагууд дор дороо хийдэг болчихсон. Өвс тэжээлийн болон махны нөөцийг. Тэгээд энэтэй шаардлагатай аймгуудтайгаа холбоотойгоор бид нар ажлаа зохион байгуулалтаа хийгээд ажиллаад ингээд явж байна аа.

Х.Булгантуяа: Мөнхтулга гишүүн нэмж тодруулна.

П.Мөнхтулга: Тэтгэврийн зээл дээр би бусад зээлүүдтэй харьцуулаагүй. Одоо яг буулгаж болохуйц боломж байгаа гэж хараад байгаа байхгүй юу. Энэ зээл маань өөрөө эргэн төлөлт нь яг хугацаандаа ордог. Яг бусад эрсдэлтэй, хугацаа нь төлөгдөх хугацаа нь тодорхойгүй зээлүүдээс шал өөр. Үнэхээр ахмадууд маань 600 хэдэн мянган төгрөгөөр амьдрахад хэцүү байгаа. Тийм учраас л зээл аваад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хүүг нь 20 хувьтай тэр бусад өндөр эрсдэлтэй зээлтэй ижилтгэж хүүлээд байх тийм шаардлага байхгүй ээ. Харин бууруулах боломж нь байна аа. Төр байгаа цагт тэтгэврээ тавьж л таараа, эргэн төлөлт нь яг хугацаандаа орж л таараа. Тэгэхээр бодлогын хүүнээсээ нэг жоохон хэдэн хувь банкныхаа үйл ажиллагааны зардлыг нэмээд.

Х.Булгантуяа: Монголбанкнаас хүн байна уу? Хурлын тамгын газар Монголбанкнаас хүн дуудах ер нь хэрэгтэй байна. Монголбанкнаас хүн яаралтай дуудъя. Бат-Амгалан сайд нэмж хариулъя.

Э.Бат-Амгалан: Мөнхтулга гишүүнээ энэ 2025 онд бүсүүдийн хөгжлийг дэмжих тэр дундаа энэ аймаг, сумдууд дээр инженерийн шугам сүлжээ цэвэрлэх байгууламжийн асуудал гээд нийтдээ багцаараа бол нэг 167.6 тэрбум төгрөг, 2025 онд санхүүжих нь 41.1 тэрбум төгрөгийн санхүүжилттэй ажлууд хийгдээд явж байгаа.

Таны яриад байгаа энэ нөгөө 34 сум дээр гэдэг бол орон нутгийн төсвөөр хийгдэж байгаа ажлууд байх гэж ингэж ойлгож байна. Манай яаман дээр байгаа яг харьяалж байгаа гол 2 ажил хангайн бүсийн тухайд энэ Баянхонгор аймгийн Өлзийт сум дээр, Өвөрхангай аймгийн Төгрөг сум дээр сумын төвийн инженерийн дэд бүтцийн ажлууд явж байгаа гэдгийг хэлье ээ.

Х.Булгантуяа: Түрүүн Жавхлан сайд хэлж байна. Тэр хамгийн чухал асуудал бол бүх зээлийн хүүг бууруулах. Энэ төсвийн ном дээр байна. Дотоодын бараа үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 11.5 хувиар өсөж, нийт инфляцын 6 нэгж хувь буюу бараг 74 хувийг бүрдүүлж байгаа. Тэгээд хүнсний үнийн өсөлт бараг 80 орчим хувийг тэрүүн дээр талх, нарийн боов, сүү, мах махан бүтээгдэхүүний үнийн өсөлт тайлбарлаж байна гээд. Тэгэхээр энэ бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг барихад төрийн бодлогод чиглэгдэж чадах юм инфляц буурна.

Инфляц буурснаар зээлийн хүү буурах ийм боломж бололцоо бүрдэж байгаа. Тэгэхээр үүн дээрээ та бүхэн маань анхаарахгүй бол хэдүүлээ зээлийн хүү ийм өндөр байхад эдийн засаг тэлнэ гэдэг үнэхээр хүнд байгаа шүү. Уг нь санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дээр Монголбанк, Сангийн сайд, СЗХ-ны дарга суугаад энэ асуудлуудыг яг ярьж байх ёстой. Мөнгөний бодлогоо яах юм. Төсвийн бодлогоо яах юм гээд. Тэгээд уналтын үед уг нь бодлогын хүүг бууруулж мөнгөний нийлүүлэлтээ яг нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулалт хэрэглээг дэмжинэ гэсэн.

Тэгээд төсөв маань хэтэрхий их тэлээд байхаар мөнгөний бодлогод ерөөсөө зөөлрөх ямар ч орон зай байхгүй. Бодлогын хүүгээ 12 хувь дээр барина гээд Монголбанк үзэж байгаа юм байна лээ. Тэгэхээр зээлийн хүү бол ирэх онд дорвитой буух ямар ч орон зай үлдэхгүй нь байна шүү. Тэгээд Засгийн газар Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам энэ тооцооллуудаа та бүхэн маань сайн хийгээрэй. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Сүүлийн үед манай энэ Ерөнхий сайд, сайд нарын амнаас данхар төр, төрийн бүтээмжийг сайжруулна, төрийн бүтэц, орон тоог бууруулна гэж ярьж байгаа нь сайшаалтай. Гэхдээ ирэх жилийн 2026 онд нийтээр нь бүх шатад төрийн албыг 9 хувиар цомхотгоно гэж ярьж байгаа нь өөрөө бас учир дутагдалтай байна аа.

Өнөөдөр манай төрийн албыг нийтээр нь харвал үндсэндээ нэг нарийхан жижигхэн гар хөлтэй тэгээд занхайсан том толгойтой болчхоод л нэг ийм хоол тэжээлийн дутагдалтай хүүхэд шиг л болчхоод байна л даа. Тэгэхээр энэ төрийн албаны цомхотгол гэдэг юм чинь энэ дээрээсээ эхлэх ёстой юм байна л гэж харж байгаа юм. Тэрнээс төрийн анхан, дунд шатад ажилдаа түүртсэн төрийн албан хаагч нар тэр дундаа төрийн захиргааны албан тушаалтнууд л байж байна.

Тэгэхээр энэ төрийн албаны цомхотголоо энэ дээрээсээ энэ 3.5 сая хүн амтай энэ манай улсад ийм олон 16, 17 яамны хэрэг байгаа ч юм уу, үгүй ч юм уу. Хорин хэдэн сайдын хэрэг орон тоо байгаа ч юм уу, үгүй ч юм уу. Эндээсээ эхлээч гэдэг. Тэрийг дагаад олон яам агентлагууд байна. Тэгээд сайд нарын хажууд үндэсний хороо, зөвлөл гээд байна. Үгүй эндээсээ л эхэл л дээ. Энэ төрийн хэмнэлт гэж ярьж байгаа бүтцээ. Үгүй анхан шатан дээр ажилдаа түүртээд ажлынхаа ачаалалд дарагдаад байж байгаа төрийн захиргааны албан тушаалтнуудыг юуг нь цомхотгох гээд байгаа юм бэ? Тэнд чинь харин ч эсрэгээрээ хүн хүчний нөөц хэрэгтэй байгаа байхгүй юу. Энэ асуудал чинь амнаас аманд яригдахаар энэ төрийн албан хаагчдын сэтгэл зүйн маш том дарамттай байна. Анхан дунд шатад чинь төрийн албан хаагч нар чинь сэтгэл зүйн маш дарамтад орсон байна аа.

Би хэзээ цомхотголд орох бол би хэзээ халагдах бол гэж. Улсын Их Хурал сая 7 сарын 8-ны өдөр 78 дугаар тогтоол гаргасан. Төрийн үйлчилгээний байгууллагуудын энэ дахин инженерчлэлийн асуудлыг тогтоол гаргаж хийсэн. Энийг хийлгүйгээр энэ бүтэц орон тоо хийх асуудлаа түр зогсоогооч гэж би хэлэх гэж байгаа юм. Энэ Шадар сайд, Сангийн сайд, Хэрэг эрхлэх газрын сайд нарт. Энэ тогтоолоор яг өнөөдрийн Монголын төрийн байгууллагуудын бүтэц, орон тооны ажлын ачаалал, чиг үүргийн давхардлыг нарийн гаргаж ирэх ёстой юм байгаа юм. Тэгээд хаана нь магадгүй зарим агентлагуудыг агентлагаар нь татан буулгахыг үгүйсгэхгүй байгаа юм. Зарим газар нь нэг ажлыг 2 хүн хийж байгаа асуудал ч байж байгаа юм. Тэгээд энэ инженерчлэлийн, дахин инженерчлэлийн асуудлыг хийсний хүрээнд энэ бүтэц орон тоо цомхотголынхоо асуудлыг яриач ээ. Тэгэхгүйгээр зүгээр механикаар бүх шатад 9 хувийн орон тоо хийнэ гэдэг бол энэ өөрөө буруу байна шүү, буруу байна шүү.

Тийм учраас энэ 78 дугаар тогтоолын хэрэгжилтийг Учрал сайд, Бямбацогт сайд нар хэрхэн яаж хангаж байна вэ? Хэзээ яаж хийх гэж байна вэ? Энэний хүрээнд ирэх жил энэ асуудал.

Х.Булгантуяа: Учрал сайд хариулах уу?

Н.Учрал: Тийм Сандаг-Очир гишүүний би саналыг бол дэмжиж байгаа. Яагаад гэхээр энэ улсын жилийн төлөвлөгөөнд 9 хувийн хэмнэлт гэж тухайн үед батлагдсан. Тэр 9 хувийн хэмнэлт гэдэг бол бүх түвшинд зүгээр ингээд тайраад хая гэсэн үг биш шүү дээ. Бүгдээрээ 9 хувь ирнэ гэнэ. Энэ чинь ерөөсөө чиг үүргийн давхардал дээр төрийн хэмнэлт бүтээмжийн зөвлөл ажиллаад ийм чиг үүргийн давхардлууд дээр нь анализ хийсэн. Аль аль чиг үүргүүд давхцаж байна вэ гээд. Ингээд нөгөө хамтын сервис үзүүлэх буюу захиргаа ч юм уу, хуулийн ч юм уу зарим чиг үүргүүдийг бол дундаа ингээд шэйрлэх байдлаар зохион байгуулдаг олон улсын нэг ийм хэд хэдэн зөвлөмжийг авсан. Тухайн үед Хэрэг эрхлэхийн дарга байхдаа. Ингээд энэ хэмнэлт хийвэл 2.2 их наяд орчим төгрөгийн хэмнэлт хийгдэж болох юм байна гэж тооцоо гаргасан байсан.

Энэ тооцоолол дээр үндэслээд сая Занданшатарын Засгийн газар энэ 2.2 их наядын хэмнэлт хийсэн. Одоо 9 хувийн хэмнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр ямар чиг үүрэг өгч байна вэ гэхээр та нар төсөвтөө багтаагаад салбарт 9 хувийн хэмнэлтийг чиг үүргийн шинжилгээ хийгээд, чиг үүргийн давхардлыг нь арилгаад зарим үйлчилгээг төрийнхөө зарим чиг үүргийг мэргэжлийн холбоо, ТББ-д шилжүүлээд зарим үйлчилгээг аутсорсинг хэлбэрээр шилжүүлээд зохион байгуул гэдэг ийм чиглэлийг өгсөн.

Ингэснээрээ ямар нэгэн төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг бол дордуулахгүйгээр үүнийг зохион байгуулах ёстой. Тийм ч учраас ийм л хатуу байр сууриудыг хэлж байгаа. Энэ хэмнэлтийн бодлогыг нөгөө далимдуулж аймаг орон нутагт бас зүгээр ажлаа хийж байгаа хүмүүсийг халдаг субьектив байдлаар ханддаг зүйл бол ажиглагдаагүй биш ажиглагдаж байгаа. Үүнтэй холбоотой гомдлууд ч ирсэн. Тэгэхээр одоо ингээд дайны хажуугаар дажин гэж зөв явж байгаа бодлогыг нураах, зөв явж байгаа бодлогыг улс төржүүлэх, нам эвслээр нь ялгах тэгээд өөрөө субьектив байдлаар өөрийнхөө нийцдэггүй өөрийг нь шүүмжилдэг нэг хэдэн төрийн албан хаагч нарыг цомхотгоно гээд ингээд дайраад байж болохгүй ээ.

Тийм учраас үүн дээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар дээрээс бид нар ингээд шалгалт явуулна, тэгээд эхлүүлсэн. Тэгээд бид нар шалгалт явуулаад дүгнэлтийг нь гаргаад ингээд араас нь шахаж шаардаад явна гэдэг ийм бодолтой бол байгаа. Зүгээр төрийн албаны багц хуулийн шинэчлэлийг бол 3 сарын хэлэлцүүлгийг хийгээд дуусгасан байсан. Тэрийг Сандагаа гишүүн тэр хуулийг харсан байх. Паблик сервис, сивил сервис гээд 2 ангилах ёстой энэ хуулиар. Ингэж байж нийтийн эрх ашиг сонирхлын төлөө үйлчилдэг, нийтийн алба төрийн алба гэж ангилна.

Тэгэхээр төрийн эмч, төрийн багш гэж байхгүй шүү дээ. Энэ чинь нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллаж байна шүү дээ. Тийм учраас тэр 36 сарын цалин, тэр цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг хуулиар нь баталгаажуулж өгөх ёстой. Тэгж байж цаашаа ингээд явна гэж ингэж бодож байгаа. Тийм учраас үүн дээр бол тэр багш, эмч, сувилагч энэ нийгмийн салбарын ажилтнуудын эрх ашгийг огт хөндөхгүй. Тэгэхээр ингээд л Төрийн албаны хууль хийнэ гэхээр л ингээд л багш, эмч нарын асуудлыг хөндөгдөж байна гээд ингэж хөөсрүүлсээр байгаад ийм байдалд оруулчихдаг. Тэгэхээр тийм асуудал бол огт гарахгүй гэдгийг би хэлье гэж бодож байна. Тэгээд үүн дээр танд тэр чиг үүргийн шинжилгээнүүдийн талаар мэдээллүүдийг илгээе. Тэгээд одоо Мэргэжлийн холбооны хууль, энэ эдийн засгийн эрх чөлөөний хуулийг дагуулаад нөгөө бүртгэлийнх нь асуудал орж ирснээрээ бид

нар нэг энгийн зөвшөөрлийг мэргэжлийн холбоонд шилжүүлэх, зарим үйлчилгээг мэргэжлийн холбоонд шилжүүлэхийг хуулийн хүрээнд нээнэ. Ингээд л чиг үүрэг үүдийг оновчилно оо.

Х.Булгантуяа: Сандаг-Очир гишүүн нэмж тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Үгүй энэ чуулганы танхимд ярих өөр байгаа юм. Анхан шат дээрээ, дунд шат дээрээ өөр байна. Тэр чиг үүргийн давхардлыг чинь хэн хийх юм тэр байгууллагын дарга хийх юм уу. Яг хэн хийх нь тодорхойгүй байгаа. Тийм учраас субъектив байдлаар хандаж байгаа асуудлууд анхан дунд шатан дээр зөндөө байна аа. Байгууллага дотроо нэг жоохон шударга болохгүй бүтэхгүй байгаа юмыг нь хэлчихдэг улсуудаа зайлуулах арга хэлбэр болж яг хувирч байна шүү дээ өнөөдөр. Яг үнэнийг хэлэхэд энэ цомхотгол чинь. Тийм учраас ард иргэд юу хүсээд байна вэ гэхээр энэ данхар том толгойноосоо энэ цэвэрлэгээгээ хийгээч, цомхотголоо хийгээч л гэж хүсэж байгаа юм.

Тийм учраас энэ асуудал дээр энэ анхан шатад байгаа төрийн албан хаагчдыг, өнөөдөр төрийн албан хаагч нар та Цахим хөгжлийн сайд байсан мянга гаруй төрийн үйлчилгээг үзүүлдэг болсон. Гэтэл төрийн албан хаагч нарын ажил үйлчилгээний дарамт шахалт гэдэг юм уу, ачаалал буураагүй. Баахан үндэсний хөтөлбөр төлөвлөгөө төслүүдийн биелэлт тайлан гаргадаг л улсууд болчихсон. Тэрэндээ л баахан яамнаас ч тэр.

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Цахим хөгжлийн сайдаар 2 жил ажилласан. НҮБ, цахим засаглалын индексийг 28 байр урагшлуулсан шалтгаан бол 1200 үйлчилгээг цахимжуулсанд байгаа. Гэтэл цаасаа нэхсээр байгаа. Энэ дээр бид нар шахсаар л байгаа. Сая гааль дээр гээд очиход системийн хувьд бэлэн болчихсон байхад яахаараа гаалийн ахлах байцаагч 55 хүн өөрөө шийдэх цахимаар шийдэж болж байгаа юмыг заавал нэг хүн өөрөө шийдэхээр журамлаад хаячихдаг юм.

Цахимжилтыг нь хийгээд өгнө, дандаа журмаар араас нь чөдөрлөнө. Тэгэхээр цахимжилтад бол бид нар бэлэн байгаа байхгүй юу. Үүнийг яагаад дэмжихгүй байгаа юм бэ. Энэ аймаг орон нутгууд. Тэр дижитал перст гэдэг чинь цахимаар түрүүлж шийдье гээд аргаа бараад 109 хуульд өөрчлөлт оруулсан шүү дээ. Архивлаж болохгүй байна гэхээр нь цаасаар болон цахимаар аль алийг нь барим баримт бичигт тооцно оо гээд. Тэгэхээр аймаг орон нутгийн удирдлагууд цахимжилтыг бүрэн дэмжих ёстой. Үүнийг бид нар үнэлгээнд тооцно шүү. Үнэлгээнд тооцно.

Дээрээс нь аймаг орон нутгийн удирдлагууд тэр субъектив байдлаар асуудалд хандахгүй шүү. Хяналт хэрэгжүүлэх газар дээр гомдол ирж байгаа шүү.

Х.Булгантуяа: Сандаг-Очир гишүүн дахиж тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Харин тийм мянга гаруй үйлчилгээг цахимаар өгдөг болчихоод байхад төрийн албаны албан хаагчдын ажлын ачаалал буурахгүй байна гээд. Тэгэхээр яг иргэнтэйгээ тулж ажиллах тэр цаг гаргахаасаа илүүтэйгээр цаасан дээр дээд газраас агентлагаас яамнаас ирүүл гэсэн тайлан дээр их суудаг цаг заваа түүнд их зарцуулдаг болчихоод байна аа.

Тийм учраас энэ үндэсний хөтөлбөр, хөгжлийн төлөвлөгөөнийхөө тайлан мэдээнүүдийг энэ анхан шатын төрийн албан хаагч нараасаа нэхдэг байдлыг цаашдаа ер нь яах юм? Яаж цэгцэлмээр юм бэ? Тэгэхгүй бол яг иргэнтэйгээ тулж ажилладаг, тэнд цагаа зарцуулах ажил үнэхээр бага байна шүү. Компьютерын ард тайлан гаргасаар байгаад л өдрийг барж байна. Ажлын ачаалал нь тэнд л зарцуулагдаж байна. Яг иргэнтэйгээ ажиллаад байгаа юм уу гэхээр та цаашаа байж бай би ажилтай байна гээд ингээд л байж байдаг нөхцөл байдал газар дээр ийм л байна шүү дээ.

Уг нь бол иргэнийг хүлээж аваад санал хүсэлтийг нь сонсоод явж байх байтал ийм л байж байгаа. Тийм учраас энэ цомхотголын асуудлыг та бүхэн энэ.

Х.Булгантуяа: Сандаг-Очир гишүүн санал хэллээ. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Сайн байцгаана уу? Мартсанаас мал мэнд үү гэдэг шиг жил 3 сарын өмнө амлаж байсан улс төрийн намуудын амлаж ам гарч санал авч байсан заалт төсвийн талаарх заалтуудыг дахиж сануулъя. Манай нам төсвийн зарлагыг ДНБ-ий 20 хувьд хүргэж бууруулахаар, АН төсвийн зардлыг 20 хувь бууруулахаар ХҮН нам төсвийн зардлыг бодитойгоор бууруулж эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, татварын ачааллыг бууруулна, хувийн хэвшлийг дэмжинэ гэж амлаж байсан.

Тэгээд 2025 онд төсвийн зарлага маань ДНБ-ий 35 хувьтай амлаж байснаасаа 10 хувь зөрөөтэй, 2026 онд 32.2 хувь байхаар ийм төсвийн төсөл оруулж ирсэн байна аа. Тэгээд Улсын Их Хурлын ээлжит сонгууль маань 2 жил 9 сарын дараа болно шүү. Сайд дарга нар та бүхэн маань бодож болгоож байгаа биз гэж. Нарийн зүйлүүдийг Байнгын хороо болон бусад хэлэлцүүлгүүдээр асуух учир энд төсөвтөө хамт дагуулж оруулж ирсэн хууль, тогтоолын төсөлтэй холбоотой 2 асуулт байна.

Нэгдүгээрт нь нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувийн буцаалтыг үе шаттайгаар шатлалтайгаар 5, 10 хувь болгохоор ийм хуулийн төсөл оруулж ирсэн байгаа юм. Энэ өөрчлөлт нь орсноор төсөвт НӨАТ-ын орлого цэвэр дүнгээрээ 386 тэрбум төгрөг, НӨАТ-ын буцаан олголт 425 тэрбумаар нэмэгдэхээр өөрөөр хэлбэл 1 их наяд төгрөгийн НӨАТ-ын буцаан олголт олгохоор иймэрхүү тооцоо гаргасан байна. Тэгээд сүүлийн жилүүдэд энэ НӨАТ-ын өр бол бас нэлээн огцом нэмэгдэж байгаа. 2024 оны сүүлийн байдлаар харахаар 2 их наяд орчим НӨАТ-ын өртэй болсон байгаа. Энэний 70 орчим хувь нь жижиг, дунд ААН-үүд 50-аас доош ажилтантай ийм ААН-үүд байгаа. Тэгээд НӨАТ-ын энэ өр болон төлж байгаа НӨАТ-ын дүнтэй харьцуулахаар сүүлийн 3 жилд огцом нэмэгдсэнийг зүгээр нэг тоон дээр жишээ болгож хэлье. Энэ харьцаа 25 хувь байснаа, 34 хувь болж нэмэгдсэн байгаа. Өөрөөр хэлбэл ААН-үүдийн байдал эргэлтийн хөрөнгө болон ашигт ажиллагааны түвшин муудаж байгаа учраас НӨАТ-ын өр энэ өр бол тодорхой хэмжээнд ингээд нэмэгдэж байгаа иймэрхүү дүр зургууд байгаа юм.

Тэгээд санал болгосон энэ өөрчлөлтөөс харахаар энэ бол хэрэглэгчдэд ашигтай харагдаад байгаа юм. Хэрэглэгчид бол 425 тэрбум төгрөгийн НӨАТ-ын буцаан олголт ол аваад авчих юм байна нэмэгдэх юм байна. Төсөв ашигтай байгаад байгаа юм. 385 тэрбум төгрөгийн НӨАТ-ын орлого олчих юм байна. Гэхдээ энэ нь

бол яг бизнес эрхлэгчдэд бол татварын ачааллыг нэмэгдүүлсэн ийм заалт болохоор харагдаад байна аа. Тэгэхээр энэ НӨАТ-ын буцаан олголтыг болиулаад НӨАТ-ын энэ 10 хувийгаа бууруулах бүгдээрээ нийтээрээ татвар төлдөг байх ийм санааг саналыг бол ААН-үүд гаргаад байгаа.

Тэгэхээр энэ чиглэлээр тооцоо хийж үзсэн үү. Тэгээд өмнө ч гэсэн өнгөрсөн оны шинэ жилээр Ерөнхий сайд, иргэд ААН-ийн санал дээр үндэслээд татвар, нийгмийн даатгалын.

Х.Булгантуяа: Хэн хариулах уу? Жавхлан сайд та эхлээд хариулах уу? Тэгээд ажлын хэсгээс нэмж хариулъя. Их чухал асуудал хөндөж байна Энхтүвшин гишүүн. Жавхлан сайдын микрофон.

Б.Жавхлан: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя аа. Тийм ээ, бид НӨАТ, хувь хүний орлогын албан татвар, ААН-ийн орлого дотор татварын багц хуулиуд дээр нэлээд томоохон. Ер нь нэгд өмнө нь татварын шинэчлэлээр хийж байгаагүй олон параметруудийг хөдөлгөхөөр ингэж зорьж байгаа. Хамгийн их хүлээлттэй байгаа НӨАТ-аасаа эхэлж байгаа. Тэр дундаа буцаан олголтыг 2-оос 5 хувь, тэрнээс биш 10-ыг 5 болгодог ч юм уу, эсвэл бүх ялгаагүй 2-ыг 5 болгодог ч юм уу ингэж болохгүй ээ.

Тэгэхээр энэ нөгөө орлогын тэгш бус байдлыг улам гааруулсан ийм буруу алхам болно. Бид Шри Ланкын араас орно. Тийм учраас шаталсан байдлаар явж байгаа. Энийг бол та өмнө нь их сайн ойлгоод дэмжиж байсан. Энэ удаа ч гэсэн дэмжинэ байх гээд итгэж байна. НӨАТ-ын өрийг асуусан. Тэр тоонуудыг манай татварынхан хэлээдэх дээ. Бусдыг нь өөр сайд нар хариулах уу?

Х.Булгантуяа: Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

Д.Энхтүвшин: Нэг тодруулж асууж чадаагүй нэг асуулт. Энэ Тавантолгойн ордын ашиглагдаагүй хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулж, олборлолт, тээвэрлэлт, экспортыг цогцоор гүйцэтгүүлэх гэрээ хийх ийм Улсын Их Хурлын тогтоол оруулж ирсэн юм байна. Тэгэхээр энэ нөгөө яригдаад байгаа Чайна Энержитэй холбоотой гэрээний асуудал байна уу? Эсвэл дахиад шинээр олборлолт хийх гэж байгаа ийм асуудал байна уу? Нөгөө муу л бол хойд талын хар овоохой гэдэг шиг мөнгө л хэрэгтэй бол урд талын хар уурхайгаар л ордог болж байна аа. Тэгээд энэ талаар тодруулга өгөөч.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тийм Энхтүвшин гишүүн ээ тэр чинь нөгөө ашиглагдаагүй байгаа гэж байгаа учраас нөгөө Чайна Энержид хамаагүй болоод явчхаж байгаа байхгүй юу. Нэгэнт хэдүүлээ бүх хамаг юмаа тавиад ийшээ дэд бүтцүүдээ татчихсан, хилийн нэвтрэн өнгөрүүлэхийг нь тэрэндээ бүр зориулаад ингээд бид томсгочихсон байгаа үед бүрэн дайчилж энийгээ эргэлтэд оруулъя л гэж байгаа юм. Бид нар ерөөсөө хөндөж чадаагүй тэгэхдээ тэнд нь асар их нөөц байгаа маш их талбайнууд байгаа. Тэрийгээ ил тод үр өгөөжтэй байдлаар эргэлтэд оруулъя. Ер нь нүүрс дээр бидэнд маш богино хугацаа байгаа шүү. Маш богино хугацаа байгаа. Ялангуяа эрчим хүчний нүүрс дээр бол нэг цаад талын хугацаа нэг 10 жилийн л боломж байгаа. Тэрнээс цааш бид нар тултал боловсруулахгүй бол ингээд бидний нүүрс маань баялаг биш болж ингэж үлдэнэ ээ.

Тийм учраас энэ богино хугацаагаа бүгдээрээ дайчилъя л гэж байгаа юм. Ажил хийе л гэж байгаа юм.

Х.Булгантуяа: Энхтүвшин гишүүн нэмж тодруулна.

Д.Энхтүвшин: Манай экспорт коксжих нүүрс чинь коксжих байгаа. Тэгэхээр энэ ашиглах хугацаа богино шүү гэж ярихаа болимоор байна Жавхаа сайд аа. Энийг бид экспортод коксжих нүүрс байгаа. Тэгээд энэ дахиад хэдэн тонны асуудал яригдаж байна. Чайна Энержитэй энэ ерөөсөө зах зээлийн бодлогогүй яваад байхгүй юу. Нэг хямдхан өгөөд л. Тэгээд энэ жишээлбэл тээвэр нь орно, уурхай нь орно гэдэг дахиад л яг Чайна энержитэй адилхан ийм асуудал орж ирэх гээд байна. Тэгэхээр энэ ямар хэдэн тонны асуудал хэдэн долларын асуудал яригдаад байгаа юм бэ? Тэгээд энэ борлуулалтын зах зээл дээр чинь хоорондоо үнүүд чинь өрсөлдөөд энэ бид нарт худалдааны компаниуд зарж байна. Ихийг гаргах тусам Монголын нүүрсүүд чинь хоорондоо өрсөлдөөд байгаа юм. Нэг компанид хөнгөлөлттэй өглөө гэхэд тэр үнэ чинь бусад нүүрсэндээ нөлөөлөөд байна.

Тэгэхээр бид нар энэ үнэд хүрэх зорилго байгаа юм уу? Зүгээр л ямар ч хамаагүй үнээр ингэж аль ч хамаагүй амыг нээж ингээд зарах гээд байгаа юм уу энэ жоохон сонин сонсогдоод байна л даа.

Х.Булгантуяа: Энхтүвшин гишүүн үг хэллээ. Хэн хариулах вэ? Жавхлан сайд хариулах уу? Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Энэ Тавантолгойн бүлэг орд маань өөрөө 5 тэрбумын нөөцтэй шүү дээ. Тэгэхээр бид нарын хөндөж чадаж байгаа нь бол нэгээхэн хэсэг нь байгаа 10.1-д нь ч хүрэхгүй. Тэгэхээр цаана нь хөндөж чадаагүй байгаа тэр хэсэг рүүгээ л эргэлтэд оруулъя л гэж байгаа ийм л зорилго шүү. Одоо яг манай энэ Уул уурхайн сайд байсан бол илүү их тодорхой мэргэжлийн хариулах байх аа. Ер нь ойрын хугацаанд хэдүүлээ энийгээ нэлээн өргөн фронтоор эргэлтэд оруулъя л гэж байгаа юм.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг.

М.Энхцэцэг: Сайн байцаана уу та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Ингээд 2026 оны улсын төсөв дээр эрчим хүчний салбарт анхаарал хандуулаагүй байна гэж хэлмээр байна аа. Яагаад гээд тэгэхээр эрчим хүчний салбар нь нөгөө л зам тээврийн салбараасаа бага төсөвтэй. Нэг эрчим хүчний салбарт 300 гаран тэрбум төгрөгийн төсөв, гэтэл нөгөө зам тээврийн төсөв нь бараг л 1 тэрбумын төсөвтэй. Гэтэл эрчим хүчний салбар өнөөдөр улс орны нийгэм эдийн засгийг боомилчхоод байгаа ганц салбар гэдгийг хүн болгон бараг биеэрээ мэдрээд байгаа, яриад байгаа. Өнөөдөр бид нар үйлдвэрээ барья, орон сууцаа барья гэсэн маш олон хэрэглэгчдийг цахилгаан дулаанаар хангаж чадахгүй байна. Насжилтын хугацаа дууссан тэр 60, 70 настай тоноглолууд нь эхнээсээ гэмтэж дэлбэрч эхлээд байна.

Энэ эрчим хүчний салбарын 17 мянган ажилчдыг бид нар аюулгүй найдвартай эрүүл орчинд ажиллуулж чадахгүй байна. Тийм ч учраас ард түмэн тэр гал алдчих гээд байгаа эрчим хүчний салбартаа нэг ахиухан төсөв тавиарай гээд

захиад байгаа. Тийм ч учраас ард түмэн бид нарт асфальтан зам хэрэггүй нэг асаалттай гэрэлтэй баймаар байна гээд захиад байгаа юм. Гэтэл хаана байна тэр захиасын биелэлт. Тэгээд захиасыг нь биелүүлэхгүй юм ард түмнээсээ асуулаа гэж шоудах ямар хэрэгтэй юм бэ? Тэгээд төсөв дээрээ олигтой мөнгө тавиагүй мөртөө эрчим хүчний салбарт 3.9 их наядыг ирэх онд зарцуулна. Эрчим хүчний салбарын хамаг асуудлыг шийднэ гээд ингээд худал мэдээлэл тараагаад байгаа. Би энийг худал мэдээлэл гэж хэлнэ. Яагаад гэхээр энэ 3.9 их наяд гэдэг нь тэр өмнөх жилүүдэд хэрэгжүүлж эхэлсэн бүхий л зээл тусламжийг хамж шимээд дээрээс нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа станцын 2.5 тэрбумыг оруулаад ингээд бид бүхэн сайхан болгочихно оо гээд хуураад байгаа.

Тэгэхээр бид нар ард түмэндээ үнэнээ л хэлэх ёстой. Тийм ээ бид нар өнөөдөр та бүхний татварын мөнгийг, төсвийн мөнгийг эрчим хүчинд олигтой төсөвлөж чадахгүй байна. Энэ бодит байдал. Та бүхэн минь тэр лаа чүдэнзээ ойрхон байлгаарай гээд үнэнээ л хэлэх ёстой. Тэгээд одоо мэргэжлийн байгууллагаас нь ЭХЯ-аас нь энэ энэ ажлуудыг хийхгүй бол энэ салбар болохоо байлаа шүү гээд ирүүлдэг. Сангийн яам нь зургаахан төслийг тавиад л бусдыг нь бүгдийг нь хасчихдаг. Тэгэхээр ийм байхад чинь яаж эрчим хүчний салбар өмнөө байгаа үй түмэн асуудлаа шийдээд, хэрэглэгчээ цахилгаан дулаанаар хангаад өвөл хөлдөөчихгүй байх юм бэ. Энэ дээр ингээд нэг хариулт өгөөч.

Ядаж бид нар шугам сүлжээндээ ядаж бид нар тэр гэрэл нь ёлтойчхоод аяга цайгаа буцалгаад уучих тийм гэрэлгүй байгаа хүмүүсийн асуудлыг шийдэхэд төсвөө зарцуулах ёстой шүү дээ. Яагаад гэвэл энэ төсвийг, энэ татварыг миний анхан шатны хэрэглээг шийдээд өгөөрэй гээд тушаасан байхгүй юу даа. Тэгэхээр гэрэл, тэгэхээр дулаан гэдэг анхан шатны хэрэглээ байхгүй юу даа.

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулах уу? Жавхлан сайд гээд таны нэрийг бүүр дурдаад асуусан байхгүй юу? Сая. Жавхлан сайд яагаад энэ төсвийг нь тавьсангүй вэ? Яамнаас явуулсан саналаас ихэнхийг нь хасчихжээ Жавхлан сайд аа гэж асуусан байхгүй юу. Тэгээд араас нь Эрчим хүчний сайд нэмээд хариулъя.

Б.Жавхлан: Манай Чойжилсүрэн сайд асуултыг нь бэлдэж өгсөн юм шиг байна. Тийм ер нь манай бүх сайд нар дээр төсөв нь хасагдсан шүү дээ. Ганцхан Чойжилсүрэн сайд биш. Одоо бид нар энэ хязгаар дотроо л багтаж амьдарна шүү дээ. Улсын Их Хурал дээрээс төлөвлөгөө гаргаж өгөөд 24 хувьдаа багтаа гэхихсэн байгаа. 28 хувь байсныг бид нар 24 хувьд багтааж байгаа. Бүгд л хасагдсан байгаа. Бүгд л танаж энэ дотроо л багтаж амьдарна. Энийгээ харин яаж үр өгөөжтэй үр ашигтай байдлаар яаж зарцуулах вэ гэдэг бол салбарын сайдын ухаан, сэтгэл 2 л шийднэ.

Х.Булгантуяа: Чойжилсүрэн сайд нэмж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Гишүүний асуултад хариулъя аа. Энхцэцэг гишүүн манай эрчим хүчний салбарын хүн учраас салбарын бодит байдал хүндрэлийг сайн мэдэж байгаа юм. Шүүмжлэл нь ч ортой. Арга байхгүй хүндэрчихсэн нөхцөл байдалд манай эрчим хүчний салбарын хуулийг Их Хурал дээр шинээр бичих ажлын хэсгийн ахлагч хийж байгаа бодит байдлыг бүгдийг нь мэдэж байгаа учраас яг олон нийтийн дунд бодит байдал, салбар дээр байгаа бодит байдлыг л олон нийтэд хэлж байгаа учраас таны энэ шүүмжлэлийг хүлээж авахаас ондоо арга байхгүй байгаа. Орон зай боломж нь л байна. Сангийн яам өгсөн хэмжээ нь л байна.

Х.Булгантуяа: Энхцэцэг гишүүн нэмж тодруулна.

М.Энхцэцэг: Тэгээд 1 асуулт байна л даа. Та бүхэн мэдэж байгаа ДЦС 4 гэдэг бол манай хамгийн хямдхан цахилгааныг үйлдвэрлэдэг ганц эх үүсвэр. Тэгэхээр энэ эх үүсвэрийг 500 тонн цагаар өргөтгөөд олон мянган айл өрхүүдийг ААН-үүдийг хямд цахилгаанаар хангая гэдэг ийм төслийг бид нар олон жил ярьж байгаа. Энэ манай намын хөтөлбөр дээр байгаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр байгаа. Тэгэхээр энийг одоо энэ маш үр ашигтай төслийг хэрэгжүүлэхэд ядаж энэ жилийнхээ төсөв дээр нэг 50, 60 тэрбум тавиад энэ ажлыг эхлүүлээч гэж Сангийн сайдаас бүүр ёстой тусгайлан гуйж байна. Энийг ард түмний өмнөөс гуйж байна аа. Яагаад гэвэл ард түмнийг бид нар асаалттай гэрэлтэй байлгах, хямд цахилгаанаар хангах нь бид нарын амин чухал асуудал. Тэрнээс биш асфальтан зам бол бид нарын амин чухал асуудал биш байхгүй юу.

Асфальтан зам дээр асгасан мөнгө алга болно. ДЦС-ыг өргөтгөх мөнгийг бид нар 4-өөс 5 жилийн дотор буцаагаад олж байх тийм үр ашигтай.

Х.Булгантуяа: Энхцэцэг гишүүн үг хэллээ. Хариулт авах уу? Хэнээс хариулт авах юм. Жавхлан сайдаас хариулт авмаар байна гэж байна.

Б.Жавхлан: Энэ тийм маазрах асуудал биш шүү. Та энэ төсвөө их сайн эргүүлж тойруулж хараарай. Энэ удаагийн төсөв ч тэр, өмнөх жилүүдийг ч тэр байгаа бид бүх эх үүсвэр боломжит хөрөнгөө энэ салбарт зориулж байгаа юм. Урсгал зардал дээрээ ч тэр хөрөнгө оруулалт дээрээ ч тэр. Одоо бид тарифаа либералчлах гээд Засгийн газар нэлээн том галтай асуудал руу зорьж орсон. Та энэ асуудлыг уг нь нэг манлайлаад өөрөө явмаар байгаа байхгүй юу. Яг энэ галтай юм руугаа орохгүй зүгээр мөнгө нэхээд байх юм. Хамгийн том асуудал чинь энэ тариф шүү дээ. Бид нар 30 жил энэ тарифыг чинь чанга барьчихсан учраас өнөөдөр ийм байдалд хүрчихсэн байгаа. Юу юугүй бүгд зогсоход бэлэн болчихсон улайсчихсан мотор шиг ийм болчихсон байгаа шүү дээ. Гол асуудал ерөөсөө л тариф байгаа. Бид тарифаа хөнгөлж чадаагүй.

Х.Булгантуяа: Энхцэцэг гишүүн нэмж тодруулна.

М.Энхцэцэг: Тэгэхээр ямар ч байсан хямд цахилгаанаар хэрэглэгчээ хангахгүй гэж байгаа юм байна. Энэ төслийг хэрэгжүүлэхгүй гэж байгаа юм байна гэж ингэж ойлголоо.

Дараагийн нэг асуулт байна л даа. Юу вэ гэхээр та бүхэн мэднэ. Бид нар хэрэглэгчийн оройны цахилгаан, шөнийн цахилгааныг хөнгөлдөг. Тэгэхээр түгээх компани нь бол хэрэглэгчээ хөнгөлөөд явж байгаа. Гэтэл бид нар нөгөө талдаа энэ хөнгөлөлтийг төсөв дээрээ суулгах ёстой. Тэгэхээр одоо хуримтлагдсан байдлаар 8 тэрбум төгрөгийг төсөв дээр суулгах ёстой байсан ард иргэдийн хөнгөлөлтийг үзүүлэх ёстой байсан бас суулгаагүй хасчихсан гэсэн. Тэгэхээр ирэх онуудад хэрэглэгчийн цахилгааны хөнгөлөлтийг үзүүлэхгүй гэж байгаа юм уу, эсвэл одоо тэр зарчмын зөрөөтэй санал гаргаад тэр 8 тэрбумыг нь тусгаач гэж хэлье ээ. Энэ дээр бас хариулт авъя аа.

Х.Булгантуяа: Жавхлан сайд, Чойжилсүрэн сайд. 8 тэрбум төгрөг.

Б.Чойжилсүрэн: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Бид Сангийн яаманд бол эрчим хүчний шөнийн тарифын хөнгөлөлтөд 104 тэрбум төгрөгийн татаас гаргах нь гэдэг ийм хүсэлт танилцуулгыг хүргүүлсэн. Төсвийн бололцоо маань дахиад л хэлэхэд төсвийн орон зай бага байгаа учраас 81 тэрбум төгрөг буюу энэ жилийнх нь түвшинд хянасан. Цаадах үлдэж байгаа 30 хэдэн тэрбум бол үнэндээ шийдэлгүй байгаа. Энэ асуудлыг эсвэл тариф нэмэх ганц л асуудал бий. Энэ талаар бас 2025 оныг дуустал цахилгаан дуны дулааны үнийг нэмэхгүй гэдэг Засгийн газрын шийдвэр гарчихсан байгаа учраас энэ оны төгсгөлд ирэх оны эхэнд энэ асуудал яригдах байх гэж бодож байна.

Хоёрдугаарт Засгийн газар улсын төсвийг өргөн барьчихсан. Одоо шийдвэр гаргах батлах эрх Их Хурал дээр байгаа учраас ажлын хэсгийн түвшинд энэ саналыг та гаргах бололцоотой. Би Засгийн газрын гишүүний хувьд Их Хурал дээр нэмж санал гаргах эрхгүй.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал.

Ж.Золжаргал: Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдтэй холбоотой нэг багц асуудлууд байна. Тэгээд боловсрол дээр. Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцын төслийн зарцуулалтын 30 хувь санхүүжилт нь гарсан, гүйцэтгэл нь 18 хувь гэсэн байгаа. Төсөв бараг 3-ны 1 нь гарчихсан байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр чинь өртөг нэмэгдэх эрсдэлд нөгөө газрын тос шиг юм үүсээд байна уу? Энэ ямар учиртай юм болоо гэж.

Хоёрдугаарт нь дүүжин тээвэр гээд нэг гайхамшигтай төсөл байдаг. 2028 хувийн санхүүжилт нь гарчихсан. Тэгээд энэ бараг л дахиад л хориод хувь, гучаад хувийн 3-ны 1-ийн зардал нь гарчихсан. Хаана юу хийх гээд байгаа юм бол энэ чинь зөндөө их мөнгө байна шүү дээ 60 сая еврогоос.

Гурав дахь нь хилийн үр ашгийг нэмэгдүүлэх АХБ-ны 100 сая долларын зээл. Дорнодын Хавиргын боомт, Баян-Өлгийн Цагаан нуур, Ховдын Булган боомт. 0.3 хувийн санхүүжилттэй. Монгол Улсын гадаад худалдаанд хамгийн чухал төсөл болохоор ерөөсөө явдаггүй. Энэ яагаад явдаггүй юм бол.

Дөрөвт нь тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл гээд байгаа АХБ-ны. Тэгээд энэ дээр их олон юм байгаагийн нэг нь Хөвсгөл нуурын эрэг дээр байдаг зам. Зун манайхан тийшээ явдаг бол нэг там шиг зам байдаг юм шүү дээ. Аймаар болчихсон. Тэгээд 7 км хэдэн жил яваад долоохон километр. Ерөөсөө явдаггүй. Энийг яана гэдэг ийм асуулт.

Тэгээд 5 дахь нь Улаанбаатар хотын ногоон орон сууцын төсөл гэж бий АХБ-ны Баянхошуунд хэрэгжиж байгаа. 5 мянган айлын гэр хороололд орон сууцын төсөл. Энэ ОУБ дээр би өөрөө зөвлөхөөр зөвлөх инженерээр төлөвлөлтийнх нь үед нь ажиллаж байсан юм. Дөнгөж нэг загвар хэдэн байрнууд баригдсан байгаа. Тэгээд энэний явцыг 53 хувь гэсэн байгаа юм. Санхүүжилт нь 14 хувь. 53 хувь гэдэг чинь одоо 2500 айлын байшин юм уу энэ ямар учиртай юм бол оо гэдэг ийм асуултууд байна.

Боловсролын хувьд энэ жил хөрөнгө оруулалт их сайн нэмэгдсэн гэсэн. Тэгэхдээ ямар эрэмбэ дарааллаар хуваарилсан юм бэ? Хүн амын нягтрал хамгийн өндөртэй БГД-ийн зарим хороонуудад ерөөсөө улсын цэцэрлэг сургууль огт байхгүй

газрууд дээр судалгаа хийгээд бид нар 19 хороод, , сургууль зайлшгүй хэрэгтэй юм гэж гаргаад саналуудыг өгсөн. Тэгээд одоогоор яах вэ Алтай хотхоны цэцэрлэг, 7 дугаар хорооны цэцэрлэг, нөгөө Эрин хорооллын сургуулийн барилгыг худалдаж авах асуудал, 13 дугаар хорооллын сургуулийн өргөтгөл гээд хорооллын эцсийн гэр хорооллын хүүхдүүд ялангуяа хойноосоо орж ирээд багтдаггүй. Ийм 4 объект туссан байгаа юм. Нөгөө 19-өөс энэ 4 нь л туссан байна. Тэгэхээр хөрөнгө оруулалт бол 1.3 их наяд боловсролд болсон гээд. Энийг ямар ач холбогдлоор ямар эрэмбээр хуваарилсан юм бэ гэж асууя.

Х.Булгантуяа: Чойжилсүрэн сайд эхлээд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын урьдчилгаа төлбөр банкны баталгаа гаргасны дагуу олгосон. 2029 он гэхэд ашиглалтад оруулахын тулд энэ гүйцэтгэгч компани маань тоног төхөөрөмжөө захиалах гэх мэт ийм зүйлд зарцуулсан. Ирэх 7 хоногт бид нар дахиад энэ гүйцэтгэлийн явц, ажлын явцын талаар, энэ урьдчилгаа төлбөрийг ямар ямар зүйлд зарцуулсан талаар тайланг нь авахаар ийм тооцоололтой байгаа.

Х.Булгантуяа: Дүүжин тээвэр. Нийслэлээс хүн байхгүй байна. Тэгэхээр хэн нэг нь хариулах хэрэгтэй. Нэгэнт улсын төсөв дээр тавиад хэрэгжиж байгаа юм чинь 4 номер. Ажлын хэсгийн микрофон.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад хариулъя Дэлгэржаргал.

Таны дурдсан төслүүдээс Эрдэнэбүрэнгийн УЦС-ын хувьд бол Бүгд Найрамдах Хятад Ард улсын Эксим банкны нэн хөнгөлөлттэй зээл. Энэ жил 30 хувийн урьдчилгаа 271 тэрбумыг бид нар гэрээний дагуу төлсөн. Ирэх онуудын ашиглалтын хувьд бол 90 тэрбум төгрөгийг ашиглалтад гаргахаар төлөвлөж байгаа.

Хоёрт нь дүүжин тээврийн хувьд бол Францын нэн хөнгөлөлттэй зээл 60.1 сая евро. 2 шугам байгаа. Эхний шугам бол яг Францтай тохирсноороо эхний шугамыг 2027 онд ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа. Энэ дээр мөн гүйцэтгэлийн дагуу ашиглалтууд нь гараад явж байгаа. Яармагаас Хархорин чиглэлийн 98 кабинтай энэ жил бол яг угсралтын ажлууд эхэлчихсэн.

Хоёр дахь нь хилийн үйлчилгээг сайжруулах төсөл бол АХБ-ны нэн хөнгөлөлттэй зээлээр боомтууд дээр 2 төсөл хэрэгжиж байгаа. Эхний 5 боомтын бүтээн байгуулалтууд бол Замын-Үүд Гашуун сухайт гээд дууссан. Ирэх жил Хавирга.

Х.Булгантуяа: 4 номер нэмж хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Хавирга Булган гэсэн боомтууд энэ дээр төлөвлөгдөөд явж байгаа. Гүйцэтгэлийн хувьд 5 хувь байгаа нь яг зээлийн ашиглалт. Дүүжин тээвэр дээр яг 2027 онд дуусна. Эхний шугам нь.

Х.Булгантуяа: Бат-Амгалан сайд нэмж хариулъя.

Э.Бат-Амгалан: Золжаргал гишүүний асуултад хариулъя аа.

Энэ таны асуусан тэр Баянхошуунд 5 мянган айлын орон сууц гэдэг маань нийтдээ Улаанбаатар хотын хэмжээнд 6 дэд төв байгаа. Энэ 6 дэд төвийг түшиглээд АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр баригдаж байгаа ийм асуудал. Үндсэн гол хэрэгжүүлэгч нь бол нийслэл байгаа. Энд нийслэлийн удирдлагууд хүмүүсээр хариулах байх. Ер нь зүгээр Баянхошуун дээр эхний ээлжийн Баянхошуу дэд төвийг түшиглэсэн 110 айлын ногоон орон сууц ашиглалтад орчихсон.

Дараагийн дэд төвүүд дээр одоо орон сууцын, ногоон орон сууцын асуудлууд бас төсөл нь хэрэгжиж эхэлж байгаа. Ийм учиртай юм байгаа юм. Үндсэн хэрэгжүүлэгч нь бол нийслэл байгаа шүү.

Х.Булгантуяа: Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Золжаргал гишүүний асуултад хариулъя аа.

Ер нь энэ жил замын салбарт бол нэлээн их мөнгө байгаа гэж сая Энхцэцэг гишүүн маань ярьж байна. Тэгээд замаар яах юм бэ гээд. Энэ 951 тэрбум төгрөгийн ихэнх нь өнгөрсөн жилийн ажлыг дуусгах гэж тавьсан мөнгө байгаа юм аа. Энэ жилийн хувьд бол зам тээврийн салбарт ердөө гуравхан замын л асуудал байгаа. Түүний нэг нь сая Золжаргал гишүүний асууж байгаа Хөвсгөлийн зүүн эргээр Моондын боомт хүртэлх энэ замыг бид барихаар оруулсан байгаа. Ингэж байж нэг талаасаа аялал жуулчлал, нөгөө талаасаа боомт холбох гэсэн ийм бодлого барьж байгаа гэдгийг хэлье ээ. Баярлалаа.

Х.Булгантуяа: Энхцэцэг гишүүний хэлээд байгаа асуудал бас та бүгдийн шинэ хөрөнгө оруулалт гээд далдугаар хуудсан дээр байгаа дээр эрчим хүч шинэ хөрөнгө оруулалтын 5 хувь 51.7 тэрбум төгрөг. Коп 20 хувь 217.1 тэрбум төгрөг, авто зам 10 хувь 108 тэрбум төгрөг. Шинэ хөрөнгө оруулалт нь шүү.

Ингээд ХЗДХ 6 хувь 68.3 хувь, ингээд цахим шинэчлэлээс хүртэл хойгуур явж байгаа юм байна. Эрэмбийн хувьд бол. 67.9 тэрбум төгрөг буюу 6 хувь цахим шинэчлэл дээр. Төрийн байгууллагуудын их засвар, тоног төхөөрөмж дээр гэхэд 53.4 тэрбум төгрөг буюу 5 хувь яг ингээд эрчим хүчнээс ч илүү төсвийг төрийн байгуулалтын их засвар тоног төхөөрөмж дээр. Тэгээд энүүн дээр л Энхцэцэг гишүүн бухимдаад байгаа байхгүй юу. Эрчим хүчний асуудал чинь хүнд байгаа юм биш үү? Энэ хүний сэтгэл нь байгаад, ухаан нь байгаад ч тэгээд мөнгө нь байхгүй бол эрчим хүчний салбараар сэтгэлээр хийдэг ажил ч биш байх л даа.

Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Энэ жилийн зам тээврийн салбарт тавьсан 108 тэрбумын шинэ хөрөнгө оруулалт бол ийм байгаа шүү. Ялангуяа нэг 40 орчим тэрбум төгрөг нь бид энэ Улаанбаатараас энэ төмөр замыг гаргахтай холбогдуулаад Хөшигтийн хөндийгөөс Төв аймгийн замыг 4 эгнээ болгох энэ төсөлд орж байгаа юм нь 40 тэрбум. Үлдсэн нь бол ихэнх нь их засвар байгаа. Тэрнээс өөр нэг их тийм илүү дутуу тавигдсан мөнгө байхгүй. Ер нь бол манай зам насжилт өндөр болсон дээр нь замын урт нэмэгдсэн. Бид цаашдаа энэ Засгийн газар дээрээ яриад замуудаа хувьчлах уу, ер нь цаашдаа замын засвараа яаж хийх вэ гэдэг ийм бодлого барьж байгаа гэдгийг энэ ташрамд хэлье. Засвар үнэхээр хүнд байгаа. Ялангуяа манай

Өмнөговь, Дундговийн замын засвар нэлээдгүй их мөнгө шаардаж байгаа. Энэ жил 44 тэрбум.

Х.Булгантуяа: Наранбаяр сайд микрофон.

П.Наранбаяр: Золжаргал гишүүний асуултад хариулъя аа. Тэгэхээр БГД бол үнэхээрийн хүн ам нягтаршил өндөртэй ийм дүүрэг. Энэ дээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар та 4 төслийг хэллээ. Үүн дээр нэмэх нь АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр бол 960 суудалтай сургуулийн барилга 10 дугаар хороон дээр, сургуулийн өргөтгөлийн барилга 320 суудалтай. БГД-ийн 18 дугаар хорооны Оюуны ундраа цогцолбор сургууль гэж ингэж орж ирж байгаа юм. Ямар байдлаар эрэмбэлдэг вэ гэхээрээ 1 дүгээрт бол улсын төсвийн хөрөнгө оруулалт нь ачаалал өндөртэй, зураг төсөв магадлалаар баталгаажсан байх. Хүүхдийн өсөлт, анги дүүргэлт гэх зэрэг ийм хүчин зүйлүүдийг тэгээд тооцож үзээд хүчин чадлыг нэмэгдүүлэх энэ шаардлагыг хангах ийм шалгуурыг оруулдаг. Түүний зэрэгцээ бид АХБ-нд газар зүйн мэдээллийн системээр хэрэгцээ шаардлага нь тодорхойлогдсон 108.

Х.Булгантуяа: Наранбаяр сайд нэмээд дуусгая.

П.Наранбаяр: 108 сургууль, 95 цэцэрлэгийн байршилд хамаарагдсан төсөл арга хэмжээг хамруулж байгаа гэдгийг тайлбарлаж хэлье. Юуны хувьд бол эдгээр энэ жил АХБ-ны шугамаар 41 төсөл арга хэмжээ хамрагдсанаас ингээд 2 нь БГД дээр тавигдсан байгаа юм аа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тийм Золоо гишүүний асуултад хариулъя аа.

АХБ-ны зээлээр манай энэ хойд талын хэдэн боомтууд урд талын Замын-Үүд боомтууд маш сайхан бүтээн байгуулалтууд хийсэн шүү. Энийгээ бас нэг тойроод үзчихвэл их сайхан болсон байгаа. Сая хэдхэн хоногийн өмнө 14 хоногийн өмнө бид хамгийн сүүлд Алтанбулагынхаа боомтын шинэчлэлийг бүрэн дуусгаад нийллээ. Мөн АХБ-ны зээлээр байгаа Боршоо боомт 28 тэрбум, Алтанбулаг 51 тэрбум, Замын-Үүд 161 тэрбум, Гашуунсухайт 100 тэрбум төгрөгөөр тус тус хийгдээд бүрэн дуусчихсан байгаа. Бичигт гэхэд 25 хувьтай явж байна. Цагаан нуур 118 тэрбумтай, АХБ-аар эхэлж байна. Булган 114 тэрбумын төсөвтэй мөн эхэлж байгаа. Хавирга 82.9 тэрбум АХБ-ны мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ингээд эхлээд бүтээн байгуулалтын ажил бол маш сайн явж байгаа гэдгийг хэлье ээ.

Тэр 0.3 гээд тэр манай ажлын хэсгээс хариулаадхаач.

Х.Булгантуяа: 4 номер ажлын хэсгийн микрофон.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад хариулъя Дэлгэржаргал.

Гүйцэтгэлийн хувьд буюу одоо гадаад зээлийнхээ яг энэ жилийн дүнгийнхээ хувьд 0.3 хувийн ашиглалттай явж байна гэсэн үг. Тэгэхээр түрүүний хэлсэн боомтуудад энэ жил яг бүтээн байгуулалт нь буюу яг сонгон шалгаруулалт нь яваад ирэх жил яг ашиглалт бүтээн байгуулалтууд нь цаашаа үргэлжлээд гарахаар байгаа. Ашиглалтын дүнгийн хувьд 0.3 хувь.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Номин.

Ч.Номин: Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би Ерөнхий сайдаас асуух гэж байлаа. Тэгээд байхгүй байгаа учраас Эдийн засаг хөгжлийн сайд, Сангийн сайдаас асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт, бид нар өнөөдөр 1.3 их наядын алдагдалтай төсөв баталж байна. Бид юу ч гэж алтан малгай өмсгөсөн энэ алдагдлаа гадаад өр зээлээр санхүүжүүлнэ. Ингээд Засгийн газрын өр улам нэмэгдэж байгаа. Яг энэ үед олон улсын нөхцөл байдал сайжраагүй хэвээрээ байгаа. Тэгвэл одоо бид нар төсвийн орлого энэ хэлээд төсөвлөөд байгаа 31 их наяддаа хүрэхгүй бол яах юм бэ сайд нар энийг анхаарч хариулж өгөөч ээ.

Цаашлаад Хятад тал нүүрсний худалдан авалт 13 хувиар өнөөдрийн байдалд буурчихсан байна. Дэлхийн хэмжээнд шүү. Дахиад цаашлаад мөн буурахаар байна гэдгийг Дэлхийн эрчим хүчний агентлагаас мэдэгдээд байна аа. Өшөө ч буурна гэж байна. Мөн үүнээс гадна Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн Энхбаяр эдийн засагч өөрөө манай экспортолж байгаа нүүрсний бодит хэмжээ 70 сая тонноос нэмэгдэхгүй. Ийм магадлал өндөр байна гээд хэлсэн. Үүнээс гадна Сангийн сайд өчигдөр өөрөө үнэнд их найдахгүй байна гэсэн. Ингээд үзэхээр бид нар дунджаар 1 их наяд төгрөгийн орлого тасрах магадлалтай байна аа. Энэ тохиолдолд бид нар яах вэ? 1 дүгээр асуулт энэ байна.

Хоёрдугаар асуулт өнөөдөр татварт дансаа хаалгасан 16 мянган ААН-үүд байгаа. Манай Ерөнхий сайдын хувьд бол бизнесээ дэмжинэ, ААН-үүдээ дэмжинэ, чөлөөт эдийн засгийг дэмжинэ цаашид ААН-үүдийн дансыг хаахгүй гэсэн. Энэ ААН-үүдийн данс хаахгүй ажиллагаа хэзээнээс эхлэх вэ? Мөн энэ хаалттай байгаа 16 мянган ААН-ийн дансыг ямар зохицуулалтаар хэзээ нээх вэ? Та бүхэн яг өдөр хоног хэлээд өгөөч ээ. Эдгээр ААН-үүд бол өнөөдөр ийм дансаа хаалгачихсан. Дээрээс нь мөнгөний бодлого хатуу, хүү өндөр байгаа энэ үед яг арилжааны банкнуудаас зээл авах гэхээр зээл гарах боломж нь бага байна. Ингэхээр бусад эх үүсвэрээс 35-аас дээш хувийн хүүтэй зээл аваад дансаа хаалгачхаад, өнөөдөр энэ хүмүүс яаж цалингаа тавиад үйл ажиллагаагаа тогтвортой явуулаад нийгмийн даатгал, хүн амын орлогын албан татвараа төлөөд явах вэ. Энэ нөхцөлийг хэзээ бүрдүүлж өгөх вэ гэдэг ийм асуулт байна.

Тэгээд цаг байгаа учраас дараагийн нэг асуултыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад тавья гэж бодож байна. Та бүхэн ямар тооцооллоор нийгмийн даатгалыг 705 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж байгаа вэ?

Х.Булгантуяа: Учрал сайд түрүүлээд хариулъя.

Н.Учрал: Макро эдийн засгийн тоонуудыг дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулсан хувь хэмжээгээр зохистой түвшнийг гаргаж тодорхойлдог. Тэгэхээр энэ удаагийн төсвийн бодлого бол төсвийн тогтвортой байдлын хуулийг чанд барьсан сахилга баттай ийм төсвийн хүрээ орж ирсэн. Тэгэхээр бид энэ удаа бол Төсвийн тогтвортой байдлын хуулийн тусгай шаардлагуудаа хангаад төсвөө хэрэгжүүлж чадах юм бол цаашдаа бол энэ төсөв өөрөө эрүүлжинэ гэдэг ийм л бодлого барих гээд байгаа юм. Нэг ёсондоо орлого зарлага 2 аль аль нь буурсан.

Тэгэхээр Номин сайд бид нарыг ажиллаж байхад барьж байсан төсөв чинь 33.4 их наядын орлоготой, 33.4 их наядын зарлагатай төсөв шүү дээ Номин. Тэр чинь юу вэ гэхээр нөгөө зарлагадаж байгаа болгоныгоо орлого гэж биччихдэг. Тэгээд ингээд яваад байсан байхгүй юу. Тэгэхээр тэр үеийн бидний нөгөө оруулж ирж байсан орлого зарлагаас энэ удаа орж ирэхдээ 1.9 их наяд орлого буураад зарлага нь 499 тэрбумаар буураад орж ирж байгаа юм байхгүй юу.

Дээрээс нь төсвийн урсгал зардал өөрөө улсын жилийн төлөвлөгөөнд туссаны дагуу 24 хувь дотроо байх энэ жилийн төлөвлөгөөгөө барьж байгаа. Уг нь хуулиар 30 хувь. Тэгэхээр 24 урсгалаа буулгаж байна гэсэн үг. Ингээд энэ макро тоонуудыг Жи Ди Питэй нь ингээд харьцуулах буюу одоо жишээ нь энэ удаа бол нийт тэнцвэржүүлсэн орлого нь ДНБ-тэйгээ харьцаж байгаа харьцаа хоёрынх нь харьцаа нь одоо бол 30 хувь. Ингээд 28 хувь болгоод эхлэхээр нөгөө дундах орон зайд нь нөгөө татварын багц хууль хэрэгжих гээд байгаа байхгүй юу. Хувийн хэвшилд орон зайг нь бий болгох гээд.

Тэгэхээр нөгөө та бас хувийн хэвшилд санаа зовж байгаа учраас энийг би хэлэх гээд байгаа юм. Тэгэхээр энэ бол том дэмжлэг болно. Тэгэхээр нөгөө бид нар ер нь төсөв хэлэлцэж байхад нэг зүйл дээр их бодох ёстой юм байна. Гишүүд эхний минутдаа зардлаа танаад өгөөч гээд ярина.

Хоёр дахь минутдаа цалингаа нэмээд өгөөч гээд зардлаа нэмээд өгөөч гээд ярина. Тэгэхээр зардал нэмэхээр чинь өөрөө ямар байдал үүсэх вэ гэхээр зардлаа нэмээд эхлэхээр алдагдал чинь улам тэлчихнэ. Татвараа бүүр буулгаад ирээч гэхээр 31.6 чинь дахиад доошилчихоор алдагдал нь бүүр тэлэгдчихнэ. Тэгэхээр алдагдлаа багасгаач гэж байгаа мөртөө нөгөө талаараа зардлаа нэмээч гэхээр болохгүй байгаа юм. Дээрээс нь цалингаа нэмээд өгөөч гэхээр урсгалын 24 хувь чинь давчхаад байгаа юм. Тэгэхээр нөгөө та бидний санаа зовж байгаа хувийн хэвшил дэх ажлын байрыг хэрхэн хадгалж үлдэх вэ гэдэг зарчим чинь алдагдчих гээд байгаа байхгүй юу. Урсгалыг 24 хувиас доош барьснаараа тэр орлого Жи Ди Пи 2-ын харьцааг 37 хувь байгаа шүү дээ. Тэрийг буулгаснаараа тэр орон зайд хувийн хэвшил бизнес хийгээсэй гэдэг ийм. бодлого бариад байгаа юм.

Дээрээс нь сая та зээл дээр санаа зовж байх шиг байна. Энэ өөрөө зээлжих зэрэглэлийг хадгалж үлдэхэд энэ гадаадын хөнгөлөлттэй зээл эх үүсвэр нь тодорхой байгаа 1.3 их наядын алдагдал чинь зээлжих зэрэглэлийг хадгалж үлдэхэд, валютын нөөцийг хадгалж үлдэхэд нэмэр болно. Тэрнээс биш орлого, зарлага тэнцүү гээд явчих юм хувийн хэвшилд шинэ ажлын байр нэмэгдүүлэхэд яаж нэмэгдүүлэх вэ яаж бусдаар гүйцэтгүүлэх ажил орлого олох вэ гээд ингээд асуудал үүсчих юм аа.

Тийм учраас үүн дээр бол сайн бодоосой гэж би хүсэж байна аа. Тэгээд та бол энийг сайн мэднэ. Тэрнээс биш өнөөдөр нөгөө нэг тэнгэрээс буугаад ирчихсэн юм шиг юм ярихаар чинь дэмий биз дээ л гэж найздаа хэлье дээ.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон.

Ч.Чимидсүрэн: Номин гишүүний асуултад хариулъя. Татварын ерөнхий газар Чимидсүрэн. Татварын өр барагдуулалттай холбоотой асуултад хариулъя. Түрүүний 16 мянган данс хаагдсан гэдэг тоо гараад зөрүүтэй байна. Өнөөдрийн байдлаар 14631 ААНБ дээр дансны битүүмж бол хийгдсэн байгаа. Энэ онд ер нь 8

сарын 31 хүртэл сүүлийн нэхэмжлэл өгсөн нь бол 68003 байна. Мөн хөрөнгө авлага битүүмжилсэн 41 татвар төлөгч, дуудлага худалдаа хийгдсэн нэг ААН бол өнөөдрийг хүртэл хийгдсэн байна. Эхний 8 сарын байдлаар нийт 57778 татвар төлөгчөөс 3.3 хуримтлагдсан өрийг бол ингээд цуглуулсан байдалтай байгаа. Түрүүний таны Ерөнхий сайд болон татварын хуулийн шинэчлэлтэй холбоотой данс хаахгүй байх гэсэн тэр заалт бол шинэ хуулийн төсөл дээр бол бий. Гэхдээ бүрэн тэр огт хаахгүй гэсэн үйл ажиллагаа байхгүй. Ер нь бол энэ данс битүүмжлэх үйл ажиллагаа бол бусад улс оронд ч гэсэн нийтлэг хэрэгжүүлдэг ийм арга хэмжээний нэг байгаа. Гэхдээ 100 хувь биш биш тодорхой хувийг нь бизнесээ эрхлэх тодорхой хувийг нь өрөндөө хураах ийм зохицуулалттайгаар бол шийдвэрлэхээр хуулийн төсөлд орсон байгаа.

Х.Булгантуяа: Номин гишүүн нэмж тодруулна.

Ч.Номин: Учрал сайдаа би танаас өмнөх одоогийн асуудлыг асуусангүй. Би тодорхой ганц л асуудал асуулаа. Хэрвээ бодит хэмжээ экспорт чинь нүүрсний экспорт чинь бүрдэхгүй бол яах юм бэ? 70 сая тонноос дээш гарахгүй бол та яах вэ гэдэг би бодлогын асуудал асуулаа. Мөн нөгөө талдаа татварын орлого дээр ч гэсэн би бодлогын талаар ямар өөрчлөлт хийх гэж байгаа вэ гэж асуусан. Түүнээс биш өнөөдрийн 14 мянган ААН асуусангүй. Би энэ 9 сарын 15-нд авсан тодруулгынхаа хүрээнд Чимидсүрэн даргаа асууж байгаа. Үүнээс гадна шинэ хууль дээр олигтой заалт ороогүй учраас асууж байгаа гэдгээ хэлье ээ.

Мөн цаашлаад би Сангийн яамнаас нэг асуулт байна энийг тодруулаад өгөөч. Нэгэнт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд байхгүй байгаа учраас. Түрүүн байхгүй байлаа та. Энэ өргөн барьсан байгаа төсөв дээр чинь байгаа хөрөнгө оруулалтууд бүгдээрээ яг 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд орсон зураг төсөв нь шаардлага хангасан төслүүд байгаа юу гэдгийг би.

Х.Булгантуяа: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Энэ яг өнөөдрийн байдлаар гүйцэтгэл 59 сая тонн байна. Нүүрс нэг тонн биет тоо хэмжээ. Энэ онд бол нэг 85 хүрнэ гэж тооцож байгаа. Төсөөлж байгаа. 2024 онд 83.4 сая тонн байсан. 2026 онд бол 90 сая тонн хүргэнэ гэж зорьж байгаа. Тэгээд ер нь төсвийн хүрээ гэдэг бол өөрөө юу вэ гэхээр орлогын доод хязгаар, зарлагын дээд хязгаар. Энэ хүрээнд Жавхаа сайд төсвөө хийгээрэй л гэсэн шүү дээ. Тэгэхээр болно 90 сая тонн хүргэнэ л гэж зорьж байгаа юм аа. Дээрээс нь эрсдэл бүр дээр стресс тест хийгээд явж байгаа. Экспортын ажлын хэсэг ажиллаж байгаа. Түрүүн би тэгээд хийсэн ажлуудаа хэлээд л байгаа. Тэгэхээр хичээнэ, зүтгэнэ л гэж хэлье дээ.

Х.Булгантуяа: Аубакир сайд.

Т.Аубакир: Баярлалаа. Номин гишүүний асуултад хариулъя.

НДШ-ийн орлогыг ямар үзүүлэлтээр, ямар тооцооллоор 700 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн юм бэ гэж асуусан. Тийм үү Номин гишүүн ээ. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2026 оны төсвийн төслийн санал 2027-оос 2028 оны дунд хугацааны төсөөллийг ҮСХ-ноос гаргасан 2022-оос 2024 оны хүн ам зүйн үзүүлэлт, ДНБ Инфляцын түвшин, нэгдсэн төсвийн орлого, зарлага, ААНБ-ын үйл ажиллагаа, эрхлэлтийн байдал, ажиллах хүчний судалгаа, мэдээлэл зэрэг

хүчин зүйлсийн нөлөөлөл, нийгмийн даатгалын сангийн гүйцэтгэл эдгээр хүчин зүйлсийн 2025 онд хүрэх түвшин, сангийн батлагдсан төсөв, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль зэргийг үндэслэн боловсруулсан.

2026 онд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ААН байгууллагуудын 57.4 хувь нь 67.2 мянга.

Х.Булгантуяа: Аубакир сайд нэмж хариулъя. Товч хариулаарай. 1 минут байгаа.

Т.Аубакир: Гэх зэрэг үзүүлэлтүүдийг тооцож тодорхой хэмжээнд НДШ төлөгч маань нэмэгдэж байгаа. Сайн дурын даатгуулагчдын тоо үргэлж нэмэгдэж байгаа гэх зэрэг үзүүлэлтүүдийг үндэслээд энэ орлогыг тооцсон байгаа. Танд би яг энэ маш урт слайд байгаа учраас би тан руу бичгээр хүргүүлье. Энэний өмнө та асууж байсан тийм учраас бичгээр хүргүүлье гэж.

Х.Булгантуяа: Сангийн яамнаас Жавхлан сайд. Дараа нь Монголбанк Баярдаваа дарга бэлдэж байгаарай. Тэтгэврийн зээлийн хүүг бууруулах боломжтой юу гэдгийг.

Б.Жавхлан: Номин сайдын асуултад хариулъя. Хэдүүлээ гуравхан сарын өмнө төсвийн хүрээгээ цуг батлуулсан. Тэр хүрээн дотроо төсөв өргөн баригдаж байгаа шүү гэдгийг сануулж хэлье 1-д.

Хоёрт та орлого дутвал яах вэ гэж санаа зовж байна. Харин тийм бүгдээрээ л санаа зовж байгаа. Орлого дутвал энэ татварынхаа өр барагдуулах ажиллагаагаа л улам чангална шүү дээ. Нэг ч данс хаахгүй эд нар гэж худлаа тийм поп амлалт бол өгч чадахгүй. Хуулийнхаа хүрээнд энэ гүйцэтгэх агентлаг маань хэрэгжүүлэгч агентлаг маань ажлаа хийж л таарна. Харин өргөн барихаар төлөвлөсөн ди парламент дээр тавьсан байгаа Татварын багц хуулийн өөрчлөлт дотор энэ албадлагын арга хэмжээнүүдийг харьцангуй зөөлрүүлж байгаа. Дансыг бүтэн хаадаг байснаа больё оо, хэсэгчилж хаая. ААН-үүд дээрээ үйл ажиллагаагаа ямар ч байсан суурь зардлаар нэг хэвийн ингээд үргэлжлүүлэх тэр боломжуудыг нь хангая, хэсэгчилье. Төлөвлөгөө гаргаж ийм хугацаатай ийм арга хэмжээнүүдийг авъя.

Х.Булгантуяа: Монголбанк Баярдаваа захирал. Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал 4 номер.

Б.Баярдаваа: Та бүхний өдрийн амгаланг айлтгая. Тэтгэврийн зээлийн хүүг бууруулах тухай асуудал дээр Банкны тухай хуулиар банкны зээл, хадгаламжийн хүүг банк өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд шийдэх ийм хуулийн тогтолцоотой. 2018 онд Монголбанк, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам банкнуудтай яриад зээлийн, тэтгэврийн зээлийн хүүг бол бууруулахаар ийм арга хэмжээ авч байсан. Тэрийг хийсэн арга механизм нь бол нийгмийн даатгалын сангийн эх үүсвэрийг арилжааны банкнууд дээр бага хүүтэйгээр байршуулаад тэр эх үүсвэр нь цаашаа бага хүүтэй зээл болгож гарч байсан ийм арга механизмыг хэрэглэж байсан.

Х.Булгантуяа: Сангийн яамнаас хөрөнгө оруулалттай холбоотой асуулт дээр Жавхлан сайд хариулах уу? 4 номерын микрофон.

Ж.Дэлгэржаргал: Номин гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал.

2026 оны төсвийн төсөл дээр нийтдээ 549 төсөл арга хэмжээ байгаа. Үүний 149 нь 2026 онд шинээр хэрэгжих 149.71 нь л яг барилга байгууламж, бүтээн байгуулалт, дэд бүтцийн ангиллын төслүүд. Улсын жилийн төлөвлөгөөнд бол нийтдээ 19 их наядын хэрэгцээ шаардлага байгаагийн 3.6 их наяд нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй. Яг өргөн барьсан төсөл өөрөө 3.2 буюу 3.2 төсвийн төсөл талаасаа жилийн төлөвлөгөөтэй 100 хувийн нийцэлтэй гарч байгаа. Шинээр яг ингэж төлөвлөсөн 71 төсөл арга хэмжээний хувьд бол аудитын дүгнэлт дээр Коп, хавдрын эмнэлэг дээр магадлал яг эцэслэж гараагүй байна гэж тусгасан байсан. Копын хувьд бол яг угсрах ийм байгууламж байгаа учраас барилгын тухай норм дүрмээрээ магадлал тусдаа гарахгүй.

Хавдрын эмнэлгийн хувьд бол нийт өртгөөс нь бид нар салгаж төлөвлөсөн учраас салгасан.

Х.Булгантуяа: Номин гишүүн нэмж тодруулга.

Ч.Номин: Аубакир гишүүн би таны тооцооллыг үзсэн учраас асуусан юм. Тооцоолол нь нийцэхгүй байна лээ. Тэгээд хэдүүлээ Байнгын хороон дээр энийг ярилцаад явъя. Би яагаад энэ хөгжлийн төлөвлөгөөтэй нийцсэн бэ гээд асуугаад байгаа вэ гэхээр би яг соёл, аялал жуулчлал, спортын салбар дээр үзсэн аудитын дүгнэлтээс үзэхэд 4 зураг төсөвгүй, шинэ төсөл арга хэмжээ хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй орж ирсэн байгаа. Баян-Өлгий аймгийн аялал жуулчлал, спортын цогцолбор, Сэлэнгэ аймгийн спорт цогцолбор. Дахиад Ховд аймагт спорт заал, Хөвсгөлд спорт заал гээд орж ирж байгаа юм. Тэгсэн мөртөө хөгжлийн төлөвлөгөөнд батлагдсан Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театрын барилга шаардлага хангачихсан зураг төсөлтэй ажил яагаад орж ирээгүй вэ? Би энэ талаас нь асуугаад байгаа юм байхгүй юу. Энэ мэтчилэн 40 гаруй төсөл хөтөлбөрүүд байна гэж гарч ирээд байгаа.

Тэгэхээр энийг л би асуугаад байгаа юм.

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулах уу? 4 номерын микрофон тэгвэл. 4 номерын микрофон

Ж.Дэлгэржаргал: Номин гишүүний асуултад хариулъя Дэлгэржаргал. Төсвийн тухай хуулийн 27.1.8, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.10.3 дээр жилийн төлөвлөгөөнд суурилах жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглүүлнэ гэж заасан. Өөрөөр хэлбэл Төсвийн тухай хууль дээр тусгагдсан төсөл арга хэмжээ заавал жилийн төлөвлөгөөнд нэрээрээ тусгагдсан байх ийм заалт байхгүй. Бид нар хуулийн хүрээнд суурилсан, чиглүүлсэн. Таны дурдсан соёл спортын салбарт хийх ажлууд 1 дүгээрт яам яг бодлогоороо эрэмбэлж оруулж ирсэн.

Хоёрдугаарт яг жилийн төлөвлөгөөний зорилго зорилттой уялдаж байгаа. Тэр зорилго зорилтыг бол хэрэгжүүлэхэд чиглэсэн байгаа.

Х.Булгантуяа: Мэндбаярын Мандхай.

М.Мандхай: 2025 оны бараг 6, 7 аймаг маш гантай хүнд зун боллоо. Энэний үр дүнд 2025-аас 2026 онд цаг агаарын таамаг ган зуд хосолсон үйлчлэлтэй хүнд жил болохоор тооцоололтой байна аа. Ургац улаан буудай 51 хувь, малын тэжээл 64 хувь, тосны ургамал 72 хувь ургацаа алдсан байна. Гэхдээ улсын төсөвт хүнсний хувьсгал, Атрын 4 дүгээр аяныг аяны хүрээнд бид малын тэжээлийн хэрэгцээг 100 хувь дотоодоос хангана гээд тусгачихсан байгаа юм. Тэгэхээр би ХАА-н сайдаас асуумаар байгаа юм. Тариаланчдын ярьж байгаагаар 20 орчим тэрбум төгрөгийн зээл авсан эргэлтийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын зориулалтаар. Энэ зээлийг бол төлөх боломжгүй болж байна. Хүндрэлтэй байна. Энэ зээлийг хойшлуулах талаар хүсэлтээ гаргачихсан байгаа.

Тэгэхээр энэ зөрүү улсын төсөв дээр малын тэжээлийг 100 хувь хангана гэгчихсэн байдаг. Ургацаа алдчихсан байгаад байдаг. Малын тэжээл алдчихсан байгаад байдаг. Тэгэхээр энэ зөрүү гарахыг судалж тооцсон уу, энэ зөрүүг хаах, төсөв дээр ямар эх үүсвэр тавьсан юм бэ гэдгийг асуумаар байна. Мөн улсын нөөцөд аюултай байдал үүсэхэд ер нь үүсэхээр ч ер нь харагдаж байгаа юм. Гамшгийн нөөц ер нь хэр байгаа вэ? Яагаад гэхлээр эрэлт үүсэхээр харагдаж байгаа.

Хоёр дахь асуулт Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын шууд зардлын багцад Малын эрүүл мэндийн ерөнхий газрын үйл ажиллагаанд 60.8 тэрбум төгрөгийн төсвийг зарцуулахаар тавьсан. Энэ нь өөрөө өмнөх оноос 9.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр төсөвлөгдсөн байгаа. Дараа нь Мал эмнэлгийн ерөнхий газар гээд орон нутгийн болон лабораторийн үйл ажиллагаанд 35 тэрбум төгрөг нийт 95.8 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвлөсөн байна. Тэгэхээр энэ мөнгө яг юунд зарцуулагдах юм бэ гэдгийг хэлмээр байгаа юм. Мал эмнэлгийн ерөнхий газар 2018 онд үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 8 жил болж өнгөрлөө. Энэ хугацаанд төсөв нь жилээс жилд өссөн байна.

Тэгэхээр Монгол Улсад малын гоц халдварт болон халдварт өвчин гардаггүй, эрүүл бүс хэдээр нэмэгдсэн бэ? Малын өвчлөлийн түвшин болон өвчнөөр хорогдсон малын тоо өмнөх 8 жилийн түвшнээс буурсан уу? Төсвийн үр дүнд дүн шинжилгээ хийсэн судалгаа байгаа юу гэдэг бодитой нэг тоо асууя.

2026 оны төл хүлээн авалт ирэх жилийн мал махны экспортын тоо хэмжээ, махны нийлүүлэлт, хангамжийн урьдчилсан тооцоо таамаг юу байгаа вэ? Нэг минутаа нэмээд авъя.

Х.Булгантуяа: Энхбаяр сайд хариулах уу? Дараа нь нэмээд тодруулчих. Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ жилийн тухайд байгаль цаг уурын тодорхой эрсдэл зарим бүс нутагт үүссэн. Гэсэн хэдий ч бас боломжийн ургац тэжээл бэлтгэж байгаа. Хууль эрх зүйн орчин тогтворгүй болсонтой холбоотойгоор улаан буудайн тариалалт 2 жил дараалаад үндсэндээ 100 мянган гагаар буурсан, 150 мянган тонн орчим улаан буудай дутагдана. Гэхдээ энийг дийлэнх нь нэлээн хэсгийг бид хотоос нөхөж чадна. Дотоодын улаан буудайгаар хүнсний гурилаа бүрэн хангана. Гахай, тахиа, шувуу тэр өндөгний аж ахуйнууд спиртийн үйлдвэрүүдийн шаардлагатай улаан буудайг

импортоор хангана. Төсвийн хэмжээ хязгаарлагдмал байгаа аль болох салбартаа бид нар зохицуулна. Үнэхээр яг дутаад зайлшгүй нэмэлт эх үүсвэр шаардлагатай бол Засгийн газрын нөгөө хөрөнгөөр шийднэ гэдэг дээр Засгийн газар дээр ярьж тохирцгоосон байгаа. Зээл хойшлуулалт зарим бүс нутагт тариаланчид ногоочдоор эрсдэл үүссэн. Засгийн газар, Ерөнхий сайд үүрэг өгсөн байгаа. Мал мах бэлтгэл шаардлагатай худалдан авахад махны үйлдвэрүүдээ эргэлтийн хөрөнгөөр дэмжих зээлийн хугацаа тулсан аж ахуйн нэгжүүдийн зээлийг зээлийн үндсэн зээл төлөлтийг хойшлуулах энэ бодлогын асуудлыг Засгаар орж хэлэлцүүлнэ гэж байгаа.

Бид эхний ээлжид ургацаа бүрэн хураах зорилт тавиад улсын хэмжээнд ургацын комисс зохион байгуулагдаад ажиллаж байна. Ургацын дүнг гаргах арай болоогүй. Зарим газар ургацын хэмжээ нэмэгдэж байна. Нэлээн их хэмжээний үр тариа тэжээл рүү шилжиж байна. 7 сар 8 сараас хойш орсон борооны үр дүнд тэжээлийн таримал сэргэж тэжээлийн масс нэлээн нэмэгдэж байна. Энэ жилийн онцлог бол 100 гаруй мянган гад малын тэжээл таригдсан. Уурагт сайн чанарын тэжээл энэ МАА-д нэлээн очно. Энэнтэй холбоотойгоор МАА-н эрсдэл нэлээн багасах байх. Өвөлжилтийн бэлтгэл дээр отрын бүс нутгуудыг зохион байгуулалтыг ханган ажиллаж байна. Зүүн аймгууд бол хадан тэжээлийн нөөц маш сайн гарсан. Энэнтэй холбоотойгоор аймгуудад газар хуваарилан хадлангийн бэлтгэл ажлуудыг хийгдэж байна.

Мал эмнэлэг дээр таны тоо дутуу буруу яваад байх шиг байна. Улсын төсөвт 59 тэрбум төгрөгийн л төсөв байгаа. Энэ дотроо лабораториудын асуудал хамтдаа шингээд л явж байдаг. Ингээд энэ тогтвортой мал эмнэлгийн салбарыг дэмжих бодлого эрчимжүүлэх бодлого явсны үр дүнд бид 2 жил дараалан 300 сая долларын экспорт хийж чадлаа. Яг одоо Монгол Улсын мах бэлтгэх, мах боловсруулах үйлдвэрүүд бүтэн хүчин чадлаараа ажиллаж байгаа. Экспорт эрчимтэй тасралтгүй явагдаж байгаа. Аль болох л бид нар экспортыг бүрэн дэмжиж байгаа. Тэгж байж мал мах үнэтэй байна. Борлуулалт сайтай байна. Нөгөө талаас байгаль цаг уур эрсдэлийг давахад одоо бид малчид шаардлагатай малаа хэрэгцээлээд борлуулаад, санхүүгээ хадгалаад ингээд эрсдэлгүй орох ийм бололцоог бүрдүүлэх ийм арга хэмжээнүүд явагдаж байгаа. Орон нутаг болгон өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлыг хийж байгаа. Яам бол отрын бүс нутаг буюу отроор нүүх мал сүргийн зохион байгуулалт Тусгай хамгаалалттай газар нутаг хилийн бүсэд орох мал, тоо толгой, өрхийн зохион байгуулалт зэрэг ийм арга хэмжээнүүдийг хийж байна. Мал бэлтгэлийг явуулж байна.

Тэгэхээр мал эмнэлгийн салбарын үйл ажиллагаан дээр дэлхийн мал эмнэлгийн байгууллага хяналт тавьдаг. Өнөөдөр яг ажлын баг ирчихсэн Монгол Улсын мал эмнэлгийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөөд явж байна. Энэ үнэлгээг бид та бүхэнд ингээд танилцуулна.

Ургац хураалт бол бүх зохион байгуулалтаа хангаад зэвсэгт хүчин, оюутан сурагчид, бусад салбарын дэмжлэгтэйгээр ургац хураалтын ажил ид өрнөж байна.

Х.Булгантуяа: Мандухай гишүүн нэмж тодруулна.

М.Мандхай: Би тэгэхээр сайдаасаа ингэж сонслоо. Ер нь өвөл хүндэрнэ. Тэр байтугай малын хорогдол ч гэсэн үүсэх төлөвтэй байгаа. Тэгэхээр энэ эцсийн тайлан гараагүй ч гэсэн хэрэв хүндрэл үүсэх юм бол Засгийн газрын нөөц сангаас бүрэн хариуцаж ямар ч байсан энэ улсдаа аль болох алдагдалгүй хорогдолгүй байх

дээр анхаарч ажиллах юм байна гэдгийг би ямар ч байсан протоколд тэмдэглүүлээд авъя гэж бодож байна.

Хоёрдугаарт та отроор нүүх хэвийн мал толгой гээд хэллээ л дээ. Яах вэ нэлээн гэдэг тоо бол яг баримттай хэлэхэд ойлгоход хүндрэлтэй байлаа. Отор дээр анхаарч байгаа төсөв аравхан сая төгрөг шүү. Нийт хэдэн мал өөрөө та оторт нүүлгэнэ гэсэн төлөвлөгөө байгаа вэ? Ер нь би дахиад нэг тодруулаад асуучихъя. Энэ малын хорогдол төл хүлээн авалт энэ ирэх жилийн энэ тоо хэмжээ чинь яг бодитой хэд юм бэ гэдэг би нэг тоог нэг тодруулж асуухлаар нэлээн.

Х.Булгантуяа: Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд отрын бүс нутаг гэсэн тусгаарлагдсан ийм газрууд байдаг. Тэнд бол малын зусланг хязгаарлаж малын бэлчээрийг сэргээгээд байгалиар нь сэргээгээд цаг үе хүндэрсэн үед орон нутгуудын захиалга дээр мал оторлодог ийм зохион байгуулалттай нийт даац нь 950 орчим мянга. Максимум 1 сая малыг отрын бүс нутагт зохион байгуулалттайгаар өвөлжүүлэх бололцоо байдаг. Тэр хэмжээндээ л энэ дээд хэмжээ нь ингэж ашиглана. Нөгөө талаас бидэнд нэг нөөц байдаг нь хилийн бүс нутаг болон тусгай хамгаалалттай газар байдаг. Энэ дээр бас орон нутаг болгон зохион байгуулж захиалгаа өгөөд ингээд явдаг. Энэ жилийн тухайд бол баруун аймгууд дээр хүндрэл байгаа. Бусад аймгууд дээр өвөлжилтийг даван туулахад харьцангуй боломжийн. Төвийн бүс мэдээж тодорхой нэлээн сумууд нь гангийн байдал орсон ч гэсэн дийлэнх сумууд нь бол.

Х.Булгантуяа: Мандухай гишүүн нэмж тодруулъя.

М.Мандхай: Ямар ч байсан Засгийн газрын нөөц сангийн эрэмбэлэлт бол төсөв дээр тодорхойгүй байсан. Тэгээд энийг Сангийн сайд тодорхой болгож өгөөрэй. Ямар ч байсан ХАА-н салбарт учирч болзошгүй нөхцөл байдлыг даван гарах хэмжээний төсөв нөөц санд байгаа гэж ойлголоо. Түрүүн хэлсэн МХЕГ-ын төсөв дээр та өөрөө төсвөө сайн хараарай би төсөв уншихсан хүний хувьд хэлж байгаа шүү. 95.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна аа. Гэвч өнөөдрийн байдлаар малын гоц халдварт өвчин халдварт өвчин гардаггүй эрүүл бүсийг бид нар хэдийг бий болгосон юм бэ гэдэг би их тодорхой асуулт асуусан боловч хариултаа авч чадсангүй.

Тэгэхээр Сангийн сайд бас надад. Үгүй ээ харин би төсөв хараад л байж байна. Мал эмнэлгийн Ерөнхий газар гээд төсөв тавьчихсан байгаа байхгүй юу. Тэгээд тэрэн дээр тэгвэл холбогдох хүмүүс нь тодорхой хариулаарай.

Х.Булгантуяа: Эхлээд Жавхлан сайд хариулъя. Дараа нь тэр Мал эмнэлгийн ерөнхий газартай холбоотой төсвийг хэн хариулах юм Энхбаяр сайд аа. Жавхлан сайдын микрофон.

Б.Жавхлан: Мандхай гишүүнийхээ асуултад хариулъя.

160 тэрбум төгрөгийн Засгийн газрын нөөц төсөв төсөл дээр байгаа шүү. Та харин энийг сайхан хамгаалаад өгөөрэй. Сая тодотгол дээр уг нь нэг жоохон нэмээд оруулъя гэсэн чинь ямар зорилготой юм мэдэхгүй Их Хурал дээр хасаад хаячихсан. ХАА-д зориулсан Засгийн газрын нөөц гэж байхгүй. Шаардлага гарвал юунд ч

зориулж болно. Тэгэхээр 160-ыгаа нэг бүтэн аваад гарчихвал ХАА-даа нэмэртэй байхгүй юу. Тэгэхээр та энийг хамгаалж дэмжиж өгөөрэй. Ер нь тэгээд зуд болбол ихэнх нь л тийшээ явдаг юм даа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анар.

Ч.Анар: Сангийн сайдаас асууяаа. Төр буй доор татвар бий гэдэг үг байдаг. Тэгэхээр өнөөдрийн төсвийн орлогын бүтцийг харвал манай Сангийн сайд энэ үгийг маш сайн биелүүлж байна аа. Монгол Улсын төсвийн орлогын бүтэц татварын орлого 85 хувь, татварын бус орлого 5.4 хувь буюу дөнгөж 1.8 их наяд байна. Энэ 1.8-аасаа 365 тэрбум нь гадаадын тусламж эзэлж байгаа. 2018 оноос хойш харах юм бол татварын орлого 5.5 дахин, татварын бус орлого 1.1 их наядаас 1.8 их наяд буюу 4.8 хувийн жилийн дундаж өсөлттэй явсан байгаа юм. Гэтэл энэ маань өөрөө инфляцаа бодох юм бол ер нь бол бодит орлого, татварын бус орлого буурсан гэсэн үг. Тэгэхээр олон улсын жишгээр бол төсвийн орлого дээр татварын эзлэх хувь бол 80-аас 90 хувьтай байх ёстой ОСТ-ийн зөвлөмж 10-аас 20 хувь, Норвег 25-аас 30 хувь, Казакстан 15-аас 20 хувь.

Манай улс 2018 онд 12.8 хувийн татварын бус орлоготой байсан бол одоо 2026 оны төсөв дээр буурсаар буурсаар 5.4 дахин хувь болж орж ирж байна. Тэгэхээр ерөөсөө бид нар татваржсан улс болж байна шүү дээ. Тэгэхээр татварын бус орлого нь 5 хувиас доошоо орж байгаа болохоор төсвийн орлогын төрөлжилт алдагдаад цэвэр үүл уурхайн түүхий эдийн мөчлөгийн савлалтад улам эмзэг болж байна. Маш олон мөрийн хөтөлбөр Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр үе үеийн сайд нарын яриаг сонсоход Засгийн газар төлөвлөгөө зорилт төрийн өмчийн үр ашгийг дээшлүүлнэ, нэмэгдүүлнэ гэж яриад байдаг. Гэтэл яг энэ тоо баримтуудыг харахаар яг эсрэг байна.

Тэгэхээр энийг хэрхэн цаашид бодлогын хэмжээнд өсгөх юм бэ? Татварын орлого татварын бус орлого буурч байгаагийн хамгийн гол шалтгаан бол ТӨК-удын засаглал үр өгөөжийн асуудал. Үүн дээр би Бямбацогт сайдаас асууяа. ТӨК-удын өгөөж 2023 онд 2026 оны хавсралт нэг дээр зааснаар бол хөрөнгийн өгөөжийг 1.02-оос 1.5 болгож өсгөнө гэж байна. Тэгэхээр одоо төр энэ ол. Хятадын ТӨК-удын хувийн хэвшлийг яриагүй ТӨК-удын өгөөж 4.4 хувьтай байна. Үүн дээр ямар бодлого баримтлах юм бэ? Төсвийн орлогоо татварын бус орлогоороо нэмэгдүүлэхгүй бол 100 хувь татвар авдаг л улс боллоо шүү дээ. Сангийн сайд, Бямбацогт сайд 2-оос хариулт авъя.

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Анар гишүүний асуултад хариулъя. Ер нь яг бодлого концепцын хувьд тантай ерөөсөө огт санал нийлэхгүй байна. Татварын бус орлого гэдэг чинь манай орны хувьд маш цөөхөн эх үүсвэрүүд байдаг юм шүү дээ. Тусламж манайд навигацийн орлого гэж нэг жоохон орлого байдаг юм. Ноогдол ашиг, хүү, торгууль, татварын бус орлогоо нэмье гэхээр та бизнес хийлгэж байгаа төрийг торгоод бай, хүү олоод бай, түрээсний орлого олоод бай, навигацийн орлого олоод бай гээд үгүй ээ эсрэгээрээ байхгүй юу. Хөгжингүй орнуудын хувьд Америк, Герман, Япон, Солонгос улс 90-ээс дээш татварын орлоготой. Тэгээд энэ улсууд маань өөрөө нөгөө татварын бааз суурь нь их тогтвортой байдаг учраас татвараар бүрдүүлдэг орлого нь өндөр байдаг.

Харин манайтай төстэй уул уурхайгаас хамааралтай улсуудын хувьд Норвег, Казахстан гээд эдгээр улсууд бол өндөр. Уул уурхайн ноогдол ашиг нь өндөр. Ноогдол ашгаараа төсвийн орлогоо бүрдүүлдэг ийм улс байна. Манай орны хувьд бол ноогдол ашгаараа бид баялгийн сангаа бүрдүүлдэг, тэнцвэржүүлсэн тэнцлийн орлого болдоггүй. Тийм учраас тогтвортой татварын бааз суурьтай байснаар төр харин бизнес хийхгүй, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй бизнесээс татгалзаад харин тогтвортой бааз суурь дээрээ бид бодлогоо явуулах ёстой ийм л юм байгаа юм. Харин тогтвортой бааз сууриа байлгана гэдэг маань татварынхаа хувь хэмжээг нэмэх биш эдийн засаг маань өөрөө тогтвортой байснаар энэ татварын бааз суурь маань өөрөө тогтвортой байх ёстой. Бодлого энэ рүүгээ явна. Татварын бус орлого олноо гээд бизнес хийгээд байж төр болохгүй ээ. Энэ аягүй буруу шүү.

Х.Булгантуяа: Бямбацогт сайд нэмж хариулъя.

С.Бямбацогт: ТӨК-удын үр өгөөжийн талаар манай Анар гишүүн асууж байна. Тэгэхээр ТӨК-удын үр өгөөж, засаглалыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээг Засгийн газраас авч хэрэгжүүлж ажиллаж байгаа. Тодорхой үр дүн гарч байгаа. 2024 оны жилийн эцсийн байдлаар ТӨК-уд нийтдээ 54 их наяд төгрөгийн хөрөнгө эзэмшдэг. Үүнээсээ 26 их наяд төгрөгийн орлого олсон. Үүнээсээ 6 их наяд орчим төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байгаа. Энийг 2023 онтой харьцуулаад үзэхээр нэлээд ахисан дэвшсэн ийм үзүүлэлт гарсан. Мөн одоо ТӨК-удын нийт хөрөнгийн өгөөж 2020 онд 0.4 хувьтай байсан бол 2024 оны гүйцэтгэлээр 9.6 хувь болж нэмэгдсэн. Ийм статистик тоо гарсан. Гэхдээ энэ бол зөвхөн уул уурхайн компаниуд дээр байгаад байгаа юм. Цаашдаа бид нар бусад компаниудын хөрөнгийн өгөөж нэмэгдүүлэх тал дээр анхаарах ёстой.

Х.Булгантуяа: Бямбацогт сайд Анар гишүүн эхлээд тодруулчихъя. Анар гишүүн нэмж тодруулна.

Ч.Анар: Жавхлан сайд хэрвээ зөв бодлого зарчмын хувьд зөв байгаа юм бол яагаад төр бизнес хийгээд байгаа юм. Яг логик нь зөрөөд байна л даа. Жишээ нь энэ уул уурхайн баялгаас хамааралтай Австрали улс гэхэд 7-оос 10 хувь татварын бус орлоготой. Манайд бүүр багасаад байна. Хэрвээ энэ логигоор зөв бодлого явж байгаа юм бол манай ТӨК төрийн өмчит уул уурхайн компаниуд багасах ёстой шүү дээ. Эсрэгээрээ тэгвэл татварын бус орлогыг нь өсгөөд төр өөрөө мундаг менежмент хийж байгаа юм бол ТӨК уул уурхайн компаниудын хөрөнгийн өгөөж болон ногдол ашгийг өсгөх ёстой. Тэгэхээрээ энэ 2 чинь зөрөөд байна. Тэгэхээр алийг нь хийх ёстой юм? Тэгэхээр зөв юм нь бол татварын орлогоо өсгөх гэдэг дээр би санал нэг байна. Тэгвэл яагаад ТӨК-уд өсөөд олшроод байгаа юм? Төр төр өөрөө янз янзын бизнес хийгээд байгаа юм. Багасах ёстой гэж байгаа байж. Тэгээд одоо бодит үйлдэл дээрээ багасахгүй ихсээд л байна шүү дээ.

Х.Булгантуяа: Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Анар гишүүний хэлж байгаа татварын бус орлого дээрээ анхаарах ёстой гэдэг дээр авах ёстой энэ саналыг хүлээж авч байгаа. Өмч хувьчлалын орлого, өмч хувьчлалын орлогын цаад талд үндсэндээ бол төр өөртөө байгаа илүүдэл үр ашиггүй дээрээс нь олон нийтэд нээлттэй болгоод олон нийтийг хяналтад оруулах ийм ТӨК-удаа хувьчлах, хөрөнгүүдээ цэвэрлэх, хувьчлаад худалдаад ийм байдлаар орлого олох боломж байгаа. Энэ дээр бид анхаарах ёстой.

Энэ дээр өнгөрсөн 2026 онд тодорхой нэмэгдэж байгаа. Мөн дээрээс нь ноогдол ашгийн орлого. Сая би хэллээ 6 их наядын цэвэр ашигтай ажилласан мөртөө төрд өгч байгаа ноогдол ашиг нь харьцангуй бага байгаад байгаа. Ялангуяа Эрдэнэс Тавантолгой компани их л ашигтай ажиллаад байдаг. Сайн ажилласан гээд яриад байдаг бодитоороо тэр нь төр ард түмэндээ өгч байгаа ноогдол ашиг нь бага байгаад байгаа. Тийм болохоор ноогдол ашгийн орлогыг нэмэгдүүлэх тал дээр 2026 онд нэмэхээр тусгасан байгаа гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Анар гишүүн хэдүүлээ татварын бус орлогод ерөөсөө найдаж болохгүй. Өмч хувьчлалын орлого яах вэ энэ нэг удаагийн орлого байхгүй юу. Тогтвортой орлого биш, орлогын бааз суурь биш. Тэгэхээр цаашдаа төр ААН хэрвээ байгаа бол энэ стратегийн чухал ач холбогдолтой ААН л байх ёстой байхгүй юу. Цахилгаан станцууд, Эрдэнэт, Эрдэнэс Тавантолгой эхнээс нь ХК болгоод олон нийтийн хяналтад оруулаад ийм бүтцийн өөрчлөлтүүд хийх хэрэгтэй. Тэрнээс биш стратегийн бус зүгээр ашиг олохын төлөө төрийн өмчийн компани байж байсан огт болохгүй. Тэгээд ийм зарчмаар л явна. Бямбацогт сайдын хэлээд байгаа тэрийг л хэлээд байна.

Х.Булгантуяа: Анар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Өмч хувьчлал дээр санал нэг. Тэр нэг удаагийн орлого, тогтвортой орлого биш. Дээрээс нь мөнгөн хөрөнгө нь бүртгэгдэх болохоос яг төсвийн орлоготой бичигдэхгүй байх гэж бодож байна. Нөгөө талаасаа энэ хэрвээ тэгээд энэ өгөөжгүй ТӨК-удыг олшруулаад тэгээд ноогдол ашиг байхгүй байгаа юм бол яах гэж энэ олон ТӨК-уд ажиллаад байгаа юм бэ? Одоо дахиад нөгөө төрийн өмчит банкаа нэмэх гэж байна. Төрийн банк гэж банк байгаа шүү дээ. Тэгээд Орон сууцын санхүүжилтийн банк гээд нэмэх гээд байна. ТУЗ-ийн гишүүдийнх нь тоо нь 200 орчим гэж сонссон. Тэр нь тэгээд нууцад байдаг. Ноднин хуулиар нээлттэй болгох гээд чадаагүй. Тэгээд энэ хөрөнгийн өгөөжийг нь харахаар өгөөжгүй байгаад байгаа юм бол энийгээ цөөлөх ёстой юм биш үү? Төр өөрөө хамгийн муу менежмент хийгээд байгаа. Жавхлан сайд та зөв юм ярьж байна. Тэгээд тэр зөв чинь эсрэгээрээ бодит байдал дээрээ өөр үр дүн нь өөр байна шүү дээ. Хувийн хэвшлээ дэмжээд татварын орлого ихэсгээ гэх юм бол болж байна. Гэхдээ үйлдэл нь нэг өөр байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр Байнгын хороод дээр нарийн шинэ деталиудаа асууя.

Х.Булгантуяа: Бямбацогт сайд нэмж хариулъя.

С.Бямбацогт: Одоо төрийн өмчит 109 компани байгаа, төрийн өмчит. Орон нутгийн өмчид ороогүй. Энийг нэг цаашдаа цомхон цөөлөөд нөгөө давхардсан чиг үүрэг нь арилгаад нэг 70 болгох ийм бодлого барьж байгаа. Тодорхой ажлууд хийгдсэн. Эрчим хүчний компаниудыг нэгтгэх, нийлүүлэх ийм ажлууд хийгдэж байна. Мөн энэ санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудыг нэгтгэх, шаардлагагүй бол ТӨК-уд татан буулгах ийм бодлогууд хийгдээд эхэлсэн. Цаашдаа ч нэлээн хийгдэнэ. Үүнээс гадна бидэн дээр бас нэг том асуудал бол нийгмийн хариуцлага хүлээдэг. Одоо эрчим хүчний компаниуд, цахилгаан станцууд, нүүрсний уурхайнууд. Үнийг нь өсгөхгүй гээд үүнээсээ болоод ашиггүй ажилладаг, алдагдалтай ажилладаг. Яагаад гэвэл нөгөө хүчээр эрчим хүчний үнэ өсөхгүй гээд. Борлуулалтын орлого, нүүрсний үнэ эрчим хүч цахилгааны үнийг нэмдэггүй учраас.

Ийм асуудлууд байна. АЗЗА-ууд, зам засварын компаниуд бас л ард иргэдийг замаар.

Х.Булгантуяа: Нэг минут нэмээд гүйцээе.

С.Бямбацогт: АЗЗА компаниуд иргэдийг ерөөсөө л бид нар аюулгүй осолгүй хурдан шуурхай зорчих бололцоо ханга. Тэр замуудаа хагархай цоорхойгоо нөх өө. Өвөл цас ороод, мөс бороо ороод халтиргаа гулгаатай болчих юм бол түүнийг нь хурдан цасаа цэвэрлээд зам даваагаа нээ гэдэг байдлаар ашиг олох чинь чухал биш гэж шаарддаг. Иймэрхүү иргэдийн аюулгүй байдлыг хангах, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх.

Дээрээс нь нийгмийн хариуцлага хүлээдэг ийм компаниудыг бид нар ашигтай л гэж шахаж болохгүй байгаад байгаа юм. Энийг бид нар аль болох хувийн хэвшилд шилжүүлэхээр эргээд нөгөө өртөг зардал төсөв дээр нэмэгдэх ачаалал нэмэгдчих гээд байдаг учраас нэг иймэрхүү компаниудыг хэрхэн яаж шийдэх вэ гэдэг дээр Их Хуралтайгаа хамтраад цаашдаа шийдэл гаргах нь зөв байх аа. Өмч хувьчлалын талаар баримтлах үндсэн чиглэлийг Улсын Их Хурал удахгүй оруулж ирнэ. Тэгээд энэ дээр нэг иймэрхүү компаниудыг хэрхэн яаж шийдэх вэ? Төрийн банкны асуудал, МИАТ-ийн асуудал, Эрдэнэс Тавантолгойн хувьцаа, АЗЗА компани. Одоо ярьж байгаа энэ цахилгаан дамжуулах түгээх шугамууд гэдэг юм уу.

Х.Булгантуяа: ТӨК-удын засаглалыг сайжруулах дээрээс нь нэмээд олон нийтэд хувьцааг нь юу яах энэ асуудал их олон жил яригдаж байгаа. Тэгээд та бүхэн маань 2026 он дээр 2024 оны гүйцэтгэлтэй харьцуулах юм бол Бямбацогт сайд 13.7 дахин их ноогдол ашиг төвлөрүүлнэ гээд тавьсан байна лээ 24 оны гүйцэтгэлтэй харьцуулах юм бол. Энэ аймаар их тоо шүү. Би олон удаа энд Улсын Их Хурал Засгийн газраас хувьчилна энэ тэр гээд л орж ирээд л энд орж ирснийхээ дараагаар үндэсний аюулгүй байдалд нөлөөлнө, орон нутгийн үйл ажиллагаанд нөлөөлнө гэж байгаад нэг ч АЗЗА-г хувьчилж чадаагүй. Нэг ч ТӨК-ийн яг үнэнийг хэлэхэд олон нийтэд хувьцааг нь яах энэ тэр тийм ажлууд хийгдээгүй шүү. Тэгэхээр тэрүүн дээрээ та бүхэн маань өөрснөө тооцоолоод зөв хийсэн тэгээд энийгээ тууштай хэрэгжүүлж чадах болов уу л гэж бид найдаж байна. Энэ талаар л гишүүд асуугаад байх шиг байна.

Тэрүүн Анар гишүүн бас хэлсэн. Манай салбар эдийн засаг уул уурхайн салбараас хамааралтай байдал улам өсөөд байна шүү түүн дээрээ анхаараарай гээд. Төсөв дээр бичсэн байна лээ. 2000-2009 онд уул уурхайн салбарын шууд болон шууд бус нөлөө нь нэг 20 хувь орчим байсан. Сүүлийн 5 жилд 30 хувь болж нэмэгдсэн. Энэ түүхий эдийн үнэ тэр тусмаа манайх шиг ганцхан түнш, худалдааны түнштэй улсын хувьд тэнд ямар нэгэн байдлаар үнийн уналт үүсэх л юм бол манай эдийн засаг энд хүчтэй савлана. Бид нар төсвийнхөө зарлагыг хөрөнгө оруулалтуудаа хийж чадахааргүй ийм нөхцөл байдалд хүрч байгаа эдийн засгийн дүр зураг руу явж байгаа гэдгийг та бүхэн маань харж байгаа байх аа.

Ингээд 13 цаг өнгөрсөн байна. Үдээс өмнөх чуулганы хуралдаан түр завсарлаад 14 цагаас үргэлжлүүлэн хуралдана.

ЗАВСАРЛАГА

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын үдээс хойших чуулганы хуралдаан үргэлжилж байна.

2026 оны төсвийн төсөлтэй холбоотой Улсын Их Хурлын гишүүд үг хэлээд одоо 13 хүн байгаа.

Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Хосбаяр.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Бид нар бүсчилсэн хөгжлийн тухай ярьж байгаа. Тэгээд одоо сонгуулиа ч гэсэн бүсчилсэн байдлаар явуулаад бүсээс сонгогдсон бүсийн төлөөлөл болсон гишүүд бас энд сууж байгаа. Тэгээд энэ жилийн энэ орж ирсэн төсвийн төслийг харахад яг бүсэд зориулсан бүсийн хэмжээний бүтээн байгуулалт хөрөнгө оруулалт ер нь бага тусгагдсан байхгүй байна гэж ингэж харж байгаа.

Тийм учраас бид нар ер нь цаашдаа энэ бүсээрээ хөгжих юм уу, бүсийн хэмжээний бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтыг ер нь яаж шийдэж явах юм бэ? Мэдээж бүсийн хэмжээний ач холбогдолтой хөрөнгө оруулалт бол томоохон дүнтэй байна. Том хөрөнгө оруулалт шаардана, цаг хугацаа шаардана. Тийм учраас энэ томоохон бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтыг бүсийн хэмжээний хөрөнгө оруулалтыг яаж шийдэх вэ? Бүсийн төвүүдийг хэрхэн яаж дэмжих вэ? Мэдээж бүсчилж хөгжихөөр бүсийн төвүүд нь илүү бүтээн байгуулалт хийж илүү үүрэг ачаалалтай явах байх. Мөн 330 сумыг бас дотор нь бүсчилж 90 сум буюу 90 өсөлтийн төв байна гээд ингээд бодлого гаргаад хууль нь батлагдсан байгаа. Тэгэхээр энэ өсөлтийн төвүүдийн хөрөнгө оруулалтыг яаж эрэмбэлж авч үзэх юм. Энэ талаар энэ Амарсайхан Шадар сайдаас асууя гэж бодсон. Дараагийн асуулт болохоор энэ Сангийн сайдаас аймгуудад олгож байгаа энэ санхүүгийн дэмжлэг буюу татаас 297.5 тэрбум төгрөг байх шиг байна. Нийт 21 аймгаас 14 аймаг нь санхүүгийн дэмжлэг авч байна. Тэгээд зарим аймгууд мэдээж санхүүгийн дэмжлэг их авч байна, зарим нь бага авч байна.

Тэгэхээр одоо миний ойлгож байгаагаар санхүүгийн дэмжлэг бага аваад өөрсдөө орлогоо олоод эх үүсвэрээ бүрдүүлээд ингээд ажиллаж байгаа аймгуудыг сайн гэж ингэж харж байна. Тэгэхээр ер нь цаашдаа энэ төсвийн бодлогоор өөрсдөө орлогоо бүрдүүлээд өөрсдөө ингээд санхүүжилтээ олоод ингээд ажиллаж байгаа энэ аймгуудыг ер нь ямар бодлогын дэмжлэг байх юм бэ? Жишээлбэл хөрөнгө оруулалт талд нь дэмжиж болох уу? Энэ дээр нэг хариулт өгөөч ээ. Дараа нь ХАА-н сайдаас асуух юм. Ер нь ноолуур энэ махны нөхцөл байдал ямар байна аа? Ноолуур хавар бид нар дотооддоо бонд босгоод дотоодынхоо мөнгөөр ноолуур авчихсан. Энэ ноолуураа яг угааж самнаад боловсруулаад гадаадад гаргаад валют орж ирсэн юм байгаа юу. Мөн энэ жилийн энэ махны экспорт ямар байна аа? Одоо бол яах вэ энэ хөдөөгүүр бас малчдын гол орлого олдог мах бас гайгүй үнэ нь гайгүй байгаа учраас бас орлого олох боломж байна.

Тэгэхээр энэ ноолуур мах 2 дээр асуумаар байна. Мөн Говь компанитай холбоотой бас энэ хувь эзэмшилтэй холбоотой ХК байж байгаад ХХК болж байгаа ийм мэдээлэл байгаа. Энэ дээр бас энэ СЗХ-ныхноос нэг мэдээлэл авмаар байна аа.

Х.Булгантуяа: Сангийн сайд түрүүлээд хариулах уу? 4 номерын микрофоноос ажлын хэсэг.

Ж.Дэлгэржаргал: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Сангийн яам, Хөгжлийн санхүүжилт, Хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал 2024 оны 64 дүгээр тогтоолоор Улсын Их Хурлаар батлагдсан. Нийтдээ яг 5 бүс, 6 бүс дээр яг энэ 149 томоохон төслүүдийг хэрэгжүүлэх, хугацааны хувьд бол 10 жилийн хугацаанд 3 үе шаттай байгаа. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд 2025 онд хэрэгжиж байгаа 3 салбар дээр яг томоохон хөрөнгө оруулалтуудыг эхлүүлсэн. Зам тээвэр, эрчим хүч, дэд бүтэц. Энэ бодлого маань үргэлжлээд 2026 оны төсөв дээр энэ төслүүд үргэлжлэн хэрэгжихээр 2027 онд эхнээсээ ашиглалтад орохоор, дараагийн бүсчилсэн хөгжилтэй холбогдуулаад энэ 2026 он дээр шинэ хөрөнгө оруулалтын хувьд бол тэргүүн эрэмбийн 4 авто зам, эрчим хүчний салбарт 6 шинэ төсөл бусад дэд бүтцийн төслүүдийг тавьсан. Тэгэхээр бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хувьд яг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтуудыг ийм бодлогын баримт бичигтэй уялдуулах энэ эрэмбэ төлөвлөлт хэрэг хийгдээд явж байна аа.

Х.Булгантуяа: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя аа. Аймгууд бол зарим аймгуудын хувьд бол татаас авч байгаа. Зарим аймгуудын хувьд бол төвлөрүүлж байгаа. Татаас авч байгаа гэдэг нь маш ойлгомжтой ойлголт. Гарах ёстой зардал буюу тухайн сумынхан тэр төрийн үйлчилгээг үзүүлэх зардал нь олж байгаа орлогодоо хүрэхгүй байна л гэсэн үг. Тэгэхээр яг тэр зөрөө хэсгээр нь бол татаас өгчхөж байгаа гэсэн үг. Нөгөө талдаа төвлөрүүлдэг бол аймгууд байгаа. Энэ бол өөрийнхөө гарах ёстой зардлаасаа бол илүү ихийг орлого олж байна гэсэн үг. Эдгээр аймгууд дээр яг Төсвийн хуулиар бол бид нар 70, 30 буюу ашгийнх нь 70 хувийг нь тухайн аймагт нь үлдээгээд энэ мөнгөөрөө та бүхэн аймгийнхаа хэмжээндээ энэ асуудлуудаа нэмэлт асуудлуудаа шийдээд дахиад цаашаа энүүгээрээ ингээд хөрөнгө оруулалт хийх боломжийг 1 дүгээрт үлдээж байгаа юм.

Хоёр дахь асуудал бол 3 жил дараалаад улсад бол орлого төвлөрүүлчихсэн аймгуудын хувьд бол бонд гаргах эрх нээгдэж байгаа. Тэгээд энэ дагуугаа бол жишээ нь Өмнөговь аймгийн хувьд аймгуудаас бол хамгийн тэргүүн ээлжид ирэх жил бонд гаргахаар бол болж байна. Ер нь бол аймгуудын хувьд бол энэ бие даасан байдлыг нь нэмэгдүүлэх, тэгээд Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу энэ чиг үүргүүдээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг болох зорилгоор бол Засгийн газраас бол болон Улсын Их Хурлаас бол ямар ч байсан орлогын хуваарилалтыг дахиж нэг удаа өөрчилчихсөн байгаа.

Жишээ нь өмнө нь бол хувь хүн буюу энэ цалингийн орлогыг аймгийн түвшинд өгдөг байсан сумын түвшинд өгдөг болчихсон илүү сумын хувьд бие даах боломж гарч ирсэн гэсэн үг. Гэхдээ бол харамсалтай нь одоогийн байдлаар бол аймгуудын хувьд нийт 330 сумаас ойролцоогоор 30 гаруй нь л одоогоор орлого нь зарлагаасаа давсан байна. Тэгэхлээр энийг илүү бэхжүүлэх шаардлагатай байна. Дараачийн нэг хийсэн ажил бол ААНОАТ-ын 40 хувийг бол аймагт нь үлдээдэг болчихсон. Тэгэхлээр бол энэ хэмжээгээрээ үлдээчхэж байгаа юм. Тэгэхлээр орлого илүү их олох юм бол энэ аймгийн хувьд бол дэвшилттэй бие дааж ажиллах нь гэдэг ийм ойлголтыг л Сангийн яамны хувьд бол өгөх гээд ажиллаад байгаа.

Мэдээж хэрэг уул уурхайтай аймгуудын хувьд бол энэ боломж нь хамаагүй илүү байгаа. Тэгэхлээр орон нутгийн хөгжлийн сан гэж аймгуудын хувьд нэг хөрөнгийн эх үүсвэр байдаг. Энэ маань өөрөө орон нутгийн хөгжлийн сангийн гол эх үүсвэр маань АМНАТ-ын 10 хувь байгаад байдаг. Тэгэхлээр АМНАТ-ын 10 хувийг бид өмнө нь бол бодлогын хувьд бол бүх иргэдийн тоогоор газар нутгийн хэмжээгээр гээд тэгшитгэж өгдөг байсан бол АМНАТ төвлөрүүлсэн хэмжээгээр нь буюу орлого олсон ийм аймагт нь илүү ихийг өгдөг байх ийм бодлогыг бол гаргаж ирээд явж байгаа.

Цаашдаа энэ хувийг бид нар цаашаа нэмэгдүүлээд явна гэсэн тийм бодлогын зорилт тавиад бол ажиллаж байгаа. Баярлалаа.

Х.Булгантуяа: ХАА-н сайд. Амарсайхан Шадар сайд. ХААЯ-аас хүн байна уу? ХААЯ Төрийн нарийн. Хосбаяр гишүүн нэмж тодруулъя. Хэрэг эрхлэхийн дарга сайд нарыгаа дуудаарай.

Г.Хосбаяр: ХАА-н сайдыг байсан бол энэ нөгөө ноолуур мах 2-ыг л асуугаад байгаа юм л даа. Говь компани маань Монголын ноолуурын салбарын том тоглогч, том үйлдвэрлэгч. Тэгээд сүүлийн өдрүүдэд энэ Говь компанийн ХК байж байгаад ХХК болж байгаа гээд бас энэ компанийн түвшинд нэлээн өөрчлөлт орж байгаа гээд ийм эмзэг мэдээлэл л яваад байна л даа. Тэгэхээр энэ дээр Санхүүгийн зохицуулах хороо 1 тайлбар хэлээч ээ. Үнэхээр тэр жижиг хувьцаа эзэмшигчдээ хохироочих вий мөн энэ Монголын ХАА-н чухал салбар стратегийн салбарт байгаа энэ том үйлдвэр маань алга болчих вий, эсвэл дампуурчих вий гээд олон ийм бодлогын юм баймаар байна л даа. Тэгэхээр энэ дээр нэг СЗХ тайлбар хэлээч?

Махны экспорт одоо ер нь яг ямар байгаа юм бэ? Өнгөрсөн жил бол нэлээн ахиу мах экспортлоод дажгүй валют орж ирсэн гэж ойлгож байгаа. Тэгээд энэ жил одоогоор яах вэ хөдөө орон нутагт махны үнэ гайгүй байна. Энийг бол би мах экспортлоод байна, экспортлох юм байна гэж харж байна. Тэгэхээр энэ.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон СЗХ.

Т.Жамбаажамц: Гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Хосбаяр гишүүний асуултад хариулъя.

Яг өнөөдрийн байдлаар Монголын хөрөнгийн бирж дээр Говь ХК-ийн. Хувьцааны арилжаа хэвийн үргэлжилж байгаа. Өөрөөр хэлбэл Говь ХК ХК-ийнхаа хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна. Аливаа ХК хэлбэрээ өөрчилж ХХК болох хуулийн боломж байдаг. 3 үе шатаар хэрэгждэг. Эхлээд компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаасаа дийлэнх хурлынхаа шийдвэрээр энэ хэлбэрээ өөрчлөх шийдвэрээ гаргана. Дараагаар нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага буюу Хөрөнгийн биржид хүсэлтээ гаргаж Хөрөнгийн бирж өөрийнхөө бүртгэлээс хасагдаж, улмаар СЗХ 3 дахь шатад нь хянадаг байгаа. Тэгэхдээ энэ дээр бол хамгийн чухал зүйл энэ жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах. Үнэлгээ тайлан нь бодитой юу үгүй юу. Аудитын тайлан болон хөрөнгийн үнэлгээний тайлан сүүлийн жилүүдийн санхүүгийн тайлан.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон нэмж өгье.

Х.Булгантуяа: Нэгж хувьцааг эргүүлж худалдаж авах үнийг бодитой тогтоосон эсэх гээд их олон тийм мэргэжлийн байгууллагуудын үнэлэлт дүгнэлт дээр үндэслэж энэ шийдвэрийг гаргадаг. Гэхдээ компани хувьцаа эзэмшигчдийн хурлаараа энэ шийдвэрийг гаргасан гэдэг нь компани ХК биш боллоо гэсэн үг биш ээ. СЗХ-ний хувьд бол хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах ялангуяа энэ жижиг хувьцаа эзэмшигчдийн 25 мянган жижиг хувьцаа эзэмшигчтэй ийм том ХК байгаа.

Тэгэхээр энэ хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд бол энэ мэргэжлийн байгууллагуудаас гаргасан дүгнэлтийг маш сайтар хянаж ингэж үзнэ. СЗХ-н дээр өнөөдрийн байдлаар хүсэлт ирүүлээгүй байгаа. Хөрөнгийн бирж дээр хяналтын ажил хэрэгжүүлж явж байгаа. Тэгээд СЗХ энэ үнэлгээний тайлан, аудитын тайлан болон бусад санхүүгийн баримтад үндэслэж энийг хянах ажиллагааг хийх юм аа. Тэгэхдээ хамгийн гол зүйл бол ХК-ийн жижиг хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг тэргүүн ээлжид.

Х.Булгантуяа: Хосбаяр гишүүн нэмж тодруулъя.

Г.Хосбаяр: Учрал сайдаас л асууя даа. Тэгвэл энэ нөгөө бүсийн хөгжил бид нар бүсийн төвүүдийг яаж хөрөнгө оруулалт хийж дэмжих юм. Мөн сумдууд дотор мөн 330 сумаас бас 90 өсөлтийн төв байна гээд ингээд энэ юмнууд маань ер нь яг ирэх жилүүдэд явах уу? Саяын Сангийн яамны хэлтсийн даргын хэлж байгаагаар 10 жил төлөвлөсөн гэж байна. Дахиад л нөгөө одоо хийсэн ТЭЗҮ зураг төсөл. Энэ төлөвлөгөөнүүд чинь 10 жилийн дараа хэрэгжинэ гэвэл дахиад л төсөв мөнгө цаг үе нь өөр болно оо тэгэхээр энэ дээр ер нь яг ямар бодлого барьж байна аа. Үнэхээр тэр төр хувийн хэвшлийн түншлэлийн хууль нь орж ирээд яг тэрэн дээр энэ бүсийн хөгжлийг дэмжих тийм хэмжээний төсөл хөтөлбөрийг яг хэрэгжүүлээд явах тийм боломж байгаа юу. Тийм төлөвлөгөө байгаа юу? Тэгэхгүй бид нар чинь бүсчилсэн байдлаар сонгуулиа явуулсан бүсчилсэн хөгжлийн тухай баахан ярьчихсан байж байж одоо эргээд ингээд бүгдээрээ чимээгүй болчихож болохгүй шүү дээ. Одоо хөдөө орон нутгийн иргэд асууж байна. Нөгөө бүсчилсэн хөгжил юу болсон, яах вэ, ийх вэ гээд.

Тэгээд энэ тал дээр нэг тайлбар мэдээлэл сонсмоор.

Х.Булгантуяа: Эдийн засаг, Хөгжлийн сайд, Учрал сайд хариулъя.

Н.Учрал: 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр Их Хурлаар батлагдсан. Тэгэхээр энэ 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ утгаараа бол бид нар үйл ажиллагааны хөтөлбөрт байсан 149 төслийг эрэмбийн тогтоосон. Энэ төслүүд дотроо 5 чиглэлд хуваагдаж байгаа. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлтэй холбоотой 52 төсөл, эрчим хүчний шинэчлэлтэй холбоотой 36, Ногоон хөгжилтэй холбоотой 10 төсөл, хүний хөгжилтэй холбоотой 6 төсөл, таны хэлж байгаа бүсчилсэн хөгжилтэй холбоотой 45 төсөл байгаа. Тэгээд энэ 120 энэ эдгээр төслүүдээс бол ер нь бараг нэг 76 л төсвөөс тодорхой тийм санхүүжилт авч явахаас биш бусад нь санхүүжилт нь тодорхойгүй, ТЭЗҮ-тэй, ТЭЗҮ-гүй олон ажлууд бол байна аа.

Тийм учраас ирэх онд зураг төсөв ТЭЗҮ-үүдийг нь боловсруулах төслүүдийг ангилсан. Санхүүжилтээр бол Төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг төсөвтөө дагуулж орж ирж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Жаргалсайхан.

Д.Жаргалсайхан: Ингээд нүүрс унахаар манай эдийн засаг ингээд тогтворгүй болдог. Цалин хөлс маань ингээд тогтворгүй болдог. Тэгээд энэ дээр олон жил ярьж байсан. Тэгээд нүүрсний үнэ унаад бид нар яг бодит байдал дээрээ бас төсвөө яаж танах вэ яаж энэ орлогодоо багтаах вэ гэдэг дээр нэлээдгүй зүйлийг гишүүд ярьж байна. 2023 онд гэхэд жишээ нь энэ манай урсгал зардал 30 хувиар өсчихсөн байгаа юм. Янз янзын ингээд төрийнхөө албан хаагчдаа цомхотгоод бариад ингээд янз янзын арга хэмжээ авсны үр дүнд 2026 оны төсөөлөл нь 2.4 хувиар өсөж орж ирж байна. Энэ бол амжилт юм аа. Ер нь цаашдаа энэ урсгал зардлаа бид нар барьж явахгүй бол ингээд л инфляц өсөхөөр ингээд л нэмээд л байдаг, нэмээд л байдаг, сүүлдээ даахгүй хэмжээнд ингээд ирсэн. Тэгээд нүүрсний үнэ унахаар ингээд л сандардаг. Тэгэхээр ер нь тодорхой, шударга, ил тод байх нь зөв л дөө.

Тэгэхээр энэ жилийн төсвийг бол бидний хувьд их дажгүй ороод иржээ гэж ингэж хэлэх гээд байгаа юм. Нэг асуулт байна. Энэ хөрөнгийн зардал дээр бусад хөрөнгийн зардал ингээд 800 тэрбумаар өсчихсөн байгаа юм. Энэ яагаад өсчхөв энэ дээрээ нэг хариулт өгөөч ээ. Мөн дээрээс нь энэ ард иргэд дээр тулгамдаж байгаа асуудал энэ үнийн өсөлтийн асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр бидний хувьд энэ үнийн өсөлтийг зогсоох дээр ямар арга хэмжээ авч байна вэ? Энэ сумууд дээр 92 бензин 5 мянга хүрчихсэн ч байх шиг.

Тэгээд энэний чинь цаана л нөгөө зардал өсөж байгаа. Янз янзын л бүтээгдэхүүн өсөж байгаа, ард иргэд дээр амьдрал жоохон хүнд тусаж очиж байна. Ер нь энэ ШӨХТГ гэж байна уу? Энэ хаана явна вэ? Ажлаа хийж байна уу? Дараа нь энэ Монголбанк өмнөх мөнгөний бодлогын талаар Улсын Их Хурал дээр танилцуулгаа хийгээд нэлээн томоохон амлалтуудыг авсан. Монголбанкнаас хүн байна уу инфляцаа янзын сайхан бууруулна, ёстой амлалт өгч байна танд гээд ингээд олон гишүүдийн өмнө ингээд хэлээд гарсан. Өнөөдөр яг энэ маань биеллээ олохгүй байна. Энэ дээр хариулт хүсэж байна. Импортыг орлох бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэл дээр манай Эдийн засаг хөгжлийн яам маань ямар бодлого барьж байна вэ? Энэ ер нь юу болж байна? Ийм ийм зүйлүүд дээр ажиллаж байж бид нар энэ инфляцыг бууруулах энэ ард иргэд дээр очиж энэ үнийн өсөлтийг зогсоох дээр ажиллах ёстой байх гэж бодож байна.

Дараагийн асуудал энэ ард иргэд маань их ярьж байна аа. Тойрогтоо очиж ажиллалаа, иргэд маань ярьж байна. 40, 50 сая төгрөгийн цалинтай ТӨК-ийн захирал гээд ярьж байна. Ер нь энэ ТӨК-уд руугаа энэ орон нутгийн өмчит компаниуд руугаа бид нар ажиллахгүй бол болохоо байсан. Сувиллын газартай, амралтын газартай, спорт заалтай одоо бид нар ойрхон жишээ ярья. Энэ Монголбанк спорт заалтай, Хууль зүйн яам спорт заалтай. Үгүй энэ чинь энэ сургууль уу? Энэ спорт заалаар яах гэж байгаа юм. Тэгээд нөгөөдөхөө ингээд түрээслээд сууж байдаг. Энэний чинь цаана ингээд л маш их урсгал зардал халаалтын зардал ингээд л үйлчилгээний ажилтны зардал гээд бүгд явж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ энэ байдлаасаа болоод манай төрийн энэ зарим энэ илүүдсэн энэ.

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Хэд хоногийн өмнө Монголбанк бодлогын хүүгээ зарласан. Тэгэхээр бид бол төсөв мөнгөний бодлого бол уялдаатай байна гэж харж байгаа. Инфляц бол энэ 8 дугаар сарын байдлаар 8.8 хувьтай. Монголбанк бол 6 хувь гэж гол зорилтоо тогтоогоод 4-өөс 8 хувийн интервалд байлгахаар зорьж бодлогын тохируулгаа бол хийж ажиллаж байгаа. Тэгэхээр бид нар яг интервалдаа бол байгаа. Тэгэхээр инфляцыг 7 хувь гэж төсөөлж байгаа нь зорилтод интервалтай нийцэж байна гэж ингэж үзэж байгаа. Яах вэ энэ бол уялдаатай ажиллаж байгаа хэлбэр. Гэхдээ энэ инфляц өсөхөөс сэргийлэх зорилгоор Засгийн газар ажил хийх ёстой. Энэ талаар энэ утгаараа бол энэ удаагийн төсвийг оруулж ирсэн. Нэг ёсондоо бол урсгал хэдийгээр хуулиараа бол 30 хувь байж болох ч гэсэн Жи Ди Пи-ийн 30 хувь байж болох ч гэсэн жилийн төлөвлөгөөнд туссан 24 хувиа барьсан.

Ингээд урсгалд 24 хувиа барина гэхээр мэдээж энэ бол өөрөө урсгал зардлаа хязгаарлаж байгаагаараа инфляцад эерэг нөлөө үзүүлэхээр зорьж байна гэсэн үг. Ингээд бид нар энэ нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого нь суурь зарлагаа тэнцвэржүүлсэн орлогоосоо хасахаар суурь тэнцэл нь өөрөө 2 хувийн ашигтай гарч байгаа. Тэгэхээр энэ бол мэдээж одоо инфляц өсөхөөс сэргийлэх зорилготой арга хэмжээ мөн үү гэвэл мөн. Мөн хүнсний нийлүүлэлтийгээ дэмжих бодлого барьж байна.

Тэгэхээр энэ атрын аян энэ хүнсний хувьсгал гээд энэ хөнгөлөлттэй зээлүүд мэдээж үргэлжилнэ. Мөн чөлөөт худалдааны хэлэлцээрүүд буюу худалдааг хөнгөвчлөх бодлого 95, 98 хувь, 90 орчим хувь гээд ингээд ялгамжтайгаар гаалийн тарифыг хөнгөлөх бодлогын хүрээнд 200 сая хүнтэй зах зээлд ХАА-н салбарын бүтээгдэхүүнийг нийлүүлэх хэлэлцээр зурагдсан. Одоо 5 орны парламентаар орсны дараа энэ чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг амилуулах ажлуудыг зохион байгуулна. Экспортыг дэмжих хүрээнд гаалийн үйл ажиллагаа, хил боомтуудын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, цахимжилтыг нь хурдлуулах, мэдээлэл солилцох боломжийг нь хангуулах зорилгоор гаднын хөрш улсуудтай ч гэсэн, дотооддоо ч гэсэн авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд явж байна. Сая экспортын ажлын хэсэг дээр бол тогтоол, Засгийн газрын тогтоол гарсан. Энэ бол дандаа энэ экспортыг дэмжих чиглэлээр арга хэмжээнүүдийг авч байна.

Ингэснээрээ бол борлуулалт нэмэгдэж байна, гарцууд бол сайжирч байна. Ингээд гааль дээр ч гэсэн сая журам нь өөрчлөгдсөнтэй холбогдуулаад шат дарааллууд үе шатуудтай буурч эхэлсэн. Тэгэхээр ер нь бол инфляцад бол арга хэмжээнүүдийг Засгийн газраас тогтмол авч хэрэгжүүлж байгаа. Мөн энэ ковидын үеэр үнийн хувьд хэт их хөөргөдөл үүсгэчихсэн. Тэр цагаас хойш огт буугаагүй, үнэ нь огт буугаагүй хэрэглээний сагсанд байдаг энэ хэдэн бүтээгдэхүүн байна. Үүн дээр ч гэсэн шалгалт явуулж байна. Монополын эсрэг газар бол Доржханд сайдын дэргэд байдаг. Гэхдээ яах вэ мэдээж Эдийн засаг, хөгжлийн яамнаас бол энэ Монополын эсрэг газарт тодорхой чиглэлүүдийг өгсөн. Энэ инфляцыг өдөөгөөд байгаа тодорхой бүтээгдэхүүнүүд дээр үнэ бууруулах худалдан авалтыг нь багцаар хийх, ялангуяа энэ эрүүл мэндийн салбарын эм, эмнэлгийн хэрэгслүүд дээр хүртэл үнэ бууруулах ямар бодлогууд байх вэ гэдэг дээр бол зохих арга хэмжээнүүдийг авахаар шалгалт оруулаад ингээд явж байгаа. Бүхэлдээ бол энэ Эдийн засгийн эрх чөлөөний хууль, Хөрөнгө оруулалтын хууль, энэ тендерийн хууль энэ төрийн зүгээс хувийн хэвшлийн үйл ажиллагаанд хэт их зохицуулалт хийж оролцдог зах зээл рүү халддаг энэ байдлуудыг зохицуулахаар 110 хуулийн өөрчлөлт орж ирнэ. Энэ бол бүгдээрээ л инфляцад.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам. Санжаадорж гишүүний асуултад хариулъя.

Бид нарын ирүүлж байгаа тооцоон дээр бол нэгдсэн төсвийн нийт зарлага дотор бол бусад хөрөнгө гэсэн ангилал байдаг. Энэ бол нөгөө Их Хурлаас улсын төсвийг баталж байгаа нийгмийн даатгалын сан, ЭМД-ын төсвийг баталж байгаа. Харин орон нутгийн төсвийг баталдаггүй. Орон нутгийн төсөв бол ингэж бөөн дүнгээрээ тооцооллын байдлаар орж ирдэг. Энэ маань өөрөө орон нутаг дээрээ очоод тэндээ задардаг гэсэн үг. Тэгэхээр бусад хөрөнгө дээр байгаа нийт 3 их наяд 942 тэрбум төгрөгийг бол 753.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байгаа. Үүнд нэмэгдэж байгаа хэд хэдэн шалтгаан байна. 1 дүгээрт бол төсвийн тухай хуулийн 56.22-т заасны дагуу аймаг нийслэлийн нөгөө орлого зарлагаа тооцоод гаргаад ирэхлээр хэрвээ ашигтай байгаа аймаг байх юм бол мөн сум ялгаагүй сум байх юм бол тухайн ашгийнх нь 70 хувийг бид нар хөрөнгө оруулалт болгож үлдээх ёстой байдаг.

Тэгэхээр энэ нөгөө объект нэг бүрээрээ биш учраас бид нар бусад зардалдаа бүртгэдэг байсан.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон нэмж өгье.

М.Санжаадорж: Уучлаарай энэ зардал бол 332 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн нийслэлийн болон аймгийн авто замын сан гэж байдаг энэ нөгөө хүү торгуультай холбоотой болон бусад орлогуудаас шалтгаалаад нэмэгддэг. Энэ 205 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн Өмнөговь аймгийн үнэт цаас гаргах зардал бол бас энэ бусад зардлын хөрөнгө дээр нэмэгдэнэ. 150 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Мөн зарим татвар хураамжийг ИТХ өөрөө тогтоох эрхтэй байдаг. Улсын Их Хурал дээрээс бол зөвхөн интервалыг тогтоогоод өгчихсөн байдаг. Жишээ нь үл хөдлөх 2 хүртэл гээд. Бид бол хамгийн бага хувиар энэ тооцоолол байдаг. Гэхдээ нэмэгдүүлэх боломж нь тухайн аймаг, нийслэл, сумдаа хөрөнгийн зардал байна гээд тооцдог. Энэ 79 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Мөн орон нутгийн хөгжлийн сан 416 тэрбум байгаа нь энэ жил, ирэх жил 440 тэрбум төгрөг болж байгаа. Энэ нь бас 24 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна аа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Жаргалсайхан гишүүн нэмж тодруулна.

Д.Жаргалсайхан: Манай ЭМД-ын сан бол энэ хөдөө орон нутагт маш их доголдсон. Суманд дөрөвхөн хүн хэвтээд л квот дуусчихсан гээд хүн хэвтүүлэхгүй байна. Мөн дээрээс нь 7 хонуулаад л шууд гаргачхаж байгаа юм. Та өгөхгүй юм байна гээд л. Тэгээд энэ дээр ард иргэд маань маш их дургүйцэж байна аа. Тэгээд таны хариулт юу хэлж байгаа вэ гэхээр даргыг нь сольчихвол зүгээр болчихно оо гэдэг. Энийг бол та сайд болохоосоо өмнө л ярьж байсан асуудал шүү дээ. Тэгэхээр яагаад энэ дарга ингээд өдий хүртэл ингээд тэнд энэ Монгол Улсын, ийм том эрүүл мэндийн салбарыг ингээд шатаагаад сууж байдаг юм бэ? Энэ асуудлаа хурдан шийдээч. Тэгээд энэ нэг дарга сольсноор шийдчихнэ гэж би бодохгүй байгаа. Энэ дээрээ хариулт өгөөч ээ.

Дараагийн асуудал манай энэ 10 аймагт тэр тусмаа энэ хангайн бүсийн энэ 3 аймаг дээр дулааны станц барих ажил. Чойжоо сайдаа энэ их том технологи аймаар

нарийн юм байхгүй шүү дээ. Ус халаадаг л халаалтын л 1 зуух шүү дээ. Тэгээд энийг та яасан олон жил ингээд.

Х.Булгантуяа: Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя даа. Асуулт гэхээсээ түрүүлээд бараг санал байна. Шүүмжлэл гэж ойлгож авлаа. Харамсалтай нь 2021 онд Корео Эксим банкны санхүүжилтээр Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулагдаад. Солонгосын талаас ерөнхий гүйцэтгэгч томилогдоод явсан. Ковид дамжуулаад түүний дараа 2022, 2023, 2024 онуудад энэ компанийг нэлээн шахаж байсан боловчиг дампуурсан. Одоо энэ компани цаашаа үргэлжлүүлэхгүй нь тодорхой болчихсон. Солонгосын Эксим банкнаас ажлын хэсэг гараад ирчихсэн байна. Одоо хийсэн ажлыг нь хүлээж аваад цаашаа яаж дуусгах вэ гэдэг, дуусгах төсвийг нь хийгээд. Энэ 11 сарын 1 гэхэд дуусгахаар ийм төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Энэ ажлын хэсгийн дүгнэлт гарсны дараа Кореа Эксим банкны зээлийг цааш нь үргэлжлүүлэх үү, эс бөгөөс энэ зээлийн хэлэлцээрийг зогсоогоод.

Х.Булгантуяа: Чойжилсүрэн сайдын микрофоныг нэмж өгье.

Б.Чойжилсүрэн: Яаж дуусгах вэ гэдэг асуудлаар энэ 11 сарын эхний 7 хоног гэхэд бид нар тодорхой болгоод Засгийн газарт танилцуулна. Холбогдох байнгын хороодууддаа танилцуулах гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа.

Х.Булгантуяа: Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Жаргалсайхан гишүүнээ ганцхан даргыг нь солиод мэдээж бүх зүйл сайхан болчихгүй ойлгомжтой. Гэхдээ даргын манлайлал, зөв байдал, алагчилдаггүй байдал, ил тод байдал энэ бүхэн их чухал.

Тийм учраас эндээс эхэлнэ. Өдий болтол яагаад сольсонгүй вэ гэж байна та. Тэгэхээр энэ Засгийн, агентлагийн даргыг Засгийн газрын хурлаар орж шийдвэр гаргадаг. Засгийн газарт өнгөрсөн энэ 7 хоногт танилцуулаад тэгээд сольж сонгон шалгаруулалт хийх үүргийг Ерөнхий сайд надад өгсөн учраас сонсох ажил нь эхэлж байгаа. Мэдээж даргыг нь солиод болохгүй ч гэсэн бид энэ 2026 онд нэг хийх гэж байгаа чухал зүйл бол төсөвтэй хамт ЭМД-ын санг бие даасан тогтолцоог нь илүү тогтвортой сайн болгох энэ нөхцөлийг бүрдүүлэх хөтөлбөрийг хамт өргөн барьсан байгаа. Энийг Сангийн яамтай хамтраад бид энэ хөтөлбөрөө өргөн бариад энэ чиглэлд 2026 ондоо ямар ч байсан ингэж.

Х.Булгантуяа: Тэгье гүйцээгээд хариулъя. Чинбүрэн сайдын микрофон. Тэгэхээр даатгалын тогтолцооны энэ гажуудал нь цоорхой сав шиг болчихоод байгаа учраас эхлээд цоорхойг нь бид эмчлэхгүй бол хэдэн ч төгрөг нэмсэн энэ нэмэр болохгүй гэдэг нь нэгэнт тодорхой болсон.

Дараагийн асуудал бол та зөв хэлж байна. Мэдээж иргэд маань та бүхэнд зөндөө л хэлж байгаа. Өнөөдөр 10 хүн өвчин тусаад эмнэлэгт хэвтэхэд 8 нь улсын эмнэлэгт очно. Очиход эм тариагаа бүгдийг нь өөрөө гэрээсээ зөөж байна шүү дээ. Ар гэр нь авч байна. Өнөөдөр мөнгө төгрөг байхгүй болчихсон. Энэ асуудал шийдэхэд маш төвөгтэй байдалд орчихсон байгаа. Боломжтой 2 нь хувийн

эмнэлгүүд дээр оччихно. Жоохон энэ илүү мөнгөө төлчихнө. Бүх эм тариаг нь төлчихнө. Энийг гүйцэтгэлийг нь 100 хувь даатгалын сангаас хийгээд байдаг. Нөгөө ачаалал даагаад байгаа улсын эмнэлгүүддээ алагчлаад санхүүжилт нь бөөн өр болгоод хийхгүй байгаа. Энэ нөхцөл байдал өөрөө ч гэсэн энэнд нөлөөлж байгаа юм.

Дараагийн зүйл хийх гэж байгаа гол чухал зүйл бол бид энд хамтын төлбөрийг оруулах асуудлыг ярьж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин.

Х.Тэмүүжин: Бид ер нь сургамж авдаггүй хүмүүс юм уу, эс үгүй бол ер нь хувийнх нь ааш аяг, хувийнх нь ашиг сонирхол босож байвал улс орон хамаагүй гэж боддог хүмүүс юм уу. Нэг юман дээр дуугарахгүй бол үнэхээр болохгүй байна. Улсын Их Хурлаас баталсан Засгийн газрын хэлсэн зам төмөр замын урагшаа гарсан гарц холболтыг тэр нүүрстэй холбоотой асуудал дээр нь нэлээн их шүүмжлээд бараг л улс орноо зарсан. Алдагдал ихтэй гэрээ хийчихлээ гэдэг ийм үг яриа гараад энэ үг яриаг нь Ерөнхийлөгч байсан хүн хүртэл олон нийтийн хэрэгслээр их л том тооцоотой дүгнэлтүүд том том үгнүүд хэлээд тэгээд коридорт сэтгүүлчидтэй уулзсан Улсын Их Хурлын гишүүд арьсаа хамгаалдаг юм уу, яадаг юм. Өө би бараг мэдээгүй, ойлгоогүй юу болсон юм бол гээд гэнэт сэрсэн юм шиг жүжиг тоглоод эхлэх юм. Энэ гэрээ хэлцлийг хийхэд 3 юм маш тодорхой байсан шүү дээ.

Монгол Улс хөрштэйгөө тохирсон тохироогоо за гээд хэлчихсэн тэр үгээ эргэж буцаад зальддаг гэдэг тийм дүр төрх рүү яваад орчихсон өчнөөн алдагдал өөрсдөө ч хүлээгээд айлын талыг ч оруулчихсан. Алдагдсан боломж гээд том том дүн зөндөө ярьсан. Ковидын үеэр Монгол Улс гадагшаа гарах гарц ганцхан Замын-Үүд байна. Бусад гарцаа ингээд өөрсдөө боомлоод хоолойгоо боочихсон юм шиг чахруулчихжээ. Гарцаа нэмэгдүүлье гэх мэтчилэн ингээд бөөн сургамж ярьсан. Тэгээд тэр сургамжаа гүйцэлдүүлээд ер нь хил холболтоо нэмэгдүүлэх ёстой юм байна, боомтуудаа нээх ёстой юм байна. Эдийн засгийнхаа боломжийг тэлэхийн тулд байгаа бүх дэд бүтцээ бас нэг гайгүйхэн шиг зардал багатай тээвэрлэхдэг түүхий эдээ гаргачихдаг болгочихъё гээд. Энэ нөхцөлөө яриад ойлголцсон гэж бодсон. Манай Улсын Их Хурлын гишүүд энэ дээр зөндөө ярьсан.

Хоёр дахь нь айлын талаас нөхцөл тавьсан шүү дээ. Тэрийг бүгдээрээ ойлгосон шүү дээ. Айлын тал чинь юу гэж хэлсэн гэхээр нүүрсээ төрийн өмчит 5 компанид зарж байгаа урт хугацаанд өгч байгаа тэр нөхцөлөөрөө өгчхөөч гэдэг нөхцөл тавьсан юм байна гээд ойлгосон шүү дээ. Тэгээд тэр нөхцөлөөр нь гэрээ хийгээд Улсын Их Хурлаас тогтоол гараад явуулчихсан шүү дээ.

Хэрвээ энэ үнэхээр алдагдалтай улс орноо зарах хэмжээний болсон гэж үзэх юм бол нөгөө өмнөх гэрээ байгуулсан 5 компани чинь тийм байгаа юу? Чалко, Норинко, Икоммерс, Чайна Энержитэй байгуулсан гэрээнүүд чинь ийм хулгайн гэрээ болсон юм уу. Ийм том алдагдалтай байгаа юм уу? Яагаад гэвэл энэ 5 компанийн үнийн дүнгээр барьж байгаад гэрээ хийе гээд хэлчихсэн шүү дээ. Нөгөө жоомоо алах гээд гэрээ шатаав гэдэг шиг ийм жүжиг тоглохоо болих юм биш үү? Энэ гэрээнүүдтэйгээ холбоотой.

Х.Булгантуяа: Хэрэг эрхлэхийн дарга Бямбацогт сайд хариулах уу?

С.Бямбацогт: Тэмүүжин гишүүний ярьж байгаа зөв өө. Энэ хил холболтын төмөр зам олон жил ярьсан яригдсан. Монгол Улс 2 хөрштэйгөө ганцхан төмөр замаар Наушик, Сүхбаатар, Улаанбаатар, Замын-Үүд, Эрээн гэсэн төмөр замаар далан жил холбогдож ирсэн. Үүнийг олон болгох, гарцуудаа нэмэх, экспортоо нэмэх, импортыгоо нэмэгдүүлэх, хурдан шуурхай, зардал багатай болгох энэ бодлогыг үе үеийн Улсын Их Хурал, үе үеийн Засгийн газраас хийх гэж хэрэгжүүлэх гэж явж ирсэн. Энэ хүрээндээ БНХАУ-тай 5 төмөр замаар хил холболтын төмөр зам байгуулъя гэж. Замын-Үүд Эрээн, Гашуун сухайт, Ганц мод, Шивээ хүрэн, Сэхээ.

Нөгөөдөх нь Бичигт, Зүүн хатавч, Ханги Мандал гэсэн ийм 5 төмөр замаар холбох асуудал олон жил яригдаж байгаа. Үүний хамгийн эхний том ажил нь бол Гашуун сухайт, Ганц модны хил холболтын төмөр зам. Энэ төмөр замыг холбоод энэ ажил шийдэгдсэний дараа араас нь Шивээ хүрэн-Сэхээ, түүний араас Бичигт-Зүү Хатавч гээд ингээд төмөр замууд Хятад улстай холбогдоно оо. Олон төмөр замаар холбогдох тусмаа бид экспортын орлого нэмэгдэх уул уурхайн бүтээгдэхүүнээ экспортод ахиу гаргах Монгол Улсын эдийн засагт төсөв санхүү сайжрах ийм л бодлоготой зорилготой. Нөгөө талаасаа бас гаднаас импортоор авах импортын гарц ганцхан Тяньжин гэсэн боомтоор ачаа бараагаа татдаг бол бичигт зүү хатавчаар холбосноороо бид нар дахиад 2 дахь далайд гарцтай болох ийм бололцоо боломж бүрдэнэ. Шивээ хүрэн Сэхээ цаашлаад Бургастай чиглэлийн төмөр замд баригдах юм бол бид нар Төв Азитай төмөр замаар холбогдоно. Энэ үүднээсээ л үе үеийн Их Хурал, Засгийн газар явуулж ирсэн энэ бодлого. Тэгээд зөрчсөн байсан төмөр зам үүнийг холбоход тодорхой зардал гарна. холбохдоо анх 2 тал ярилцаад ажлын хэсэг байгуулаад хэлцэл хийгээд сая өнгөрсөн онд Их Хурал энэ хил холболтын төмөр замын хэлэлцээрийг баталсан 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг.

Энэ хэлэлцээрийг батлах гэж холбогдох сайд нар мөн холбогдох албан тушаалтнууд олон сар, олон жил ажилласан юм байна лээ. Тэгээд үүнийг Их Хурал дээр орж нээлттэй ярьж байгаад л Улсын Их Хурлын 126 гишүүн бүгдээрээ шүүж үзээд л тэгээд болох юм байна гээд л баталсан. Нэгэнтээ Улсын Их Хурлаар баталсан Улсын Их Хурлын шийдвэр учраас асуудалтай байвал Улсын Их Хурал эргэж харна асуудалтай бол. Тийм болохоор өнөөдөр Улсын Их Хурал дээр энэ асуудал яригдаагүй байхад юу гэдэг юм нэгэнт Монгол Улсын Их Хурлын баталсан хууль, тогтоол шийдвэр бүгд үйлчлэх ёстой. Энэ хүрээндээ үйлчлэх ёстой л гэж харж байгаа. Үнэхээр асуудалтай байна уу үгүй юу гэдэг дээр холбогдох шаардлагатай бол Засгийн газраас, Их Хурлаас ажлын хэсэг байгуулаад ажлын хэсэг байгуулж болно оо болно. Одоогоор ийм асуудал яригдаагүй байгаа.

Тийм болохоор таны хэлж байгаа нэгэнтээ Их Хурал дээр яригдсан асуудлыг бид нар улс төржүүлээд байх одоохондоо шаардлагагүй болов уу гэсэн л тийм байр суурьтай байгаа.

Х.Булгантуяа: Тэмүүжин гишүүн нэмж тодруулна.

Х.Тэмүүжин: Бямбацогт сайдын улс төржүүлээд байх шаардлагагүй болов уу гэдэг үгтэй санал нэг байгаа юм. Ардын нам намын даргынхаа дотоод өрсөлдөөн дээр давуу байдал олох гэсэн юм уу яах гэсэн юм энэ сэдвийг гадагш нь гаргаж шидээд одоо тэгээд шидсэн сэдэвтээ өөрсдөө ороогдох хэмжээнд болж байна.

Гадуур ингээд ийм хардалт үүсэж байгаа юм. Монгол Улс ингээд Хятадын зах зээл дээр өрсөлдөгч нүүрс болон уул уурхайн бүтээгдэхүүнээ гарж зарахын тулд төмөр замаа нэмэгдүүлэх шаардлагатай байгаа. Гарц орчихсон. Яг энийгээ шийдэх болоод ирэхээр л нөгөө танк орж ирнэ гэдэг шиг дахиад нэг юм үүсээд ирэх юм. Яг энэний үр дүн дээр юу болсон бэ гэхээр сая нөгөө Владивосток гэх мэтчилэн ингээд сүүлийн хойшоо налсан хэдэн 2, 3 хэлтэстэй холбоотой юм уу яасан юм бүү мэд. Дахиад л урагшаагаа нээх гэж байгаа төмөр замууд гацах хэмжээнд ирэх гэж байна. Тэгээд олон нийт тэгж бодож байна шүү дээ. Монгол Улсыг хаалгыг нь түгжиж авч байгаад зөвхөн хойд хөршийнхөө газыг дамжуулагч төдийгөөр тийшээгээ харж амьдрах хэмжээний бодлого дахиад яваад эхэлж байгаа юм биш биз дээ гэдэг ийм хардлага хүртэл гарч эхэлж байгаа байхгүй юу.

Жоохон эрүүл саруулаар бодож дотор улс төрөө гадагш нүүр царай руугаа оруулахгүй байвал уул нь хаа хаанаа л зөв санагдаад байгаа юм. Тэгэхгүй бол үнэнийг хэлэхэд сүүлийн Газын хоолойтой холбоотой 2 хүүгийн чинь ар дээр урагшаа.

Х.Булгантуяа: Тэмүүжин гишүүн асуудлыг анхааруулж үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа.

Э.Болормаа: Ингээд 2026 оны төсвийг боловсруулсан оруулж ирэхэд амаргүй байсан гэдгийг ойлгож байна. Засгийн газарт ажиллаж байсан хүний хувьд бас хязгаарлагдмал нөөцийг хязгааргүй гэмээр их хүсэлтүүдийг эрэмбэлэн оруулж ирнэ гэдэг бол хэцүү. Энэ удаагийн төсөв дээр боловсролыг дэмжих, мөн хүний хөгжлийг нэн тэргүүнд тавьсан нь их сайшаалтай гэж харж байгаа. Би эндээс хүүхдийн шим тэжээлийг онцлон асууя гэж бодож байгаа. Хамгийн сүүлийн Монгол улсын хүн амын хоол тэжээлийн үндэсний судалгааны дүнгээр Монгол Улсад хүүхдүүдийн ЕБС-ийн хүүхдүүдийн шим тэжээлийн дутагдал маш өндөр байна гэсэн цочирдмоор дүн гарсан. Жишээлж хэлэх юм бол хүүхдүүдийн Д витамин дутагдал 90 хувьтай байна. Бүүр 67 хувь нь хүнд хэмжээний дутагдалтай байна гэсэн ийм тооцооллууд гарсан. Бас их сонин зүйл нь хот гэхээс илүү хөдөө шим тэжээлийн дутагдал өндөр байна гэсэн ийм тооцоолол гарсан.

Тэгэхээр яахын аргагүй бид нарын эрэмбийн тэргүүн эгнээнд явах ёстой зүйл бол хүүхдүүдийн шим тэжээл юм байна гэж байгаа юм. Ер нь олон улсын байгууллагууд ч гэсэн энийг хэлдэг. Жишээлбэл ДЭМБ, Дэлхийн банк, НҮБ-ын Хүүхдийн сан гэх мэтчилэн байгууллагуудын судалгаагаар хүүхдийн шим тэжээлд оруулсан нэг төгрөгийн хөрөнгө оруулалт 35 дахин буюу 35 төгрөг болон иргэн өгөөж нь ирдэг ээ. Тэгэхээр олон улсын эдийн засагчдын хувьд энэ хамгийн зөв хөрөнгө оруулалт гэж үздэг. Хүүхдийн шим тэжээл бол зардал биш хөрөнгө оруулалттай гэж хардаг байгаа. Бид нар бүүр өрхийн хэмжээнд ярих юм бол жишээлбэл шим тэжээлээ хангалттай авсан хүүхэд том болоод 25-аас 46 хувь илүү орлоготой болдог гэж Лансет гээд дэлхийн шинжлэх ухааны тэргүүлэх сэтгүүлд судалгаанд гарсан байна л даа.

Тэгэхээр энийг бид нар хэрхэн энэ төсөвтөө оруулах вэ гэдэг талаар би тодруулъя аа. Аудитын дүгнэлтээр бол Засгийн газрын нэг жилийн төлөвлөгөөнд суусан байгаа өдөр бүр нэг аяга сүү гэсэн хөтөлбөр зардал нь суугаагүй байна энэ хүүхдийн шим тэжээл гэсэн нэгдсэн байдлаар суусан байна. 263 тэрбумаар.

Тэгэхээр энэний яг задаргаа нь Наранбаяр сайдаас тодруулж асуухад яг үүнээс хэдэн төгрөгийг хүүхдийн сүүний хөтөлбөрт зарцуулж байгаа вэ?

Х.Булгантуяа: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Болормаа гишүүний асуултад хариулъя. Ер нь хүүхдийн хоолны түүхий эд материалын зардал төрийн өмчийн 222000.5 мянган хүүхдэд 122.4 тэрбум төгрөг олгохоор тооцсон байгаа. Засгийн газрын 2024 оны 73 дугаар тогтоолоор нийслэлд цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 4 мянга, улсын төсвөөс 3 мянга. Эцэг эхийн асран хамгаалагчаас мянган төгрөгийг хариуцаж хамтын санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлснээр бол шим тэжээл дээшилсэн гэж ингэж үздэг. Ер нь хүүхдийн нэг өдөр бүр нэг аяга сүү гэж энэ “Сүү хөтөлбөр” гэж ингээд яригдаж байгаа. Энэ аудитын дүгнэлтийг бид харсан. Энэ аудитын дүгнэлт дээр бол тусад нь бие даасан хөтөлбөр болгож хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн ийм байсан.

Тэгэхээр бид тооцоо хийж үзэхэд бол өнөөдөр байж байгаа энэ хүүхэд үдийн хоолны зардал дээр энэ нь шууд сүү хэлбэрээрээ тусаж ороогүй байгаа. Тусдаа ингэж хийгээд үзэх юм бол бага ангийн 1-ээс 5 дугаар ангийн хүүхдэд өнөөдөр 342296 хүүхэд сурч байна. 200 мл-ээр сүү өгнө өө гэж үзэх юм бол 7 хоногт 3 өдрөөр, 5 өдрөөр гэсэн тус тус тооцоонууд байгаа. 3 өдрөөр байгаа нөхцөлд 30 тэрбум төгрөг шинээр шаардлагатай гэж үзэж байгаа. Дунд ангид 6 дугаар ангиас 9 дүгээр анги гэсэн үг 249712 хүүхэд байна. Энэ дээр нэмэлтээр 32 тэрбум 362 сая төгрөг хэрэгтэй гээд. Нийлээд 63 орчим тэрбум төгрөгийн хэрвээ санхүүжилтийг шийдэх юм бол бид өдөр болгон 7 хоногт 3 удаа сүү хүүхдүүддээ өгөөд байх ийм боломжтой болно. Та бүхэн бүгд мэдэж байгаа. Сүүнээс бол авах эрүүл мэндийн болоод өсөлтийн бүхий л сайн талууд энд байгаа. Энэ сүү хөтөлбөрийг анх энэ Дундговь аймагт эцэг эхийн санаачилгыг мөн орон нутгийн санаачилгаар ингээд хэрэгжүүлээд ингээд эхэлсэн байгаа.

Бас нэг мэдээ байхад нийслэл бас өөрсдийнхөө төсвийг хэлэлцүүлэх үеэр 1-ээс 6 дугаар ангийн нийслэлийн хүүхдүүдэд сүүг сүү хөтөлбөрийг хэрэгжүүлж олгох боломжийг эрэлхийлж төлөвлөж байгаа юм байна лээ. Ер нь дунд ангид орон нутгийн төсвийн санхүүжилтээр Сүү хөтөлбөрийг бид хэрвээ хэрэгжүүлэх юм бол өдөр болгон сүү өгнө гэж үзэх юм бол 80.3 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн ийм тооцоо гарсан байгаа. Өмнө нь гарч байсан санаачилгуудыг харах юм бол жишээлбэл 7 хоногийн, 5 хоногийн 5 өдрийн нэг өдрийг нь Засаг дарга нь, нэг өдрийг нь ухаандаа сургуулиасаа. Нэг өдрийг нь эцэг эх нь гэх мэтээр ингээд өөрсдөө санаачилж сүү хүүхдүүддээ уулгаж эхэлсэн ийм орон нутгийн ийм байгууллагууд аймгууд байдаг. Тэгэхээр хэрвээ энэ удаагийн төсвийн хэлэлцүүлэг дотор бид энэ сүү хөтөлбөрөө тодорхой санхүүгийн эх үүсвэрийг нь нэмэгдүүлж орж ирэх юм бол би тантай 100 хувь санал нэг байна. Юу вэ гэхээрээ зэрэг энэ сүү гэдэг бол энэ хоолонд оруулж байгаа зардал биш энэ хөрөнгө оруулалт гэдэг утгаараа энэ туйлын чухал гэж харж байгаа юм. Баярлалаа.

Х.Булгантуяа: Болормаа гишүүн нэмж тодруулъя.

Э.Болормаа: Би энэ нөгөө орон нутгийн туршлагуудын нэгийг нь хэрэгжүүлсэн хүн байгаа юм л даа. Ховд аймагт ажиллаж байхдаа аймгийн иргэдийн хурлын дэмжлэгээр, шийдвэрээр бид нар Ховд аймагт 2024 онд бүх цэцэрлэгийн насны болон бага ангийн хүүхдүүдэд 7 хоногт 2 удаа сүү уулгасан. Тэгэхээр энэ

ямар эерэг үзүүлэлттэй байдгийг би яг биеэрээ аягүй сайн харж мэдэрсэн. Хэрэгжиж болдог зөвхөн орон нутгийн санаачилгаар хийж болдог. Гэхдээ яам эндээс нэг тийм зохион байгуулалтын ажил руу илүү нарийн ормоор байгаа юм. Ингээд жишээлбэл бид нар 2 сургууль дээр эцэг эхийн зардал гаргаад хөдөө сумд аймгийн төв дээр бүх хүүхдүүдэд хоол олгодог болсон. Эцэг эхийн зардлаар гэх мэтчилэн зохион байгуулалтын ажлууд дээр нэлээн анхаарч болж байгаа юм аа.

Тэгэхээр энэ дээр Эдийн засаг хөгжлийн сайд ч гэсэн анхаарах зүйл нь жилийн төлөвлөгөөнд бол 66.5 тэрбумыг суулгана гээд заачихсан байгаа. Тэгэхээр энийгээ хэрэгжүүлбэ. Энэ дээр гишүүд дэмжлэг үзүүлээд энэ хөрөнгө оруулалтыг хийе.

Х.Булгантуяа: Наранбаяр сайд нэмж хариулъя.

П.Наранбаяр: Тиймээ энэ орон нутгаасаа эхэлсэн маш зөв санаачилга байдаг. Тэгээд энэ дээр танд нэг мэдээлэл хэлэхэд улсын хэмжээнд энэ хичээлийн жилд 12 аймгийн 280 орчим сургууль, цэцэрлэгт 90 мянга орчим хүүхэд орон нутгийнхаа болоод эцэг эхийнх нь дэмжлэгтэйгээр сүү хөтөлбөрт хамрагдаад явж байгаа. Зохион байгуулалтын хувьд дэмжих, энэ дээр яам ажиллахад бэлэн байна. Энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт бас үйл ажиллагааны төлөвлөгөөнд нь тусчихсан энэ ажил байгаа. Тэгээд манай Эдийн засгийн яам бас Сангийн яам эд нар энэ гэрээн дээр бас дэмжлэг үзүүлээд явах юм бол бид хамтран ажиллахад бэлэн байна аа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Цэндсүрэнгийн Мөнхтуяа.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Засгийн газрын 2024 оны 8 сарын 28-ны өдрийн 53 дугаар тогтоол гэж гарсан. Энэ тогтоолоор цэцэрлэг ЕБС-ийн нэг сурагчид ноогдох хувьсах зардлыг байршил, хүүхдийн тооноос хамааран өсөн нэмэгдэх итгэлцүүрийг батлахдаа аймгийн төв нийслэлийн 2 мянгаас дээш сурагчтай төрийн өмчийн ЕБС-ийн нэг суралцагчийн хувьсах зардлыг үржүүлэх итгэлцүүрийг 0.91-ээс 0.79 болгосон. Энэ нь одоо 9-өөс 21 хувиар буурч очиж байгаа хүүхдүүдэд. Энэ нь Монгол хүүхдийн сурч боловсрох эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг гэж харж байгаа бид нар.

Энэ 300 гаруй мянган хүүхэд, 100 гаруй төрийн өмчийн ЕБС-ийн 600 мянган эцэг эх, 16 мянган багш, ажилтны эрх ноцтой зөрчигдөж байгаа. Наранбаяр сайд өөрөө ч мэдэж байгаа энийг. Тэгээд 50, 60-уулаа ч чихэж хохирдог.

Дээрээс нь хувьсах зардлаа ингээд тануулчихдаг байдал нь хэр тохиромжтой вэ. Тэгээд хувийн сургуульд сурдаг хүүхдүүд бол мэдээж орчин тансаг нөхцөлд байгаа. Эгэл ардын хүүхдүүд болохоор 60, 70-уулаа 1 ангид суугаад дээрээс нь хувьсах зардлаа тонуулаад сууж байна гэдэг бол үнэхээрийн байж боломгүй үзэгдэл ээ. Тэгээд хувийн сургуулийн төлөөлөл, боловсролын толгойд гараад суучихсан байдаг. Төрийн өмчийнхөө сургуулиудаар ер нь явж байна уу Наранбаяр сайд аа.

2026 онд багш нарын цалин 25 хувиар нэмэгдүүлнэ гээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр Сангийн сайд үгүй гээд байгаа юм. Сангийн сайд та 2 яг хоёулаа 1 хариулт өг дөө. Багш нар энэнд итгээд явж байгаа шүү дээ. 25 хувь нэмнэ гээд.

Дараагийн асуудал багш нарын нэмэгдлүүдийг үндсэн цалинд оруулна гэж юу яриад байна Наранбаяр сайд аа. Нөгөө нэг жоохон мөнгийг нь дахиад л хасаж танах юм яриад байх юм. Одоо энэ багш нар чинь дэвтэр засалтын мөнгө авъя нэмэгдүүлж авъя гээд байгаа шүү дээ. Тэгж байхад дээрээс нь энэ нөгөө багш нарынхаа хэдэн анги даалт, кабинет гээд нэмэгдлүүдийг хасаад үндсэн цалинд оруулна гэсэн ийм шум яваад байна аа. Хамгийн сүүлд нэг ноцтой асуудал байна аа. Хүүхдийн ходоод руу бид нар хоол хийгээд байна уу, хор хийгээд байна уу гэдэг асуудал яригдаж байна. Өнөөдөр хүүхдийн үдийн цай ямар ч чанаргүй шим тэжээлгүй. Тэгээд дээрээс нь тэр нэг цахим дэлгүүр гэдэг нэг ийм тонон дээрэмдэх газар бий болчихсон байна. Бүх юмыг цахим дэлгүүрээс ав гэнэ. Тэгээд цахим дэлгүүрийнх нь юмнууд чанаргүй, ангийн багш нар анги удирдсан багш нар цэцэрлэгийн багш нар ярьж байна шүү дээ. Хүүхдийн хоол үнэхээр шим тэжээлгүй чанаргүй байна аа. Энэ хүүхдийн хоолыг.

Х.Булгантуяа: Наранбаяр сайд түрүүлж хариулъя. Тэгээд Сангийн сайд.

П.Наранбаяр: Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя. Хувьсах зардлын асуудлын тухайд бол сургуулийн сургалтын байгууллагын хүүхдийн тооноос хамаарсан итгэлцүүр байдаг. Энэ нь манай улсын газар зүй, хүн ам зүйн онцлогоос хамааруулаад боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн сургалтын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад оршиж байгаа. Манай улсын хувьд ЕБС нь 9-өөс 6 мянга хүртэл ийм хүүхэдтэй сургуулиуд байдаг. Нөгөө талаасаа хүүхдийн тооны итгэлцүүр нь боловсролын чанарыг дээшлүүлэх ийм хөшүүрэг байх боломжтойгоор тогтоож байгаа. Өөрөөр хэлэх юм бол өнөөгийн нөхцөл байдлаас шалтгаалан ерөнхий боловсролын сургуулиуд дунджаар 2 мянган хүүхэдтэй байгаа. Тэгэхээрээ Засгийн газраас тогтоосон нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлын хэмжээ нь дундаж хэмжээ. Тэгээд энэнээсээ олон хүүхэдтэй сургалтын байгууллагуудын итгэлцүүр нь буурах хувьтай байхаар ингэж тооцоолсон байгаа.

Энэ нь бол сургалтын байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байхаар ингэж тооцсон. Тэгэхээрээ хүүхэд цөөтэй газар бас энэ хувьсах зардлыг түлхүү олгохгүй бол сургуулийн одоо хэвийн үйл ажиллагааг хангах боломжгүй болдог гэдгийг та ч ойлгож байгаа байх аа. Цалингийн асуудал дээр бол бид судалгаа хийж үзсэн. 25 хувиар нэмэгдүүлэх юм бол 560 тэрбум төгрөг нэмэлтээр хэрэгтэй байна гээд. Ийм тооцоог гаргаж өгч Сангийн яамандаа хүргүүлсэн байгаа. Энэ дээр бол бид нэмж чадах эсэх нь энэ Улсын Их Хурлын өөрийнх нь шийдэх асуудал.

Өнөөдөр төсвийн энэ асуудал яригдаж байгаа ийм үед ялангуяа урсгал зардлаа бид нэмж чадах уу үгүй юу? Тэр улсын төлөвлөгөөн дотор байгаа 24 хувийг бид хуульд заасан 30 хувь руу оруулж чадах уу үгүй юу гэдэг нь өөрөө энэ цалин нэмэхдээ шууд холбогдоод явчихна. Эрдэнэбат гишүүн бас хэлээд байна лээ. Тэр тэтгэврийн сан нийгмийн даатгалын сан эд нарыг энэ урсгал зардал дээр ингээд бүрэн тооцож оруулдаг чинь буруу шүү гээд. Ийм бичилт эд нараа янзалж чадах юм бол бид нар энэ цалинг нэмэх боломжууд гарч ирэх юм байна гэдгийг ингэж харж байгаа. Ер үндсэн цалинг нь нэмэхгүйгээр бид өнөөдөр энэ чанарлаг сайн багшийг өнөөдөр сургуулиуд дээр ажилд оруулах нь хүндэрсээр байгаа гэдэг энэ бодитой байдлыг та ч мэдэж байгаа бид ч мэдэж байгаа. Цалин нэмүүлэх тал дээр бид бүгдээрээ адилхан байр суурьтай байгаа гэдгийг энд онцлон тэмдэглэе ээ. Түүний

зэрэгцээ цалингийн бүтэц дээр бид судалгаа хийж үзэхэд бол ер нь нэмэгдлүүдээ тооцсоор байгаад хамгийн ихдээ 1.5 дахин их авч байна. Ингээд ийм цалингийн айхтар их ялгаа гаргасан явдал үндсэн цалинг нэмэх шаардлага байна гэдгийг л харуулаад байгаа юм.

Бид бүх нэмэгдлүүдийг үндсэн цалинд ерөөсөө шингээсэн юм байхгүй ээ. Хоёрхон нэмэгдлийг л тэр докторынх нь нэмэгдэл байна. Магистрынх нь нэмэгдэл тэр доктор дээр олгодог нэмэгдэл байгаа. Эрдмийн зэргийн. Мөн одоо кабинет хариуцсан энэ нэмэгдэл гэх мэт ийм л зүйлүүдийг нь үндсэн цалин руу нь гүйцэтгэлийн үнэлгээнийхээ ер нь 50 хувийг нь үндсэн цалинд нь шингээчихье гэсэн ийм л тооцоолол хийсэн юм. Тэгэхээр зэрэг энийг хэрвээ шаардлагатай гэвэл би танд нарийвчилсан бүх мэдээллийг өгөхөд бэлэн байна аа. Хүүхдийн хоол тэжээл илчлэгийн хэмжээний тухайд бол бид бас өдөр тутамдаа энэ хоол зүйч ажиллуулж байгаа. Мөн өнөөдөр энэ түүхий эдийн зардлыг хэрхэн оновчтой зарцуулж байна вэ гэдэг дээр хяналт тавиад явж байгаа.

Тодорхой жишээнүүд байвал та надад өгөөрэй. Тэрэн дээр бид арга хэмжээ аваад явна аа. Хоол тэжээл гэдэг бол хүүхдийн өсөлтөд бол эергээр нөлөөлдөг. Түрүүнд бас энэ Болормаа гишүүн хэлж байсан. Энэ хүүхдэд оруулж байгаа хоол тэжээлийн чинь энэ зардал биш шүү, хөрөнгө оруулалт шүү гэдэг. Энэ бол яахын аргагүй үнэн үг. Энэ чиглэлээр бид дорвитой шинэчлэл хийхээр бас энэ сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар бас энэ намрын чуулганд өргөн барьж байгаа гэдгийг танд хэлье ээ. Баярлалаа.

Х.Булгантуяа: Мөнхтуяа гишүүн нэмж тодруулна.

Ц.Мөнхтуяа: Хүн ам зүйн бодлогоос хамаараад олон хүүхэдтэй тусмаа хохироод байх юм уу сайд аа. Цөөн хүүхэдтэй нь сургалтын таатай орчин бүрдүүлээд олон хүүхэдтэй 60, 70-аараа сууж байгаа хүүхдүүд нь хувьсах зардлаа хасуулаад хохироод суух ёстой юм байна таны бодлоор бол би тэгж ойлголоо. Сая та тэгж хэлж байна шүү дээ. Тэгээд одоо энэ цахим дэлгүүр гээд нэг луйврын газар байна. Энийгээ тайлбарла даа. Хүүхдийн хоол тэжээлийг ингээд нийлүүлж байгаа гээд цахим дэлгүүр гээд эзэгнээд суучихсан нэг хэдэн монопол нөхдүүд энэ хүүхдийн хоолыг идэж уугаад сууж байна шүү дээ. Хүүхдэд нь очих ёстой хамаг мөнгийг нь танаад хасаад тэгээд илчлэгийг нь бууруулаад явдаг юм уу. Би одоо энэн дээр бол ажлын хэсэг байгуулаад энэ Болормаа гишүүн эд нартай хамтраад явъя гэж бодож байна. Хүүхдийн хоолны асуудлаар. Яахаараа тэр нэг монопол хэдхэн компани нь сургуулийн захирал тэр цэцэрлэгийн эрхлэгч нарыг дарамтлаад заавал цахим дэлгүүрээс махаа ав, будаагаа ав гээд сууж байдаг юм. Ингэж болохгүй шүү дээ. Энэ хүүхдийн хоолоор хүртэл ингээд муухай бизнес хийчихсэн ийм муухай байж болохгүй үнэхээр ёс зүйгүй санагдлаа.

Х.Булгантуяа: Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя аа.

Тэгэхээр түрүүнд би тайлбарласанчлан ер нь бол 2 мянган хүүхэдтэй сургуулийг л дундаж болгож үзээд тэрэн дээр хувьсах зардлаа тооцоод сургуулийн үйл ажиллагааг ямар нэгэн саадгүй явуулахад зориулсан ийм тооцоолол дээр үндэслэсэн. Хувьсах зардал өөрөө хэмжээ хязгаартай. Тэгээд энэ дээр нь цөөхөн хүүхэдтэй сумын сургуулиудыг бид хаячхаж болохгүй шүү дээ. Хүүхдийн тоогоор

ингээд зардал нь очиж байгаа үед хүүхэд нь цөөхөн багш ажилтнуудынхаа цалингаас авхуулаад хангамжаас нөхөн хангалтын зардлаас авхуулаад явуулж болохгүй.

Тийм учраас 2 мянга дээр дундажлаад 2 мянгаас дээш гарсан тохиолдолд итгэлцүүрийг нь бууруулж ингэж тооцож байгаа гэдгийг танд хэлье. Тэр цахим дэлгүүрийн асуудал бол тендерийн хуулиар явдаг. Энэ яг шууд манай яамны хариуцаад ингээд явдаг юм биш. Тендерийн хуулиараа цахим дэлгүүрээсээ худалдан авалт хийдэг. Энэ тендерийн хуулийг тэгээд Тендерийн хуулийгаа сайжруулах шаардлагатай бол хамтран ажиллахад бэлэн байна л гэж хэлье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Мөнхтуяа гишүүн нэмж тодруулъя.

Ц.Мөнхтуяа: 2000-аас дээш хүүхэдтэй, 6 мянган хүүхэдтэй дээр 21 хувь төсөв хасагдаж байгаа шүү дээ. Тэгээд 6 мянган хүүхэдтэй сургууль дээр сард 2 тэрбум төгрөгийн төсөв хасагдаж байгаа. Энэ дээр та тооцоо судалгаа хийсэн үү? Ингээд олон хүүхэдтэй сургуулиуд нь хохироод, цөөн хүүхэдтэй нь яах вэ хэвийн ажиллах юм байна тийм үү? Тэгэхээр энэн дээр бид нар бол тэр 100 гаруй сургуулийн багш, ажилчид нийлээд нэгдээд явъя гэсэн ийм гомдлууд ирээд байгаа сайд минь. Энэн дээрээ та учир зүйгээ олоорой. Би заавал тан руу дайраад байгаа юм бол байхгүй шүү. Бодит байдал чинь л яг ийм байна. Тэгэхээр тэр 300 гаруй мянган хүүхдийн хувь заяагаар тоглогчихсон байна шүү дээ бид нар. Тэгээд энийгээ засах хэрэгтэй шүү. Энэ дээр маш их гомдлууд ирж байгаа. Нэг сургуулиас сард 2 тэрбум төгрөг хасагдаж байна 6 мянган хүүхэдтэй сургууль.

Энийгээ яах юм бэ? Одоо тэгээд тэр хүүхдүүдийн буруу биш, тэр сургуулийн үйл ажиллагаа явуулж байгаа захирал, ажилчдын буруу биш шүү дээ. Бодлого хийж байгаа.

Х.Булгантуяа: Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя. Ер нь түрүүнд хэлсэнчлэн 2 мянган хүүхэд дээр бид нар гол тооцоогоо хийгээд 2 мянган хүртэл ямар нэгэн бууралттай итгэлцүүр байхгүй байгаа. Бүрэн олгож байгаа. 2 мянга хүртэл дээр. Дээшээгээ гараад ирэхээрээ зэрэг итгэлцүүрийг нь бууруулж явж байгаа нь бол танд хэлсэнчлэн бид хангалттай ийм төсөв, хүрэлцээтэй төсөв бол байхгүй шүү дээ. Энэ нөхцөлд бид цөөн хүүхэдтэй ийм сургуулиуд дээрээ илүү асуудлыг нь шийдэхийн тулд ийм итгэлцүүр хэрэглэж байгаа гэдгийг танд тайлбарлая. Ер нь бол бид цаашдаа үнэхээрийн хувьсах зардлаараа дамжуулаад олон асуудлыг шийдэж болно гэж хардаг. Тэр байтугай багшийн цалин хангамжийг ч гэсэн энэ хувьсах зардлаар дамжуулж бас шийдвэрлэх боломж байна гэж хардаг.

Цаашдаа бид энэ илүү сайн төсвөө дотоодынхоо нийт бүтээгдэхүүний 20 хувь хүртэл зардлыг энийгээ ингээ, энэнийхээ энэ зардлыг бид төсөв рүүгээ оруулж чадах юм бол энэ асуудлыг шийдэхэд ямар ч асуудалгүй болно шүү.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрах байхгүй байна.

Улсын Их Хурлын гишүүн Жудгийн Баярмаа.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Бид нар Улсын Их Хурлын шинэ бүрэлдэхүүн бүрэлдсэнээс хойш жил гаруйн хугацаа өнгөрч байна. Тэгээд төсвийг бол бараг 5 дахь удаагаа хэлэлцэж байх шиг байна. Нэг бодлын бид нар их азтай улс юм. Нөгөө бодлын их эмгэнэлтэй улс юм. Тэгэхээр энэ өмнөх төслүүд яаж явагдаад, яаж батлагдсанаас батлагдаж байсныг бид нар маш сайн мэдэж байгаа. Өмнөх жилүүдийн төсөв бол ерөөсөө 3, 5, 8 их наядаараа нэмэгдэж орж ирдэг байсан. Миний санаж байгаагаар 2023 оны төсөв 22 их наяд байж байгаад 2024 онд 27 буюу 5 их наядаар нэмэгдээд тодотгол хийгдээд 30 их наяд болж байсан. Өөрөөр хэлбэл бүхэл бүтэн 8 их наядаар нэмэгдэж орж ирж байсан. Тэгээд ноднинхон бид нар бас л 33.8 гэсэн орлого, зарлага нь 35.8 гэсэн ийм зарлагатай төсөв орж ирж байсан. Алдагдал нь 1.9 байсан.

Тэгээд тэр үед чинь бөөн юм боллоо. Та бүхэн санаж байгаа бол. Бөөн тэмцэл юм өрнүүлж байж эцэс сүүлд нь Ерөнхийлөгч хориг тавьж байж алдагдалгүй төсөв батлагдсан. Тэр үед би бүүр зориуд цохон тэмдэглэж хэлье. Тухайн үеийн Засгийн газрын гишүүд чухамхүү ийм алдагдалтай байх нь зөв юм. Ингэж байж эдийн засаг тэлдэг юм. Ингэхгүй бол болохгүй гээд зүгээр тал талаас барьж идчих гээд л шүүмжилсэн хүмүүсийг попорлоо энэ тэр гээд л бөөн юм болж байсан. Үгүй тэгээд яг тэр улсууд өнөөдөр шал эсрэг юм яриад суугаад байх юм. Үнэн гэж нэг л баймаар юм. Тоо гэж нэг л баймаар юм. Тэгээд энэ чинь зүгээр алдагдлын зөрөөг харахад л 1.9-ийн алдагдал 1.3-ын алдагдал 2-ын зөрүү ямар байна 1-д.

Хоёрт би бол их айж байлаа л даа. Дахиад нэг 3, 4 их наядаар нэмэгдүүлээд ороод ирэх бий вий дээ гээд. Тэгсэн чинь ямар ч байсан азаар тэгсэнгүй. Их даруулгатай. Ёстой нөгөө хөнжлийнхөө хэрээр хөлөө жийсэн ийм төсөв байна гэж харж байгаа. Төсвийн хүрээний мэдэгдэл дотроо. Тэгэхээр ямар ч байсан үнэнтэйгээ нүүр тулжээ гэж бас харж байна. Энийг бас дэвшил гэж ойлгож байна.

Мэдээж гадаад дотоод зөндөө нөхцөл байдал байгаа. Тэгээд энийг ямар ч байсан ингээд үнэтэйгээ нүүр тулаад ийм даруухан даруулгатай төсөл оруулж ирж байгаад бол бас нэг талаасаа дэвшил гэж харж байна. Нөгөө талаасаа тэгээд энэ манай зарим Их Хурлын гишүүд ялангуяа өмнөх Засгийн газрын гишүүд жоохон зарчим гэж нэг л юм баримаар байна. Засаг дотор байхаараа зарчим нь өөр болоод Засгаас гарахаараа өөр байгаад баймааргүй байна. Тэгээд бүх юман дээр нэг л зарчим баримаар байна.

Тийм учраас би бол яг өмнө нь ч хэлж байсан. Алдагдалгүй байх нь тусдаа асуудал. Алдагдалтай байж болно. Гагцхүү тэр алдагдал өөрөө эргээд Монгол Улсын эдийн засагт ямар үр өгөөж авчрах юм бэ гэдэг л болохоос биш зөвхөн ингээд л энэ орлогодоо багтаана гээд суугаад байх юм бол ёстой нөгөө эдийн засаг чинь тэлэхгүй байх магадлалтай гэж ноднин ч хэлж байсан одоо ч би дахиж хэлнэ.

Тэгэхээр эхний асуулт.

Х.Булгантуяа: Эхлээд хариулт. Баярмаа гишүүн нэмж тодруулах цаг өгөх үү? Нэг минут.

Ж.Баярмаа: Тэгэхээр энэ алдагдал дахиад л асуултаа асууя. 1.3 их наядын энэ алдагдал маань яг ямар үр өгөөжийг өгөх гэж байгаа вэ? Монгол Улсын эдийн засагт. Энэ төсвийн бодлого энэ тэрээ бас тодорхойлсон байна. Ер нь өмнө нь бараг

тодорхойлдог ч үгүй байсан юм шиг байна. Энэ төсвийн тогтвортой байдлын зөвлөл их сайшаасан байна. Тэгэхээр энэ мэргэжлийн байгууллага арай ч нэг хий хоосон юм дүгнээгүй байх гэж найдаж байна. Тэгэхээр энэ алдагдал чинь яг ямар өгөөж авчрах юм бэ? Эдийн засгийн өсөлтийг дэмжинэ, хувийн хэвшлийг дэмжинэ гэсэн маш сайхан зорилтууд дэвшүүлсэн байна л даа. Төсвийн бодлого дотроо. Тэгэхээр яг ямар үр дүн ямар өгөөж авчрах юм бэ. Энэ чинь яг цэвэр зээлээр бүтээн байгуулалтад оруулна гэж хэлээд байгаа. Тэгэхээр энийг төсөв хараад бид нарт харагдахгүй байгаа байхгүй юу. Өмнөх алдагдал ч гэсэн магадгүй та нарын энэ удаагийн яриагаар бол 1.9 их наядад л зээл байгаа юм. Тэгээд энэ зээлээ ашиглаж байгаа юм гээд тайлбарлах ёстой атал тэгж тайлбарлахгүй байсан. Ноднин бол та нар. Энэ жил болохоор зээл байгаа юм.

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Эхлээд талархал илэрхийлье. Манай төслийг дэмжиж байгаад. Бид ерөөсөө энэ алдагдал гэдгийг бүтцийг хуульчилчихсан байгаа. Баярмаа гишүүн та тэр хуулийн төсвийн тогтвортой байдлын хуулийн заалт нь хэдийн хэд билээ дээ. Тэрэн дээр бүр ингэчихсэн байгаа. 2 тэнцэл байгаа. Суурь тэнцэл, тэнцвэржүүлсэн тэнцэл гээд. Тэнцвэржүүлсэн тэнцэл нь татварынхаа орлогоороо хүүхдийн мөнгө, цалин, тэтгэвэр тэтгэмжээ бүгдийг нь санхүүжүүлээд, бүүр нэмэх 2 хувийн ашигтай байх ёстой шүү гэдгийг бүүр хуульчилчихсан.

Тэрүүгээр тухайн жилийнхээ зээл, өр төлбөрүүдийг төлнө, тэр 2 хувиар. Алдагдалгүй гэж юуг хэлж байгаа вэ гэхээр ерөөсөө зээлийн санхүүжилт. Зээл ашиглалт. Өөрөөр хэлбэл бид нар алдагдлаа зээлээр нь өгөх гээд байгаа биш. Энэ алдагдал маань өөрөө зээлийн ашиглалт юм байгаа юм. Тэгэхээр энэ зээлийн ашиглалт дотор маань ерөөсөө нөгөө хэдэн мега төслүүд маань л байгаа. Тэр нөгөө зээлийн ашиглалт дотор байгаа шүү. Хамгийн том нь нефть боловсруулах үйлдвэр. Эрдэнэбүрэнгийн УЦС, Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламж. Улаанбаатар хотын цэвэр усны хангамжийг сайжруулах мянганы сорилын сангийн төсөл, 17 эмнэлэг гээд эдгээр нь бол манай эдийн засгийг ойрын хугацаанд гэлтгүй цаашдаа ч урт хугацаанд бүүст хийж болох хамгийн чухал үр өгөөжтэй гэсэн ийм мега төслүүд байгаа юм гэдгийг би онцолж хэлье ээ.

Тийм учраас энэ удаагийн энэ алдагдлын бүтэц бол өмнөхөөс өөр, өмнөхөөс өөр. Бид ноднин төсөв батлахаас өмнө орлогоо алдах нь тодорхой болсон. Өөрөөр хэлбэл бид цалин, тэтгэвэр, тэтгэмжээ санхүүжүүлж чадахгүй. Магадгүй тэрийг бол жинхэнэ ёстой өөр гадаад бонд ч юм уу, дотоод бонд ч юм уу гаргаж санхүүжүүлэх ийм байдал руу явж орсон.

Тийм ч учраас орлого, зарлагаа хоёуланг нь танахаас өөр аргагүй болж ирж байсан. Сая тодотголоор ч гэсэн мөн адил. Тийм учраас энэ удаагийн энэ алдагдал бол цэвэр өсөлтийг дэмжсэн эдийн засгийг бүүст хийсэн ийм энэ удаагийн төсвийн бодлогын илрэл. Манай эдийн засгийн өсөлтийн дархлаа гэж хэлж болно.

Х.Булгантуяа: Баярмаа гишүүн нэмж тодруулъя.

Ж.Баярмаа: Монгол Улсад уг нь нэг ийм хөгжлийн тэргүүлэх чиглэл гэж уг нь байх ёстой л доо. Тэр нь яг юуг хэлдэг юм. одоог хүртэл ойлгохгүй л яваад байгаа юм. ХАА юм уу, уул уурхай юм уу. Тэгээд санал авсан сая олон нийтийн хэлэлцүүлэг

хийгээд. Тэр бол дахиад дэвшил. Анх удаагаа ийм санал авсан гэж байгаа юм. Тэгэхээр тэр ноднингийн тэр тэмцэл энэ тэр чинь ер нь тодорхой хэмжээнд бага ч атугай үр дүнд хүрсэн гэж би бодож байгаа. Гэхдээ эрэмбийн асуудал байна. Тэгэхээр энэ эрэмбэлэлт ер нь ямар зарчмаар яаж явагдаад байдаг юм бэ? Жишээлбэл Сангийн яаманд 485 төсөл ирсэн юм байна. Тэрний 118-ын төслийг нь үнэлээгүй. 485-ыг нь үнэлээд, 71 төслийг нь 2026 оны төсвийн төсөлд оруулжээ гэж байгаа юм. Тэгээд энэ 71 төслийн зарим нь болохоор бага оноотой байсан мөртөө орчихсон гэж байгаа юм.

Гэтэл ороогүй тэр төслүүд нь энэ орчихсон төслүүдээс өндөр оноотой гээд байгаа юм. Тэгэхээр янз нь нэг оноо өгөөд байдаг юм шиг байгаа юм.

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Баярмаа гишүүний асуултад нэмж хариулъя. Сангийн яам салбарын бодлогоор өмнүүр нь орж бид эрэмбэлдэггүй шүү. Жишээ нь Боловсролын яам. Боловсролын яам энэ жил нэлээн дэвшилттэй. Бид нарын хувьдаа л хиймэл оюун ухаан юм даа. Тэгээд биг датагаа хуримтлуулж байгаад ингээд бид эрэмбэлсэн. Салбарын мэргэшсэн салбар энэ дээр маш сайн ажилласан. Манай Галбадрах гишүүн энэ дээр маш сайн бидэнтэй хамтарч ажилласан. Яг ингээд маш олон до үзүүлэлтээр оруулж байгаад эрэмбэллээ. Тэгээд хязгаартаа багтаагаад л тэрүүгээр тайлагдаад л ороод ирж байгаа. Салбар болгон дээр ингэж байгаа. Одоо жишээ нь боловсролын салбар дээр тухайн хамгийн суурь эрэмбэ нь жишээ нь тухайн сургууль дээр хэдэн хувь юутай байна. Ээлжийн коэффициент нь хэд байна, 3 байна уу, 2 байна уу?

Улаанбаатар хотын 84 байршил дээр жишээ нь маш өндөр индекстэй байгаа. Тэгээд тухайн сургуулийн бэлтгэл ажил хангагдсан. Зураг төсөв нь бэлэн байна уу, бэлэн биш байна уу энүүгээрээ эрэмбэлэгдэнэ. Энэ жил жишээ нь.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж нэг минут.

Б.Жавхлан: Энэ жил жишээ нь гуравхан сургууль хоёрхон цэцэрлэг бэлэн байдалтай байгаа байхгүй юу. Зураг төсөв магадлал бүх юм нь нээгдчихсэн. Одоо энд 5 эрэмбэлэгдээд байх юм байхгүй зайлуул ингээд л шууд ороод ирж байгаа юм. Өөр бэлэн юм байна уу гэхээр байхгүй. Нөгөө 108 сургуулийнх чинь ингээд 3 тийшээгээ явчхаж байгаа юм. Цаана нь 105 сургууль үлдчихнэ эрэмбэлэгдчихсэн. Тэрийг яг ингээд л дээрээс нь тайраад л 34 сургууль, 7 цэцэрлэг АХБ-ны зээлд орж ирнэ ээ. Тэгэхээр бусад зам дээр ч гэсэндээ Дээгий сайд байвал өөрөө хэлэх байх. Зам дээр жишээ нь бас л уг нь боомтын зам, уул уурхайн зам, одоо нөгөө 5 цагариг зам гээд ийм бодлогуудаараа эрэмбэлнэ. Гэтэл яг бодит байдал дээр очихоор яг бэлэн, шаардлага хангасан төсвийн шаардлагууд хангасан ийм эрэмбээрээ орж ирээд л тэгээд дараа нь хязгаартай баригдаад л ингээд л тавигдаад л орж ирж байгаа юмнууд байгаа юм.

Тэрнээс биш Сангийн яаман дээр бол салбарын бодлогуудыг эрэмбэлэхгүй ээ. Сангийн яам бол хязгаараа л тавьж явна.

Х.Булгантуяа: 2 тодруулчихсан. Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатарын Ганбаатар.

А.Ганбаатар: Өдрийн мэнд хүргэе гишүүддээ.

Би нэг асуудалд жоохон санаа зовоод байгаа юм аа. Тухайлбал, баялгийн сан, бүүр тодруулбал баялгийн сангийн менежмент гээд. Эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах чиглэлээр шинэ Засгийн газар тухайлбал Ерөнхий сайд Учрал сайдад эд нар тодорхой ажлууд хийж байгааг бол харж байгаа. Гэхдээ Эрдэнэс Монголын доор баялгийн сангийнхаа менежментийг аваачиж тавьдаг нь яаж байгаа юм бэ? Бид нар Норвегийн санг бүгдээрээ мэднэ ээ. Очиж үзсэн. Менежментээ тусгай хөрөнгө оруулалтын сангаар удирдуулдаг. Тухайлбал аппли, гүүгл ч гэдэг юм уу арилжаа сайтай ийм найдвартай компаниуд 4-өөс дээшгүй ийм хувиар хөрөнгө оруулалт хувьцаа аваад ингээд баялгийн санг үржүүлж явж байдаг. Яах вэ Жаргалан сайд, энэ Жавхлан сайд тайлбарлаж байсан. Английн банканд хадгалаад, өөр газар хөрөнгө оруулахаар зээлжих зэрэглэлд нөлөөлөөд байдаг юм гээд. Тэрийг бол ойлгож байна л даа.

Тэгэхдээ дөрөвхөн хувиа тараахад бол өчүүхэн жоохон хэсэг болох байх гэж бодоод байгаа юм. Тэгээд баялгийн сангаа төвлөрүүлэх дээр стратегийн ордуудыг одоо ингээд хуруу дараад татаж аваад улсад аваад гэх юм уу даа. Магадгүй 34 хувь, 51 хувь АМНАТ-ийн хэлэлцээр эд нар хийгдэх л байх гэж найдаж байгаа. Ингээд мөнгө төвлөрүүлчихдэг. Тэгээд энэ мөнгөнийхөө менежментийг буцаад удирдаж байгаа удирдлага нь тухайлбал эрдэс Монголын доор байгаа нь болохгүй байна аа. Яагаад би энд итгэхгүй байна гэхээр нөгөө талынх нь зүүн гарынх нь эрчист Монголынх нь захирал хулгай хийнэ гэж зарлаад байна шүү дээ. Өчигдөр ч би энийг хэлсэн. Тэгэхээр энэ эрдэс Монголын чинь доор байгаа нөхдүүд идэхгүй уухгүй байх баталгаа хаана байгаа юм бэ? Цугласан нь болохоор тэр хөгжлийн сан дээр юм байхгүй байгаа юм байна. Ирээдүй өв сан, Хуримтлалын сан 2 дээр жоохон юм байгаа юм байна. Цаашдаа ч нэмэгдэх байх. Өчигдөр Дамдинням сайд зүйтэй санал хэлж байсан. Стратегийн ордууд гэж ярихаасаа илүүтэйгээр стратегийн бүтээгдэхүүнээ зарлая гээд. Зарим газар жимс нь хүртэл стратегийн бүтээгдэхүүн болчихсон явж байгаа шүү дээ.

Тэгэхээр бид нар алт, зэс, нүүрс гээд л ингээд зогсоод байх бас нэг. Дараа нь төрөлжүүлэе. Стратегийн бүтээгдэхүүнүүд өөр салбараас гарч ирэхийг үгүйсгэхгүй шүү дээ ялангуяа ХАА. Тэгэхээр энэ менежментээ та бүхэн яаж хараад байгаа юм бэ? Хуулиар хийчихсэн гээд ингээд өөрчилж болохгүй гээд хэвтээд байх юм уу. Миний хувьд бол итгэхгүй байна. Энэ их мөнгийг цугларуулчхаад дараа нь Эрчис Монголын захирал шиг нөхдүүд удирдах гээд байна шүү дээ. Энд л санаа зовоод байгаа юм л даа.

Х.Булгантуяа: Эдийн засаг хөгжлийн сайд хариулъя.

Н.Учрал: Үндэсний баялгийн сангийн хууль 2024 онд батлагдсан. Тэгээд тухайн үед хууль батлахад би оролцсон. Тэгээд ингээд сонгуулийн дараа шинэ Засгийн газар байгуулагдаад Хэрэг эрхлэх газар дээр ажиллаж байхад энэ Эрдэнэс Монгол нэгдлийг хариуцаж байсан. Тэгээд тухайн үед бид цаашаа Үндэсний баялгийн сангийнхаа энэ 3 санг хэрхэн зөв авч явах вэ гэдэг дээр бол нэлээдгүй олон ажлуудыг бол эхлүүлээд ч үргэлжилж байна. Тэгээд одоо бол та мэдэж байгаа. Энэ баялгийн санд бол Ирээдүй өв сан, Хуримтлалын сан, хөгжлийн сан гээд бид нар хуульчилсан. Гэтэл Хөгжлийн сан бол өөрөө юу юм бэ гэхээр нийгэм эдийн засгийн одоо энэ томоохон төслүүдээ санхүүжүүлэх зорилготой ийм сан. Гэхдээ энэ санд тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарахад л хуваарилалт хийгддэг.

Тэгэхээр бид нар Төсвийн хүрээний мэдэгдлийнхээ хуулийн төсөл, төсвийн тэнцлийг бол энэ жил 1.3 гээд үе шатлалтайгаа бууруулаад 2028 оноос бол алдагдалгүй төсөв батлах зорилго руугаа явна гэдэг ийм л зорилготой байгаа. Энэ бол зөв үедээ зөв тохируулга хийж байгаа л хэлбэр болохоос биш энэ үргэлж ингээд алдагдалтай явж болохгүй шүү дээ. Бид нар чинь өнөөдөр 33.4 их наядын орлого олж байхдаа орлого зарлагыг нь тэнцүүлж тавиад ийм байдалд хүрчхээд.

Өмнө нь бол 2011-2012 онд бол яг мөчлөг сөрсөн бодлого бүрэн хэрэгжүүлж чадаагүй. Тэгээд 2012-2016 онууд гээд. Ингээд 17 онд тэгээд ингээд мөчлөг сөрсөн бодлогоо хэрэгжүүлж чадаагүй. Нэг ёсондоо хуримтлал үүсэх боломжтой үе буюу эдийн засаг тэлж байх үед бид нар огт энэ мөчлөг сөрсөн бодлогоо хэрэгжүүлж чадаагүй. Тэгээд ийм байдалд оччихжээ. Тэгэхээр 2026-аас 2028 онуудад бол энэ хөгжлийн санд ямар нэгэн хуримтлал үүсэхээргүй харагдаад байгаа юм. Тэгээд тухайн үед бол Хэрэг эрхлэх газрын дэргэд хувьцаа эзэмшигчийн хувиар энэ Эрдэнэс Монгол нэгдэл дээр бид нар цаашаа энэ менежментийг зөв авч явах гэдэг утгаараа энэ хуулийн шинэчлэл хийх, энэ баялгийн сангийнхаа менежментийг зөв төлөвлөх чиглэлээр тэр Норвегийн сан дээр Сингапурын Тимасек энэ тэртэй харилцаа хамтын ажиллагаагаа хөгжүүлээд хуулиа бэлэн болгох зорилгоор ийм төслийн компани Эрдэнэс Монголд дэргэдээ байгуулсан.

Тэр Чингис хаан баялгийн сангийн менежмент гээд байгаа. Тэр бол өөрөө яг хөрөнгө удирддаг Ассет менежмент компани биш. Зүгээр бэлтгэл ажлаа хангуулах зорилгоор ийм төслийн, тэгээд нөгөө Тимосек, Норвегийн сан энэ тэртэй. Тэрнээс тэд нар бол хөрөнгө удирдах тийм эрх байхгүй. Одоо дараагийн түвшинд яах ёстой вэ гэвэл Баялгийн сангийн хуулийг Их Хурлаар оруулж ирээд хөгжлийн сангаасаа Их Хурлаар нөгөө хөгжлийн сангаа санхүүжүүлэх төслүүдийн жагсаалтыг баталдаг. Ийм эрхтэй. Гэхдээ энийг зөвхөн тэр төсвийн тэнцэл ашигтай гарсан тохиолдолд хуваарилалт хийдэг биш, хөрөнгө мөнгө татдаг хуримтлалыг нь өөр хэлбэрээр үүсгэх бололцоогоор нь хуулийн хүрээнд олгоод тэр хөгжлийн сангаа удирддаг компани нь СЗХ-оос зөвшөөрлөө авсан хөрөнгө оруулалтын менежментийн компани байх ёстой гэж би үзэж байгаа юм.

Тэр утгаараа хуулийн шинэчлэл ч гэсэн ийшээ чиглэсэн. Тэгэхээр тэрийг бол Чингис хаан баялгийн сангийн компани гэдгийг бол хөрөнгө удирдаад байна гэж ерөөсөө хэлж болохгүй. Тэр хөрөнгө удирдаагүй. Жишээ нь Хөгжлийн банкны дэргэд бол нөгөө Хөгжлийн банкны ассет менежмент гээд СЗХ-оос юм уу нөгөө хөрөнгө оруулалт менежментийн компанийн зөвшөөрөл авсан ийм юм байдаг юм билээ. Яг энэ дээрээ ч юм уу нэгтгээд бид нар СЗХ-нд гол хяналтаа өгөөд явах нь улс төрөөс хол байхад том тус тус дэм өгнө өө гэж ингэж зорьж байгаа. Тэр хуулиар нээнэ. Тэгээд яг хомкыг байгуулаад энэ хомкоор дамжуулаад тэр сангаа удирддаг болгох нь бол.

Х.Булгантуяа: Ганбаатар гишүүн нэмж тодруулна.

А.Ганбаатар: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тэр дүгнэлт дотор нөгөө эконометрик судалгаан дээр төсвийн зарлага, ДНБ-ий 27 хувьтай тэнцэж байх нөхцөлд бол өсөлт эерэг байх юм гэсэн ийм дүгнэлт хийсэн байна лээ. Тэгээд энэ өсөлт рүү чиглэхэд таны барьж байгаа Засгийн газрын барьж байгаа энэ мөчлөг сөрсөн бодлого зөв байна аа. Үүнийг дэмжиж байна. Гэхдээ ийшээ очиход чинь нөгөө орлоготой байж байж энэ хувьдаа хүрэх байлгүй дээ тэ. Тэгэхээр энэ хувьдаа

хүрэхэд энэ ТӨК-удын менежментийн асуудал анхаарал татаад байгаа байхгүй юу. Саяын баялгийн сангийн менежментийг ерөнхийд нь ойлголоо. Хуулиар орж ирэх юм байна гэж ойлголоо. Одоо байж байгаа энэ Эрдэнэс Монголын нөгөө Тавантолгойн бүлэг орд гэдэг шиг Эрдэнэс Монголын бүлэг компани, Эрдэнэс Монголын бүлэг компаниудын хэдийнх нь дарга нарын цалин буураад, хэдийнх нь компанийг менежментийн хувьчлалд оруулаад.

Х.Булгантуяа: Саяынх дээр бараг үг хэлчих шиг боллоо доо. Асуултаа бүрэн гүйцэд асууж амжсангүй. Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 2025 оны 6 дугаар сарын 12-ны Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар Монгол Улсын ерөнхий сайдаар Гомбожавын Занданшатар томилогдсон байдаг. Тэгээд Ерөнхий сайдын эхний 100 хоног бол 9 дүгээр сарын 20 буюу маргааш тохиож байгаа юм байна. Тэгээд аливаа Ерөнхий сайдын хувьд Засгийн газрын хувьд бол эхний 100 хоног тэгээд ямар шийдвэр гаргана вэ? Энэ эхний 100 хоногтоо шийдвэрлэсэн асуудлууд ингээд маш олны анхаарлын төвд байх учиртай байдаг. Би тэр шинэ Ерөнхий сайд томилогдох өмнөх Ерөнхий сайдыг огцруулах хуралдааны үеэр өмнөх Ерөнхий сайдад нэг ийм үг хэлж байсан юм. Аливаа улс орныг айдсаар бус итгэлээр удирддаг юм гэж. Тэгээд шинэ Ерөнхий сайд томилогдоход бол ийм бодлогын манлайлал иргэдэд мөрөөдөл, эрмэлзэл ийм итгэл найдвар өгөх нь чухал гэдэг үг хэлж байсан. Тэгээд шинэ Засгийн газар шинэ Ерөнхий сайдын эхний 100 хоногоос яг үнэнийг хэлэхэд ийм бодлогын манлайлал, улс төрийн манлайлал, иргэд олон нийт, ард түмэнд ийм итгэл найдвар хүсэл мөрөөдөл өгсөн шийдвэрүүд харамсалтай нь гарсангүй.

Улсын нэгдсэн төсөв гэдэг бол шинэ Засгийн газрын хувьд өөрсдийнхөө энэ бодлогын ялгарлыг харуулах ийм боломж байсан. Харамсалтайгаар та бүхний өргөн барьсан төсвийн төслөөс ийм ялгарал харагдахгүй байгаад байна. Тэгэхээр нэгэнтээ бид нэг Засгийн газрыг огцруулаад дараачийн Засгийн газрыг томилж байгаа нөхцөлд бол ийм бодлогын ялгарал маш чухал байсан. Тэгээд энэ шинэ төсвийн төслөөс чинь ямар ч тийм манлайлал шинэчлэл харагдахгүй байгаад байна аа. Яг л өмнө нь байсан хэдэн тоонуудаа наана цаана оруулж тавиад. Тэгээд өмнө нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд төсвийн хэлэлцүүлгийн хүрээнд Их Хурал дээр яригдсан бүх зүйлүүдийг дахиад л яриад суугаад байна.

Тэгэхээр бид нар хэзээ ингээд ийм арай өөр түвшинд гарах юм бэ. Энэ хүмүүс иргэд маш их бухимдалтай байна шүү дээ. Иргэдийн амьдрал ахуй сайн биш байна. ААН-үүд болохоор өр төлбөр татварын дарамт доор тун хэцүү байдалд байна. Тэгэхээр энэ улс орны эдийн засагтай холбоотой асуудлыг шийдэх талаар огтхон ч ярихгүй.

Тэгээд л нэг өмнөх ярьдаг хэдэн зүйлүүдээ л эргэн тойруулж яриад байна. Тэгээд харамсалтай нь Ерөнхий сайд маань Улсын Их Хурлын чуулганы танхимд алга. Тэгээд би бол Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдэд гишүүдэд гишүүдэд 2025 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээс Ерөнхий сайдад хүргүүлсэн бодлогын шаардлагыг шаардлагад тусгагдсан зарим нэг зүйлсийг дахин сануулахыг хүсэж байна аа.

Төрийн өмчит ААН-үүдийн тоог цөөлж олон нийтийн нээлттэй ХК болгох орон тоог 2 дахин бууруулах.

Х.Булгантуяа: Жаргалан гишүүн нэмж нэг минут.

Б.Жаргалан: Төрийн өмчит ААН-үүдэд реформ хийх.

Хоёрт хувийн хэвшилд ноогдох татварын дарамтыг 20 хувиас доошгүй хувиар бууруулах, ажлын байр шинээр бий болгох. Агаар орчны бохирдолтой тууштай тэмцэж иргэдийн амь насанд заналхийлж байгаа утаанаас бүрэн ангижрах гэх зэрэг одоо нийтдээ 9 заалт бүхий бодлогын шаардлагыг хүргүүлсэн. Үүнд бол албан ёсоор хариулт ирээгүй. Энэ шинэ төсвийн төсөлд эдгээртэй холбоотой тодорхой зүйл заалтууд алга аа.

Тэгэхээр надад бол асуулт алга. Би бол Ерөнхий сайд болон Засгийн газрын 100 хоног бол ийм ямар ч шинэчлэлгүй, ийм манлайлалгүй шувтарч байна гэдгийг бол энэ танхимд сануулахыг хүсэж байна. Тэгээд энэ төсвийн төслийн хэлэлцүүлгийн үе шатад бид нар эдгээр тулгамдчихсан асуудлуудаа шийдвэрлэх нь чухал гэсэн тийм зүйлийг хэлэхийг хүсэж байна аа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Жаргалан гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат.

Д.Ганбат: Уул нь Ерөнхий сайд өмнөх төсвүүдээ бодоход суугаад хариулаад байх шиг байсан. Сая надтай зөрчхөв өө дөө тиймээ. Сайд нар маань ч овоо сууж байгаа харагдана. Гэхдээ ерөнхийдөө танхим сул байгаа шүү. Тийм сайд нар тэгээд жоохон тийм байгаа. Улс орон бол нэг их яадгаа алдчихсан хамгийн сүүлд орчихсон ч юм алга л байна л даа. 200 улсын дунд хавиар л явна. Боломж уул нь эхний 50-д байх ёстой л доо. Ийм л улс орон мөн үү гэвэл мөн манай Монгол Улс. Би юу асуух гээд байна вэ гэхээр чуулганы нээлт төсвийн ярихын өмнөхөн Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан үг хэлсэн.

Тэр үг хэлсэн юман дотор хэд хэдэн юмтай нь миний бие санал нийлж байна аа. Та бүхэн ямар байна вэ? Уул нь би Ерөнхий сайдаас л асуух гээд байгаа юм л даа. Тэр нийгмийн даатгал, тэр нэмүү өртөг, иргэдийн хүсээд байгаа энэ Засгийн газар чинь иргэдээс аягүй их санал аваад байгаа гэж яриад байгаа шүү дээ тийм ээ тэрийг хууль болгож, бодлого болгож оруулж ирж байна аа. Төсөв бол өргөн хэлэлцүүлэгдэж байна гэсэн зүйл ярьж байна. Эндээсээ ямар ямар дүгнэлт хийв ээ? Шинэ юм юу байна вэ? Өөрчлөгдсөн юм юу байна вэ? Үндсэн хуульд зааснаар юу байгаа шүү дээ.

Бид нар чинь эрүүл аюулгүй орчинд амьдрах ёстой. Үр хүүхдээ сурч боловсрохоор хангах ёстой, ерөнхий боловсрол үнэгүй байх ёстой гээд ийм зүйлүүд бий л дээ. Улс орон бол энэн шиг өндөр төсөвтэй энэн шиг мөнгө төрдөө хуримтлуулж ингэж ажиллуулж байсан түүх бол сүүлийн 100 жил байхгүй. Сүүлийн 5, 10 жилд их өндөр төсөвтэй ажиллаж байгаа. Төрийн өмчтэйг өмчтэй компаниуд ч нөгөө социализмын үед бүгдээрээ л өмчгүй байсан л даа. Тэрийг эс тооцвол бүгдийг нь хамаад авчихсан байж байгаа.

Тэгээд би асууя. Тухайлбал одоо дулааны ихэнх сайдууд нь байж байгаа шүү дээ. Үргэлжлүүлэн ажиллаж байгаа. 10 станц баригдсангүй. Одоо энийг хэн хариуцах юм бэ? Ингээд иргэд хохирчхож байгаа байхгүй юу бид нар. Би тэр иргэд дотор би өөрийгөө оруулаад байна л даа. Манай 3 аймаг байна. Миний төлөөлж

байгаа. Баянхонгор, Архангай, Өвөрхангай. Энэ хүмүүс энэ хугацаанд ингээд хордож байна утаанд. Энэ хохирлыг хэн төлөх юм бэ? Хохирлыг нэхэмжилнэ шүү дээ. Энийг хэн төлөх вэ? Энийг яаж засаж сайжруулах вэ? Тэр эрүүл мэндийг нь хэн хариуцах юм. Засгийн газар хариуцах юм уу? Ардын нам хариуцах юм уу? Тэр сайд нь хариуцах юм уу? Энийг та нар нэг хэлээд өгчихмөөр байна.

Хоёрдугаарт энэ боловсрол. Энэ чинь тэгээд тухайн үеийнхээ.

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Ганбат гишүүний асуултад хариулъя. Энэ удаагийн төсөв дээр бид нар нэлээн том бодлогын асуудал давхар дагуулж барьж байгаа. Тэр маань дунд хугацаанд татварын багц реформоо эхлүүлж байгаа, эхлүүлж байгаа. Энэ удаагийн татварын реформ бол өмнө нь хийгдсэн 3 удаагийн реформуудаас хамаагүй далайц өндөртэй. Иргэдийн нэлээн хүлээлт дунд хийж байгаагаараа ялгаатай. Бид ер нь томоохон 16 параметр хөдөлгөж байгаа. НӨАТ, ХХОАТ, ААНОАТ.

Нийт өртөг нь 4 их наяд. Өөрөөр хэлбэл төсвийн орлого талд ийм ачаалал ирнэ гэсэн үг. Ирэх жилээс 1 сая төгрөг хүртэлх НӨАТ-ын уншуулсанд 2 хувийн буцаалтыг 5 хувь. Энэ өртөг нь өөрөө бараг 1 их наяд. Нэг их наяд төгрөгийн ийм буцаан олголт ирэх жил хийгдэнэ гэсэн үг. Энэ хэмжээгээр иргэдийн өрхийн орлого дээр очно оо гэсэн үг. Тэгэхээр энэ татварын реформ бол ди парламент дээр тавигдчихсан иргэдээс санал аваад явж байгаа. 10 сарын дундуур гэхэд өргөн барихад бэлэн болно. Энэ удаагийн татварын реформын онцлог гэх юм бол зөвхөн Засгийн газар дангаараа бэлдээгүй. Улсын Их Хурал дээрээс ажлын хэсэг гараад бид нар хамтарч ажилласан. Энүүгээрээ нэлээн онцлогтой ийм бэлтгэл ажлаа хангачихсан явж байгаа шүү. Нийгмийн даатгалын хувьд ч тэр ер нь нэг тогтолцооны нэлээн томхон өөрчлөлт хийхээр Гэр бүл нийгэм хамгааллын яаман дээр би бэлэн болсон байгаа. Аубакир сайд удахгүй энэ намар өргөн барина аа. Энүүгээр нэлээн том өөрчлөлт болно гэдэгт итгэлтэй байна аа.

Тэр 10 аймгийн дулааны станцын асуудлыг Чойжилсүрэн сайд ярих нь зөв байх аа.

Х.Булгантуяа: Чойжилсүрэн сайд байхгүй. Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга ЭХЯ-ны Хуягцогт дарга нэмж хариулъя. 4 номерын микрофон.

О.Хуягцогт: Ганбат гишүүний асуултад хариулъя. ЭХЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Хуягцогт. 10 аймгийн дулааны станц барих төсөл бол 2018 онд зээлийн гэрээ байгуулагдаад хэрэгжсэн. Өнөөдөр үүссэн нөхцөл байдал нь бол зээлийн гэрээний дагуу Солонгосын тал ерөнхий гүйцэтгэгчээр шалгарсан компани дампуурснаас үүдэлтэйгээр гэрээ цуцлагдах. Ингээд үлдэж байгаа хугацаанд уг нь бол энэ төсөл 2026 оны хагас жилээр дуусахаар анх төлөвлөгдсөн байсан. Энэ хохирлыг барагдуулж төслийг дуусгах энэ талаас бол 2 талаас хэлэлцээр хийгээд ингээд шийдэл гаргаад дуусгахаар ажиллаж байна аа.

Ингээд ирэх 7 хоногт Солонгосын Санхүү стратегийн яам, манай Сангийн яам, ЭХЯ энэ асуудлаар хэлэлцээр хийж байгаа. Ингээд энэ шүүхийн процессоос болоод нэг хагас жилээс нэг жил орчмын ингээд хугацаагаар хойшлох ийм эрсдэл үүссэн. Тэгээд Монголын талаар.

Х.Булгантуяа: Болчихсон уу Ганбат гишүүн айн. Нэг минут.

Д.Ганбат: Хэн нь хариулаад байсан юм энд хариулаад л байх шиг байсан шүү дээ. Байгаа юмаа өгчих яах вэ. Тэгээд иргэдийг хохироосон бол ард түмнийг хохироосон тэр хохирлоо төлнө шүү дээ. Тэр хохирол юмаа төлөх юмаа ерөөсөө ярихгүй юм. Иргэд шүүхэд хандах эрх нээлттэй шүү дээ. Тэр насаараа тухайн үедээ авах боловсролоороо бүх юмаараа хохирч байгаа байхгүй юу. Тэгээд тэр хариуцлагаа яаж тооцоод байгаа юм бэ? Тэр хариуцлага гэж байна уу? Тэрийгээ хэл л дээ. Би тэрийг л асуугаад байна л даа. Яагаад гишүүдийн асуултад хариулдаггүй юм бэ? Тов тодорхой асуулт асууж байхад чинь. Тэгээд хариулахгүй юм бол бид энэ дээр цаг хугацаа үүрч суух шаардлага юу байгаа юм? Тэр хохирлыг барагдуул. Хэчнээн хэмжээний хохирол гэж бодож байна вэ? Яах юм, тэр эрүүл мэндээрээ, тэр цаг хугацаагаараа, тэр бүх юмаараа хохирч байна шүү дээ.

Энэ ардчилсан улс оронд бүгд нэхэмжилдэг. Засгийн газраас ч юм уу хэнээс ч юм. Тэрийг нь төлдөг.

Х.Булгантуяа: Хэн хариулах юм? Ганбат гишүүний асуултад Жавхлан сайд хариулах юм уу? Хуягцогт дарга 4 номерын микрофон дээрээс.

О.Хуягцогт: ЭХЯ-аас нэмэлт мэдээлэл өгье гэрээ цуцлагдсантай холбоотой үүсэж байгаа хохирлыг барагдуулахаар ерөнхий гүйцэтгэгчээс бол тендерийн баталгаа 5.5 сая доллар. Мөн урьдчилгаа төлбөр болгоод гүйцэтгэлээр суутгасан тооцоо нийлж үлдэгдэл авах ёстой ийм 19 сая доллар. Ингээд нийтдээ 26.5 сая долларыг нэхэмжлээд энэ дээр шүүхийн процесс эхлүүлээд явж байгаа баталгаа гаргагч талаас бол энэ эдгээр баталгааг шилжүүлж авах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч байна аа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагай.

Н.Алтаншагай: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

2026 оны улсын нэгдсэн төсөв ярилцаж байна хэлэлцэгдэж байна. Иргэд маань их хүлээлттэй байна. Мэдээ мэдээлэл их ирүүлж байна, хэвлэл мэдээллийн байгууллагуудаар бүх төрлийн мэдээллүүдээ аваад иргэд тойргоос ч их хүсэлтүүд их ирж байна. Тэгээд гол яг яригдаж байгаа зүйл бол 2026 онд ажлын байр хэрхэн нэмэгдэх юм бэ? Орлогоо иргэд маань хэрхэн нэмэгдүүлэх юм бэ? гэсэн. Энэ дээр их төвлөрч байгаа юм. Улсын төсвийн бодлого иргэдийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлд яг ямар бодлого баримталж байгаа вэ?

Цалин тэтгэвэртэй холбоотой маш олон асуудлууд бүх гишүүд ярьж байна. Тэтгэвэр яригдаж байгаа тэтгэвэр. Тэтгэврээс өөр орлогогүй ахмадууд маань яаж энэ 572 мянган төгрөг бүрэн тэтгэврийн доод хэмжээ 689 мянган төгрөг байгаа. 6 хувиар нэмэгдүүлэхэд хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 34 мянган төгрөгөөр, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 41340 төгрөгөөр нэмэгдэхээр байгаа юм. Энэ маань одоо бас яг бодит үр дүнг үзүүлэхэд маш хүндрэлтэй байгаа.

Дээр нь энэ инфляцын түвшин энэ валютын өсөлттэй холбоотой иргэдийн маань гар дээр очиж байгаа мөнгө өдрөөс өдөрт үнэгүйдэж байгаа юм. Энэ дээрээ яг ямар бодлого барьж уялдуулж иргэдийнхээ энэ боломжийг хадгалах юм бэ? Улс

нь баян болоод иргэн баян болохгүй. Иргэн баян байж байж улс баян болно. Энэ дээрээ яг дорвитой бодлого байна уу? Энэний хариулт өгөөч.

Хоёрдугаарт энэ сая Жавхлан сайд хариулж байх шиг байна. Татварын реформ хийгээсэй гэж ард иргэд хүсэж байгаа юм. Төсвийн төсөлд ХХОАТ, НӨАТ, ААН-ийн орлогын албан татварууд яг шинэчилж тусгасан уу? 2026 онд татварын орчин нь энэ хэвээрээ үргэлжлэх үү? Энэ хэвээрээ үргэлжлэх юм бол өмнө жилийн өмнө ярьж байсан зүйл яг бахь байдаг хэвээрээ л байхаар байна. Маш их хүлээлттэй. Улаанбаатар хотын иргэд, Монгол Улсын иргэд дээр нь энэ яг гэр хороололд байгаа иргэд маань одоо өмнө жил ярьж байсан зүйлүүд яг хэвээрээ л байгаа. Ямар ч өөрчлөлт гарч чадахгүй байна. Амьдралын түвшин сайжрахгүй байна, орчин нь сайжрахгүй байна, хүлээлт байгаад байдаг. 2025 онд улсын төсөв дээр энэ дүүрэгт ямар нэгэн хөрөнгө оруулалт тавигдаагүй. Энэ жил бүр мөн адил тавигдаагүй. 2 жил дараалаад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар юу ч байхгүй шүү дээ.

Ганцхан СХД-ийн 33 дугаар хороонд 122 дугаар сургуулийн өргөтгөл гэсэн ганцхан л юм байгаа. Энэ дээр яг ямар эрэмбэ байгаа юм бэ? Их Хурал.

Х.Булгантуяа: Алтаншагай гишүүн нэмэлт нэг минут.

Н.Алтаншагай: Их хурлын гишүүдээс санал авсан шүү дээ. Эндээс тусгагдсан санал нэг ч байхгүй байгаа юм. Соёл, спорт, аялал жуулчлалын яаман дээр нэг шинээр хөрөнгө оруулалт гээд 3 юм байна лээ. Энд 3 сайдын муухайгаар хэлэх юм бол энэ нутаг дээрх нь нэг нь Хөвсгөлд, нэг нь Сэлэнгэд, нэг нь Ховдод гуравхан спорт заал байгаа. Бусад гишүүд нь яачихсан юм. Яагаад энэ санал нь орохгүй байгаа юм.

Дараачийн асуулт. Энэ улсын төсөвт орон нутгийн төсвийн бие даасан байдал дээр хангах чиглэлээр яг ямар бодлого баримталж байгаа вэ? Дээшээ хараад л хүлээгээд байдаг. Тийшээ бодит шийдвэрүүд нь очдоггүй, бодлогын дэмжлэг байдаггүй, ноднин 2025 онд бас яригдаж л байсан асуудал. Яг бодлогын ямар дэмжлэг үзүүлэх юм, ямар төсвийн бие даасан байдлыг нь тухайн орон нутагт өгөх юм. Энэ 21 аймаг, 9 дүүрэг, Улаанбаатар хотдоо. Одоо энэ тойргоос сонгогдсон гишүүд энэ улс төрийн юм ярьж байж магадгүй. Тойрог дээр очиход 2 жил юу ч хийгээгүй.

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн сонгуулиар бид бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гэж сонгууль явагдсан. Энэ үзэл баримтлалыг ард түмэн дэмжсэн. Ингээд бид үүнийгээ жилийн төлөвлөгөөндөө оруулаад ингээд явж байгаа. Энэ жилийн төлөвлөгөө маань ер нь 19 их наядын. Бид нарын боломж нь 3.2 их наяд. Төлөвлөгөө талаасаа харах юм бол дээр доор байгаа. Харин төсөв талаасаа харах юм байгаа. Бүх боломжоо энэний төлөө тавьсан байгаа. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гээд. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал бол жалга довоороо хөгжлөө төлөвлөөд тэр рүүгээ ингээд талаар нэг тараагаад хаячихъя гэдэг юм. Яг эсрэгээрээ шүү. Таны ярьж байгаа тэр 3 спорт байгууламжууд яамаараа эрэмбэлэгдээд дээрээс нь төсвийн бүх шаардлагуудыг хангаад, жилийн төлөвлөгөөнд, мөн зорилго зорилтдоо ороод явж байгаа ийм л төслүүд байгаа болов уу гэж ингэж бодож байна. Тийм учраас бүсчилсэн хөгжлөө л

бид одоо 2028 онд ярьж очно оо. Энэндээ нийцэж бүгдээрээ төлөвлөгөөгөө ч хийнэ, төсвөө ч хийнэ.

Цалин, тэтгэвэр, тэтгэмжийн хувьд мөн л бид төсвийнхөө хязгаарт багтаж байна. Доороос нь бид 200 хуулиар, мянга гаран заалтаар төсвийн хуваарилалтыг хийчихсэн. Жил болгон 1 их наядаар төсвийн зардал автомат өсөж байгаа статистик тоогоор, статистикийн өсөлтөөр. Дээрээс нь 24 хувьд багтаана шүү гээд. Ингээд дээрээс нь ингээд шахчихсан бодлогын орон зай цаашдаа улам их нарийн болж ирнэ ээ. Ер нь л байхгүй болж ирж байгаа. Гэсэн хэдий ч ажлын байр нэмэгдүүлэх, ажлын байраа ядаж хадгалах, өрхийн орлогуудыг дэмжих бодлого энэ татварын бодлогоор үргэлжилнэ. Би түрүүн хэллээ ирэх жил зөвхөн НӨАТ-ын ганц параметрийг хөтлөхөд 2-ыг 5 хувь болгоход 1 их наядын зөрүү гарч байгаа. Нэг их наяд төгрөг ард иргэдийн гар дээр нэмж үлдэнэ гэсэн үг. Нэмж үлдэнэ гэсэн үг. Мөн бусад татварын өөрчлөлтүүд хүлээгдэж байна. Энэ намартаа өргөн барина. Их Хурал татварын өөрчлөлтийг дэмжиж энэ жилдээ энэ намрын хурлаараа амжиж би баталчих болов уу гэж ингэж бодож байгаа, хүлээж байгаа.

Ингээд 2027, 2028 онуудаар үргэлжлээд энэ татварын реформууд явна. Татварын реформоор дамжиж хувийн хэвшил баялаг бүтээгчдээ дэмжинэ ээ. Ажлын байрыг хадгална. Ажлын байрыг нэмэгдүүлнэ.

Дээрээс нь энэ удаагийн төсвийн алдагдал гэж байгаа 1.3 их наяд маань дан бүтээн байгуулалт байгаа. Дан бүтээн байгуулалт. Эрчим хүч, нефть боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц, Улаанбаатар хотын та бол хамгийн сайн мэдэж байх ёстой. Цэвэрлэх байгууламж танай дүүргийн. Мөн танай дүүргийн нутаг дэвсгэр дээр оршиж байгаа Улаанбаатар хотын цэвэр усны нөөцийг нэмэгдүүлэх бараг мега төсөл байгаа. 460 сая долларын. Энэ бүх зүйл маань хувийн хэвшлийг дэмжих, дэд бүтцээ сайжруулах, эдийн засгийн өсөлтийг хангах ийм төслүүд байгаа гэдгийг хэлье ээ.

Тийм учраас та энэ удаагийнхаа төсвийн төслийг дэмжинэ байх гэж найдаж байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Алтаншагай гишүүн нэмж тодруулна.

Н.Алтаншагай: Энэ орон нутгийн бие даасан байдлыг хангах чиглэлээр төсөв дээр ямар бодлого баримталж байгаа вэ гэсэн. Нэг тодорхой хэдэн төсөв бүрдүүлдэг хэдэн аймаг байгаа. Бусад нь татаасаар байгаа. Тэгээд тухайн орон нутгийн иргэдийн хурал нь шат шатын иргэдийн хурал нь нэг шийдвэрүүд гаргаад явдаг. Орж ирсэн, жоохон цугларуулсан төвлөрүүлсэн мөнгөө тухайн орон нутагт зарцуулах тэр эрх мэдлийг нь тухайн орон нутгууд нь өгөөч гэж хүсэж байгаа юм. Энэ дээр яг ямар шинэчлэл хийгдэх вэ? Орон нутгаас ч гэсэн энийг асууж байгаа.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулна.

Ж.Болд: Гишүүний асуултад нэмж хариулъя.

Орон нутгийн бие даасан байдал гэхээр ер нь засаг захиргааны асуудал. Дээрээс нь төсвийн ч асуудал яригддаг. Төсвийн хувьд 21 аймаг нийслэлээс, 14 аймаг татаас авч байгаа. 7 аймаг орлогоороо бүрэн санхүүжээд тодорхой хэмжээнд ул нэгдсэн төсөв рүү орлого төвлөрүүлж байгаа. Энэ 14 аймгийн хувьд татварын

орлого болон бусад төсвийн нөхцөл байдлаасаа уялдаад харилцан адилгүй байгаа, харилцан адилгүй. Гэсэн хэдий ч аймгуудын шаардлагатай байгаа суурь татаасуудыг зардлуудыг бүрэн хянаад шаардлагатай хэмжээнд нь зөрөөн дээр нь татаас өгөөд ингээд явж ирсэн байдаг. Бие даасан байдал гэх юм бол хэдхэн жилийн өмнө нэг 4 тавхан аймаг байсан юм. Энэ жил ингээд 7 аймаг болж ирж байна. Уг нь бараг арваад аймаг болох шахсан. Энэ жилээс нөгөө дулаан цахилгааны үнүүд нэмэгдэж байгаа учраас ингээд төсөвт байгууллагууд.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Ингээд аймгууд явж байна. Энэ жилийн хувьд нэг том өөрчлөлт гэх юм бол ер нь яах вэ энэ жил жил ирэх жил, ганц Өмнөговь аймаг дээрээс эхэлж байгаа ч гэсэн энийг битгий чамлаарай. Өмнөговь аймаг бол одоо хамгийн их орлого төвлөрүүлж байгаа ийм аймаг. Жил бүр бүүр 1 их наядаас давсан татварын орлогыг бүгд улсын төсөвт бүрдүүлдэг. Энүүгээр нь бусад аймгуудаа бид тэжээдэг. Ингээд Өмнөговь аймгийн бие даасан байдал яаж илүү сайжирч байна вэ гэхээр цахилгаан станцаа энэ аймаг өөрийнхөө төсвөөс шийдэж байгаа. Энэ ирэх жил бонд гаргана. 150 тэрбум төгрөг хөрөнгө төвлөрүүлнэ. Энүүгээрээ одоо 70 мвт-ын цахилгаан станцаа санхүүжүүлээд явна. Аймгууд ингээд бонд үнэт цаас гаргах ийм бие даасан байдалтай болж ирж байна. Төр хувийн хэвшлийн түншлэл дээр Учрал сайдын бэх байх. Аймгууд мөн нэлээдгүй тийм эрхтэй болж ирж байгаа. Өөрөөр хэлбэл ирээдүйд байх төсвөө өөрсдөө урьдчилж зарах. Ингэснээр хөрөнгийн менежментдээ.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабал.

Б.Заяабал: Өдрийн мэнд хүргэе ээ. 2026 оны төсвийг бид хэлэлцэж байна аа. Төсвийг хүлээж байгаа ард иргэд бизнес эрхлэгчид нэлээдгүй байгаа. Цалин минь яах бол, тэтгэвэр минь яах бол. Миний амьдран суугаа оршин суугаа газар маань энэ нийгмийн асуудлууд, сургууль, эмнэлэг хэр зэрэг шийдэгдэх бол. Бизнесийн орчин минь яах бол. Энэ жил ханш дээр ямар асуудал үүсэх бол, бизнесийг яаж дэмжих бол гэх мэтчилэн маш олон хүлээлт энэ Төсвийн тухай хуулийн цаана явж байгаа явж байгаа. Энэ удаагийн төсөв бол яах вэ өнгөрсөн жилийг бодоход энэ орлогоо ч буулгасан, нийт зарлагаа ч буулгасан. 1.3 их наядын алдагдалтай ийм төсөв орж ирж байгаа. Өнгөрсөн жил бол орлогоо ч нэмээд зарлагаа ч нэмээд дээрээс нь алдагдалтай орж ирж байсан учраас Ерөнхийлөгчийн хориг тавигдаж байсан гэж ингэж ойлгож байгаа? Алдагдалтай төсөв бол мэдээж манайх шиг ийм хөгжиж байгаа орнуудын хувьд явах ёстой л доо. Тэгээд явахаас ч өөр арга байхгүй. Гэхдээ алдагдлын цаана үр дүн байна уу гэдэг нь хамгийн чухал байгаа юм. Үр дүн байна уу гэдэг хамгийн чухал. Энэ дээр бол онцгой анхаарах ёстой шүү гэдгийг би онцгойлж хэлье. Ингээд төсөвтэй холбоотой орлого талд болон зарлага талын хэд хэдэн асуултууд байна.

Нэгдүгээрт нь орлого тал дээр ганц орж ирж байгаа зүйл нь энэ нэмэгдсэн өртгийн албан татварыг дагаж 1 сая хүртэлх худалдаа хийсэн бол 5 хувийг олгоно оо гэсэн ийм юм орж ирж байгаа. Өмнө нь 5 ам бүлтэй айл байлаа гэхэд тавуулаа нийлүүлээд нэгэн дээрээ И баримтаа бүртгүүлээд 2 хувийн буцаан олголт авдаг байсан бол одоо ингээд айлын 5 хүн тавуулаа 5 салгаж ингээд бүртгүүлэх болж байна л даа. Ингээд 5 хувийн буцаан олголт авах юм байна. Өмнө нь явж байсан бодлого бол НӨАТ-ын систем хамаагүй гудамжинд ч гэсэн газраас ч гэсэн хаа хамаагүй газраас олсон баримтаа бүртгүүлээд яв аа. Хамгийн гол нь орлогыг нь бид

нар хяная гэдэг ийм л зорилго бид нар барьж явж байсан. Одоо бол иргэн болгон бүртгүүл гэдэг ийм систем рүү явж байна л даа. Энэ нь цаанаа ямар асуудал байгаа юм бэ? Иргэд ямар хөрөнгөөр юу аваад байгаа юм бэ гэдгийг нь хянах гээд байгаа юм уу? Энэ чинь тодорхойгүй бодлого орж ирж байна аа. Тодорхойгүй маш тодорхойгүй бодлого орж ирж байна гэдгийг 1 дүгээрт хэлье.

Энэ дээр ямар бодлого байгаа вэ? Энийгээ хариулж өгөөч. 1 дүгээрт нь.

Энэ бол Сангийн яамны танилцуулга өргөн барьсан төсвийн танилцуулгыг уншихад бол энэ төсвийн орлогыг нэмэх эдийн засгийн эрэлтийг нэмсэн ийм бодлого оо гэж хэлээд байгаа байх. Нөгөө нөгөө талдаа тэгвэл нийлүүлэлтийг дэмжсэн ямар татварын бодлого явж байгаа юм бэ?

Хоёрдугаарт нь энэ хуулийн төсөл явж байгаа. Сангийн яам өргөн бариад ингээд ажлын хэсэг дээр бид нар яриад явж байгаа. Би бол энэ дээр маргаантай байгаа. Татварын хуулийн хувь хэмжээг багасгасан, дарамтыг багасгасан гэхээсээ илүү нэмсэн ийм байгаа. Би байр сууриа ажлын хэсэг дээр илэрхийлж байсан. Шаардлагатай би олон нийт рүү энэ асуудлыг гаргаж тавина гэсэн ийм бодолтой байгаа. Тэгээд өмнө нь би энэ төсвийн хууль гарахад хэлж байсан. АМНАТ-ийн хуулийг бие даасан хууль явуулаач. Хөрөнгийнхөө хуулийг засаач. Адилхан 2 барилга өөр өөр татвар төлөөд байна гэдэг ийм асуудлыг ярьж байсан. Өмнөх жил сайд Сангийн сайд хэлэхдээ уйлмаар сайхан санал хэллээ гэж миний асуултад хариулж байсан. Одоо хаачсан бэ тэр хуулиудын төслүүд чинь хаачсан бэ гэдгийг.

Х.Булгантуяа: Нэмээд нэг минут.

Б.Заяабал: Хоёрдугаарт нь энэ нийгмийн даатгалын орлого, ЭМД-ын орлого, гаалийн орлого, татварын орлогыг нийлүүлээд энэ бүх Засгийн газрынхаа энэ бүтцийг нийлүүлээд Үндэсний орлогын газар гээд явж болохгүй байгаа юм уу. Иймэрхүү жоохон том шинэчлэл хийхгүй юм уу гэсэн ийм дараагийн асуулт байна аа.

Зарлага дээр энэ урсгал зардал чинь 9 хувиар буулгаж байгаа гэж үү гэж байгаа боловч нөгөө талдаа дахиад мянган хүний орон тоо нэмээд ороод ирчихсэн байна аа. Урсгал зардал чинь нэмэгдчихсэн байна. Энэ ямар учиртай юм бэ? Хөрөнгө оруулалт дээр энэ Хөрөнгө оруулалтын тухай бие даасан хууль оруулж ирнэ гээд та өнгөрсөн жил төсөв орж ирэхэд ярьж байсан энэ хууль хаачсан бэ? Тендерийн чинь гүйцэтгэл жилдээ нэг 70, 80-хан хувийн гүйцэтгэлтэй яваад байгаа. Энэ чинь зөв юм уу? Одоо бол тендерийн гүйцэтгэл энэ жилийн худалдан авах энэ хөрөнгө оруулалтын чинь гүйцэтгэл өшөө бага хувьтай явж байгаа.

Дээрээс нь төсвийн зарлага тал дээр энэ ямар ч тодорхойгүй. Төсвийн хуулийн 32.2 дахь зүйлийг та бүхэн ороод уншаарай. Энэ төсвийнхөө хуулийг зөрччихсэн ийм тоног төхөөрөмж гэсэн бөөн дүнгээр сайд болгоны багц дээр ингээд ингээд мөнгө тавиад өгчихдөг нь ямар учиртай юм бэ?

Х.Булгантуяа: Эхлээд Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Заяабал гишүүний асуултад хариулъя. Татварын байгууллагыг олон жил удирдсан хүн НӨАТ-ыг ингэж тайлбарлаж байгаад би маш харамсаж байна. 1 сая төгрөгийн борлуулалт хийсэн бол биш шүү 1 сая төгрөг хүртэл. 500

мянга ч байсан, 600 мянга ч байсан 5 хувийн буцаалт. Сая 500 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн бол сая төгрөг дээр нь 5 хувь, давсан дүн дээр нь 2 хувь хуучнаараа. Энэ НӨАТ-ын систем маань өөрөө төсвийн орлого бүрдүүлэхээс гадна бүртгэлийн томоохон систем байдаг. Та энийг хамгийн сайн мэдэх хүн шүү. Хамгийн сайн мэдэх хүн. 5 сая төгрөгийн жишээ нь худалдан авалт хийсэн өрх 5 ам бүлтэй бол тавуулан дээр нь хуваахад 5, 5 хувийн буцаан авалт хийнэ. Таны хэлж байгаа тэр зөв. Өмнө нь ингээд нэг хүн бүртгэгддэг байсан бол 5 бүртгэгдээд нөгөө суурь маань тэлэх юм байгаа юм. И баримтын систем 16 онд ажиллаж эхэлснээр хамрагдалт 44 байсан. Тэрнээс хойш өнөөдөр 76 болчихсон байгаа. Энэ 76 хувь хүргэхэд та сайн ажилласан хувь нэмрээ оруулсан. Энэ том байгууллагыг амжилттай удирдсан.

Одоо энийг цаашаагаа 90 болгохоор зорьж байгаа. НӨАТ-ын систем хамгийн сайн хөгжсөн Шинэ Зеланд улс байна. Тэнд 93 хувьтай байдаг. Энэ НӨАТ-ын буцаан олголтыг сая төгрөг хүртэл бид 5 хувь болгосноор энэ хамрагдалт маань ойрын жилүүдэд ер нь 90 хувь руу дөхнө гэсэн бид нар хүлээлттэй байгаа. Яах вэ далд эдийн засаг гэж яриад байдаг. Ямар юмных нь далд байх вэ дээ тэр нуугдаад байх юм байхгүй. Бид нарын татварын орчин маань өөрөө тийм боломжийг нь бүрдүүлчихсэн байгаа. Тэгээд иргэдийн буруу байхгүй. Тэгэхээр и баримт энэ систем хөгжихийн хэрээр татварын суурь тэлнэ ээ. Өөрөөр хэлбэл Ерөнхий сайд хэлж байсан бид 3 сая ийм татварын байцаагчтай болно гээд энэ рүүгээ явчхаж байгаа ийм хөгжил юм шүү. Энэ дэвшил юм байгаа юм. Тэр мянга гаран хүн орон тоо нэмэгдсэн гэж Бямбацогт сайд хэлэх байх. Гааль татварын байгууллагуудыг нэмээд орлогын институт гээд өмнө нь бол нэг удаа АН-ын үед Засаг барьж байх үед нэг хийж байсан шүү дээ. Тэгээд болохгүй байна гээд буцаагаад салгасан. Татварын байгууллага төсвийн орлогыг бүрдүүлдэг ийм гол институт. Гааль бол бор манай төсвийн орлогын нэг 30-аас 40 хувийг бүрдүүлдэг. Гэхдээ өөр нэг том зорилго нь өөрөө энэ үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын асуудал, хил гаалийн асуудлууд тусдаа өөр зорилготой ийм байдаг.

Тийм учраас энэ үүрэг функц нь болохгүй байна гээд ингээд салгасан байдаг. Тэр салгасан нь ч зөв байх аа. Энэ 2-ыг нийлүүлэх нь нэг их зөв гэж харагдахгүй байгаа. Хөрөнгө оруулалтын тухай хууль бэлэн болчихсон байгаа. Энэ талаар хэн манайхаас хэлээдэх вэ?

Бид хэзээ өргөн барих билээ? Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хууль шүү тийм гадаадын хөрөнгө оруулалт биш. 4 номер дээр.

Х.Булгантуяа: 4 номерын ажлын хэсгийн микрофон.

Ж.Дэлгэржаргал: Заяабал гишүүний асуултад хариулъя.

Дэлгэржаргал Сангийн яам. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай гээд бие даасан яг төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй холбоотой хөрөнгө оруулалтуудыг бүхэлд нь яг төлөвлөлтөөс нь авхуулаад ер нь өмчид бүртгэх ашиглалтын үр өгөөжийг тооцох анхдагч хуулийн төслийг боловсруулаад 10 сард өргөн барихаар ингээд санал авах боловсруулах шатдаа явж байна аа.

Х.Булгантуяа: Заяабал гишүүн нэмж тодруулна.

Б.Заяабал: Тэр АМНАТ-ийн хууль, Хөрөнгийн хуулийг та хариулсангүй ээ. Тэгээд би бусад асуудлуудаар олон нийт рүү би мэдээллээ өгч гаргая аа. Өөр арга алга аа. Ингээд ийм хариулт нь зөрөөд байгаа учраас. Би ингээд аудит үлдсэн. Ингээд аудит Хөдөө аж ахуйн яам 2 руу асууя гэж бодож байна. Аудитын байгууллага энэ тоног төхөөрөмж, Төсвийн хууль зөрчсөн тоног төхөөрөмж бөөн дүнгээрээ 400, 500 тэрбум төгрөг орж ирж байхад юу хийж байсан юм бэ? Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 70, 80-хан хувьтай гараад байхад та нар ямар дүгнэлт гаргаад байгаа юм бэ. Үр дүнд суурилсан төсвийн чинь үр дүн нь байхгүй болчихоод байна шүү дээ. Хэмнэлтийн хуулиар сая 500, 600 тэрбум төгрөг байхгүй болчихлоо. Нөгөө үр дүн чинь салбаруудын чинь үр дүн нь байхгүй болж байхад та нар ямар дүгнэлт хийгээд суугаад байгаа юм бэ гэсэн ийм 3 асуулт байна.

ХАА-н сайдаас өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад малын чинь экспортын тоо хэмжээ өнгөрсөн жил мөн үе дээр 88 сая доллар байсан. Одоо 72 сая доллар болчихсон. Боловсруулсан арьс 2 сая доллар байсан. Одоо 620 мянга болчихсон. Ноолуур 244 сая байсан 86 сая болоод 65 хувиар буучихсан. Ноос чинь буучихсан.

Х.Булгантуяа: Эхлээд Үндэсний аудитын газраас индрийн 3 номерын микрофон дээрээс. Дараа нь Энхбаяр сайд хариулахад бэлдэж байгаарай.

Д.Энхболд: Үндэсний аудитын газар, Гүйцэтгэлийн аудитын газар, Энхболд Заяабал гишүүний асуултад хариулъя аа. 2026 оны төсвийн төсөл дээр цахим системд ТЭЗҮ, тоног төхөөрөмжийн зардлын ангиллыг авч үзсэн байгаа. Энэ дээр тоног төхөөрөмжийн ангилал дахь төсөл арга хэмжээг төлөвлөхөд үндэсний хэмжээнд мөрдөхөөр баталсан холбогдох ангиллыг хооронд нь зөрүүлэх, хууль тогтоомжийн зарчим, шаардлагад бүрэн нийцэхгүй байх учир дутагдалтай байна гэдэг дүгнэлтийг хийсэн. Энэ дээр төсвийн ерөнхийлөн захирагчдаас тоног төхөөрөмжийн ангиллын нийт 268 төсөл арга хэмжээний 3.8 их наяд төгрөгийг төгрөг төлөвлөх санал ирүүлснээс бол 22 төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад 63 төсөл арга хэмжээний 521 тэрбумыг.

Х.Булгантуяа: 3 номерын микрофоныг нэмж өгье. Бүрэн хариулъя.

Д.Энхболд: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд тоног төхөөрөмжийн төсөл арга хэмжээг 2026 онд бол хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй. Тоног төхөөрөмжийн ангилалд хамаарах төсөл арга хэмжээний төсөвт өртгийн 17.6 хувийг бол Байгаль орчны сайд хамгийн хамгийн ихийг, хамгийн бага буюу 1.6 хувийг Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын төсөл арга хэмжээнд тус тус эзэлж байна гээд дүгнэсэн байгаа.

Х.Булгантуяа: Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Заяабал гишүүн хаанаас мэдээлэл авсан тэрийгээ эргэж шалгаарай. 9 сарын 10-ны байдлаар 140 сая долларын мал мах экспортолчхоод байна. Хонин толгойд шилжүүлбэл 2 сая толгой мал экспорт гарчхаад байна. Мах мал бэлтгэл ид өрнөж байна. Гэрээнүүд, зах зээлүүд, эрэлтүүд өндөр байгаа. ОХУ Япон, Хятад, Узбек, Казак, Тажек, Иран, Ирак, Хонконг, Эмират, Катар, Вьетнам, Армен, Кувейт, Хятад, Ардчилсан Солонгос гэсэн орнуудад мах экспортлогдож байна. 2 жил бид нар 300 сая долларын мах экспортолсон. Энэ жил энэ түвшиндээ хүрэхийн төлөө ажиллаж байна. Давуулахын төлөө ажиллаж байна.

Ноолуур 8 сарын байдлаар 1571 тонн самнасан ноолуур гараад 131 сая доллароор экспорт хийчхээд байна. Энэ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад биет хэмжээ болон үнийн дүнгээр 3 дахин өсчхөөд байна.

Х.Булгантуяа: Энхбаяр сайдын микрофоныг нэмж өгье. Энэ дэлхийд худалдаа дайны дайнтай энэ үед бид яаралтай арга хэмжээ авсны үр дүнд Монгол Улс ноолуураа дотроо үйлдвэрүүд нь 100 хувь аваад 100 хувь самнаад хамгийн үнэтэй Европын зах зээл гаргадаг болчхоод байна шүү дээ. Үр дүн гараад байна та ажил дээр очвол болно, шинэ үйлдвэрүүдэд очиж үзэж болно. Олон 10 үйлдвэр өргөтгөл хийлээ. Олон үйлдвэр шинээр бий боллоо. Зөвхөн ноос ноолуур дээр. Биет хэмжээ болон үнийн дүнгүүд өсөж байгаа. Бид чадвал оны сүүл гэхэд ХАА-н салбар тэрбум долларын экспорт хийдэг салбар болно. Энэ зорилтоо хангахын төлөө ажиллаж байгаа. Дандаа авдаг биш энэ чинь бас Эрдэнэтийн дайтай экспорт хийдэг эх орондоо валют олдог салбар болж хувирч байна шүү дээ. Энэ олон хөтөлбөрийн үр дүнд.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж дууслаа. Улсын Их Хурлын гишүүд нэр өгсөн дарааллын дагуу. Нэрс аваагүй байгаа тийм ээ. Асуулт асууж дууслаа. Одоо 2026 оны төсвийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Нийт 26 гишүүн нэр өгсөн байна аа. Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа.

Д.Үүрийнтуяа: Би өчигдөр асуусан асуулттайгаа уялдуулаад хэд хэдэн санал хэлье. 2026 оны улсын төсвийг аваад үзэхээр бид нар энэ хөрөнгө оруулалтын зардал дээр бол зайлшгүй анхаарах шаардлага байна аа. Би Ерөнхий сайдыг байсан бол энд тодорхой санал хэлье гэж бодсон юм. Тэгээд Шадар сайд байгаа учраас энийг ажил хэрэг болгоосой гэж хүсэж байна.

Жил болгоны төсвийн асуудлыг ярихад бид нар урсгал зардал нь хүрэхгүй, сургууль, цэцэрлэгээ барьж чадахгүй, хөрөнгө оруулалтынхаа зардлыг тодорхой түвшинд нь хүргэж чадахгүй асуудал болж байхад үнийн өсөлттэй холбоотой асуудал олон жил ужгирсаар байна. Барилга байгууламж нь дуусдаггүй салбар болгонд.

Тийм учраас Ерөнхий сайд энэ салбарынхаа бүх сайд нарт үүрэг даалгавар өгсөн албан даалгавар гаргаач ээ. Сайд бүхэн салбар салбарынхаа хэмжээнд байгаа нийт хөрөнгө оруулалтын асуудлуудыг хэдэн жил үргэлжилж байгаагаар нь ангилж эрэмбэлж, үүнийгээ хэрэгжих боломжтойг нь дуусгаад хэрэгжих боломжгүйг нь шүүх цагдаагаар яваад энэ асуудлаа эцэслээч. Нэгтгэж оруулж ирээч ээ. Хэдэн жил ингэж үргэлжлэх юм бэ? Үндэсний аудитын газар дүгнэлт гаргасан байна лээ. Гүйцэтгэлийн аудит. 100 төсөлд 194 тэрбум төгрөгт ямар ч зөрүү гарав уу үгүй юу гэж. Ядаж магадлал стандарт хазайлтад тооцохоор магадлалын онолын дагуу бол 2-оос 5 хувийн зөрүү байна даа. Би маш их эргэлзэж байгаа.

Дараагийн асуудал мөн энэ хөрөнгө оруулалттай холбоотой боловсролын салбар Эрдэнэт хотод би жишээ авч Эрдэнэтээр жишээ авч байгаа. Улсын хэмжээнд ийм хэмжээний хэчнээн сургууль байгааг хэчнээн барилга байгууламж байгааг би мэдэхгүй. Эрдэнэтийн хоёр, Рашаантын 2 сургууль, 19, 20 онд эхэлсэн өнөөдөр хүртэл дуусаагүй. Энэ оны төсвөөс төсвийг нь хасаад хаячихсан. Сангийн сайд ч тэр, Наранбаяр сайд ч тэр аль аль нь аудитын дүгнэлт байхгүй гээд байгаа.

Уучлаарай 2023 оны 10 сарын 18-ны өдрийн аудитын дүгнэлтээр төсвийг нь баталгаажуулчихсан. 2 жилийн хугацаа нь дуусаагүй байна.

2023 оны 10 сарын дүгнэлтээр 2024 оны төсөвт энэ тусгагдаж чадаагүй. 2025 оны төсөвт тусгасан. Наранбаяр сайд та эрхээ шилжүүлээгүй, эрхээ шилжүүлэхгүй, тендерээ зарлахгүй байсаар байгаад энэ мөнгө 5 сарын 31-ээр татагдсан. Өнөөдөр эргээд энэ хоёрыгоо хасчхаж байгаа юм. Тэгээд худлаа тайлбар өгөөд сууж байдаг Улсын Их Хурлын чуулганы танхимд худлаа хариулт өгөх юм бол хуулийн хариуцлагатай байх шүү дээ сайд нараа.

2023 оны 10 сарын 18-ны өдрийн аудитын дүгнэлт нь байж байгаа шүү энэ 2 дээр. Тэгээд энэ асуудлыг би зарчмын зөрүүтэй санал гаргана сайд би танд өмнө нь энэ хаврын чуулган дээр асуулга явуулж байсан асуулгынхаа хариуг өдий болтол авч чадаагүй. Дахиад энэ 2 асуудлыг тавьж байна. Шаардлагатай бо сайдын өөрийн багц дээрээс энэ асуудлыг зарчмын зөрүүтэй санал гаргаж оруулна аа.

Тэгэхээр улсын хэмжээнд ийм хэчнээн сургууль байна гэдгийг би аймаг болгоноор би гаргаж чадахгүй байна. Тийм учраас энэ мэдээллээр Улсын Их Хурлын гишүүдийг хангаач, энэ мэдээллээ гаргаж өгөөч, ил болгооч. Багцалчихсан энэ тоогоо задлаач ээ.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очир.

Д.Бум-Очир: Төсөв хасагдсантай хамаатай зарим ОУБ-ын өмнө Монгол Улс эвгүй байдалд орохоор хэмжээний зарим нэгэн асуудлууд яваад байгааг сайд дарга нар болоод гишүүдийн сонорт хүргэх гэсэн юм аа. Юнеско дээр хөөцөлдөөд 2023 онд шиг санагдаж байна. Энэ нүүдлийн соёл иргэншлийн ном бичнэ гээд Ерөнхий ассамблейн хурлаар нь батлуулаад авсан юм. Тухайн үедээ мань мэтийн энэ чиглэлээ анхаардаг сонирхдог хүмүүс их баярлаад ингээд явсан. Монгол энэ дээр манлайлал үзүүлэхээр болсон. Түүнээс хойш төсөв нь байдаггүй ээ.

Юнеско өнөөдөр Монгол Улсаас номоо нэхээд сууж байгаа. Тухайн үед Боловсролын сайд байсан Энх-Амгалан сайд бол энийг маш сайн мэдэж байгаа. Дараа нь яам хуваагдсан, шинжлэх ухааны салбар нь Эдийн засгийн яам руу явсан. Ингээд 2 яам энэ тэр болоод явж байх хооронд энэ төсөв суугдаж чадахгүй ингээд байж байна. Үүний үр дүнд өнөөдөр бид нар Юнескогийн царайг яаж харахаа мэдэхгүй сууж байгаа гэдгийг би хэлмээр байна аа. Энэ мөнгийг нь аль сайд нь хаанаас юм гаргаж өгмөөр байна аа. Юнейскоийн өмнө бид эвгүй байдалд орох тийм сайн юм биш ээ. Мэдээж өнөөдөр төсөв хэцүү байгааг ойлгож байна. Гэхдээ олон улсын ийм томоохон байгууллагуудын өмнө бид нэр нүүрээ алдаад баймааргүй байна.

Энэ нүүдлийн соёл иргэншлийн бодлого гэдэг манай Монгол Улсын энэ бүс нутагт хийх зөөлөн хүчний бодлогын хамгийн чухал тулгуур нь байхгүй юу. Бид нар энэ дээрээ манлайллаа үргэлжлүүлээд хадгалмаар байгаа юм. Гэтэл нэг ном барь бичнэ гээд ингээд амлаад Ерөнхий ассамблейн хурлаар нь шийдвэрлүүлээд гэтэл Засгийн газар нь тэр ном бичих мөнгийг нь гаргаж өгөхгүй байхаар бид энэ нүүдлийн соёл иргэншлийнхээ асуудалд тууштай хандахгүй байгаа юм шиг харагдаж байгаа юм.

Гэтэл энд нөгөө талдаа маш олон өрсөлдөгч улсууд байдаг. Бидний хөрш эргэлдэх энд Төв Азийн Турк тийм ээ, Казахстан, Киргизстан, Турк гээд энэ олон улсууд энэ ажлыг чинь авчих боломжтой шүү дээ. Бид нар маш эвгүй улсаараа нэр нүүрээ алдсан ийм байдалд орох гэж байгаа.

Дараагийн нэг зүйл юу вэ гэхээр энэ олон улсын стандартын байгууллага ISO гэж хэлдэг. Энэ байгууллагын өмнө бид чухал хариуцлага хүлээсэн байдаг. Монголын олон бараа бүтээгдэхүүнүүд үндэсний болоод олон улсын стандартыг давчихсан байх нь нөгөө бидний яриад байдаг эдийн засгийг солонгоруулахад чухал үүрэгтэй.

Манай Стандарт хэмжил зүйн газар энэ ажлыг хариуцдаг. Шадар сайд ч гэсэн энийг мэдэж байгаа байх. Төсөв нь хасагдчихсан. 2 жил дараалаад олон улсын стандартын байгууллагынхаа хуралд очиж чадаагүй өнөөдөр бандуулчихсан явж байгаа. Гэтэл тэнд чацарганын стандарт олон улсын, ингэний зүүний стандарт эд нарыгаа лоббидоод уул нь бол олон улсын стандартын байгууллага дээрээ нэр нүүртэй байгаад ард нь гарчихвал ард нь эдийн засгаа солонгоруулах тухай асуудал явдаг гэдгийг анхааруулж хэлмээр байх юм.

Гэтэл одоо төсөв мөнгөгүй гээд хуралдаа ч орж чадахгүй би Санхүүгийн зохицуулах хорооныхонтой уулзсан. Хувиасаа мөнгө гаргаад ч болсон очихгүй бол болохоо байлаа гээд ингээд яриад сууж байна шүү дээ. Тэгэхээр мэдээж төсөв мөнгө хэцүү байгааг ойлгож байна. Гэхдээ энд тийм их олон тэрбум төгрөг ороод байхаар биш. Ийм жижиг жижиг зардлуудыг анхаараад уул нь сайд нь байх юм уу салбар нь байх юм уу шийдвэрлээд учир зовлонг нь ойлгоод дэмжээд явбал хэрэгтэй байна аа.

Үүний ард Монгол Улс улс олон улсын байгууллагуудын өмнө олон улс орны өмнө тодорхой хэмжээгээр нэр нүүрээ алдаад байгаа нь бидний анхаарах ёстой асуудал болов уу гэдгийг онцлон хэлмээр байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижир.

Ө.Шижир: Өдрийн мэнд. Яах вэ дээ тэгээд илжигний чихэнд алт хийсэн ч сэгсэрнэ, ус хийсэн ч сэгсэрнэ гэдэг. Одоо аманд нь өвс хийсэн ч сэгсэрдэг турхирдаг л болчихлоо л доо. Тэгээд бид нар нэг асуусан болоод сайд нар нэг хариулсан болоод ингээд дуусна. Нөгөө өнгөрсөн жил алдагдалгүй төсөв гээд байсан юмнууд нь яг л хэвээрээ. Ер нь манай сайд нар их гоё гоё я юм яриад л яг өнөөдрөөс энэ жилээс ёстой гоё болно гээд байх юм. Үгүй та нар чинь бүгдээрээ л өмнөх хэд хэдэн Засгийн газар сайд дарга байсан хүмүүс биз дээ. Өөрсдийгөө танихаа больчихсон юм уу? Нэг толинд харж өөрөө өөртэйгөө ярилцах юм уу? Ер нь энэ байдлаараа явах юм бол хэдэн жилийн дараа улсын төсвийн орлого түүхий эдийн бүтээгдэхүүний үнийн уналтаас хамаараад буурах юм бол улсын төсөв чинь урсгал зардлаа ч дийлэхээ болино. Юун хөрөнгө оруулалтын зардал. Энэ нөхцөл байдал руу явах нөхцөл байдал үүсэж байна аа.

2016 оноос хойш сүүлийн 10 жилд сумын ЗДТГ, аймгийн ЗДТГ, 1 цэгийн үйлчилгээ, нийгмийн даатгал гэх мэт төрийн ямар нэгэн 623 ширхэг барилга байгууламж 1.8 их наяд төгрөгөөр баригдсан байна. Энэ чинь эргээд урсгал зардлаа нэмж байгаа юм. Зөвхөн 2026 оны төсөв дээр 5-аас дээш жил үргэлжилж байгаа 1

тэрбум төгрөгөөс дээш төгрөгөөр анхны төсөвт өртөг нь өссөн 42 ширхэг барилга байгууламж байна.

Үүний нийт өртөг нь төсөв нь 357 тэрбум төгрөг буюу тэтгэвэрт гарсан ахмад настны тэтгэмжийг 2 хувааж өгөөд байгаа. Мөнгө байхгүй гээд байгаа мөнгө чинь энд байгаа байхгүй юу. Он дамжуулж хойшлуулахгүйгээр анхны төсөвт өртгөөр нь барьсан бол бид нар өнөөдөр тэтгэвэрт гарах ахмадынхаа мөнгийг ямар ч асуудалгүй өгөх байжээ. Тэгээд боловсролын жил гээд зарлаад байгаа юм бол тэвчиж байгаа зардлуудаа тэвчиж болох зардлуудаа бүгдийг нь тэвчээд сургууль цэцэрлэгийнхээ хүртээмжийг 100 хувь шийдье ээ.

Үүнд 1.2 их наяд төгрөг хэрэгтэй. 2026 он өөрөө боловсролын жил мөртөө Улаанбаатарт байгаа 2 төв номын сан ном худалдаж авах өртөг нь 12.5 сая төгрөг төсөв нь. 21 аймаг тус бүр 2.5-хан сая төгрөг. Тэгээд ийм боловсролын жил гэж байдаг юм уу? Тэгэхээр Ундрам сайдаа Төсвийн байнгын хороон дээр би энэ талаар зарчмын зөрүүтэй санал гаргана. Номын сангийн суурь. Та энэ дээр дэмжээрэй.

Тэгээд замын асуудал яригдсан хэдэн өдөр. Зам дагаж хөгжил ирдэг гэдэг бол даргаа дагаж замд явдаг болсон шүү. Зам дагаж хөгжил биш даргаа дагаж замд явдаг болсон шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дүгэрийн Рэгдэл.

Д.Рэгдэл: 2 санал хэлэх ёстой гэж бодож байна аа. Өчигдөр асуултдаа хангалттай хариу аваагүй учраас ярьж байгаа юм.

Нэгдүгээрт Засгийн газар Энэ төсвийн төслөө оруулж ирэхдээ төсвийн тухай хуулийнхаа шаардлагыг л бүрэн хангаж ирмээр байна. Одоо энэ чинь хөрөнгө оруулалтын төсөв дотор, төслүүд дотор төсөл хийгдээгүй төсөв нь хийгдээгүй ийм ажлууд нэлээн хэд орж ирж байна. Хэдэн 100 тэрбумаараа яригдаж байна аа. Тийм учраас энэ хөрөнгө оруулалт энэ төслүүд нь ийм төслүүдийг шууд хасмаар байгаа юм. Энэ гадаад дотоод ямар ч хамаагүй шүү дээ. Ингэж байж тас цохихгүй бол магадлан хийгдээгүй төсөвтэй, зурагтай объектууд орж ирдэг энэ үйл ажиллагаа олон жил үргэлжлэх гээд байгаа юм аа.

Хоёрдугаарт энэ төсвөө оруулж ирэхдээ төрийн хэмнэлтийнхээ тухай хуулийг барьж оруулж ирмээр байна аа. Энэ төрийн хэмнэлтийн хуулиар чинь хөрөнгө оруулалтын төслүүдийг үргэлжлэх хугацаанд нь тэнцүүхэн хуваагаад оруулж ирэх л ийм л заалттай шүү дээ. Тэгсэн чинь одоо нэг объект ороод ирэх дээр зэрэг нийт 3 жил үргэлжлэх объект гэж бодоход нийт төсвийнхөө 10 хувийг нь 2026 онд өгнө өө. Үлдсэн 90 хувийг нь дараагийн 2 жилд нь өгнө гэсэн маягтай. Нэг хошуу шургуулаад авах зорилготой ийм юмнууд их явж байна аа.

Тэгэхээр зэрэг энэ төрийн хэмнэлтийн хуулийн дагуу ийм объектууд ялангуяа тэр соёлын төвүүд дээр, тэр иргэдэд мэдээлэл өгөх мэдээллийн төвүүд дээр сургуулиудын барилга дээр гээд нэг 10 хувийг нь тавьчихсан юмнууд их байна аа. Энийгээ цөөлөөд тэр 3 жил үргэлжлэх юм бол 30 хувийг нь тавиад ингээд явмаар байна. Энэ дараагийн хэлэлцүүлгүүд дээр энэ хөндөгдөнө шүү.

Хоёрдугаар санал юу байна вэ гэхээр зэрэг энэ шинээр эхэлж байгаа, явж байгаа, явах гэж байгаа тэр тусмаа улс даяар их олноороо баригдах энэ

объектуудад сайн судалгаа хиймээр байх юм. Одоо тэр иргэдэд мэдээлэл өгөх иргэдэд үйлчлэх мэдээллийн төв гээд 8 барилгын санал орж ирж байгаа. Тэр 8 бол үндсэндээ 2.2 -оос 3.2 тэрбумын төсөвтэй дахиад 2026 онд нийтдээ нэг 5.7 тэрбумыг тавьчихсан. Гэтэл энэ сумын сум болгоны төв дээр ийм барилга барих гэж байгаа юм байна гэж харагдаад байгаа. Энэ барилгад чинь өдөрт хэчнээн хүн орж ирээд мэдээлэл авах юм бэ. Тэд нарт мэдээлэл өгөх гээд энд хүмүүс сууж байх юм уу хаашаа юм. Одоо энэ чинь мэдээлэл дамжуулдаг их өгөгдлүүдтэй харьцдаг энэ сангууд мэдээлэл хүлээж авдаг техник хэрэгсэл ингээд бүгд сайжирчихсан байхад бид нар 330 сумдаа 2 давхар жижигхэн дөрвөлжин байшин бариад тэндээсээ мэдээлэл өгөөд сууна гэсэн ийм төсөөлөлтэй орж ирж болохгүй ээ.

Тийм учраас энэ дараагийн дараагийн хэлэлцүүлэгт энэ жоохон байшинд чинь өдөрт хэчнээн хүн орж ирэх юм.

Хоёрдугаарт энэ чинь яагаад яагаад юу байх вэ? Энэ чинь улирлын шинж янзтай ажиллана аа. Хүйтний улирал угаасаа халааж чадахгүй учраас хаагаад хаячихна. Тэгээд зуны нэг амралтын цаг голцуу улирлуудад ингэж ажилладаг ийм юмнуудаа хянаж үзээд шилжүүлж барих энэ ажлуудаа ялангуяа энэ Их Хурлаас байгуулагдсан төсвийн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг маш сайн үзэхгүй бол болохгүй байна аа.

Гуравдугаарт төсөв нэмэгдүүлээд байдаг энэ магадлангаар ороод энэ жил магадлангаар оруулж ажлаа авчхаад ажлаа хийж явж байгаад төсвөө 2 дахин нугалуулаад тавьчихаж байна аа. Энэ Төсвийн хяналтын дэд хороо гэж байдаг санагдах юм. Энэ дэд хороо энэ сүүлийн 10 жилд ингээд магадлангаар төсвөө огцом огцом ахиулаад байдаг энэ ажлуудаар нь хянаж үзмээр байна. Энэ ямар компаниуд ингээд байдаг юм? Яагаад ингээд гэнэтхэн огцом огцом нэмээд байдаг юм? Нэмэх шалтгаан нь бол.

Х.Булгантуяа: Рэгдэл гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлан. Биш уучлаарай. Өдөржингөө хэдэн өдөр Жавхлан сайдын нэрийг дуудаж байгаад. Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга.

Б.Уянга: Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хууль дээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын н багцад үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан гээд энэ мэдээллийг энэ сангийн талаар мэдээллийг харж болно. Булгантуяа дарга бол энэ сангийн талаар нэлээн их мэдээллийг гишүүдэд ялангуяа уул уурхайн салбартай холбоотой байдаг гишүүдэд анхаарах нэг ийм бид бид нарын ашиглаж болох анхаарал хандуулж болох сан байдаг шүү гэдэг мэдээллийг удаа дараа өгч байсан маш сайн мэдэж байгаа.

Яагаад энэ санг он өнөөдөр ингэж онцолж байгаа вэ гэхээр энэ санд болохоороо мэргэжлээс шалтгаалсан өвчтэй болж магадгүй осолд өртөж магадгүй тийм мэргэжлийн, ажил мэргэжил эрхэлдэг нөхдүүд өөрийнхөө НДШ-ээсээ 0.5 -аас 2.5 -ыг төвлөрүүлж байдаг ийм сан байгаа. 496 ажил мэргэжил байгаа. Энд нь болохоор уул уурхайн салбар.

Тэгээд барилгын салбарынхан байгаа. Хамгийн өндөр хувиа төвлөрүүлдэг нь. 2026 онд болохоор 253 тэрбум төгрөг бол яг энэ санд хуримтлагдахаар байгаа байхгүй юу. Зарцуулалт нь тэгэхдээ 69 тэрбум байхаар энэ нийгмийн даатгалын

сангийн 2026 оны төсвийн тухай хууль дээр орж ирсэн байгаа. Юунд зарцуулдаг юм бэ гээд хараад үзэнгүүт дандаа осолд орсны дараа мэргэжлээс шалтгаалсан өвчтэй болсны дараа энэ санг дэмжлэг авах байдлаар тэтгэвэр авах байдлаар рашаан сувилалд эмчлүүлэх байдлаар энэ санг зарцуулдаг юм байна.

Тэгэхээр энэ дээр нэг зүйлийг манай гишүүд сайн анхаараад авчихвал зүгээр байна аа. Одоо ямар ч мэргэжил эрхэлж байгаа, ажил эрхэлж байгаа хүн тэгээд осолд орсных нь дараа анхаарал хандуулах биш осолд орохоос нь сэргийлсэн ийм байдлаар энэ санг ашиглах хэрэгтэй байна аа. Тэгэхээр энэн дээр яг Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлээд холбогдох саналуудыг хэрэг өгөхөөр ингэж ажиллаж байгаагаа албан ёсоор хэлэхийг хүссэн юм.

Бид нар Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан баг гээд баг байгаа. Гашуунсухайт боомтоор гарч байгаа энэ нүүрсний тээврийн жолооч нар ар гэрийнхэн нь бүгдээрээ тэнд хөдөлмөрлөж амьдарч байгаа 30 мянга гаруй иргэд байдаг гэж үздэг. Энд болохоор эрүүл мэндийн чиглэлээр нийгмийн асуудлыг нь шийдэх чиглэлээр олон ажлуудыг хийх ийм санал ирдэг ээ. Ерөөсөө аль нь ч бол энэ 2026 оны төсөв дээр тусаж багтаагүй.

Тэгэхээр яг энэ тэнд байгаа 30 мянган иргэдийнхээ эрүүл мэнд, нийгмийн асуудлыг нь шийдэхээр энэ сангийн зарцуулалтыг 2026 онд гаргах ийм саналуудыг өгнө өө. Тэгээд холбогдох сайд Аубакир сайд дэмжиж ажиллана гэж найдаж байна аа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа.

33 их наядын зарлагатай 1.3, 1.4 их наядын алдагдалтай төсөв орж ирэхдээ төрийн албан хаагчдаа тэтгэвэрт нь гаргахдаа хуулиар олгодог нэг удаагийн тэтгэмжээ харамлан хууль зөрчин 50 хувийг нь л тусгаж яах вэ? Яах вэ хэдүүлээ болчихно шүү дээ гэж. Тэгж байгаад болгоно оо гэж хэлж байгааг бол хүлээн зөвшөөрөх арга байхгүй юм аа. Ийм учраас яаж ч байсан ирэх онд хуулиар хүлээсэн үүргээ төр бол биелүүлэх ёстой. Энэхүү тэтгэмжийг бүтнээр нь тавих ёстой. Тэгээд яагаад би үүнийг хэлж байна вэ гэхлээр нөхцөл байдал ярьж байгаа шигээ тийм сайн биш ээ. Нэг их тийм мундаг сайхан эерэг төсөв орж ирчихлээ гэж дүгнээд байгаа шиг биш Үндэсний статистикийн хороо сар болгон албан ёсны статистикийг гишүүдэд хүргүүлдэг олон нийтэд мэдээлдэг төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2025 оны эхний 7 сард 1.3 их наяд төгрөгийн алдагдалтай байгаа дараа жилийн төлөвлөж байгаа. 1.3, 1.4 их наядын алдагдал чинь энэ жилийн хувьд бол бол эхний 7 сард яг ийм хэмжээнд бол байгаа.

Ирэх онд нөхцөл байдал сайжирна гэдэгт би итгэхгүй байгаа. Засгийн газар өөрөө өгч байгаа мессеж, хөрш орнуудтайгаа харилцаж байгаа харилцаа гадаадын хөрөнгө оруулагчдад өгч байгаа мессеж бол нэг их тийм эерэг бол харагдахгүй байгаа. Ийм учраас бид энэ бүх юм сайхан болно оо гэдэг үгэнд итгэхгүйгээр хуулиар хүлээсэн үүргээ бол биелүүлэх ёстой. Төрийн албан хаагчдынхаа тэтгэвэртээ гарахдаа олон жил хүлээж байгаад үүний л төлөө ер нь ажиллаж байгаа аж амьдралаа ер нь үүнтэй л тэсэж бодож хүлээж байдаг энэ тэтгэмжийг бол бүтэн тавих хэрэгтэй. 178 тэрбум төгрөг урсгал зардал дээр хаа нэгтэйгээс олж шилжүүлнэ гэдэг бол маш хүнд гэдгийг бол бид бүгдээрээ мэдэж байгаа.

9 сарын 15-аас хэлэлцэж эхэлдэг болсон нэг үе шат нэмэгдүүлсэн энэ цаг хугацаа бол бас Засгийн газарт алдаагаа засах ийм боломж олгож байгаа гэж үзэж байгаа учраас би Засгийн газарт хандаж юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр эргүүлж татаж аваад хуульд нийцүүлээд эргүүлэн оруулж ирсэн нь илүү зохистой болов уу гэж ийм зүйлийг санал болгох гээд байна. Ер нь бол 2 хуулийн заалтыг зөрчсөн байгаа гэдгийг би дахин давтан хэлмээр байна. Нэг нь болохоор Төсвийн тухай хууль өр авлага үүсгэж болохгүй буюу 50 хувийн өрийг дараа жил рүүгээ оруулах гээд байна шүү дээ. Ер нь 2027 оны төсвийг бид нар хаа байсан хэлэлцэж, эхлээ ч үгүй, бодоо ч үгүй байхад 27 оны төсвийг бас төсөвт суулгана төсөвт оруулж байна гэж ярьж байгаа нь өөрөө зарчмын хувьд бол буруу.

Хоёр дахь хуулийг зөрчиж байна гэдэг маань бол энэ төрийн албан хаагчдын нийгмийн хамгааллыг хамгаалсан 9.2 дээр байгаа. Ямар нэгэн байдлаар улс Засгийн газар төсвөө хумьж байгаа бол энэ нь өөрөө эргээд төрийн албан хаагчдын тэтгэмж, урамшуулал, нэмэгдэл хөлс бууруулах саналыг оруулж болохгүй ээ, бууруулж болохгүй, төр бол бүрмөсөн зогсоож болохгүй гэдэг ийм хуулийн хамгаалалт. Ийм учраас байдаг юм аа.

Тэгэхээр энэ хуулийг зөрчиж байгаа гэж үзэж байна. Маш олон төрийн албан хаагчдыг цомхотгол нэрээр ер нь бол хэлмэгдүүлэн халж байгаа. Зохистой таналт бол биш. Ямар нэгэн байдлаар ажлын байрны тодорхойлолт дээр зураглал дээр суурилж давхардлыг арилгасан асуудал ердөөсөө байхгүй. Яг хөрсөн дээр бол ер нь хамгаалах хүнгүй хүмүүс л хамгийн түрүүнд халагдаж байгаа ийм нөхцөл байдал бол байгаа.

Ирэх ондоо тэгсэн мөртөөсөө дахиад л 1200 орон тоо шинээр оруулж ирж байгаа нь бол л яг дахиад л яг үүнийг бататгаж байгаа. Тэгэхээр Засгийн газрыг төсвөө эргүүлэн татаж шинээр оруулж ирэхийг хүсэж байна аа.

Х.Булгантуяа: Ариунзаяа гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал.

О.Батнайрамдал: 2026 оны энэ төсвийн төсөлдөө Монгол Улсад гадаад болон дотоод хөрөнгө оруулалт 4.5 их наяд байна гэж төсөөлж байгаа юм байна. 14 төслөөс 4.5 их наяд төгрөг гадаад, дотоод хөрөнгө оруулалт болно оо. Яг энэ хэмжээний мөнгө Оюу толгой төслөөс Рио Тинто компанид нэг жилийн зээлийн хүүд гадагшаагаа урсана. Доллароор тооцох юм бол 1.3 тэрбум долларыг бид нар 2026 онд Оюу толгой компаниас Рио Тинто компанид зөвхөн зээлийн хүүд нь төлнө шүү зээлийн хүүд.

Уул нь бид нар 6.1 тэрбум долларын зээл анх авсан. Энэний хүүгийн хүү гэж явсаар байгаад өнөөдөр 2 дахин буюу 12 тэрбум долларын зээл болчихсон байгаа юм. Тэгээд энэ дээрээ 12 тэрбумаас л бид нар цаашаагаа 11 хувийн хүүтэй зээл төлөөд байгаа юм л даа. 11 хувь гэдэг бол яг зах зээлийн зарчим мөн үү үгүй юу гэж. Оюу толгой төсөл дээр бол нэг талаасаа Монгол Улсын Засгийн газар зээлдэгч, нөгөө өөрийнхөө мөнгө гаргаж чадахгүй эсвэл хувь нийлүүлэгчдийн зээл гээд 11 хувийн хүүтэй зээлж байгаа. Нөгөө талаасаа Онтрэ компани Канадын бодлогын хүүн дээр нэмэх нь 2 хувь буюу 6.7 хувийн хүүтэй зээлээд байгаа байхгүй юу. 6.7 хувь гээд.

Тэгэхээр 1 төсөл дээр яагаад Монгол Улс 11 хувь хүү төлөөд, Онтрэ 6.7 хувь -ийн хүү төлөөд байгаа юм. Магадгүй 2011 онд 2009 онд энэхүү тухайн үедээ зах зээлийн тэр эрсдэлийг нь илэрхийлж байсан байх. Гэхдээ өнөөдөр Оюу толгой төсөл гүйцэтгэл маань 99 хувьтай бараг 100 хувь болж байгаа. Төслийн эрсдэл нэг ёсондоо алга болж байгаа энэ үед бид нар анх төсөл 2009 онд эхэлж байсан. Тэр тэр хүүг өнөөдөр бид нар төлөөд байх нь зах зээлийн зарчмаас гажуудчихсан байна аа. Энэ дээр зах зээлийн зарчим руу буулгаж нийлүүлэх зайлшгүй шаардлага байна л гэж үзэж байгаа.

Бидний 2009 онд байгуулаад 11 онд тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээ гэж маш том гэрээ байгаа. Энэ гэрээний 11.3-ын ё-д нь бол энэ хувь нийлүүлэгчдийн зээлийг бид нар 7 жил тутам нэг удаа авч хэлэлцээд 2 талд хүлээн зөвшөөрснөөр бууруулах боломжтой гэж заасан байгаа. Тэгэхээр Монгол Улсад энэ ашигтай байж болох энэ эрхээ гэрээнийхээ өөрт олгосон эрхээ хэрэгжүүлэх хугацаа нь 2025 онд тохиож байгаа юм. 2025 оны 12 сарын 31 гээд энэ гэрээгээр олгосон 7 жил тутам ганцхан олдох хугацаа нь дуусах юм.

Тэгэхээр бид нар Монгол Улсын эрх ашгийн төлөө Монгол Улсын хувьцаа эзэмшигчийг төлөөлж энэ гэрээнийхээ эрхийг хэрэгжүүлж хүүг өнөөдрийн зах зээлийн зарчим руу л аваачих нь зайлшгүй шаардлагатай юм аа. Тэгээд энэ хүүгийн хэлэлцээрийг Ерөнхий сайдын захирамж гараад Жавхлан сайд ажлын хэсгийг ахалж байгаа. Тэгээд Жавхлан сайдад амжилт хүсье. Бид нар Улсын Их Хурал дээр Хянан шалгах түр хороо ажиллаж байгаа. Засгийн газар Улсын Их Хурал бүгдээрээ Монгол Улсыг төлөөлж байгаа. Монгол Улсын эрх ашгийн төлөө л бид нар хамтдаа энэ хэлцэлд орж хамтдаа бид нар хамтдаа зогсох болно оо. Энийг л Монголын ард түмэн харж байгаа.

Өнөөдөр бид нар төсвөө ингээд ямар ч байсан 11 сардаа батална хугацаандаа батална. Гэхдээ Улсын Их Хурал ч ялгаагүй Засгийн газар ч ялгаагүй олон нийт бид нарт ямар дүн юун дээр үндэслэж тавих вэ гэвэл энэ Оюу толгой дээр бид нар энэ Монгол Улсын эрх ашгийн төлөө гэрээгээ хэрэгжүүлж, гэрээгээр олгосон эрхийг хэрэгжүүлж шийдэл гаргаж ирж чадсан уу гэдгийг л ард түмэн чих тавин 3.5 сая иргэн харж байгаа учраас бид нар энэ дээр цаг хугацаандаа хөдөлж энэ үлдсэн 100 гаруй хоногтоо бол бид нар заавал шийдэл гаргах ёстой. Тэгээд амжилт хүсье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар.

С.Эрдэнэбат: Миний нэр хааччихав?

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн. Сүхбаатарын Эрдэнэбат.

С.Эрдэнэбат: Өчигдөр саналуудаа хэлсэн. Ямар ч байсан энэ төсвөөс жирийн ард иргэд, ажилчид, ААН байгууллагууд миний орлого хэрхэн нэмэгдэх вэ л гэдгийг их асууж байна. Өөр олон тоо баримт юуг бол хараад ойлгож мэдэхгүй олон хүн байгаа.

Дээрээс нь суурь салбарууд маань бас цалин хөлс орлогыг одоо нэмэх шаардлагыг бол нэлээн хүчтэй тавиад эхэлсэн. Тийм учраас энэ тал дээр бол Засгийн газар хэлэлцээр хийж тодорхой бодит үр дүнд хүрэх энэ боломжийг нь тавьж өгөх үүднээс ялангуяа энэ боловсролын салбар, эрүүл мэндийн салбар гэх мэтчилэн энэ суурь салбарын төрийн албан хаагчдынхаа цалин хөлсийг нэмэх

хэрэгтэй. Ирэх жил боловсролын жил юм бол бодитоор дорвитойхон нэмчихгүй бол магадгүй маш олон байшин барилга бариад ирэх 10 жил багшийн дутагдал, хүний нөөцийн дутагдал чинь улам нэмэгдэх нь ээ.

Тийм учраас энэ тал дээр энэ 2 салбар дээр төсвийг нэмж өгөөч гэж хүсмээр байна. Дараагийнх нь эрүүл мэндийн салбар бол яг байгаа байдлаар төсвөөрөө үндсэндээ төлбөртэй юу руу шилжих ийм юм руу ороод эхэлчхэж бараг бүрэн санхүүжүүлж чадахгүй болчихож. Тийм учраас энэ тал дээр эс үгүй бол тодорхой хамтын төлбөрийн асуудлыг ярих цаг болсон. Эс үгүй бол зарим төрлийн үйлчилгээг үзүүлж чадахгүй гэдэг ийм юм руу л орох ёстой болсон. Тийм учраас төсвөөс яг ийм бодитой төсвийн үр дүнгүүдийг л бид нар ярьж бодитоор нь энэ асуудлууд дээр ярих хэрэгтэй байна гэдгийг хэлмээр байна.

Нөгөө талаар тэр ЭМД-ын санг алагчлаад зарим хувийн эмнэлгүүд ашиг сонирхлын зөрчлөөр гулгуулаад байгаа, хулгай залгиа хийгээд байгаа асуудлуудыг нь боохгүй бол бас дээрээс нь нэмж өгсөн юмнуудыг нь буруу тийш нь цутгуулаад байвал харамсалтай. Энийг засаж янзлах хэрэгтэй биз.

Тэтгэврийн асуудал дээр өчигдөр нэлээн маргаан гарсан манай 2, 2-ын харьцаатай өчигдөр чуулган дээр мэтгэлцээн өндөрлөсөн. Ерөнхий сайд Ариунзаяа сайд 2 бол нэг тал байх шиг байсан. Нөгөө тал нь бол Жавхлан сайд нэг нь хэн билээ арай өөр өнцгөөр авч үзсэн. Булгаа дарга байсан байх. Тэгэхээр яах аргагүй аль аль нь харах өнцөг мөн. Яг бүх тэтгэврээ өнөөдөр байж байгаа өндөр авч байгаа 3, 4 сая төгрөгийн тэтгэврээ авч байгаа хүмүүс бүгдээрээ шударгаар тогтоолгоод насан туршдаа яг өндрөөр төлөөд байсан гэвэл үгүй.

Сүүлийнхээ 5 жилийг маш өндрөөр огцом төлдөг жилд 3 мянган хүн байгаа юм байна лээ тоо нь. Би энийг мэднэ. Зарим нь бол нэлээн эрт гаргачихсан хүмүүсийг хөөгөөд шахуу гаргачихсан. Тэгээд нэмэгдээд нэмэгдээд 1 сая ч хүрэхгүй тэтгэвэртэй маш олон шударгаар төлсөн хүмүүс байгаа. Тэр суурь доод тэтгэвэртэй нийцүүлдэггүй юм гэхэд дундын хувилбараар тавихгүй бол тэтгэврийн зөрөө улам холдох нэг асуудал байгаа. Нөгөө талаас нь өндөр байгаа тэтгэвэртэй хүмүүсийг одоо тусад нь ялгаварлаад байгаа асуудал биш. Суурь тэтгэврээ нь өөрөө амьдралд хүрч байна уу гэдгийг нь харж үзээд дундын хувилбараар шийдэх ёстой. Энийг нийгмийн даатгалын үндэсний зөвлөл хэлэлцээд сайд тодорхой аргачлалыг гаргаж ингэж батлах ийм нэмэх ёстой байдаг.

Тэгэхээр энэ тал дээр нэг их айхтар талцуулалгүй дундын хувилбараа шийдэх ийм санал байна гэж. Хөдөө орон нутгаар ингээд явсан. Би сая энэ зун Хөвсгөл аймгаар тойрсон. Тэгээд Хатгал, Ханх гээд намайг хүүхэд байхад бараг 30 жилийн өмнө яригдаж байсан юм. Зам тавигдах нь яах юм гээд. 180 км-ийг бол үндсэндээ 12 цаг туулж очиж байна лээ.

Тийм учраас энэ тал дээр ингээд харахад 40 тэрбум төгрөг тавьсан байна. 10 тэрбумыг нь 2026 онд тавина гэсэн байна. Нөгөө амсуулаад л хаях гэдэг юм руу л орчих гээд. Дахиад жоохон энэ тал дээр нэмэх боломж байна. Энэ өөрөө эдийн засаг нийгмийн бас нэлээн ач холбогдолтой юу байгаа юм гэдгийг нь би хэлмээр байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүдийнхээ өдрийн мэндийг дэвшүүлье. 2026 оны улсын төсөвтэй бид нарийвчлан танилцаж байна. Төсөв боловсруулахтай холбоотой мэргэшсэн бүтцээс санал, дүгнэлт зөвлөмж нь гарсан. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн санал зөвлөмжийг дүгнэлтийг уншихад бол өнгөрсөн жилийн төсөвтэй харьцуулбал энэ жилийнх бол 60-аас 70 хувиар харьцангуй жишээ нь сайжруулаад оруулаад ирсэн байна гэсэн ийм дүгнэлт хийж болохоор байгаа юм. Өөрөөр хэлбэл өмнө нь өгсөн санал зөвлөмжүүдийг тухайлан авч чаддаггүй байсан бол энэ удаа аль болох авах гэж хичээсэн нь сайшаалтай. Үүнийг зориуд тэмдэглэх ёстой. Ер нь бид бол төсөв боловсруулах тооцоолол хийхдээ мэргэжлийн бүтцийн саналыг авч байгаа нь өөрөө бас ямар нэгэн байдлаар дэвшил болж байгаа шүү гэдгийг тэмдэглэх нь зүйтэй байх аа.

Боловсролын салбарын тухайд онцгойлон ярих зүйл бий. Боловсролын салбарт 198 тухайлсан бүтээн байгуулалт хийгдэхээр болж байгаа нь сайшаалтай л даа. Ирэх жил угаасаа боловсролыг дэмжих жил болж байгаа юм. Манай Улсын Их Хурлын гишүүд манай хөгжлийн тэргүүлэх чиглэл юу юм бэ гээд асуугаад байна лээ. Хөгжлийн тэргүүлэх чиглэл чинь угаасаа боловсрол мөн. Энийг бол Засгийн газар өөрөө зарлачихсан. Манай үндэсний хөгжлийн томоохон бодлогын мэргэжилтэй ч гэсэн энэ тодорхой байж байгаа. Энэ үүднээс нь харах ёстой хөрөнгө оруулалт хэр орсон бэ гэж. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 18 хувь нь боловсролын салбарт байгаа нь сайшаалтай. Үүнээс гадна гаднын зээл тусламжийн 17 хувь нь боловсрол руугаа чиглүүлсэн байна. Үүнийг зориуд тэмдэглэх ёстой. Гэхдээ энэ бидний хувьд хангалттай биш байна гэдгийг хэлэлцүүлгээс харж байна. Царсан барилгууд байна. Би Наранбаяр сайдад зориуд хэлж байгаа юм. Зарим царцсан барилгуудаа нэлээд хөдөлгөж байгаа юм. Царцааж ерөөсөө болохгүй. Царцаах тусмаа энэ бол өртөг нь нэмэгдээд цаана боловсролын хүртээмж хангагдахгүй байгаа асуудал үүсэж байгаа учраас энэ чиглэлээр үлдсэн 16 жишээ нь объект байгаа энэ дээр анхаараач гэж байгаа юм.

Зарим нь аудитын дүгнэлт урьдчилаад гардаг бол ахиад байгаа жишээ нь төсвийнхөө хүрээнд шийдвэрлүүлэх саналаа оруулах ёстой. Үүнийг бид дэд хороо болон Байнгын байнгын хороод дээр санал болгож дэмжихийг хичээнэ гэж байгаа юм.

Цалин хөлстэй холбоотой асуудал нар Наранбаяр сайдаа мэдээжийн хэрэг бол тооцооллууд хийгдсэн. Гэхдээ нэг зүйлийг нарийн тайлбарламаар байна. Ерөөсөө бүгдийг нь үндсэн цалин руу оруулна гэдэг ийм зүйл ярьж байна. Бид буцаж социализм руу ухарч ерөөсөө болохгүй. Бид тодорхой гүйцэтгэлээр тэр хүн ямаршуу жишээ нь ажил гүйцэтгэж ямар чанар гаргасан юм бэ гэдэг дээр үнэлдэг энэ цаашид багшийн хөгжлийн үндэс болж байгаа гүйцэтгэлийн үнэлгээгээ огт хаяж болохгүй. Гэхдээ энийг бол эргээд жишээ нь балансалъя гэж байна шүү дээ. Балансалж байгаа нь үнэн. Гэхдээ багш нарын үнэлгээ дотор арга зүйг нь ингэж харах ёстой юм байна. Нарийн мэдээллүүд авч байна. Нийт багш нарын 3-ны 1 нь л үнэлэгдээд эндээс бол гүйцэтгэлийн үнэлгээгээр урамшуулал авч байна шүү дээ.

Эсвэл үлдсэн багш нар дээр тодорхой тэр аргачлалаар 1-ээс 5 хүртэл үнэлж байгаа бол 1-ээс 4 хүртэлхээр нь бид энэ урамшууллыг олгох механизмаа боловсронгуй болгох ёстой. Гэхдээ авах ёсгүй хүнд бол өгөхгүй гэдгээ тодорхой хэлэх ёстой. Тэгж байж боловсролын чанар яригдана. Мэргэжлийн боловсрол дээр та хэлсэн 20 сая долларын бид хөрөнгө оруулалт хийнэ гэсэн энийг сайшааж байна.

Гэхдээ нэг зүйлийг онцгойлон анхаараач ээ. Мэргэжлийн боловсрол хариуцсан бүтцээ яам маань аваад хаячихсан. Энэ цаанаас өгсөн аргачлалын дагуу аваад хаячихсан юм шиг байгаа юм. Энэ бүтэц заавал байх ёстой шүү яаман дотор. Яаман дотор зорилгоо жишээ нь тодорхойлоод зорилгоо хэрэгжүүлэх хуулийн хэрэгжилтийг хангуулахад чиглэсэн бүтэц байхгүй бол бид эндээс үр дүн харахад хэцүү. Энийг та анхаарах ёстой шүү гэж байгаа юм ингээд миний хувьд энэ бүтэцтэй холбоотой асуудлуудыг илүү дэлгэрэнгүй бид бас Байнгын хороон дээр ярих байх гэж бодож байна аа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан.

Ц.Туваан: Асуултуудаа асуугаад заримд нь хариулт аваад заримд нь хариулт авч чадаагүй. Энэ дээр бас нэг тодорхой хэдэн зүйлийг хэлэхгүй бол болохгүй нь ээ. Бид нар 2024 оны сонгуулийг Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулж байгаа 126 гишүүнтэй болгож хийсэн. Бүсчилсэн хөгжлийн бодлого гэдгийн цаад талд бол аймаг, сум, жалга довын үзлийг байхгүй болгож хөгжлийг Их Хурлын гарч байгаа шийдвэрүүдийг бүсчилсэн байдлаар гаргах гэдэг ийм зорилтоор хийсэн. Мэдээж энэнийхээ үр дүнг бид нар харах ёстой байх. Цаг хугацаа бага өнгөрсөн учраас дүгнэж хэлэхэд эрт байна. Тэгэхдээ энд нэг зүйл байгаа. Улсын Их Хурлын гишүүдийн хувьд тойрог дээр жишээлбэл миний хувьд Төв аймаг гээд өмнө нь Төв аймгаас сонгогдож байсан бол одоо Дархан-Уул, Сэлэнгэ аймаг орж ирсэн. Мэдээж Улсын Их Хурлын гишүүддээ тэнд сонгосон ард иргэд маань маш их зүйлийг ярьж байгаа. Өмнө нь авч байсан ачаалал хүсэлтүүдээс 3 дахин их асуудал бол нэг Их Хурлын гишүүн дээр ирж байна аа. Сургуулийн барилга, зам, цэцэрлэг, эмнэлэг гээд бүх асуудлуудыг ярьж байна.

Тэгэхээр бид нар энэ асуудлуудаа яаж, хаана, тавих юм бэ. Чаддагаар нь хэдэн яамдынхаа сайд нар дээр Сангийн сайд дээр энэ асуудлаа ярьдаг шийдэгддэггүй ингээд явчихдаг. Магадгүй эрх барьж байгаа хүмүүст намаараа ч юм уу бүлгээрээ ч юм уу дамжуулаад асуудлаа тавьж болох байх. Цөөнхийн бүлэг эрх бариагүй хүмүүст бол энэ асуудал нэлээн том хана болчихоод байна шүү гэдгийг хэлье.

Зүгээр зарим нэгэн жишээг хэлье л дээ. Энэ зам дээр гэхэд л Төв аймгийн Мөнгөн морьтын зам, Угтаал, Цээл, Заамарын зам, Цээл, Сэлэнгийн Орхонтуулын зам гээд л ингээд энэ олон замуудыг Батсүмбэрийн замууд гээд эд нарыг ингээд бол ингээд хурдан хугацаанд тавиад дуусгачихмаар байна аа. Жил жилд нэг жоохон жоохон дусаагаад өгөх юм. Энэ нь эргээд дараа жил гээд хийх гээд тэр хэмжээндээ хийгээд явж байтал бараа материалын үнэ өсөөд төсөв нь хүрэхгүй болчих юм ингээд удах юм гээд ингээд маш олон асуудал ярьж байна.

Сургууль цэцэрлэг эмнэлэг дээр гэхэд л Төв аймгийн Мөнгөнморьт сумын сургуулийн засвар, Баянчандмань сумын дотуур байр, Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн сургууль. Энэ сургуулийг би анх төсвийг нь тавьж байсан юм. 5 жил боллоо. Ямар учиртай юм мэдэхгүй улс төрждөг юм уу. Ингээд жоохон жоохон тавиад төсөв нь гүйцдэггүй. Мөн энэ сумын төвүүдийн асуудал дээр гэхэд энэ Сэлэнгэ аймгийн Мандал сумын сумын төвийн авто замын асуудал.

Дээрээс нь иргэд сонгуулийн үеэр маш их хэлсэн. Сэлэнгэ аймгийн Мандал гээд 30 орчим мянган хүнтэй том тосгоны хэмжээнд очиж байгаа энэ сумын хувьд бол төмөр замаар ингээд 2 зааглачихдаг. Тэгээд энэ заагласан 2-ыг хооронд төмөр

зам дээгүүр нь бид нарт нэг гүүр тавиад гүүрэн гарцаар ингээд холбоод өгөөч. Маш их тойрч цаг зав, бензин тос илүү зарж байна гэдэг энэ асуудлыг тавьсан. Тэгэхээр иймэрхүү зүйлүүд байдаг юм байна аа.

Тэгэхээр энийг бас манай энэ төсөв дээр хэдүүлээ ярилцаад Бүсчилсэн хөгжлийн бодлогынхоо хүрээнд Улсын Их Хурлын энэ гишүүддээ энэ боломжуудыг нь гаргаж өгмөөр байна аа. Тэгэхгүй бол бид нар нөгөө ажил хийгээгүй эргээд тойрогтоо санал санаачилга гаргаж явдаггүй гээд нэг ийм нэртэй ийм байгааг манай энэ Сангийн яамныхан, Засгийн газрынхан анхаарч өгөөч ээ.

Дээр нь эрүүл мэндийн салбар дээр бол гүйцэтгэлийн санхүүжилтийн бодлогоо хэдүүлээ бас нэг зөв тийш нь болгох юмаа харахгүй бол худлаа онош бичдэг, худлаа шинжилгээ тавьдаг, шинжилгээ авдаг юм бол зөндөө.

Х.Булгантуяа: Туваан гишүүний хэлж байгаагаар намын зарчмаар ч шийдсэн юм байхгүй л дээ. Яах вэ бид нарыг нэг 15 тэрбумын санал өг гэснийг нь хүмүүс буруу ойлгоод 15 тэрбумыг кармандаа ав гэж ойлгосон юм шиг байгаа юм. Тэгээд тэрүүндээ бантсан нүүрэндээ тэрэнд 2026 онд санхүүжих дүн нь 5 тэрбум төгрөг. Энэ 5 тэрбум төгрөгийг жишээлбэл доор тойргийн 78 гишүүнээр үржүүлэхэд энэ жилийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын 7.8 хувь, дээрээс нь нэмээд энэ нийт Монгол Улсын төсвийн 1.2 хувь болж байгаа юм. Тэгээд 1.2 хувь дээр энэ дандаа л гишүүд, сургууль цэцэрлэгийн санал өгдөг. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг 3 л голцуу байдаг. Энэ уг нь бол боловсролыг дэмжих жилд гишүүд өөрснөө саналаа л өгөх үүрэгтэй нэг бодлын нөгөө талдаа энд хамгийн ойрхон очиж ажилладаг тойрогтоо очиж ажиллахад иргэдээс ирсэн энэ саналыг уламжлах угаасаа нөгөө талдаа бид үүрэгтэй. Татвар төлөгчид өөрөөр хэлбэл манай аймаг орон нутагт юу хэрэгтэй байна гэдэг саналаа л хүргүүлж байна гэсэн үг.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү.

Ц.Баатархүү: Төсвийг олон талаас нь Улсын Их Хурлын гишүүд сайтар хэлэлцэж байна аа. Гишүүдийн хэлж байгаа зүйлүүдтэй санал нэг байна аа. Сангийн яам, Эдийн засаг хөгжлийн яамныхан энэ гишүүдийн хэлж байгаа зүйлд анхаарал хандуулж энэ хүмүүс нэг ийм зүйлийг жил болгон ярьж байдаг юм байна гэсэн хандлагаар биш илүү бүтээлчээр хандаж байгаа гэж найдаж байна. Энэ жилийн төсөвт 2 сайн зүйл орж ирсэн байна Бямбацогт сайдаа.

Нэгдүгээрт нь бол иргэд олон нийтээс асуусан байна. Энэ бол дэвшил.

Хоёрдугаарт эрүүл мэндийн салбар тэр дундаа зүрх судлал, хавдар судлалын чиглэлээр томоохон хөрөнгө оруулалтын ажлыг шийдвэрлэе гэдэг зориг гаргасан байна аа. Энэ бол бас дэвшил. Бүх зүйлийг шүүмжлээд байж болохгүй. Гэхдээ одоо Засгийн газар Бямбацогт сайдаа боловсролын жил болгож зарлаж байгаа бол боловсролын жил л болгож зарлая. Ирэх жил юуны жил болгох юм? Өнгөрсөн жил бордюрын жил, энэ жил бол явган хүний бетонон хавтангийн жил байсан. Тэгээд ажлын уялдааг ЗГХЭГ-ынхан нэг сайжруулж өгөөч гэж би хүсэж байгаа юм.

Нэгдүгээрт нь энэ Улаанбаатар хотын орлогч дарга нь хотод шинээр баригдсан сургууль, цэцэрлэг чинь тавилгагүй байна. Эрхлэгчийг нь томилж болохгүй байна гээд ингээд сошиалаар мэдэгдээд байдаг. Боловсролын яам

болохоор өөр зүйл ярьж байна л даа. 2012-оос 2016 онд нийслэл Улаанбаатар хот 800 тэрбум төгрөгийн төсөвтэй байсан. 16 бага сургууль, цэцэрлэгийг өөрсдийнхөө төсвөөр шийдчихсэн. Бид нар энэ бордюр сольж байхаар энэ 10 их наядын төсөвтэй боллоо. Явган хүний замыг зүгээр байхад нь хуулаад шинээр тавихынхаа оронд нэг мөсөн ингээд боловсролынхоо асуудлыг шийдчихвэл яасан юм бэ. Ер нь Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ тухайн жил болгож зарлаж байгаа бол боловсролын асуудлыг сууриар нь, үндсээр нь шийддэг болбол яасан юм бэ? Багш нарынхаа цалинг нь нэмдэг. Нийгмийн асуудлыг нь шийддэг. Тогтолцооны зөв өөрчлөлт хийдэг, сургууль цэцэрлэгийн хүртээмжээ сайжруулдаг ийм ажил хийхгүй бол жил болгоны төсөв чинь бүх зүйл дээр жоохон жоохон дусаагаад ямар ч реформ болдоггүй. Хүрэлцдэггүй. Ийм байдлаар 30 жил явлаа. Учрал сайдад нэг зүйлийг хандаж хэлье ээ. Бид нарын алдаа юу юм бэ гэдэг оношоо нэг тодорхойлъя оо, оношоо тодорхойлъя. Бид зөв яваагүй юм байна. 30 жил болоход нэг хүнд оногдох ДНБ 10 мянган доллар хүрсэнгүй. 1960 онд эдийн засгийн хөгжил сул байсан улс орнууд жишээлэх юм бол Солонгос 1990 он гэхэд нэг хүнд оногдох ДНБ 12 мянган доллар давж байсан.

Тэгэхээр бид нэг ийм байдлаар бие биеэ аргалаад төсөв тавиад асуудлыг шийдэхгүй нь ээ. Энэ жил багш нарынхаа асуудлыг боловсролын асуудлыг нэгмөсөн шийдье. Өрхийн эмнэлгүүдийн асуудлыг нэг мөсөн шийдмээр байна.

Гурав дахь шатлалын эмнэлэг бол чухал. Тэр эмнэлэгт очих хүртэл эрт илрүүлэг анхан шатны тусламж үйлчилгээ гэдгийг энэ мэргэжлийн хүмүүс энэ Улсын Их Хурал дотор байна. Сайжруулж байж эрүүл Монгол хүн болно оо. Яаралтай түргэн тусламж зөвхөн хотын төвд биш хүн амьдардаг газруудад байх хэрэгтэй. Хүмүүсийн хамгийн ойрхон байдаг өрхийн эмнэлгүүд илүү олон шинжилгээ авдаг зөвлөх үйлчилгээ үзүүлдэг болох хэрэгтэй байна аа.

Тэгэхээр хөрөнгө оруулалтын эрэмбийг хамгийн зөв тавимаар байна гэдгийг дахин хэлье.

Гуравдугаарт нь Монгол Улс, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин.

Д.Энхтүвшин: Энэ удаагийн төсөв дээр татвартай холбоотой НӨАТ-тай холбоотой санал орж ирсэн. Буцаан олголтыг нэмэгдүүлэхээр. Тэгээд иргэд ААН-үүдийн саналыг авсан гэж байгаа юм. Хэрвээ ААН-үүдийн санал энэ нь орж ирсэн төслөөс эсрэг байгаа. Бүгдээрээ нийтээрээ татвараа төлдөг болъё. Буцаан олголт биш энэ татварынхаа хувийг багасгая гэсэн ийм санал байгаа. Тэгэхээр ийм байдлаар шийдээсэй гэсэн. Одоо энэ буцаан олголтыг нэмж байгаа нь бол хэрэглэгчдэд тодорхой хэмжээний 4 зуугаад тэрбум төгрөгийн буцаан олголт нэмэгдэж байгаа ч гэсэн ААН-үүд дээр энэ нь буцаад эргээд дарамт болж байгаа.

Тэгэхээр энэ яриад байгаа иргэд ААН-үүдийн саналыг сонсож татварын өөрчлөлтийг хийж байгаа гэдэгтэй бол нийцэхгүй бодит байдал дээр нийцэхгүй байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

Хоёрдугаарт түрүүн асуусан Тавантолгойн дахиад нэг ам нээж нүүрс экспортлох гэж байгаа юм байна. Тэгээд яахаараа дандаа ингээд энэ Хятадтай ч юм уу эсвэл өөр улстай ингээд юм ярихаараа Монголын эрх ашгийн төлөө биш өөр

улсын эрх ашгийн төлөө саналууд ороод ирдэг юм. Эсвэл тохирчхоод асуудлуудаа нэг компанитай ч юм уу ярьчихаад тэрийгээ ингэж хүчээр оруулж ирдэг юм уу? Тэгээд энэ гэрээн дээр бас тогтоолын төсөл дээр уурхайн олборлолтыг, тээвэрлэлтийг нь тэгээд борлуулалтыг нь нэг компанитай дахиад гэрээ хийх юм байна л даа. Тэгэхээр энэ нүүрсний зах зээлээ хэдүүлээ бүүр ингээд тараагаад байхгүй болголоо мөнгө хэрэгтэй болж байна гээд нийтээрээ экспортолж байгаа бүх нүүрснийхээ үнэ цэнийг унагаж байна.

Тэгэхээр энэн дээр ийм нэгдсэн зах зээлийн хувьд борлуулалтын хувьд тээвэр ложистик энэ нэгдсэн бодлоготой баймаар байна. Хятадын компаниудын төлөө энэ Тавантолгойн ордоо ингэж ашигладгаа болимоор байна аа. Монгол компаниудыгаа аж ахуйн нэгжүүдээ дэмждэг иймэрхүү чиглэлд яваасай гэж хүсэж байна.

Гуравдугаарт нь болохоор түрүү жил болохоор бид хэд гишүүд ярьж л байдаг сайд нар тэгээд хариулсан болоод л өнгөрдөг байсан. Тэгээд Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт орсон байгаа тэрийг сануулъя. Тэгээд 21.30 дээр болохоор төсөв хэлэлцэх үед худал мэдээлэл ирүүлсэн, танилцуулсан, мэдээллийг санаатайгаар дарагдуулсан нийтийн албан тушаалтанд энэ нь нотлогдвол үүрэгт ажлаас нь чөлөөлөх ийм заалт байгаа. Мөн Төсвийн тухай хуулийн 70.5 дээр тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага өр төлбөр үүсгэсэн албан тушаалыг чөлөөлөх үндэслэл болно оо гээд. Тэгэхээр сая 1 дүгээр эхний энэ өнөөдрийн өчигдрийн хэлэлцүүлгүүдээс асар олон сайд нар их олон удаа худлаа ярилаа. Тэрийг баримтжуулж сайд нарыг энэ хууль тогтоох байгууллага маань өөрсдөө бид нар хуулиа хэрэгжүүлдэг юм уу гэдгийг үзье гэж бодож байна. Тэгээд энэ худлаа хэлсэн сайд болгоны үгийг нь нотлоод ч энэ асуудлыг оруулж ирнэ гэж бодож байгаа.

Тэгэхээр сайд нар та нар нэг худлаа ярихгүй бид нарыг аргалдаг цаг чинь өнгөрсөн шүү гэж хэлмээр байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Даваасамбуугийн Ганмаа.

Д.Ганмаа: Оройн мэнд ээ. Засгийн газар хүний хөгжлөө бодсон гол бодлогоо ярьж орж ирсэн. Өнгөрсөн жилийн Засгийн газар юу ч гэсэн хүний хөгжил ярихаар зэрэг эдийн засгаа тэлээд, мега прожекттой, хөдөлгөөнтэй, мөнгө, эдийн засаг хэрэгтэй учраас тэгж байж хүний хөгжил ярина гэдэг байсан. Засаг солигдоход санаа зовж байсан боловч яах аргагүй залгамж халаа байдлаар хүний хөгжлөө ярина гээд орж ирэхэд маш баяртай хүлээж авсан. Тухайн үед тэр үгээ ч илэрхийлж байсан. Тэгээд хүний хөгжил гэхээр эрүүл мэнд, боловсрол орлогын асуудал бид нар яригдана. Эрүүл мэнд дээр авууштай юм байна уу? Байна. Эрүүл мэндийн хөрөнгө оруулалт 5.5 дахин ихэссэн. Баярлалаа.

Доторхыг нь ингээд харахаар зэрэг яах вэ авууштай юм байна. Жишээлбэл яаралтай түргэн тусламж, эмнэлгийн гадуурх нас баралтыг бууруулна. Тэдний тоног төхөөрөмж чадавхыг сайжруулна хүртээмжийг сайжруулна гэсэн үг гэсэн үг. Гэхдээ энэ маш бага хувь. Бусад нь тэгээд л нөгөө барилга байшин зарим хүмүүс хавтан гэж ярьж байна зарим нь шавар гэж ярьж байна. Энэ ер нь барилга байшин барихдаа дээрээс нь өөрөө ч биш Азийн хөгжлийн зээлээр өмнөх зээл нь улам хуримтлагдаад л байгаа хийж байгаа зээл дээрээ үйл ажиллагаа явж байгаа юм нь зогсчихсон юмнууд зөндөө байгаа гэдгийг бид нар өнгөрсөн жил их ярьсан шүү дээ.

Ер нь Монгол Улсаас өөр Азийн хөгжлийн банкаас зээл аваад тэрүүгээрээ барилга байшин бариад байгаа улс орон үлдсэн үү үлдээгүй гэж би бодож байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ барилга байшин барихад чинь эмнэлгийн хувьд бол зүгээр нэг барилга байшин биш хийлт технологи ассессмент гэж буюу эрүүл мэндийн технологийн үнэлгээ гэж юм хийдэг. Хаана ямар барилга байшин барьж байж ямар өвчин буурч яаж хүртээмж нь сайжирч энэ нь үр ашигтай байх юм уу улсад хэрэгтэй юу үгүй юу гэж. Энийг хийхгүй яваад байх юм аа. Энэ зөвхөн барилга байшинд ч биш ерөөсөө амьдралын чанар, эрүүл мэнд, чанар хүртээмж, хариуцлагын тогтолцоо бүх юмтай уягддаг. Энэ барилга байшин баригдлаа. Хавдрыг хэдээр бууруулах юм, гадагшаа явж байгаа эмчилгээний зардлыг хэдэн төгрөгөөр багасгаж байгаа юм. Зүрх судасны өвчлөлийгөө хэдээр багасгах юм. Энийгээ уях шалгуур үзүүлэлт нь байна уу. Үнэхээр энэ барилга байшин баригдсанаараа энийг үр ашигтайгаар шийдсэн энэ арга нь байна уу байгаа бол энийг суурь үндэстэй нь, зорилго зорилттой нь, шалгагдах механизмтай нь хамт оруулж ирмээр байна.

Шалгуур үзүүлэлт гэснээс зарчмын зөрүүтэй санал гээд өнгөрсөн жил оруулж ирээд 2, 3 Байнгын хороогоор орсон. Чуулган дээр хэлэлцсэн. Тэгсэн мөртөө тэр шалгуур үзүүлэлтүүд нь дахиад л орж ирээгүй байх. Би анх мэдэхгүйдээ хийдэггүй юм болов уу гэж бодсон. Одоо ирээд энд жил болохдоо ер нь мэдээд хийдэггүй юм байна гэж боддог байгаа болоод байна. Албаар хариуцлагагүйжүүлэхийн тулд, зугтаахын тулд. Бодлогоор энийгээ тооцоолохгүйн тулд хийгээд байдаг юм уу ямар учиртай юм бэ гэдгийг асуумаар байх юм. Ер нь энэ шинжлэх ухаанч тооцоо судалгаа гэдгийг бид нар хэзээнээс хийж эхлэх юм бэ? Чинбүрэн сайд мэдэж байгаа нөгөө актуар тооцоог та өөрөө зөндөө ярьж байсан шүү дээ. Одоо бид нар энэ ЭМД-ын сан дээр актуар тооцоо хийгээд юу гэсэн үг вэ гэхээр зэрэг энэ амархнаар тайлбарлавал ямар өвчлөл хэзээ яаж гарах гээд байгаа юм, яаж урьдчилан сэргийлэх вэ, тэрэндээ ямар тоног төхөөрөмж, эм эмнэлэг, тэр байтугай барилга байшингаа зарцуулах юм бэ гэдэг урьдчилсан тооцоо байхгүй юу.

Тэгж байж энэ ЭМД-ын сангаа зөв авч явах юм. Яг жинхэнээсээ мөнгө төгрөгт тооцогдох юм. Орлого зарлага нь ч гэсэн тэнцвэржиж эхлэх ёстой байхгүй юу. Түүнээс тэдэн хувийг тэгж хасъя гэдэг зүгээр нэг автомат байдлаар яриад явахгүй юм аа. Энэ Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2, 12.2.3, 12.2.6 дахь заалтуудыг хүчингүй болгох шаардлагатай гэж үзэж байна. Ингэснээрээ энэ төсвийг төсвийн хүрээний мэдэгдлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ хуулийн төслийн үр нөлөөг үнэлж тодорхой судалгаа хийдэг болно. Тэгэхгүй бол одоо зүгээр л тийм тайлбар танилцуулга дүн шинжилгээ хийхгүй яваад байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлан сайд үг хэлэх шаардлагагүй байх байх ч үгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Номин.

Ч.Номин: Та бүхэндээ энэ оройн мэндийг хүргэе ээ. Би өнөөдөр энэ удаадаа яг энэ аудитын дүгнэлт дээр гаргасан 2 ерөнхий дүгнэлтийг тодорхой хэлээд үг хэлье гэж бодлоо.

Нэгдүгээрт, Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн төсөл улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжихэд бүрэн чиглэгдээгүй байна гэж хэлж байна Учрал сайд аа. Та энийг бүрэн чиглэгдсэн гэж хэлсэн боловч аудитын дүгнэлт дээр энэ нь бүрэн чиглэгдээгүй байна гэж гарч ирж байна.

Хоёрдугаарт дахиад мөн ялгаагүй төсвийн орлого уул уурхайн салбараас хамаарч тасрах эрсдэлтэй байгаа тул цаашид санхүүгийн хуримтлалыг тогтвортойгоор үүсгэж үр дүнтэй удирдахыг шаардаж байна гэсэн ийм шаардлагатай аудитын дүгнэлт гарсан байгаа гэдгийг би Эдийн засгийн хөгжлийнхөө сайдад сануулъя.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай.

М.Мандхай: Би 3 асуудал хэлье. Ер нь төсвийн хүрээний мэдэгдлийг ярьж байх үед хэлж байсан. Төсвийн орлого олон улсын байгууллагуудын гаргасан дунджаас манай төсвийн орлого дээгүүр тавигдсан байгаа. Тэгэхээр үндсэндээ энэ бодит байдал дээр бол өөдрөг төсөөлөл оруулж ирсэн гэж харж байгаа. Тийм учраас үүнтэй холбоотойгоор зардлын хэрэгжилт бүрэн биелэхгүй байх, төсвийн орлого тасалдах, ингээд цаашлаад шинээр өр авах төсвийн тодотгол хийх ийм зайлшгүй шаардлага хэрэгцээ гарах эрсдэл харагдаж байгаа. Яагаад гэхээр уул уурхайн түүхий эдийн эрэлт буурах, уул уурхайгаас олж байгаа гол орлогын асуудал бол түүхий эдийн эрэлт буурахаас гадна ХАА-н салбар дээр онцолсон байгаад байгаа юм.

Гэтэл ХАА-н салбар дээр яг бодит байдал дээр одоогийн байдлаар 6, 7 аймаг, баруун 5 аймаг, төвийн бүс болон Сэлэнгийн зарим нутгуудаар гантай зун болсон. Энэнтэй холбоотойгоор ер нь нэлээн хүнд өвөл болох ийм шинжтэй байгаад байгаа. Үүнийг дагаад ХАА-аас хүлээгдэж байгаа орлого буурах ийм эрсдэл байгаа шүү гэдгийг би анхааруулж хэлмээр байгаа юм.

Хоёрдугаарт мал, мах, экспортоо хасаад ойролцоогоор 58 сая мал энэ жил өвөлжихөөр харагдаж байна. Өвс тэжээл 4 сая, тэгээд үр тариа нэг багсармал тэжээл гэхэд 1.6 сая тонн хэрэгцээ шаардлага үүсэхээр харагдаж байна. Хэрэв тэжээлийн нөөц дутагдаад импортлох эрэлт нэмэгдээд ирлээ гэж бодох юм бол одоогийн байдлаар Оросын зах зээл бол өвөл хүндрэх юм байна гэдэгтэй холбоотойгоор хивэг тэжээлийн үнийг нэмчихсэн байгаа. Тэгэхээр Монгол Улсад өндөр үнээр орж ирэх ийм малчдад эргээд дарамт үүсэх ийм эрсдэл үүснэ шүү гэдгийг анхааруулж хэлмээр байна. Мөн зудын нөлөөлөл их их байх уу, бага байх уу гэдгээс шалтгаалаад малын хорогдол урьдчилсан прогнозоор 730 мянгаас 5.9 сая толгой мал хорогдох эрсдэл байгаа. Зудын үргэлжлэх хугацаанаас хамаараад эдгээр эрсдэлд өөрчлөлт орохыг үгүйсгэхгүй. Хохирол гэхдээ нэмэгдэнэ үү гэхээс багасах төлөв харагдахгүй байна.

Тийм учраас малын хээл хаялт нэмэгдэх ийм шинжтэй байгааг судлаачид хэлж байгаа. Тэгэхээр МАА-н эрсдэл өөрөө хүн амын хүнсний хангамж тэгээд амьжиргаанд цаашид нөлөөлнө. Мөн цаашлаад хүнсний хангамж аюулгүй байдлын асуудалд бас хэрхэн нөлөөлөх энэ урьдчилан сэргийлэх асуудал үүсэхээр харагдаж байгаа юм. Иймд би Сангийн сайдад зориулаад хэлмээр байгаа юм. Одоогоос энэ гамшгийн нөөцийг 3-ны 2-ыг ХАА-н салбарын энэ хүндрэх нөхцөлд хуваарилах шаардлагатай шүү гэдгийг анхааруулж хэлмээр байна аа. Түрүүн бас нэлээн гишүүд ярьж байх шиг байна. Орон нутгийн тойргийг төлөөлж байгаа энэ гишүүдэд хандаад хэлэхэд цаг үеийгээ мэдрэх шаардлага хэрэгцээ байна аа. Энэ өвөл малчдын амьжиргаанд учирч болзошгүй энэ хүнд байдал инфляц ялангуяа энэ үр тариа тэжээлийн энэ үнийн нэмэгдэл, энэ асуудал хүндрэх, амьжиргаанд нь учирч болзошгүй эрсдэл үүсэж байгаа учраас энэ хүндрэлээс сэргийлэх ерөөсөө гол энэ

зээлийн асуудал бол шинэ хоршоо хөдөлгөөний зээл шүү гэдгийг би хэлмээр байгаа юм.

Шинэ хоршоо, хөдөлгөөний зээл, атрын 4 дүгээр аян, цагаан алт гэсэн эдгээр энэ гол хөтөлбөрийн зээлүүд маань яг энэ хүнд нөхцөл байдалд гол санхүүгийн эх үүсвэр болон хөшүүрэг болж өгөх боломжтой шүү. Энэ зээлийг ашиглаад малын хоригдлоос урьдчилан сэргийлэх, хашаа хороогоо сайжруулах, өвс тэжээл хэв худалдаж авах, өвөлжилтийн бэлтгэлийг хангахад энэхүү зээлүүд нь явна аа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Хэрлэн.

Б.Хэрлэн: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр хүний хөгжлийг бодлогынхоо цөмд тавина гэж энэ төсвийн баримт бичигт маш тодорхой бичиж орж ирж байгаа. Энэ зорилгоороо эрүүл мэндийн болоод боловсролын салбарт реформын шинжтэй өөрчлөлтүүдийг хийнэ гэсэн ийм том зорилтыг тавьсан. Энэ нь эргээд ард иргэдэд одоо л бид нарын амьдрал ахуйг өөд нь татах нь уу даа гэсэн ийм хүлээлтийг бий болгоод байгаа. Энэ дээр би эрүүл мэндийн салбартай холбоотой түүнчлэн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой нэг 2 санааг хэлье гэж бодож байна.

Тэгэхээр ЭМД-ын сангаас өнөөдөр даатгалын сангийн нөөцийг өвчлөл нас баралтаараа тэргүүлэх өвчин эмгэгүүдэд түлхүү зарцуулаад хүлээж болохуйц буюу архаг хууч өвчтэй ийм үед эмчилгээний үнэ, үйлчилгээний төлбөрийг иргэд хариуцах хамтын төлбөрийг нэмэгдүүлнэ гэж өнөөдөр ингэж том зорилт болгож орж ирсэн байгаа. Өөрөөр хэлбэл энэ бол өвчтөний карманаас гарах төлбөрийн хэмжээг нэмэгдүүлнэ гээд. Тэгэхээр энэ байдал нь болоод ирэхээр өнөөдөр ходоод жишээлэх юм бол дурандуулахад 170-аас 200 мянган төгрөгийн төлбөртэй байгаа. Энэнээс бол нэг 70 мянга нь ЭМД-ын сангаас гараад үлдсэн 100 гаруй мянга нь иргэний карманаас гарч байгаа. Тэгэхээр энэ мэтээр ингээд хүн өвдлөө гэхэд төлбөрөө өөрөө төлөөд яваад байх юм бол ахмад настны хувьд, олон хүнтэй, ам бүлтэй гэр бүлийн хувьд ажил орлогогүй хүмүүсийн хувьд бол энэ их хүнд тусгаар байгаад байгаа юм аа. Тэгээд нөгөө талдаа бас энэ бол эрүүл мэндийн байгууллагад нөгөө худлаа онош бичиж арга ядсан үед хүмүүст туслах ийм байдлыг үүсгэхэд хүргэж болзошгүй байгаа.

Тэгэхээр эмчилгээ үйлчилгээний төлбөрийг иргэд хариуцах хамтын төлбөрийг нэмэгдүүлэх гэсэн энэ өөрчлөлтөд өнөөдөр бид нар бэлэн үү? Энэ өөрчлөлтийн нийгмийн үр дагавар юу байж болох бол? Хувь хүн дээр гэр бүл дээр буух ачаалал ямар байх болов оо гэдгийг эргэж нэг харах хэрэгтэй байна гэж хэлмээр байна.

Хоёрдугаарт нь өнөөдөр төрийн албанаас 14 мянган төрийн албан хаагчийг чөлөөлөх ийм шийдвэр гараад өнөөдөр хэрэгжүүлээд явж байгаа. Өөрөөр хэлэх юм бол 14 мянган хүн цалин орлогогүй болно гэсэн үг. Магадгүй тэд нарын дийлэнх нь ипотекийн зээлтэй байгаа, цалингийн зээлтэй байгаа. Тэгэхээр төрийн албанаас ингээд цомхотголоор ингээд чөлөөлж байгаа байдал нь эргээд хөдөлмөрийн зах зээл дээр энэ мэдлэгтэй боловсролтой, ялангуяа дээд боловсролтой энэ хүмүүсийг хэрхэн яаж байршуулж байна вэ? Энэ хүмүүсийг цалин орлоготой болгох талаар хэрхэн шуурхай арга хэмжээ авч байна вэ гэдгийг бид нар эргэж хармаар байгаад байгаа юм. Энэнтэй холбогдуулаад надад 2 санаа төрөөд байгаа юм л даа.

Нэгдүгээрх нь ер нь төрийн албаны хувьд төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, ажлын байрны баталгааг хангах талаар хуулийн зохицуулалтууд өнөөдөр маш тодорхой байх хэрэгтэй байна.

Тэгэхээр төсвийн хэмнэлтийг хийх үүднээс гэнэтхэн ажлаас нь халдаг цалин орлогогүй болгож байдаг ийм шийдвэрүүдийг тодорхой хэмжээгээр хязгаарлах зохицуулалт байхгүй бол энэ мэтийн шийдвэрүүд цаашдаа төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллах хүн олдохгүй болоход хүргэж болзошгүй байгаад байгаа юм.

Хоёрдугаарт нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хувьд энэ дээр бас нэг анхаарах зүйл байгаа. Тэр нь юу вэ гэхээр одоо ингээд ажлаас гэнэт халагдсан хүмүүсийг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулаад хөдөлмөрийн зах зээл дээр аль болохоор түргэн шуурхай байршуулах аль болох хурдан цалин орлоготой нь залгуулах тухай энэ бодлого зохицуулалт өнөөдөр хэр тодорхой байгаа юм бэ? Энийг бид нар эргэж хармаар байгаа юм. Ер нь ажлаасаа гэнэт халагдаад албан хаагчид ер нь хохирч үлдэж болохгүй. Одоо энэ дээр энэ төсвөөс ингээд харахад бол ерөнхийдөө хөдөлмөр эрхлэлтийн сангийн хөрөнгө 2025 онтой харьцуулах юм бол 2026 онд 16 тэрбум 388.4 саяар ингээд буурсан ийм тоо харагдаж байгаа.

Тэгэхээр ахиад тэгээд цаашлуулаад ингээд харах юм бол ер нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сургалт, үнэлгээний судалгааны институтийн төсөв бас 715 сая төгрөгөөр буурч орж ирсэн гэсэн байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабал.

Б.Заяабал: Баярлалаа. Тэгэхээр улсын төсвөөр Монгол Улсынхаа бүх асуудлыг шийднэ гэвэл яагаад ч бүтэхгүй л дээ. Хэрвээ бид нар төсвөөрөө бүх асуудлыг шийднэ гээд эхлэх юм бол Монгол Улс коммунизм байгуулахтай адилхан юм болно оо, адилхан юм болно. Бүх асуудлыг төсвөөр шийдэх ямар ч боломж байхгүй ээ. Тийм учраас төрийн эдийн засгийн салбарт оролцож байгаа энэ оролцоо багасах ёстой. Энэ хэрээр хувийн хэвшлийн орон зай нэмэгдэх ёстой энэ бодлогыг бол төсвөөр дамжиж хэрэгжүүлэх нь хамгийн чухал. Энэтэй холбоотой би юу хэлэх гээд байна гэхээр зэрэг өнөөдөр төсвөөр дамжуулж хэрэгжүүлж байгаа маш олон үндэсний хөтөлбөрүүд байгаа.

Одоогийн байдлаар өнгөрсөн 1, 2 жилийн хугацаанд гэхэд үндсэндээ 3 орчим их наяд төгрөгийг гаргаад төслүүд хэрэгжүүлчихсэн. Хэчнээн ажлын байр бий болсон юм, нийгэм, эдийн засагт ямар үзүүлэлтүүд гарсан юм. Бид тэрийг бас эргэж харж үзэх хэрэгтэй. Энэний хажуугаар бид нар төсвөөс гадуурх энэ төслөөр, хөрөнгөөр энэ эдийн засгийг тэлэх ийм бодлогыг явуулах хэрэгтэй.

Тухайлбал газрын тосны үйлдвэрийг бид нар барьж байгаа. Монгол хүн болгон хүлээж байгаа. Монгол хүн болгон дэмжиж байгаа ийм том үйлдвэр ээ. Энэ үйлдвэр миний Их Хурал дээр өгсөн мэдээллийн дагуу миний бодож байгаагаар нэг, хоёр жилийн дараа гэхэд ингээд ашиглалтад орчих байх аа. Энийг дагаад маш олон ийм ЖДҮ-лэлүүд явах боломжтой гэж би харж байгаа юм аа. Өнгөрсөн хугацаанд бид нар ЖДҮ-лэлийг хөгжүүлнэ гээд төсвөөс нэлээдгүй хөнгөлөлттэй зээл олгоод нэлээдгүй арга хэмжээ явсан. Яг зах зээлийнхээ сонгодог утгаараа бол тухайн барааг зэргэлдээ оронд маш хямдаар үйлдвэрлэж байгаа нөхцөлд Монголд энд дахиж өндөр өртөгтэй үйлдвэрлээд ашиг олох маш хүндрэлтэй.

Эндээс ямар дүгнэлт хийж байгаа юм бэ гэхээр зэрэг энэ томоохон үйлдвэрүүдийг дагаж ЖДҮ-лэлүүд хөгжих ийм боломжтой юм байна гэж ингэж харж байгаа юм. Оюу толгойн туслан гүйцэтгэгч компаниуд Оюу толгой дээр гэрээ хийдэг компаниуд Эрдэнэт дээр туслан гүйцэтгэгч хийдэг, Эрдэнэтээс гэрээ авч ажил хийдэг ЖДҮ-лэлүүд бүгдээрээ хөл дээрээ босчихсон. Өнөөдөр Монгол Улсын төсөвт л үүрэг үүрээд ачаа үүрээд явж байгаа ийм ЖДҮ-лэлүүд байдаг.

Тэгвэл энэ газрын тосны үйлдвэрлэлийг дагаад хөгжих боломжтой тэр ЖДҮ-лэлүүдийг одоогоос яагаад бид нар бодож болохгүй гэж. Зайлшгүй төсвийн хөрөнгөөр биш бид нар Хөгжлийн банкныгаа өшөө илүү төгөлдөршүүлж энэ татаж авчирсан энэ хөрөнгөөрөө яг энэ газрын тосыг түшиж туслан гүйцэтгэгч болж тэндээс гарч ирж байгаа хаягдал бүтээгдэхүүнүүдээр нь түүхий эд боловсруулж дараагийн шатын хуванцар бусад материалуудыг үйлдвэрлэх ийм ЖДҮ-лэлүүдийг одоогоос зээл өгөөд хөгжүүлэх ийм боломж харагдаад байгаа юм аа.

Тэгэхлээр жижиг дундыг бодит утгаар нь хөгжүүлэе гэвэл том үйлдвэрүүдийгээ түшиглэж хөгжүүлэх юм бол илүү үр дүнтэй гэж ингэж хардаг аа. Тэгэхлээр энэ чиглэлээрээ тодорхой бодлогуудыг оруулж ирэх ёстой гэж ингэж бодож байгаагаа хэлье ээ.

Аудитын ерөнхий газар бол энэ төсөвтэй холбоотой миний хийсэн дүгнэлтэд үнэхээрийн чамлалттай байгаа шүү. Төсвийн хуулийг зөрчиж оруулж ирсэн хөрөнгө оруулалтуудыг хэвээр нь үлдээдэг ийм дүгнэлт өгөөд явж явж байна гэдэг цаашдаа энэ Үндэсний Аудитын газрын бүтэц, орон тоо, тогтолцоог нь өөрчлөх ийм зайлшгүй шаардлага Их Хурлын өмнө тулж байна гэж ингэж үзэж байна. Энэнтэй холбоотойгоор үргэлжлүүлэн би санал бодлоо хэлсээр байх болно оо. Төсөвтэй холбоотой жижиг зүйлүүд зөндөө байгаа. Тэрийг бол Байнгын хороо, холбогдох ажлын хэсэг дээр би яриад явъя гэж бодож байгаа. Энэ дээр эцэст нь ганц зүйл хэлэхэд 2 жил төсвийн зураг төсөв ТЭЗҮ нь хийгдсэн 2 жилийн доторх хийгдсэн төсвүүдийг хөрөнгө оруулалт дээр тавьдаг. Сая 2 жил төсвийн хөрөнгө оруулалтынхаа юу зураг төсвөө хийгдээд 2 жил болчихсон төслүүд тавигдаагүй байна л даа. Ингээд дараа жил тэр хэрэггүй цаас болж хувирах гээд байгаа юм.

Тэгэхээр энэ дээрээ ямар бодлого байх юм бэ гэдэг дээр бас.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир.

Ц.Сандаг-Очир: Бид нар Улсын Их Хурлын тухай хууль, Хуралдааны дэгийн тухай хуульдаа өөрчлөлт оруулаад төсвийг 5 үе шаттай хэлэлцдэг болсон. Тэгээд эхний хэлэлцүүлэг эхний үе шат бол энэ Засгийн газраас 2026 оны төсвийн төслийг танилцуулж, танилцуулах үе шат ингээд 2 өдөр үргэлжилж байна. Ерөнхийдөө ирэх жилийн улс орны эдийн засаг нөхцөл байдал ямаршуухан байх юм. Бид бүхэн Засгийн газар, Их Хурал ямар бодлого баримтлах юм гэдэг ерөнхий мэдээллүүдийг авч танилцлаа.

ТББХ-ны даргын хувьд ирэх жилийн орж ирж байгаа төсөв дээр 2 зүйл дээр анхаарч өгөөрэй. Дараагийн 2 3 дахь хэлэлцүүлэг дээр энэ асуудлаа гишүүнийхээ зүгээс дахин дахин тавих болно оо гэдгийг хэлье.

Нэгд ирэх жил нийт бүх шатын төрийн байгууллагууд дээр төрийн албан хаагчдын 9 хувийн цомхотгол хийх асуудал дээр онцгой анхаарал хандуулж ажиллаарай. Дээрээсээ энэ том данхар том бүтэцтэй байгаа яам, агентлаг, газруудаасаа энэ бүтэц орон тооны цомхотголоо хийгээрэй. Тэрнээс анхан шатын нэгж дээр байгаа энэ төрийн захиргааны байгууллагууд, төрийн улс төрийн байгууллагууд албан тушаалтнууд чинь яг байдаг орон тоогоороо байж л байгаа шүү. Тэндээс цомхотгох гээд байх юм ерөөсөө байхгүй. Харин ч хийх ажлаа ачаалал нь ихэдчихсэн улсууд л байж байгаа.

Тийм учраас энэ бүтэц орон тооны цомхотголыг дээд талаасаа хийх тал дээр анхаараарай гэж.

Дараагийн нэг асуудал энэ. Төрийн албан хаагчдын 36 сарын тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн тэтгэмжийн асуудлыг он дамнуулж өгөх гэж байгаа асуудал дээр бас анхаарах ёстой юм шүү. Энийг одоо ингэж он дамнуулж байгаа нь бас өөрөө тодорхой хуулийн зарим заалтуудыг зөрчиж байгаа асуудал бий.

Хэрвээ 2027 онд муугаар ярья. Тэр хүн нас барчихвал үлдэгдэл тэтгэврээ, тэтгэмжийг нь хэн авах юм гэдэг ч юм уу асуудлууд амьдрал баян шүү дээ. Тийм учраас тэр 20 жил, 30 жил ажиллачихсан улсууд үндсэндээ энэ тэтгэмжээ хүлээгээд л байж байгаа. Бараг зарцуулахаа өнөөдөр яаж хэрхэн юундаа зарцуулахаа өнөөдөр төлөвлөчхөөд байж байгаа улсууд. Тийм учраас энэ тэтгэмжийн асуудлыг онд нь багтааж өгөх асуудлыг дараа дараагийн хэлэлцүүлгээр тавина аа. Миний хувьд шинэ Засгийн газар байгуулагдаад хэдхэн сар болж байна. Ирэх жил болоод бүрэн эрхийн хугацаанд 3 зүйл дээр анхаарч ажиллаач л гэх гэж байгаа юм.

Нэгд, татварыг нэмэхгүй байх, энэ өөрөө мөрийн хөтөлбөр дээр ч байгаа. Засгийн газраас тогтоодог хувь хэмжээг тогтоодог татвар байна. Аймаг нийслэлийн түвшинд тогтоодог татвар байна. Өнөөдөр автомашины агаарын бохирдлын татварууд яаж нэмэгдлээ. Тэгээд бид нар хувийн хэвшлийг дэмжинэ л гээд байгаа. Хувийн хэвшлийг яг яаж дэмжих юм гэхээр нэгд энэ төрлийн татваруудыг нэмэхгүй байх. Нөгөө талаар дулаан цахилгааны үнэ тарифын асуудал бол тэр үнэхээр хувийн хэвшлүүдээ дэмжье л гэвэл энэ хэдхэн татварууд дээр л анхаарвал хувийн хэвшлийнхэн том дэмжлэг болно, том дэмжлэг болно. Нөгөө талаараа ямар ч хэлбэрийн халамжийг бас нэмэхгүй байх тал дээр анхаарч ажиллаач ээ.

Сонгуульд зориулаад, сонгууль дөхөхөөр бид нар ард иргэдэд олон нийтэд хайр зарлаад тийм ч урамшуулал олгоно ийм ч дэмжлэг үзүүлнэ гэж баахан халамжуудыг нэмдэг. Миний бодож байгаагаар 72, 73 төрлийн халамжийн төрөл байгаа. Өшөө нэмэгдсэн ч байж магадгүй. Тийм учраас нэг талаар татвараа нэмэхгүй байх, нөгөө талаар халамжийн төрлийг нэмэхгүй байх тал дээр онцгой анхаарах ёстой.

Гурав дахь анхаарах юм бол төрийн албаны бүтэц, орон тоог дахиж нэмэхгүй байх, бууруулах энэ тал дээрээ анхаараач ээ. Бүтэц, орон тоогоор маш олон хүнд зориулсан гэх нь хаашаа юм салбар зөвлөл, үндэсний хороо 9 шидийн орон тоонуудыг.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат. Байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрах.

Ж.Галбадрах: Та бүхэндээ оройн мэнд хүргэе. Гишүүд төсвийг олон талаас нь ярьж байна. Ялангуяа боловсролтой холбоотой төсөв дээр олон гишүүд санал хийж байгаад их талархалтай байна аа. Гэхдээ Засгийн газрын гишүүд маань асуултад хариулахдаа бодлогын шийдлээ түлхүү ярьдаг байгаасай гэж хүсэж байна. Тэгэхгүй бол иргэд маань бид нарыг нэг сандал ширээний асуудал, барилга байшин барих асуудал яриад байна уу гэж хараад байх шиг байна. Ерөнхий сайд боловсрол, эрүүл мэндийг тэргүүн ээлжид тавина гэсэн.

Хүний хөгжлийн хөгжлийн бодлогыг мега төслийн хэмжээнд авч үзнэ гэснийг бид боловсролын салбарын мянга мянган багш нар талархалтай хүлээж авсан. Хий хоосон амлалт битгий байгаасай. Ерөнхий сайдаас өөрөөс нь салбарын реформыг яг юунаас эхлэх гэж байгааг, ямар бодлого ямар бодит ажил хийх гэж байгааг асуумаар байгаа. Дорвитойхон төслөө нэмээсэй гэж хүсэж байна. Энэ жил боловсролыг дэмжих жил болгож зарласан бол зарласан шиг зарлаад нэгмөсөн тулгараад байгаа асуудлуудаа шийдье ээ.

Гэхдээ судалгаан дээр үндэслэж энэ шийдвэрээ гаргах нь зөв байна аа. Төсөв бол бодлогын толь гэж хэлдэг. Тэгээд манай ажлын хэсгээс би бол Их Хурал дээр Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилтийн ажлын хэсгийг ахалж ажилладаг. Тэгээд энэ ажлын хэсгээс хэд хэдэн бодлогын чанартай тодорхой санал гаргаад Сангийн яам, Боловсролын яаманд танилцуулж хамтдаа тооцоолол хийж маш олон цагаар бид нар сууж уулзалтууд хийсэн. Гэвч тэр шийдвэрүүд маань тэр бодлого маань улсын энэ төсөвт сууж орж ирсэнгүй нь маш харамсалтай байна. Гадаадын зээл тусламжид боловсролын хөрөнгө оруулалт маань нэлээн АХБ-нд нэлээн найдаж орж ирсэн байна. Ийм баймааргүй байна аа. Улсын төсөвтөө л хөрөнгө оруулалтыг тусгах ёстой. Яагаад гэвэл гадаадын зээл тусламжид маш олон шалгуур тавигддаг, маш олон хязгаарлалтууд байдаг. Ийм учраас тэр төлөвлөсөн төсөв арга хэмжээнүүд маань хойшлогдох, хоцрох ийм бас аюул байгаа гэж ингэж бодож байна.

Их Хурлын дарга чуулганы нээлтээр боловсролын талаар маш тодорхой тэгээд маш тоо баримт сайтай зүйлийг хэлсэн.

Хамгийн эхэнд багшгүй сургуулиуд болох нь гэж хэлсэн. Энэ бол бодитоор нүүрлээд байгаа аюул шүү. Багшийн хомсдолын талаар суурь судалгаа хийсэн хүний хувьд бид нэг жилд 50 тэрбум төгрөг урсгал зардалдаа тусгаад байвал багш нарынхаа хомсдолыг бууруулж чанарыг ахиулах боломжтойг бид нарын ажлын хэсэг дээрээс санал болгосон байгаа. Ингэж бодлого ярьсны үндсэн дээр судалгаан дээр суурилж бид нар тооцооллуудыгаа гаргамаар байна.

Үндэсний аудитын газраас хийсэн хяналт шалгалтаар 100 төсөл арга хэмжээн дээр 194.5 тэрбум төгрөг төгрөг нэмэгдсэнийг илрүүлж дүгнэлт гаргасан байсан. Ямар ч хамаагүй аргаар тендер авдаг тэгээд төсөв нь хүрэхгүй байна гээд сургууль цэцэрлэгийн барилгаа дуусгадаггүй. Тэр хугацаанд олон мянган хүүхдийн эрх ашиг зөрчигддөг. Бид нар ингээд харж байна. Цаашид ийм явдал давтагдахгүй байх тал дээр хаа хаанаа анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүдээсээ хүсэж байна аа. Тэгээд шалгуур үзүүлэлтүүд тавигдаж байгаа. Төсвийн 1 дүгээр хавсралтад заасан.

Энэ дээр их ойлгомжтой тодорхой болох хэрэгтэй байна. Жишээлбэл ерөнхий боловсролын сургалтын чанарыг хот хөдөөгийн боловсролын чанарыг ялгааг бууруулсан байна гэсэн шалгуурт мэргэжлийн багшаар хангагдсан сургуулийн суурь

түвшин 99.5 хувь байсныг 99.7 гэж маш өндөр хувьтайгаар гаргасан байна аа. Бид нар өнгөрсөн оны Байнгын хорооны хурал дээр 2024 оны 12 сарын 18-ны өдрийн хурал дээр ярьж байхад сургуулиудын дөнгөж 22 хувь нь л мэргэжлийн багш нар хангагдсан байна гэж ярьж байсныг санаж байна. Иймэрхүү үнэнд нийцэхгүй ийм мэдээллүүдийг засах.../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жудгийн Баярмаа байхгүй байна. Улсын Их Хурал дахь бүлгийн дэд дарга Жаргалан гишүүн. Жаргалан гишүүний микрофоныг өгье.

Б.Жаргалан: Улсын Их Хурлын гишүүдээ энэ оройн мэндийг хүргэе. Өнөөдөр нэг ноцтой асуудал гарсан учраас Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн зүгээс яах аргагүй энэ мэдэгдлийг хийхээс өөр аргагүй байдалд ороод байна.

Өнөөдөр буюу 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр 15 цаг 30 минутын орчимд АТГ-ын Балдандорж, Батмөнх нарын 2 мөрдөгч Төрийн ордонд ажилладаг нэр бүхий албан тушаалтны нэр дээр нэг удаагийн нэвтрэх зөвшөөрөл авч орж ирээд Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатарын өрөөнд бичлэг хийж орж ирээд энэ гүйцэтгэх ажиллагаа явуулсан асуудал гарлаа.

Энэ явдал бол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхэд халдсан, парламентын дархлааг үлэмж сулруулсан энэ засаглал хоорондын хяналт тэнцлийг үгүй хийсэн, тэгээд Улсын Их Хурлын байр Төрийн ордонд гүйцэтгэх аж ажиллагаа явуулсан ийм ноцтой асуудал гарсан учраас Улсын Их Хурал дахь АН-ын бүлэг энэ асуудалд зайлшгүй анхаарал хандуулах ёстой гэж үзэж цаашид бид энэ Үндсэн хуулиар баталгаажсан засаглал хоорондын хяналт тэнцлийг хадгалах, парламентын дархлаагаа бэхжүүлэх энэ асуудлууд Улсын Их Хурлын бүрэлдэхүүний хувьд нэн чухал гэж үзэж байгаа учраас энэ төсвийн хэлэлцүүлэг дээр авсан завсарлагаагаа сунгах хүсэлтэй байна аа.

Ялангуяа яг төсөв хэлэлцэж байгаа ийм цаг хугацаанд цөөнхийн гишүүнийг онилсон, цөөнхийн гишүүд рүү дайрсан энэ АТГ бөгөөд бусад энэ хууль хүчний байгууллагуудын явуулж байгаа үйл ажиллагаа бол зөвхөн цөөнхийн гишүүд төдийгүй ер нь энэ парламентын дархлааг сулруулах маш ноцтой асуудал үр дагавруудыг гаргаж байгаа учраас бид бол Улсын Их Хурлын дарга, удирдлагаас өмнө нь энэ төсвийн хэлэлцүүлэг дээр аваад байсан манай бүлгийн завсарлагыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу сунгаж өгөхийг хүсье.

Тэгээд энэ хугацаанд бид нар нэг дэх өдөр бүлгийн хурал болно. Энэ асуудлыг ярина. Тэгээд энэ танхимд сууж байгаа Улсын Их Хурлын гишүүдээсээ ч гэсэн хүсэхэд цаашид бид нар энэ Төрийн ордонд гүйцэтгэх ажиллагаа явуулах үйл ажиллагааг дэмжих юм уу? Энэ асуудал дээр ямар арга хэмжээ авах юм бэ? Энийг Улсын Их Хурал маш ноцтойгоор авч хэлэлцэх ёстой гэж үзэж байгаа. Тэгээд та бүхэндээ энэ асуудалд анхаарал хандуулахыг уриалж байна аа. Тэгээд манай завсарлагааг Дэгийн тухай хуулийн 12.1-ийн дагуу сунгаж өгөхийг хүсье ээ.

Өмнө нь 2 хоногоор авчихсан байгаа шүү дээ. 5 хоног хүртэл байгаа. Тэгээд энэ завсарлагыг сунгаж өгөхийг хүсье. 3 хоногоор сунгаж өгөхийг хүсье ээ.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12.1-ийн дагуу завсарлагын хугацааг нэг удаа ажлын 3-аас илүүгүй өдрөөр сунгаж болно гэж заасан байгаа. Нийт завсарлагын хугацаа бол 5-аас илүүгүй өдөр байх. Түрүүн Жаргалан дэд дарга, бүлгийн дэд дарга уншиж танилцууллаа.

Тиймээс АН-ын бүлгийн хүсэлтийн дагуу 3-аас илүүгүй өдрөөр сунгахаар шийдвэрлэлээ. Ингээд 5 гишүүн уг нь үг хэлэхээр байсан. Ингээд 3-аас илүүгүй өдрөөр максимум 5 хоногийн хугацаатайгаар сунгалаа АН-ын завсарлагыг. Үг хэлэхээр өгсөн нэрсийн дараалал 5 гишүүн байгаа. Яг Улсын Их Хурлын Тамгын газраас яг энэ дарааллаар нь нэрсийг нь хадгалаад чуулган үргэлжилнэ гэсэн үг. АН-ын завсарлага дуусахаар.

Ингээд өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаан дууслаа.

17.21 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА